



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ХҮРЭЭЛЭН

ҮР НӨЛӨӨТЭЙ БОДЛОГЫН СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ НЬ

Төв болон Зүүн Европын бодлогын зөвлөхүүдэд зориулсан гарын авлага

Оуэн Янг, Лиза Квинн



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ХҮРЭЭЛЭН

ҮР НӨЛӨӨТЭЙ БОДЛОГЫН СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ НЬ

Төв болон Зүүн Европын бодлогын зөвлөхүүдэд зориулсан гарын авлага

Зохиогч: Оуэн Янг, Лиза Квинн
Орчуулсан: А. Гэрэлмаа, Б. Энхбайгаль

Анхны хэвлэлт 2002 он, Будапешт хот
Нутгийн удирдлага, төрийн үйлчилгээний шинэчлэлийн санаачилга, Нээлттэй Нийгэм Хүрээлэн
анх 2002 онд Будапештэд хэвлүүлсэн.

Хаяг
Nabor utca 11, H-1051, Budapest, Hungary,
P.O. Box 519, H-1357
Утас: (36-1) 327-3104
Факс: (36-1) 327-3105
<http://lgi.osi.hu>, lgprog@osi.hu

Орчуулгын анхны хэвлэлт 2003 он, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн, Улаанбаатар хот
© ННХ/НУШ, 2002
©МННХ

Дахин орчуулж, хянан тохиолдуулсан хоёр дахь хэвлэл 2013 он
Нээлттэй Нийгэм Форум, Улаанбаатар хот
© ННХ/НУШ, 2002
©ННФ

Зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан болно.

Хаяг
Нээлттэй Нийгэм Форум, Жамъян гүний гудамж -5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 48
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

DDC
346.043.8
O-98

ISBN: 978-99962-56-42-4

ӨМНӨХ ҮГ

Сүүлийн жилүүдэд Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн “Нутгийн удирдлага, төрийн үйлчилгээний шинэчлэлийн санаачилга” (НУШ) хөтөлбөрийнхэн бид олон улсын хөгжлийн шинэ хандлагад аажмаар шилжиж байна. Төсөл хэрэгжүүлэх, тэтгэлэг олгох, чадавхи хөгжүүлэх зэрэг уламжлалт үйл ажиллагаагаар хүрээгээ хязгаарлалгүй бодлого боловсруулах, бодлого төлөвлөх ажилд бид идэвхтэй оролцдог болоод байна. Улмаар бид шинэ түншүүдтэй болж, шинэ бүтэгдэхүүн гаргадаг болоод байна. Тухайлбал, НУШ хөтөлбөр өмнөхөөсөө хамаагүй олон тооны бодлогын судалгаа захиалж, бодлогын харьцуулсан болон хавсарга судалгаа хийдэг мэргэжлийн түнш байгууллагууддаа тэтгэлэг олгохын зэрэгцээ өөрсдөө ч бодлого боловсруулах, бодлогын судалгааны арга зүйд сургах ажилд олон улсын байгууллагуудтай хамтран идэвхтэй оролцож байна.

Төв болон Зүүн Европт ажиллахад бидэнд өвөрмөц бэрхшээлүүд тулгардаг. Бидний хамтран ажиллагсад, мөн зорилтот бүлэг болох бодлого боловсруулагчдын хувьд англи хэл төрөлх хэл нь биш ч гэлээ харилцаанд өргөнөөр хэрэглэгддэг. Бодлогын судлаачид санал, дүгнэлтүүдээ өөрийн төрөлх хэлээр боловсруулж гаргахын зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулагч, хандивлагч, зөвлөхүүдэд зориулан англи хэлээр дахин танилцуулах шаардлагатай болдог.

Энэ ном бол бодлогын судалгааны баримт бичиг боловсруулах ажилд тус нэмэр болох гарын авлага, удирдамж, лавлагаа эх сурвалж юм. Мөн энэ ном бодлогын судалгаа хийх, бодлогын судалгааны тайлан бичих, хэвлэн нийтлэхтэй холбоотой олон ном, гарын авлага, сурах бичгийн тойм болохын хувьд бодлогын баримт бичиг бичиж боловсруулах зорилготой сургалтын суурь болж болно.

Уг гарын авлага бодлогын судлаач, мөн эрдэм шинжилгээний болон хавсарга судалгааны эрдэмтэн, судлаачдад хэрэгтэй зүйл болсон гэж бид найдаж байна. НУШ хөтөлбөр, түүний төслүүдийн үр шимийг хүртэх

хүмүүсийн аль алины нь хувьд хөтөлбөрөөс хэвлэн гаргах бүтээлүүдийн чанарыг сайжруулах нь нэн чухал асуудал юм. Аливаа судалгаа, тайлан, өгүүлэл, номыг бодлого боловсруулах үйл явцад оролцогч талууд (бодлогын сүлжээнийхэн) болон бидний зорилтот бүлэг болох бодлогын зөвлөхүүдэд хүргэхийн тулд тэдний дунд нийтлэгээр хүлээн зөвшөөрөгддөг тэр л хэлбэр загварт оруулах шаардлагатай болдог билээ.

Бүс нутгийн бодлого боловсруулагч, бие даасан судалгааны байгууллагуудыг дэмжих зорилготой НУШ хөтөлбөрийн “Олон нийтийн бодлого” төслийн зорилго, чиглэлд энэхүү гарын авлага бүрэн нийцэж байгаа юм. Төсөл маань шинээр байгуулагдсан бодлогын төвүүдэд менежментийн чиглэлийн зөвлөгөө өгч, мэргэжлийн дэмжлэг үзүүлж байна. Бодлогын судалгааны баримт бичиг боловсруулж бичих тухай энэхүү гарын авлага бодлогын судалгааны эдгээр төв, бидний бусад түнш, мөн бодлого боловсруулах үйл явцад оролцож буй бидний хамтран ажиллагсад ашиг тусаа өгнө гэж найдаж байна.

НУШ хөтөлбөрийн зүгээс энэ номыг бичих, хянан тохиолдуулах ажлыг нэн чадамгай хийж гүйцэтгэсэн Оуэн Янг, Лиза Квинн нарт талархал илэрхийлж байна. Энэ номыг бэлтгэхэд мэргэжлийн зөвлөгөө, санал дүгнэлт өгч хувь нэмрээ оруулсан Хосе де Баррос, Петра Ковач, Петер Радо, Виола Зентай нарт гүн талархал илэрхийлье. Саролта Кереш, Эва Фигдер нарын бүтээлүүд энэ номыг боловсруулахад хувь нэмэр болсныг онцлон дурьдах хэрэгтэй.

Габор Петери

НУШ хөтөлбөрийн Судалгаа хариуцсан захирал

ТАЛАРХАЛ

Энэ гарын авлага Төв болон Зүүн Европын орнуудын бодлогын сүлжээ, тухайн бүс нутагт ашиглагдаж байгаа бодлогын судалгааны баримт бичгийн мөн чанарыг судлахад гол анхаарлаа хандууллаа. Иймд энэ номын агуулгыг боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулж, цаг заваа харамгүй зориулсан Габор Петери, Петра Ковач, Хосе де Баррос, Виола Зентай, Томас Басс нарт зохиогчид гүн талархал илэрхийлж байна. Дэлхийн Банк хэвлэн гаргасан тайлангуудаасаа хэсэгчлэн авч, дүн шинжилгээний жишээ болгож ашиглахыг зөвшөөрсөнд бид талархаж байна. Энэ номын дизайн, хэвлэлийн форматыг бэлтгэсэн Жудит Ковачид баярлалаа.

Эрхэм уншигч Та энэ номын тухай санал сэтгэгдлээ хуваалцахыг хүсвэл ecoin@bos.org.yu, эсвэл lisa@bos.org.yu хаягаар холбоо барина уу.

Зохиогчид: *Оуэн Янг ба Лиза Квинн
Белградын Нээлттэй сургуулийн
Чадавхи бэхжүүлэх төв*

ТОВЬЁГ

ӨМНӨХ ҮГ.....	3
ТАЛАРХАЛ	5
1. УДИРТГАЛ	8
2. БОДЛОГЫН СҮЛЖЭЭ	12
2.1. Бодлогыг тодорхойлох нь	12
2.2. Бодлогын сүлжээний гишүүд	14
2.3. Улс төр судлалаас бодлого судлал руу	15
2.4. Бодлого судлал хавсарга шинжлэх ухаан болох нь	17
3. БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ	20
3.1. Бодлогын мөчлөг	20
3.2. Бодлого боловсруулах үйл явцад бодлогын судалгааны баримт бичгийн гүйцэтгэх үүрэг	25
3.3. Бодлогын холбогдолтой санал дүгнэлтээ түгээн дэлгэрүүлэх нь	27
4. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧИГ: ТОЙМ	28
4.1. Бодлогын баримт бичгийн төрлүүд: Бодлогын судалгаа ба бодлогын шинжилгээ	30
5. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧИГ: БҮТЭЦ БОЛОН БИЧВЭРИЙН БҮРДЭЛ ЭЛЕМЕНТҮҮД	33
5.1. Баримт бичгийн агуулгыг схемчлэн төлөвлөх нь	34
5.2. Гарчиг	36
5.3. Товьёг	39
5.4. Хураангуй юу, товчоон уу.....	43
5.5. Удиртгал	49
5.6. Асуудлын тодорхойлолт	56
5.6.1. Асуудлын тодорхойлолт боловсруулах нь: Бүтэц ба үндэслэл	57
5.6.2. Асуудлын тодорхойлолтыг боловсруулах нь: Бичвэр ба үндэслэл	64
5.7. Бодлогын хувилбарууд	76
5.7.1. Бодлогын хувилбаруудыг боловсруулах нь: Бүтэц ба үндэслэл	77
5.7.2. Бодлогын хувилбаруудыг боловсруулах нь: Бичвэр ба үндэслэл	87

5.8. Дүгнэлт, зөвлөмжүүд	90
5.9. Төгсгөлийн тэмдэглэл	98
5.10. Номзүй	99
5.11. Хавсралт	102
5.12. Индекс	104
6. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГЭЭ ХЭВЛЭН ГАРГАХ НЬ	107
6.1. Тодорхой хэвлэн нийтлэгчийг “онилж” бичих нь	108
6.2. Эх хувийг хүлээлгэж өгөхөд бэлтгэх нь	109
6.3. Эх хувиа хүлээлгэн өгөх нь	117
6.4. Хянан тохиолдуулагчтай хамтран ажиллаж, бүтээлээ хэвлэлтэд бэлдэх нь	118
7. ТӨГСГӨЛИЙН ҮГ	120
ХАВСРАЛТ А. УДИРТГАЛЫН ЖИШЭЭ.....	121
ХАВСРАЛТ Б. Америкийн сэтгэлзүйчдийн нийгэмлэгийн загвар	128
Ашигласан эх сурвалжийн жагсаалт.....	133
ЛАВЛАХ МАТЕРИАЛ	
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Зураг 1.1. Гарын авлагын бүтэц.....	9
Зураг 2.1. Бодлогын сүлжээ бодлогын зөвлөхийн нүдээр	15
Зураг 2.3. Бодлогын шинжлэх ухааны хамрах хүрээ.....	16
Зураг 3.1. Бодлогын мөчлөг	21
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 4.1. Бодлогын судалгаа ба бодлогын шинжилгээний баримт бичгийн ялгаа.....	31

1. УДИРТГАЛ

Чанартай сайн бодлогын баримт бичиг гадаад хэл дээр боловсруулж гаргахад шаардлагатай мэдлэг, чадвараа хөгжүүлэхийн тулд тухайн гадаад хэлийг тун сайн мэдэж байхын зэрэгцээ судалгаа, шинжилгээг тань авч хэрэглэх тэрхүү бодлогын сүлжээний гишүүн нь болох хэрэгтэй. Энэ номыг бодлогын сүлжээний гишүүд болох бодлогын зөвлөхүүдэд зориулсан бөгөөд үүнд бодлогын судлаач, шинжээчдийн аль алиныг багтааж байгаа юм. Бодлогын зөвлөхүүд уг сүлжээний хүрээнд хэвшин хэрэглэгддэг арга зүй, зорилго, дэг жаяг, үг хэллэг, харилцааны арга хэрэгслийг сайн ойлгож, хэрэглэж чаддаг байх ёстой. Гэхдээ бодлогын сүлжээнд судлаачид хэрхэн оролцох нь тухайн улс орны өвөрмөц нөхцлөөс мөн ихээхэн хамаарна.

Нийгмийн шинжлэх ухааны энэхүү хандлагад¹ суурилсан уг ном танд бодлогын оролцогч талууд, бодлого боловсруулах үйл явц, бодлогын баримт бичгийн тухай багагүй мэдээлэл өгөх ч эдгээр нь бүгд таны өөрийн орчин нөхцөлд шууд хэрэглэгдэх боломжтой гэсэн үг хараахан биш юм. Иймд энэ мэдлэг мэдээллийг өөрийн нөхцөлд хэрхэн хамгийн нийцтэйгээр “буулган” хэрэглэх талаар шийдэл олохыг хичээх аваас бодлогын судлаач болж хөгжих, төлөвших үйл явцад энэ ном танд үнэхээр чухал дэмжлэг болж чадна. Улмаар уг гарын авлага судлаачдад дараах төрлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилготой:

- Өөрөө гишүүн нь болсон тэрхүү бодлогын сүлжээний мөн чанарыг ойлгох, ажилдаа харгалзан тусгах;
- Бодлогын судалгааны баримт бичиг бол бодлого боловсруулах үйл явцад ашиглагддаг арга хэрэгсэл болохыг ойлгож, энэ чиг үүргийг нь судлах;

¹ Энэхүү гарын авлагад баримталсан нийгмийн шинжлэх ухааны хандлагын суурь нь Беркенкоттер, Хакин (1993), Хайленд (2000), Жонс (1997), Миллер (1984), Приор (1998), Расселл (1997), Свейлс (1990) нарын бүтээл болно.

- Бодлогын судалгааны баримт бичгийн бүтэц, бичвэрийн бүрдэл элементүүдийн талаарх судлаачийн мэдлэг, ур чадварыг ахиулах;
- Бодлогын судалгааны баримт бичгээ боловсруулах, хэвлүүлэх бүхий л үе шатад мэдээлэл өгч, дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Энэ гарын авлага нь эхлээд бодлогын судалгааны баримт бичиг бол бодлого боловсруулалтад ашигладаг хэрэгсэл болох тухай тайлбарлаад, дараа нь бодлогын судалгааны баримт бичгийн үндсэн элементүүдийг танилцуулж, эцэст нь баримт бичгээ хэвлэн нийтлүүлэх үйл явцыг тодорхой авч үзэх юм. Дараах зураг дээр гарын авлагын бүтцийг тоймлон харууллаа.

Зураг 1.1. Гарын авлагын бүтэц



Гарын авлагыг сайн ойлгож, ашиглахад тус болох үүднээс үүнийг боловсруулахдаа баримталсан хандлага, сонгож авсан гол фокусын тухай товч тайлбар өгье. Бид бодлого судлалын салбарт ашигладаг бодлогын судалгааны тодорхой нэг л төрлийг сонгон авч энэ

Энэ гарын авлагын гол фокус бол бодлого судлалын талбарт ашигладаг бодлогын баримт бичгүүд юм.

гарын авлагад нарийвчлан үзэж байгаа билээ. Энэ сонголт нь Төв болон Зүүн Европ (ТЗЕ)-д бодлого судлалын шинжлэх ухаан эхлэлээ тавьж, олон тооны анхдагч бодлогын судалгааг дэмжих хэрэгцээ шаардлага үүсээд байгаатай шууд холбоотой. Энэхүү гарын авлага юуны өмнө бодлого судлаачдад зориулагдсан боловч бодлого судлал, бодлогын шинжилгээний салбарууд хоорондоо нягт уялдаатай, мөн энэ хоёр салбарт ашиглагддаг бодлогын судалгааны баримт бичгүүдийг бид номын хэсэг, бүлэг бүрт л зэрэгцүүлэн тайлбарлаж байгаа тул энэ гарын авлага бодлогын шинжээчдэд ч хэрэг болох юм.

Энэ номд ашигласан бодлогын судалгааны баримт бичгийн тодорхойлолтыг боловсруулан гаргахдаа өмнө нь хэвлэгдэн гарсан бодлогын судалгааны баримт бичиг, тус бүс нутгийн бодлогын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага, энэ төрөл жанрыг тодорхойлсон тайлбарууд зэрэг олон эх сурвалжийг ашигласан юм. Бодлогын судалгааны баримт бичгийн талаар энэ бүс нутагт тогтоод байгаа нийтлэг ойлголт, хандлагыг харуулах үүднээс бид бүс нутгийн асуудлаар саяхан хэвлэгдэн гарсан бодлогын судалгааны хэд хэдэн баримт бичгийг жишээ болгон ашигласан нь номын туршид ишлэн дурьдаж байгаа дараах баримт бичгүүд болно:

- (i). “Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах нь: Захиргаадлаас зах зээлд” (Бёрд, Эбель, Воллих нар, 1995);
- (ii). “Орон нутгийн түвшний төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл явц дахь нээлттэй өрсөлдөөн, ил тод байдал, төвийг сахисан байр суурь” (Баар, 2001);
- (iii). “Идэвхтэй сайшаах, идэвхгүй дэмжих ба үл итгэн хойш суухын хооронд” (Свианиевич, 2001);
- (iv). “Нэгдмэл үзлээс олон ургальч үзэлд шилжих нь: Румын дахь цөөнхийн бодлогын хүрээнд зохицуулалтуудыг нарийвчлах хэрэгцээ” (Хорват, Скаццо нар, 2001);
- (v). “Төв ба Зүүн Европын орнуудад худалдааны бодлого, өрсөлдөөнийг уялдуулах нь” (Хүүкман, Мавроидис нар, 1994).

Энэ номоос олж авсан мэдлэгээ бэхжүүлэхийн тулд бодлогын судалгааны жишээ баримт бичгүүдийг бүрэн эхээр нь уншихийг танд зөвлөж байна.²

Бодлогын баримт бичгийн бүрдэл хэсэг бүрийн үүрэг роль, нийтлэг бүтэц, бичвэрийн онцлог, бусад судлаачдын ашигласан арга хандлага зэргийг сайтар шинжилж судалснаар та өөрийн баримт бичгийн бат бэх суурийг бий болгоно. Тиймээс ч бодлогын таван баримт бичгээс хэсэгчлэн иш татсан хэсгүүдээ “Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгүүдийн шинжилгээ” нэртэй хайрцгаар танилцуулан, нарийвчлан шинжлэх зорилгоор тавдугаар бүлгийн тохирох хэсгүүдэд байршууллаа. Эдгээр жишээ нь бодлогын баримт бичгийн “нийтлэг”, “шилдэг” загвар гэсэн утгаар бус харин тодорхой асуудлыг онцлон харуулах, задлан шинжлэхэд тохиромжтой жишээ болж байгааг энд онцолъё. Ер нь бодлогын баримт бичиг бүрийн бичих, хэвлэн нийтлэх үйл явцыг хүрээлж буй орчин нөхцөл бүр нь ээдрээтэй, төвөгтэй байдгийг харгалзвал тийм нийтлэг загвар байх боломж үгүй билээ.

Мэдлэг, чадвар эзэмших нь “хийх явцдаа суралцдаг”³ идэвхтэй бөгөөд хөгжих үйл явц мөн гэсэн итгэл үнэмшлээр бид баримт бичгээ төлөвлөх, бичихдээ ашиглах Хяналтын хуудсуудыг гарын авлагад оруулж өглөө. Эдгээр хяналтын хуудас нь асуулт асуух замаар бодлогын баримт бичгээ төлөвлөх, бичих, сайжруулан боловсруулах бүхий л үе шатад танд тус дэм болох юм.

Энэхүү гарын авлага бодлогын сайн баримт бичиг боловсруулахад туслах үр дүнтэй хэрэглэгдэхүүн болж чадсан хэмээн найдаж байна. Хамгийн гол нь та бодлогын судалгааны сайн баримт бичиг боловсруулж, амжилттай хэвлүүлснээр өмнөө тавьсан зорилгодоо хүрч чадна гэж бид найдаж байна.

² Номд хэсэгчлэн авсан жишээ таван баримт бичгийг бүрэн эхээр нь татаж авах интернет хаягийг энэ номын Эх сурвалж хэсгээс үзнэ үү.

³ Англи хэлт олон улсын орчинд Даалгаварт суурилсан болон бие даан суралцахуйн үзэл санаа нь Брийн (1987), Хатчинсон ба Вотерс (1987), Иллих (1970), Ноулс (1983), Нунан (1988), Виддоусон (1998) нарын бүтээлээс эхтэй болно.

2. БОДЛОГЫН СҮЛЖЭЭ

Номын энэ хэсэгт бид бодлого боловсруулах үйл явцад оролцогч талууд болон судалгааны энэ салбарын тухай товчхон авч үзнэ. Энэ салбарт дөнгөж хөл тавьж буй шинэхэн судлаачдад энэ бүлэг маш энгийн удиртгал болж болох бол туршлагатай бодлогын мэргэжилтний хувьд таны хийж буй ажлыг чиглүүлэн залж буй зарчмуудыг эргэн харах боломж юм. Бодлогын баримт бичиг боловсруулахтай холбоотой энэ сүлжээний баримталдаг суурь зарчим, үзэл баримтлал, үнэт зүйлс, бодлогын судалгааны баримт бичигт эдгээрийн үзүүлэх нөлөөг судлаач танд сайтар ойлгуулах үүднээс бид юуны өмнө бодлогын сүлжээний тухай авч үзэх болно.

Энэ бүлгийн эхэнд бодлогын хэд хэдэн тодорхойлолт, тэдгээрийн ялгааг хэлэлцээд, дараа нь бодлогын сүлжээний гишүүд, тэдний гүйцэтгэх үүрэг ролийг авч үзнэ. Дараагийн дэд хэсэгт бодлого судлалын шинжлэх ухааны түүхэн хөгжлийг тоймлон танилцуулаад, эцэст нь бодлого судлал нь хавсарга шинжлэх ухаан болох тухай тайлбарлах юм.

2.1. Бодлогыг тодорхойлох нь

Төрийн бодлогыг олон янзаар тодорхойлдог ч эдгээрт нийтлэг талууд бий.

Судлаачид “бодлого” хэмээх ойлголтыг олон янзаар тайлбарласан байдгийн дотор “Засгийн газар хийхээр болон хийхгүй байхаар сонгодог зүйлс” (Дие, 1992 Андерсоны ишлэснээр, 1994, 4 дүгээр нүүр) гэсэн маш өргөн хүрээтэй жишээнээс авахуулаад “Тодорхой бэрхшээл, асуудлыг шийдэх зорилгоор нэг, эсвэл хэсэг хүмүүсийн хэрэгжүүлж буй зорилтот багц ажиллагаа” (Андерсон, 5 дугаар нүүр) гэсэн онцлог шинжүүдийг нь тайлбарласан илүү нарийн тодорхойлолт ч багтдаг. Энэ салбарт оршиж буй үзэл бодлын ялгаа, олон ургальч байр сууриудыг тоймлон харуулахын тулд янз бүрийн тодорхойлолтод туссан гол зарчмыг онцолж харах хэрэгтэй. Андерсоны шинжилснээр, янз бүрийн тодорхойлолтод дараах үндсэн зарчууд нийтлэгээр туссан байдаг ажээ:

Төрийн бодлого бол:

- *төр, засгийн эрх мэдлийн хүрээнд багтах үйл ажиллагаа:*

Төрийн бодлого бол тухайн үйл ажиллагааг явуулах эрх зүй, улс төр, санхүүгийн эрх мэдэл бүхий төрийн байгууллага, этгээдийн хэрэгжүүлж буй ажиллагаа

- *бодит амьдралд тулгарч буй хэрэгцээ, асуудалд үзүүлэх хариу үйлдэл:*

Төрийн бодлого нь нийгэм, иргэн, төрийн бус байгууллага, төрийн байгууллага зэрэг нийгэм дэх бүлгүүдийн тодорхой хэрэгцээ, асуудалд хариу шийдэл болох ёстой.

- *зорилготой:*

Төрийн бодлого нь сайтар тооцоолж боловсруулсан багц зорилтуудыг хангахад чиглэгддэг бөгөөд эдгээр нь зорилтот бүлгийн тодорхой хэрэгцээг хангах, тодорхой асуудлыг шийдэх чиглэлээр гаргаж буй хүчин чармайлтын илрэл болдог.

- *багц үйл ажиллагаа:*

Төрийн бодлого бол ихэнхдээ салангид ганц шийдвэр, үйлдэл, хариу үйлдэл бус харин нарийн бодож зохицуулсан стратеги, хандлага байдаг.

- *арга хэмжээ авах, авахгүй байх тухай шийдвэр:*

Бодлого нь илэрч гарч ирсэн асуудлыг шийдэх зорилгоор тодорхой арга хэмжээ авах, эсвэл асуудал өнөөгийн эрхзүйн хүрээнд яваандаа шийдэгдэх тул тодорхой арга хэмжээ авах шаардлагагүй гэсэн итгэл үнэмшилд тулгуурласан байж болно.

- *нэг, эсвэл хэсэг оролцогч хэрэгжүүлдэг:*

Бодлогыг төрийн нэг төлөөлөгч, нэгж, эсвэл хэд хэдэн оролцогч хэрэгжүүлж болно.

- *үйл ажиллагааны үндэслэл:*

Бодлогын баримт бичигт энэхүү бодлогыг гаргах болсон шалтгааныг тайлбарласан үндэслэл багтаадаг.

- *гаргасан шийдвэр:*

Төрийн бодлого нь амлалт, эсвэл сэдэл биш харин гаргачихсан шийдвэр юм.

2.2. Бодлогын сүлжээний гишүүд

*Бодлогын сүлжээнд
ялгаатай үзэл
бодолтой оролцогчид
багтдаг.*

Бодлого боловсруулалт бол нийгэмд шууд нөлөөлдөг үйл явц тул түүний янз бүрийн үе шатад янз бүрийн сонирхол сэдэлтэй олон хүн оролцдог. Бодлогын тодорхой шийдэл ашиг сонирхлыг нь шууд ба шууд бусаар хөндөж байгаа төрийн байгууллага, бодлогын зөвлөх, янз бүрийн төрийн бус болон иргэний бүлэг, хувь хүмүүсийг сонирхогч талууд гэж нэрлэдэг. Ийм сүлжээний төвд тухайн асуудал, бэрхшээлийг шийдэх үүрэг хүлээсэн төрийн байгууллагууд байрлана (Зураг 2.1-ийг харна уу). Зарим тохиолдолд төрийн байгууллага нь бодлогын шинжээч, бодлогын судалгааны төв, шинжилгээний мэргэшсэн байгууллагатай зөвлөх үйлчилгээний шууд харилцаа тогтоодог. Энэ тохиолдолд төрийн байгууллага бодлогын зөвлөхөөс асуудлыг ул суурьтай, нарийвчлан шинжлээд, бодлогын үндэс суурь болох зөвлөмж гаргаж өгөхийг хүснэ. Ерөнхийдөө, тухайн асуудлаар бодлогын судалгааны төвүүдийн өмнө хийж гүйцэтгэсэн судалгаанууд энэ нарийвчилсан шинжилгээний эмпирик суурь болдог. Шинжээч, засгийн газар хоорондын ийм шууд харилцаа ТЗЕ-ын бүст төдийлөн өргөн тархаагүй ч олон бодлогын судлаач, шинжээч, судалгааны төв тодорхой асуудлаар бодлогын хэлэлцүүлэгт оролцож, шийдвэрт нөлөөлөхийг хичээж байна. Энэ зорилгодоо хүрэхийн тулд тэд судалгаагаа хэвлүүлэн гаргаад, дараа нь санал зөвлөмжөө олон хүнд хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мөн бусад арга замаар сурталчлан тараадаг билээ.

Ардчилсан аль ч нийгэмд бүх талууд л өөрийн бодлоор хамгийн оновчтой гэсэн бодлогын хувилбарыг тараан таниулахын тулд асуудал хариуцсан төрийн байгууллага, төрийн болон парламентын нэгжийн төлөөлөл, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гээд хамгийн үр нөлөөтэй гэж үзсэн чиглэлд бүхий л боломжоо дайчлан ажилладаг. Эдгээр сонирхогч тал нь, жишээлбэл, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, бодлогын зөвлөх, бодлогын судалгааны төв, орон нутгийн засаг захиргаа, улс төрийн нам, иргэдийн бүлэг, эвсэл зэрэг байж болно.

Зураг 2.1. Бодлогын сүлжээ бодлогын зөвлөхийн нүдээр



2.3. Улс төр судлалаас бодлого судлал руу⁴

“Бодлого судлалын түүх урт ч уламжлал нь богино. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн мянган жилийн туршид хийгдсэн олон судалгаа төрийн бодлогын тухай асуудлыг хөндөж ирсэн ч системтэй судалгаа нь хэдэн арван жилийн өмнөөс л эхэлсэн” гэж Питер Де Леон (1994, Хаулетт, Рамеш нарын ишлэснээр, 1994, 18 дугаар нүүр) тэмдэглэжээ. Үнэндээ бол Дэлхийн II дайны дараагаас л уламжлалт улс төр судлалын зэрэгцээ засгийн газар юу хийдгийг авч үзэх, нарийвчлан судлах шаардлагатайг ойлгох болсноор бодлого судлалын шинжлэх ухааны үндэс тавигдсан юм. Энэ салбарыг чиглүүлж байдаг философийн тулгуур гурван ойлголт бий:

Бодлогын шинжлэх ухааны тулгуур гурван зарчим: олон шинжлэх ухааны уулзвар цэг байх, асуудал шийдэх, хэм хэмжээг тогтоох

- Олон шинжлэх ухааны уулзвар байх

Бодлого судлалын шинжлэх ухаан нь нийгмийн ухааны ойлголт, судалгаа, арга зүйд тулгуурлахын зэрэгцээ хөгжлийнхөө явцад өөрийн гэсэн хандлагуудыг бий болгосон.

⁴ Энэ тойм Хаулетт ба Рамеш (1995) бүтээлд тулгуурласан болно.

- Асуудал шийдэх

Тодорхой нийгэмд бодитой тулгарч буй асуудал, бэрхшээлийг шийдэхэд анхаардаг.


- Хэм хэмжээтэй байх

Хэдийгээр хэм хэмжээнд тулгуурлан хүрээ тогтоох хандлагаас сүүлийн үед татгалзах болсон ч бодлого судлалын салбарт сонголт хийхдээ үнэт зүйлсэд тулгуурлах зайлшгүй шаардлага олонтаа үүсдэг.

Бодлогын шинжлэх ухааны хоёр салбар: бодлогын судалгаа ба бодлогын шинжилгээ

Цаг хугацааны явцад бодлогын шинжлэх ухаан хоёр салбарт хуваагджээ. Эхнийх нь бодлогын тодорхой асуудлаар анхдагч судалгаа хийх замаар бодлого боловсруулах үйл явцыг ойлгож, мэдээллээр хангахыг зорьдог бодлогын судалгаа юм. Бодлогын судалгаа бол бодлого судлаач, академик судалгаа хийдэг эрдэмтдийн сонирхлын талбар юм. Хоёрдахь чиглэл нь бодлогын шинжилгээ юм. Энэ чиглэл нь илүү улс төрийн сэдэлтэй бөгөөд төрийн байгууллагын өмнөөс бодлого боловсруулж өгөх замаар бодлогын бодит үр дүнд шууд нөлөөлөх зорилго агуулдаг. Бодлогын шинжилгээг ихэвчлэн бодлогын шинжээч, бодлогын судалгааны төвүүд хэрэгжүүлдэг. Дараах зурагт бодлогын шинжлэх ухааны хамрах хүрээг дүрслэн харууллаа.

Зураг 2.2. Бодлогын шинжлэх ухааны хамрах хүрээ



Бодлогын шинжлэх ухааны аргазүйн эдгээр хандлагыг ТЗЕ-ын бүс нутагт шилжилт эхэлснээс хойш буюу саяхнаас л хүлээн зөвшөөрсөн билээ. Тиймээс энэ бүс нутагт бодлого судлал эхлэл төдий байгаа бөгөөд хэн юу хийх, хэний төлөө, хэрхэн гүйцэтгэх нь бүрэн ойлгомжтой болоогүй л байна. Түүнчлэн, бодлогын хүрээнүүдийн эмпирик шинжилгээ энэ бүс нутагт үнэндээ дөнгөж эхэлж байгаа тул өнөөг хүртэл хийсэн судалгааны ажлын ихэнх нь бодлогын хамгийн анхны судалгаанууд буюу бодлого судлалын асуудлуудад төвлөрч байгаа хэрэг юм. Гэлээ ч, ялангуяа 1990-ээд оны эхээр энэ бүс нутгийн судалгааны олон байгууллага бодлогын шинжээчийн үүргээр засгийн газартайгаа уламжлалт үйлчлүүлэгч - зөвлөхийн харилцаа тогтоосон байсан бөгөөд энэ харилцаагаараа дамжуулан тэд Дэлхийн Банк, Олон улсын валютын сан зэрэг олон улсын дэмжигчдийнхээ бодлогыг сурталчлан тарааж байжээ (Крастев, 2001). Үнэндээ, аль ч бүс нутаг, орчин нөхцөл дэх бодлогын ертөнц дээд зэргээр улс төржсөн байдаг тул бодлогын өөрчлөлтүүд тэр бүр эмпирик судалгаанд суурилсан байдаггүйг санахад илүүдэхгүй. Улс төрийн ширүүн өрсөлдөөнт, хувирамтгай ертөнцөд өөрчлөлтийг өдөөгч хүч нь сонгуулийн амлалтыг гүйцээх гэхчилэн цэвэр улс төрийн хүсэл зориг байдаг нь үнэн.

Бодлого судлал Төв болон Зүүн Европт эхлэл төдий байна.

Төлөвлөлтөд ашиглах хяналтын хуудас

Бодлогын судалгааны баримт бичгээ бичиж эхлэх гэж байхдаа та дараах асуултад анхаарлаа хандуулаарай:

- Одоо гүйцэтгэж байгаа энэ бодлогын холбогдолтой судалгааны ажил тань бодлогын судалгаа юу, бодлогын шинжилгээ юу?
- Таны сонгож аваад судалж байгаа бодлогын асуудлыг танай бодлогын сүлжээний ямар гишүүд сонирхож байгаа вэ?
- Та бодлогын баримт бичгээрээ шууд болон шууд бусаар хэнтэй харилцахыг хүсч байна вэ?

2.4. Бодлого судлал хавсарга шинжлэх ухаан болох нь

Бодлогын шинжлэх ухаанд баримталдаг зарчим, үнэт зүйлсийг нэгтгэн дүгнэхэд энэхүү шинжлэх ухааны салбар илтэд хавсарга шинж чанартай болох нь тодорхой харагдана. Бодлогын шинжлэх ухааныг уламжлалт суурь шинжлэх ухаанаас ялгаатай болгодог хоёр гол хүчин зүйл бий. Эдгээр нь дараах болно.

- *Амьдралд бодитой тохиолдож буй асуудал, бэрхшээлийн шийдлийг олох*

Асуудал – шийдэл гэсэн холбоос гол нь юм.

Уламжлалт суурь шинжлэх ухаан нь бүлэг эрдэмтдийн дунд шинэ мэдлэг бий болгохыг зорьдог бол бодлогын шинжлэх ухаан амьдрал дээр тохиолдож буй бодит асуудал, бэрхшээлийн шийдлийг олж, улмаар тухайн нийгэмд уг шийдлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зөвлөмж, бодлогын хүрээг гаргаж өгдөг. Жишээлбэл, ажилгүйдлийг нийгмийн үзэгдлийнх нь хувьд ойлгож, танин мэдэхийн тулд тодорхой нэг нийгэм дэх ажилгүйдлийн шалтгаан, хэв загварыг судлах нь хангалтгүй юм. Харин бодлогын судалгаа нь асуудлыг бодит орчин нөхцөлд нь авч үзэх ёстой тул тухайн нийгэм дэх ажилгүйдлийн шалтгаануудыг тайлбарлан, эдгээр нь энэ орон нутгийн хувьд тулгамдаад байгаа асуудал, бэрхшээл мөн болохыг харуулаад, энэ асуудлыг шийдэх зорилгоор хэрэгжүүлж болох багц үйл ажиллагааг санал болгох замаар мэдлэгээ тодорхой нэг орон нутгийн бодит амьдралд “буулган” хэрэглэх ёстой. Тиймээс асуудал - шийдэл гэсэн логик холбоосыг энэ салбарын гол зарчим гэж харах нь зүйтэй бөгөөд өөрөөр хэлбэл, хийж буй шинжилгээ бүхэн практик мөн чанартай, хэрэгжих боломжтой, цогц үр дүнд хүрэх зорилгод хөтлөгдсөн, үүнд чиглэсэн байх шаардлагатай.

- *Үнэт зүйлсэд түшиглэсэн үндэслэл гаргах*

Цуглуулсан мэдээлэлдээ шинжилгээ хийсний үндсэн дээр үнэт зүйлсэд түшиглэсэн үндэслэл гарга.

Практик ач холбогдол бүхий, үр нөлөөтэй шийдлийг хайхдаа байгаа бүх мэдээлэл, өгөгдөлд бүх талын нарийвчилсан шинжилгээ хийхээс гадна судалж буй асуудал нь нийгмийн шинжтэй учраас үүнийг шийдэх хамгийн оновчтой бодлогыг сонгохдоо бодлогын судлаач өөрийн үнэт зүйлс, үнэлэмжид тулгуурлан зарим нэг субъектив дүгнэлтийг хийх хэрэгтэй болдог. Иймд төрийн бодлогын угийн улс төржсөн орчинд, өргөн хүрээтэй сонсогчдод хандан тодорхой шийдлийг санал болгоно гэдэг нь бодлогын мэргэжилтэн зөвхөн өгөгдөлд тулгуурласан дүн шинжилгээний “хуурай” тайлбар өгөөд зогсохгүй, магадгүй үүнээс ч илүүтэйгээр, өөрийнх нь санал болгож буй бодлогын зөвлөмжүүд өнөөгийн энэ нөхцөлд хамгийн тохиромжтой шийдэл мөн гэдэгт сонсогч, уншигчдыг ятгаж үнэмшүүлэх чадвартай байх ёстой болж байна. Өөрөөр хэлбэл, цуглуулсан мэдээлэл, өгөгдлийн шинжилгээний үр дүнг танилцуулаад

орхих нь тухайн асуудлаарх бодлогын яриа хэлэлцүүлэгт нөлөөлөх хэмжээний үр дүн авчрахгүй байх магадлалтай. Харин эдгээр өгөдлийг өөрийн байр суурийг дэмжсэн цогц бөгөөд логиктой үндэслэлийн нотолгоо, дэмжих баримт болгож ашиглаж чадвал таны судалгааны баримт бичиг жинхэнэ өөрчлөлтийг авчрах арга хэрэгсэл болж чадна.

Мэжоун (1989) энэ санааг ийнхүү тоймложээ:

Бодлого боловсруулах, бодлогын тухай зөвлөх нь мэс засал хийх лугаа ур чадвар шаардсан ажил бөгөөд бид чадварлаг гүйцэтгэлийг гүйцэтгэгчийн толгойдоо хуримтлуулсан мэдээллийн хэмжээ юмуу, эсвэл албан ёсны төлөвлөлтийн цар хүрээгээр үнэлдэггүй. Харин цаг үеэ олсон, асуудлыг нарийвчлан авч үзсэн байдал; боломжтой болон боломжгүйн зааг хязгаарыг мэдрэх, улмаар хязгаарлалтыг бүтээлчээр ашиглах, мөн бусдын алдаанаас суралцах чадавхи; юу хийх ёстой байсныг харуулах чадавхиар бус харин юу хийх ёстой талаар хүмүүсийн бодож төсөөлж байгаа тэр зүйлсийг хийх итгэл үнэмшлийг бий болгох чадвараар үнэлдэг (17 дугаар нүүр).

3. БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

Бид хоёрдугаар бүлэгт бодлогын сүлжээний мөн чанартай танилцсан бол энэ бүлэгт бодлого боловсруулах үйл явцын мөн чанар, энэ үйл явцад ашигладаг харилцааны арга хэрэгслүүдийг авч үзэх юм. Эхлээд бодлого боловсруулах үйл явц буюу нийтлэгээр бодлогын мөчлөг гэж нэрлэж заншсан загварын тухай товч өгүүлнэ. Гэхдээ энэ ном бодлогын шинжлэх ухааны арга зүйн⁵ асуудлыг судлах зорилго тавиагүй тул бодлогын мөчлөгийг маш товч авч үзлээ. Энэ тойм нь бодлогын үйл явцын үр дүнг баримтжуулан цаасан дээр буулгах, тайлагнахад ашигладаг харилцааны гол хэрэгсэл, номын маань гол сэдэв болж буй бодлогын судалгааны баримт бичгийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болоход танд тусална.

Хоёрдахь дэд бүлэгт бид бодлого боловсруулах үйл явцад бодлогын судалгааны баримт бичгийн гүйцэтгэж болох олон янзын үүрэг ролийг авч үзнэ. Энэ хэсгийн эцэст бодлогын судалгааны санаа, зөвлөмжөө илүү өргөн хүрээнд тараан түгээхийн тулд ашиглаж болох харилцааны олон арга хэрэгслээс сонголт хийхдээ ашиглаж болох стратегийн хандлагыг танилцууллаа. Сүүлийн энэ хэсгээр бодлогын судалгааны баримт бичиг болон бусад арга хэрэгслийн уялдаа холбоог харуулахыг зорьлоо.

3.1. Бодлогын мөчлөг⁶

Орчин нөхцөл, зорилгоосоо хамааран бодлого боловсруулах үйл явцыг олон янзаар тайлбарлаж болох ч бодлого судлалын салбарт нийтлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн нь “бодлогын мөчлөг” хэмээх загвар юм (Зураг 3.1-ийг үзнэ үү).

⁵ Андерсон (1994), Бардак (1996), Дай (1992), Хаулет ба Рамеш (1996).

⁶ Энэ хэсгийг Андерсон (1994), Бардак (1996), Дай (1992), Хаулет ба Рамеш (1996), Охайо мужийн Их сургууль (1998), Нээлттэй Нийгэм Хүрээлэн (1999), Пал (2000), Смит (2000) нарын бүтээлд түшиглэлэн бичлээ.

Зураг 3.1. Бодлогын мөчлөг



Аливаа загварын нэгэн адилаар, бодлогын мөчлөг нь судлаачийн ажлыг чиглүүлж өгч чадах давуу талтай ч уян хатан байж чаддаггүй сул талтай. Өөрөөр хэлбэл, бодлогын мэргэжилтэн тодорхой нэг нөхцөлд яг ямар арга хэмжээ авахыг энэ загвар зааж өгч чадахгүй ч тэргүүн туршлага, шилдэг шийдлийг авч хэрэгжүүлэхийн тулд ямар орчин нөхцөл бий болгохоор зорих ёстойг ойлгоход нь тус болж чадна. Түүнээс гадна, зургаан үе шаттай бодлогын энэхүү мөчлөгийн шат бүр нь өмнөх болон дараагийн шатдаа нөлөөлж байдаг нь бодлогын үйл явцын жинхэнэ дотоод мөн чанарыг харуулж байгаа юм. Жишээлбэл, хамгийн оновчтой бодлогын шийдлийг сонгохоор боломжит бодлогын хувилбаруудыг үнэлэх үйл ажиллагаа нь эргээд асуудлын тодорхойлолтыг өргөжүүлэх, гүнзгийрүүлэхэд тус болж мэднэ. Иймд, Бардачийн тэмдэглэсэнчлэн (1996), бодлого боловсруулах үйл явц угаасаа дахин дахин давтах шинжийг агуулдаг буюу тохиромжтой үр дүнд хүртлээ үе шат бүрийн элементүүдийг олон дахин давтаж хийхийг шаарддаг юм.

Бодлогын мөчлөгийн үе шат бүр хамтын ажиллагаа, харилцан нөлөөлөлд түшиглэдэг онцлогтой. Хамгийн үр нөлөөтэй бодлогын судалгаа, шинжилгээг багаар гүйцэтгэж, судалгааны туршид олон сонирхогч талыг

Бодлогын мөчлөг бол бэлэн жор биш, чиглүүлж өгөх удирдамж юм. Энэ нь дахин давтагдах шинжтэй, хамтын ажиллагаа шаардсан үйл явц юм.

төрөл бүрээр татан оролцуулсан байдаг. Ийм хамтын ажиллагааны жишээ гэвэл, тухайлбал, асуудлаа тодорхойлох шатад бодлогын судлаачидтай санал солилцож ярилцахаас авахуулаад зорилтот бүлэгтэй хамтран бодлогын хувилбарын өртөг, үр ашгийг тооцоолох, бодлогын зөвлөмжөө хүргэхийн тулд төр, засгийн төлөөлөгчидтэй уулзах зэрэг үйл ажиллагааг нэрлэж болно. Одоо бодлогын үйл явцын үе шатуудын мөн чанарыг ойлгуулах үүднээс алхам бүрийг товч авч үзье.

- **Алхам 1. Асуудлаа тодорхойлох/ Асуудал болгож дэвшүүлэх**

Төр, засгийн оролцоог шаардсан асуудал, бэрхшээл байна гэдгийг харуул.

Ихэнхдээ, тодорхой нийгэмд амьдарч буй бүлэг хүн бэрхшээл, хүндрэлийг олж хараад, гаргаж тавьснаар бодлого боловсруулах үйл явц эхэлдэг. Бодлогын мэргэжилтний хувьд, та ч бас тодорхой нэг бэрхшээлийг олж хараад, шийдүүлэхийг хүсэх юм бол энэ бэрхшээлийг асуудал болгон томъёолж, төр, засгийн хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах, харин нэгэнт хэлэлцэх асуудлын жагсаалтад орчихсон байгаа бол ач холбогдлыг нь нэмэгдүүлж, эн тэргүүнд шийдэх асуудал болгохын төлөө ажиллана. Энэ зорилгодоо хүрэхийн тулд төр, засгаас арга хэмжээ авахыг шаардсан бэрхшээл бодитойгоор оршиж буйг асуудал хариуцсан төрийн байгууллага, бодлогын сүлжээний гишүүдэд ойлгуулах хэрэгтэй болно. Бодлогын улс төржсөн ертөнцөд энэ зорилгодоо хүрэхийн тулд та төрөл бүрийн эх сурвалжид тулгуурлан хүндрэл, бэрхшээлийн шалтгаан, үр дагавар, цар хүрээг итгэл төрүүлэхүйц, үнэмшилтэй, цогцоор тайлбарлан, танилцуулах хэрэгтэй болно.

- **Алхам 2. Бодлогын хувилбаруудыг боловсруулах/ Бодлогыг томъёолох**

Боломжит бүх хувилбарыг авч үзээрэй.

Асуудлын мөн чанарыг хангалттай хэлэлцэн ойлголцоод, төр, засгийн хэлэлцэх асуудлын жагсаалтад багтаачихсан байгаа бол одоо шийдэл хайх үе шат эхэлнэ. Энд юуны өмнө уг асуудлыг шийдэх арга замууд буюу өөрөөр хэлбэл, бодлогын хувилбаруудыг тодорхойлох хэрэгтэй. Бодлогын хувилбаруудыг гаргаж ирэхийн тулд та одоо авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, бусад хүмүүс санал болгож буй шийдэл, өөрийн хувилбар зэргийг судлаарай. Бодлогын хувилбарууд бол нэг шийдлийн хувиралтууд бус харин нэг нь нөгөөдөө уусаж шингэх боломжгүй,

харилцан бие биеээсээ үл хамаарах, жинхэнэ утгаар бие даасан шийдлүүд байх ёстой. Мөн төгс хувилбар гаргаж ирэх нь тун хэцүү; ихэнхдээ тухайн орчин нөхцөлд хэрэгжих хамгийн өндөр магадлалтай, хамгийн бодитой хувилбар олохыг хичээх нь зүйтэй.

- Алхам 3. Шийдлийг сонгох/ Бодлогын оновчтой хувилбарыг сонгох

Хувилбар бүрийг нарийвчлан боловсруулсны дараа үнэлгээний багц шалгуурын тусламжтай асуудлыг хамгийн оновчтойгоор шийдэж чадах хувилбарыг сонгоно. Шалгуур үзүүлэлтэд тулгуурлан үнэлгээ өгөх энэхүү үйл явц нь тохиромжтой хувилбарыг сонгоход тань туслах төдийгүй санал болгохоор сонгосон бодлогын хувилбарынхаа үндэслэлтэй бөгөөд оновчтой байдлыг итгэлтэй хамгаалах суурь болж өгөх юм. Хэдийгээр үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд нь тухайн асуудлын мөн чанар, түүний илэрч буй орчин нөхцлөөс хамаарах ч бодлогын үйл явцад ашигладаг нийтлэг шалгуур үзүүлэлтүүд нь дараах болно:

Хувилбар бүрийг үнэлээд, хамгийн сайн гэж үзсэн хувилбарыг сонго.

- *Үр нөлөө:* Энэ хувилбар нь хүсэж буй үр дүнг хэдий хэмжээнд бий болгож чадах вэ? Өөрөөр хэлбэл, асуудлыг хэдий хэмжээнд шийдэж чадах вэ?
- *Үр өгөөж:* Мөнгө хөрөнгө болон нийгмийн нөлөөллийн аль алийг тооцсон өртөг, үр ашгийн тооцоонд үндэслээд харахад энэ хувилбар зорилтот бүлэгт хэрхэн нөлөөлөх вэ?
- *Шударга байдал:* Зардал, үр ашгийн тархалт шударга байж чадах уу?
- *Хэрэгжих боломж:* Энэ хувилбарыг үр өгөөжтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай улс төрийн дэмжлэг, эрх зүйн орчин, захиргааны чадавхи бүрдсэн үү?
- *Уян хатан байдал/ сайжруулах боломж:* Энэ хувилбар өөр орчин нөхцөлд нийцүүлэн өөрчлөх, эсвэл сайжруулах боломж агуулсан уян хатан чанартай юу?

Бардак (1996) бодлогын мөчлөгийн энэ алхмын тухайд нэгэн ашигтай зөвлөгөө өгсөн нь бодлогын хувилбар, цаашдын төсөөллийн аль болох олон талыг нь тоон үзүүлэлтээр илэрхийлэх (мөнгө хөрөнгө болон

нийгмийн нөлөөллийн аль алиныг), шалтгаан, үр дагаврын логик загварчлалын аргуудыг ашиглах, бодлогын хувилбарын боломжит үр дүнгийн тухай өөдрөг төсөөллөөс илүүтэй бодитой хандахыг хичээ гэжээ. Бодлогын хувилбаруудаа бүгдийг нь үнэлж, үр дүнг харьцуулан, ялгааг нь цэгнэснийхээ дараа та аль нь хамгийн оновчтой хувилбар болохыг шийдэх хэрэгтэй.

- Алхам 4. Хэрэгжилтийн механизмууд, үйл явцыг төлөвлөх буюу бодлогын дизайныг боловсруулах

Бодлогыг аль байгууллагад хариуцуулан, ямар арга хэрэгслээр хэрэгжүүлэх сонголтыг төр, засаг хийдэг.

Та хамгийн оновчтой гэж үзсэн бодлогын хувилбараа нэгэнт сонгож, асуудал хариуцсан төр, засгийн төлөөлөлд танилцуулсны дараа тэд таны саналыг бүрэн юмуу өөрчлөн хувиргаад хүлээн зөвшөөрсөн гэж бодвол одоо таны санал төрийн бодлого болж байна (2.1-д өгүүлсэнчлэн). Одоо энэ бодлогыг хэрхэн хамгийн үр нөлөөтэйгөөр хэрэгжүүлэхээ төрийн байгууллагууд шийдэх ёстой. Бодлогын оновчтой хэрэгжилтийг нарийвчлан боловсруулахын тулд бодлогын арга хэрэгслүүдийн (эрх зүйн, байгууллагын, хамтын ажиллагааны) оновчтой хослол, бодлогод туссан бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх байгууллагуудын (төрийн ба төрийн бус, төсвийн ба хувийн) оновчтой хослолыг төрийн байгууллагууд сонгох шаардлагатай болно.

- Алхам 5. Бодлого хэрэгжүүлэх, хэрэгжилтэд мониторинг хийх

Төр засаг бодлогыг хэрэгжүүлж, хяналт тавьдаг.

Одоо боловсруулсан дизайныхаа дагуу бодлогоо хэрэгжүүлнэ. Бодлогын сайн дизайн, үр нөлөөтэй хэрэгжилттэй хосолж байж хамгийн сайн үр дүн бий болдог. Үүний зэрэгцээ, бодлогын хэрэгжилтийн үйл явцад тогтмол мониторинг хийж байх хэрэгтэй бөгөөд энэ нь мэдээллийн олон эх сурвалжид тулгуурласан бодлогын цогц үнэлгээний суурийг бүрдүүлэх юм. Бодлогыг хэрэгжүүлэх арга зам, стратеги нь бодлогын үр дүнд шууд нөлөөлдөг тул бодлогын мэргэжилтнүүд энэ үйл явцыг ихэд сонирхдог бөгөөд энэ сэдвээр нэлээдгүй зүйл бичиж нийтлүүлдэг тухай Андерсон (1994), Хаулет ба Рамеш (1995) нар дурджээ.

- **Алхам 6. Үнэлэх**

Бодлогын сайн дизайн, хэрэгжилтийн төлөвлөгөөтэй зэрэгцээ бодлого хэрэгжихийн хэрээр гарах үр нөлөөг тооцох, цаашдын шийдвэр гаргалтын суурийг бүрдүүлэх үнэлгээний цогц үйл явц чухал үүрэгтэй. Бодлогын үнэлгээг төлөвлөхдөө төрийн болон үйлчилгээ үзүүлэх байгууллагууд бодлогын зорилтуудыг хэрхэн үнэн зөв, үр нөлөөтэй хэмжих, цуглуулсан үнэлгээний үр дүнг цаашдын шийдвэр гаргалтын суурь болгож хэрхэн ашиглах талаар сайтар бодож тооцох шаардлагатай болно. Тодорхой бодлого амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэхдээ бодлогын зорилтууд, тэдгээрт хүрэхийн тулд ашиглаж буй арга хэрэгслүүдийн үүднээс харж баримтжуулна. Энэ үйл ажиллагаанд төрийн захиргааны албан тушаалтан, улс төрч, мөн төрийн бус байгууллага болон бусад сонирхогч тал зэрэг олон хүн оролцох магадлалтай.

Төр засаг болон үйлчилгээ хүргэгч байгууллагууд бодлогын үр нөлөөг үнэлдэг.

Бодлогын мөчлөг тойрог хэлбэрээр давтагдах мөн чанартай тул бодлогын үр нөлөөг үнэлэх алхмын араас бид асуудлаа шинээр тодорхойлох, бодлогын оновчтой хувилбарыг сонгох, бодлогын дизайн боловсруулах, хэрэгжүүлэх үе шатын алинаас ч эхлэн бодлогын үйл явцаа давтаж болно. Ингэснээр тухайн асуудал нэг бол төр засгийн хэлэлцэх асуудлын жагсаалтад шинээр томъёологдон орж ирэх, эсвэл бодлогын үйл явцын өөр нэг шатнаасаа дахин давтагдах, эсвэл одоо байгаагаараа үргэлжлэн хэрэгжих юм.

3.2. Бодлого боловсруулах үйл явцад бодлогын судалгааны баримт бичгийн гүйцэтгэх үүрэг

Бодлогын судалгааны баримт бичиг бол бодлого боловсруулах үйл явцад янз бүрийн зорилгоор ашиглаж болох маш хүчтэй арга хэрэгсэл юм. Бусад мэргэжилтэн, судалгааны байгууллагуудад зориулж, тэдний үйлчлүүлэгчдэд нөлөөлөх зорилгоор бичиж хэвлүүлсэн бодлогын судалгааны баримт бичиг олон байдаг. Дээр өгүүлсэнчлэн, ТЗЕ-ын бүс нутагт дэлгэрч эхлээд байгаа ийм баримт бичиг нь бодлогын судалгааны аргазүйд тулгуурлан боловсруулагдсан анхны л судалгаанууд юм. Эдгээр баримт бичгийн зарим нь бодлого боловсруулах үйл явцын аль ч үе шатад

Бодлогын судалгаа шийдэхээр зорьж буй асуудалдаа захирагддаг бол бодлогын шинжилгээ захиалагчаасаа хамааралтай байдаг.

ашиглаж болох ерөнхий мэдээлэл, мэдлэгийг өгдөг бол бодлогын үйл явцын тодорхой нэг юмуу, тодорхой хэдэн шатад төвлөрсөн баримт бичгүүд ч бий. Жишээлбэл, тодорхой хүрээгээр хязгаарлагдсан бодлогын баримт бичгийн зарим нь бодлогын хувилбаруудыг тайлбарлаад, тодорхой хувилбарыг санал болгох, эсвэл бодлогын хэрэгжилтийн тодорхой дизайныг дэмжин сурталчлах, эсвэл сонгож авсан бодлогын хувилбарыг үнэлэх зэрэг зорилготой байж болно. Ерөнхийдөө, бодлогын судлаачийн ажил бие даасан шинжтэй, бодлогын баримт бичиг нь шийдэхээр зорьж буй асуудалдаа захирагддаг онцлогтой.

Ийм төрлийн бодлогын судалгаа нь шийдвэр гаргагчдад зориулан тодорхой зорилтот орон нутагт хэрэгжүүлэх бодлогын дизайныг боловсруулан танилцуулсан бодлогын шинжээчдийн судалгаанаас ялгаатай. Эдгээр ялгаа нь бодлогын шинжилгээний явцад захиалагч болох төрийн албан хаагч, бодлогын зөвлөх хоёр шууд хамтран ажилладагтай холбоотой бөгөөд энэ явцдаа үйлчлүүлэгч нь баримт бичгийн мөн чанар, түүний агуулгад хүчтэй нөлөөлдөг ажээ. Харин бодлогын судалгаа нь бодлогын шинжилгээний баримт бичгийн суурь болдог тул энэ хоёрын хооронд шууд холбоо бас бий. Мөн тус бүс нутаг дахь бодлого судлалын хөгжлийн өнөөгийн үе шатад хэвлэгдэн гарч буй бодлогын баримт бичгийн төрлүүдийн хооронд нэлээдгүй давхцал байхыг ч бас үгүйсгэхгүй.

Төлөвлөлтөд ашиглах хяналтын хуудас

Бодлогын судалгааны тайлангаа бичиж эхлэх гэж байгаа бол та дээрх бодлого боловсруулах үйл явцыг харгалзан, өөрсдийн хийсэн судалгаагаа эргэн харж дараах асуултад хариулна уу.

- Та өөрийн бичиж буй бодлогын баримт бичгээр бодлого боловсруулах үйл явцын яг аль үе шат(ууд)-д нөлөөлөхийг хичээж байгаа вэ?
- Бодлого боловсруулах үйл явцын үе шат бүрт сонирхогч ямар талууд оролцсон, эсвэл оролцож байна вэ?
- Та шийдэхийг зорьж буй асуудал, бэрхшээлээ ойлгомжтой тодорхойлж чадсан уу? Үүнийгээ та хоёр өгүүлбэрээр тоймлож чадах уу?
- Ийм асуудал/ бэрхшээл бодитойгоор оршиж байна гэсэн дүгнэлтээ батлах хангалттай, иж бүрэн нотолгоо танд бий юу?
- Энэ асуудлыг шийдэх бодлогын боломжит хувилбаруудыг та тоймлон гаргаад, үнэлсэн үү? Үнэлгээний ямар шалгууруудыг та ашигласан бэ?
- Хамгийн оновчтой гэж үзсэн хувилбараа сонгосон уу?
- Сонгож авсан бодлогын хувилбар тань бусад хувилбараас илүү гэдгийг үнэмшилтэй, үндэслэлтэй батлан харуулахад таны бүрдүүлсэн нотолгоо хангалттай юу?

3.3. Бодлогын холбогдолтой санал дүгнэлтээ түгээн дэлгэрүүлэх нь

Таны судалгаа бодлогын судалгаа юу, бодлогын шинжилгээ юү гэдгээс үл хамааран судлаачийн байр сууриа бусдад сонсгон, шийдвэрт нөлөөлөхийн тулд та бодлогын баримт бичгээ олон хүнд хүргэх хэрэгтэй болно. Ингэхийн тулд таны “бодлогын баримт бичиг уншигдаад зогсохгүй хэлэлцэгдэж, ойлгогдох ёстой” (Бартл, 2002). Гэхдээ энэхүү өргөн хүрээтэй уншигчдын бүлгийн дотроос хэвлэмэл тайлан ашиглахгүй хүн олон гарна. Иймд таны санал болгож буй санаануудыг бүрэн ойлгож, хэлэлцэх боломжийг тэдэнд хангаж өгөхийн тулд байр суурь, санал зөвлөмжөө шууд ойлгогдохуйц арга хэлбэрээр хүргэх шаардлагатай. Бодлогын баримт бичгээсээ бусдад хүргэх гол санаануудаа тоймлож аваад, ашиглаж болох харилцааны олон арга хэрэгслээс аль аль нь таны хүрэхийг хүсэж буй зорилтот бүлэгт хүрч, зорилгоо хангахад тань тус болохыг шийдэх хэрэгтэй болно. Тухайлбал, та олон нийтийн уулзалтаар мэдээлэл өгөх үү, эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ашиглах уу? Ихэнхдээ та хэд хэдэн зорилтот бүлэгт нэгэн зэрэг хүрэх харилцааны арга хэрэгслийг сонгох байх. Иймд гол санаагаа нарийн мэргэжлийн нэр томъёо болон хар ярианы үг хэллэг ашиглалгүй, товч бөгөөд энгийнээр илэрхийлэхийг хичээгээрэй.

Төлөвлөлтөд ашиглах хяналтын хуудас

Бодлогын судалгааны баримт бичгийнхээ санаа, зөвлөмжийг амжилттай тараан түгээх стратегиа боловсруулахдаа дараах асуултуудыг харгалзан үзээрэй.

- Та мэдээллээ хэнд (улс төрчид, төрийн бус байгууллага, иргэд) хүргэхийг зорьж байна вэ?
- Та яагаад бодлогын энэ асуудлаар тэдэнтэй харилцахыг хүсч байна вэ?
- Тэд энэ асуудлаар хэр их ажилладаг вэ?
- Тэд энэ асуудлаар юу мэдэж байгаа вэ?
- Бодлогын судалгааны баримт бичгийнхээ ямар гол гол элементийг тэдэнд мэдээлж таниулахыг та хүсэж байгаа вэ?
- Тэд таны санааг ойлгож, таны байр суурийг хүлээн авч дэмжихийн тулд энэ асуудлаар юу мэдэх хэрэгтэй вэ?
- Зорилтот бүлэгт өөрийн санаагаа хамгийн үр нөлөөтэй хүргэхэд харилцааны ямар арга хэрэгслүүд тохиромжтой вэ (ганцаарчилсан уулзалт, бүлгийн танилцуулга, хэвлэлийн мэдэгдэл/ хэвлэлийн бага хурал, дугуй ширээний ярилцлага)?

4. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧИГ: ТОЙМ

Энэ номын дөрөв, тавдугаар бүлэгт бид бодлогын судалгааны баримт бичгийг нарийвчлан судлах болно. Энэ хэсэгт та бодлогын судалгааны баримт бичгийн зориулалт, агуулга зэрэг үндсэн асуудалтай тоймлон танилцах болно. Бодлого судлалын салбарт ашиглагддаг бодлогын судалгааны баримт бичгийг бодлогын шинжилгээтэй зэрэгцүүлж жиших замаар бидний сонирхлыг хамгийн ихээр татаж буй бодлогын судалгааны баримт бичгийн онцлогийг тайлбарлалаа. Тавдугаар хэсэгт бодлогын судалгааны салбарт ашиглагддаг бодлогын баримт бичгийн бүтцийн болон бичвэрийн нийтлэг элементүүдийг нарийвчлан авч үзнэ. Илүү ойлгомжтой болгох үүднээс энэ хоёр хэсгийг уг номд тусд нь гарчиглаж оруулсан ч эдгээрийг бодлогын баримт бичгийн цогц тодорхойлолтын салшгүй хоёр хэсэг гэж үзвэл зохино.

Бодлогын судалгааны баримт бичгийн дараах хоёр шинжийг онцолж байна:

- **Бодлогын судалгааны баримт бичиг бол шийдвэр гаргах арга хэрэгсэл юм.**

Бодлогын судалгааны баримт бичиг бол шийдвэр гаргах хэрэгсэл юм.

Бодлогын судалгаа юу, бодлогын шинжилгээ юу гэдгээс үл хамааран боловсруулж гаргах судалгааны баримт бичиг нь асуудлыг шийдэх зорилготой, үнэт зүйлсэд суурилсан шинжтэй харилцааны хэрэгсэл юм. Иймд бодлогын мэргэжилтнүүдэд ч хандсан бай, шийдвэр гаргагчдад ч хандсан бай бодлогын судалгааны баримт бичиг дараах зориулалттай:

Таны боловсруулсан бодлогын зөвлөмжийг дэмжих иж бүрэн, үнэмшилтэй үндэслэл болж өгснөөрөө шийдвэр гаргах хэрэгслийн үүргийг гүйцэтгэж, зорилтот бүлгийг арга хэмжээ авахад дуудсан уриалга болно.

Энэ зорилгод хүрэхийн тулд ашиглах арга зүйн хандлагыг мөн дурдъя:

- Бодлогын өнөөгийн орчин дахь шийдэл шаардсан буюу тулгамдаад байгаа асуудлыг томъёолж, нарийвчлан тайлбарлах;
- Тухайн асуудлыг шийдэх боломжит арга замууд (бодлогын хувилбарууд)-ыг тодорхойлох;
- Өөрийн боловсруулсан Дүн шинжилгээний хүрээ, мөн өнөөгийн бодлогын орчинд илэрч буй баримт, нотолгоонд тулгуурлан эдгээр хувилбараас гарах магадлалт үр дүнг үнэлж, тайлбарлах;
- Хамгийн оновчтой гэж үзэж буй хувилбараа (бодлогын зөвлөмж) сонгоод, таны сонголт яагаад хамгийн сайн бодлогын хувилбар болж байгааг баттай харуулах сайн үндэслэл гаргах.
- **Бодлогын судалгааны баримт бичиг: Эрдэм шинжилгээний биш, хэрэглээний мөн чанартай**

Дүгнэлт нь бодитой оршиж буй тодорхой асуудлыг шийдэх, ингэхдээ энэ асуудлыг шийдэх тодорхой арга зам, багц зөвлөмжийг дэмжих үндэслэл болох ёстой гэдэг утгаараа бодлогын судалгааны баримт бичиг нь эрдэм шинжилгээний ажлаас арга зүйн хандлага, зориулалтаараа ч илт ялгаатай. Бодлогын судалгааны баримт бичгийн цөм болсон асуудал – шийдэл гэсэн логик холбоос нь тодорхой зорилтот бүлэгт хандсан, тодорхой бодлогыг дэмжсэн баримт бичиг боловсруулж гаргахын шалтгаан, үндэс юм.

Бодлогын судалгааны баримт бичиг бол бодлогын нэг асуудалд тодорхой шийдлийг авч хэрэглэх нь зүйтэй гэсэн байр суурийн үндэслэл, тайлбар болж өгдөг.

Ийм арга хандлагаар судалгааны баримт бичиг боловсруулж байгаа судлаач эсрэг тэсрэг хоёр хүчин зүйлийг тэнцвэржүүлэх хэрэгтэй болдог. Энэ нь:

- Амьдралд бодитойгоор тулгарч буй асуудал, бэрхшээлийг тодорхойлж, боломжит бодлогын хувилбаруудын тухай нийгэмд өрнөж буй маргаан мэтгэлцээнийг өнөөгийн бодлогын орчин дотор нь аль болох бүрэн дүүрэн, иж бүрнээр гаргаж тайлбарлах, ингэхдээ судлаачийн байр суурийг илүү үндэслэлтэй болгох, цаашилбал энэ байр суурийг мэдлэг мэдээлэлтэй үнэлж, ойлгоход шаардлагатай байгаа бол анхдагч судалгааны дүгнэлтийг ч хүртэл багтаан тайлбарлах хэрэгцээ

- Ингэхдээ гол үндэслэлийг дэмжсэн, судлаачийн байр суурьтай холбоо хамааралтай нотолгоо, мэдээллийг л багтаах хэрэгцээ зэрэг болно.

Бодлогын судлаачдын гаргадаг хамгийн түгээмэл алдаа бол судалгааны явцад олж авсан бүх мэдээлэл, өгөгдлийг баримт бичигтээ багтаах гэж оролддог явдал хэмээн Ю.Бардач (1996) тэмдэглэсэн нь бий.

Мөн бодлогын судалгааны баримт бичиг бол хөндлөнгийн объектив дүгнэлт биш харин судлаачийн үнэт зүйлсдээ түшиглэн боловсруулсан нотолгоо, гаргалгаа байдаг нь эрдэм шинжилгээний ажлаас ялгагдах өөр нэг томоохон шинж нь юм. Бодлогын судалгааны баримт бичгээрээ та бодит амьдралд тулгарч байгаа асуудал, бэрхшээлийг шийдэх практик шийдлүүдийг өргөн хүрээтэй хийгээд ихээхэн улс төржсөн уншигчдад хүргэх ёстой. Хэдийгээр нягт нарийн шинжилгээнд тулгуурладаг ч гэлээ бодлогын мэргэжилтний хувьд та энд яригдаж байгаа асуудлыг хамгийн үр дүнтэй шийдэх арга замын талаар өөрийн байр суурь, үзэл баримтлалтай байх хэрэгцээ илт харагдаж байна. Ийм ч учраас бодлогын хувилбаруудаас сонгох, тэдгээрт үнэлгээ өгөхдөө ашигласан хүлээн зөвшөөрөгдөхүйц хэм хэмжээнүүд нь таны бодлогын судалгааны баримт бичгийн гол тулгуур элемент болно.

4.1. Бодлогын баримт бичгийн төрлүүд: Бодлогын судалгаа ба бодлогын шинжилгээ

Бодлогын судалгаа болон бодлогын шинжилгээний салбарт ашиглагддаг судалгааны баримт бичгүүд хоорондоо нэлээд ялгаатай.

Гуравдугаар хэсэгт өгүүлсэнчлэн, бодлогын судалгааны баримт бичиг нь судалгааныхаа үр дүнг бодлогын сүлжээнийхэнд хүргэхдээ бодлогын мэргэжилтнүүдийн ашигладаг харилцааны үндсэн хэрэгсэл юм. Бодлогын судлаачид судалгааны баримт бичгээ бодлогын судалгаа, шинжилгээгээр мэргэшсэн хүмүүст голлон зориулж бичдэг. Бодлогын шинжээчдийн боловсруулсан баримт бичиг нь дийлэнхдээ бодлогын судлаачдын ажилд тулгуурладаг учир энэ хоёр чиглэл хоорондоо шууд уялдаа холбоотой. Харин бодлогын шинжээчийн гаргасан баримт бичиг нь тухайн шинжилгээг захиалан хийлгэж буй шийдвэр гаргагчид шууд хандсан, захиалагчтай нягт хамтран ажилласны улмаас түүний хүчтэй нөлөө туссан байдаг онцлогтой. Дараах хүснэгтэд энэ хоёр баримт бичгийн ялгааг харууллаа:

Хүснэгт 4.1. Бодлогын судалгаа ба бодлогын шинжилгээний баримт бичгийн ялгаа

Ялгаа	Бодлогын баримт бичгийн төрөл	
	Бодлогын судалгаа	Бодлогын шинжилгээ
Зорилтот бүлэг	Бодлогын судлаачдад хандсан	Шийдвэр гаргагчдад хандсан
Фокус	Асуудалдаа захирагдсан шинжтэй: бодлогын тодорхой асуудлаар ерөнхий зөвлөмж, мэдээлэл	Захиалагчдаа захирагдсан: шууд хэрэгжих тодорхой бодлогын боловсруулалт
Арга зүй	Анхдагч судалгаа нэлээд ашигласан байж болно	Анхдагч судалгаа ашиглах нь тун ховор
Санаа / үг хэллэг	Шинжлэх ухааны салбарын болон мэргэжлийн үг хэллэг ашигласан байх магадлалтай	Маш энгийн, ойлгомжтой байх ёстой
Хэмжээ	20 000 хүртэлх үгтэй	Ихэвчлэн 5000 үгээс хэтрэхгүй

Зорилтот бүлэг, судалгааны фокус, арга зүйн хандлагатай холбоотой ялгаанаас гадна бодлогын судалгаа, шинжилгээний баримт бичгүүдийг харьцуулахдаа бичвэрийн урт, формат, үг сонголтын асуудлыг заавал анхаарах хэрэгтэй. Баримт бичиг нь судлаачийн байр суурийг бүрэн гүйцэд, итгэл үнэмшилтэй тайбарласан үндэслэл болж чадахуйц л урттай байх ёстой. Бодлогын судалгааны баримт бичиг нь бодлогын шинжилгээнийхээс урт байдаг. Бодлогын судалгааны сэдэв, мөн судлаачийн байр суурийг дэмжсэн багагүй хэмжээний нотолгоо баримт ашиглах шаардлага зэргээс үүдэн ийм баримт бичиг 70-90 хуудастай байх нь элбэг. Гэхдээ заавал ийм байх албагүй бөгөөд тухайлбал, энэ номд ашигласан бодлогын судалгааны таван баримт бичиг 30-аас 100 гаруй хуудсын хооронд хэлбэлзэж, дунджаар 60 орчим хуудастай байна. Мөн хэвлэн нийтлэгчдийн ихэнх нь хуудасны тоог хязгаарласан шаардлага тавьдагийг судлаач та анхааралдаа аваарай.

Хоёрдугаарт, бодлогын судалгаа, шинжилгээний баримт бичгүүд нь цар хүрээтэй асуудлыг авч үзэхийн зэрэгцээ ерөнхий мэдээлэл авах, эсвэл тодорхой асуудлыг сонирхох зэрэг янз бүрийн зорилготой уншигчдад хүрдэг

Бодлогын судалгааны баримт бичиг нь үндэслэлээ сайн тайлбарлан өгүүлэхэд л хангалттай урттай байна.

Бодлогын судалгааны баримт бичгүүд ихэнхдээ тайлан хэлбэртэй байдаг.

тул ихэнх баримт бичгүүд товьёг, хураангуй, дэд бүлэг, дэд гарчиг, дугаарласан дэд хэсэг, хүснэгтэлсэн өгөгдөл, схем зураг, жагсаалт зэргийг агуулсан тайлангийн хэлбэртэй байдагт гайхах зүйлгүй. Эдгээр нь янз бүрийн зорилготой уншигчдад хэрэгцээндээ нийцсэн мэдээллийг олж авахад тус болдог нь дамжиггүй. Бодлогын баримт бичгийн форматын хувьд хэвлэн нийтлэгч танд тодорхой удирдамж заавар өгөх буй за.

Мэргэжлийн нэр томьёо, этгээд үг хэллэггүй энгийн найруулга ашигла.

Гуравдугаарт, бодлогын судалгааны баримт бичгийн үндсэн уншигчид нь бодлогын мэргэжилтнүүд байх учраас эдгээр нь бодлогын шинжилгээний баримт бичгийг бодвол илүү мэргэжлийн шинжтэй байх хандлага ажиглагддаг. Гэхдээ таны энэ судалгааны баримт бичгийг илүү өргөн хүрээний уншигч уншиж судална гэдгийг харгалзаад, мөн Төв болон Зүүн Европ дахь энэ шинжлэх ухааны хөгжил эхлэл төдий үедээ байгааг (2.2-т өгүүлсэнчлэн) анхаараад аль болох энгийн найруулгаар, мэргэжлийн нэр томьёо болон этгээд үг хэллэг ашиглахгүйгээр бичих нь зүйтэй.

Төлөвлөлтөд ашиглах хяналтын хуудас

Бодлогын судалгааны баримт бичгээ бичихээр төлөвлөж байгаа үедээ та дараах асуултыг харгалзаарай:

Зориулалт ба уншигч

- Судалгааны баримт бичиг тань ямар зориулалттай вэ?
- Та, эсвэл танай байгууллага судалгааны энэ баримт бичгийг бичиж, нийтэлснээр ямар үр дүнд хүрэхийг хүсч байна вэ?
- Энэхүү баримт бичгийг тань унших гол хүмүүс хэн бэ?
- Өөр ямар хүмүүс унших вэ?

Баримт бичгээ бичих, нийтлэх нь

- Та бодлогын судалгааны энэ баримт бичгийг ганцаараа бичих үү? Хэрэв үгүй бол та хамтран бичигчтэйгээ хэрхэн ажиллахаа шийдсэн үү?
- Та болон таны хамтрагчид бодлогын судалгааны баримт бичгийн тухай ижил ойлголттой байгаа юу?
- Бодлогын судалгааны энэ баримт бичгийн хэвлэн нийтлэгч нь хэн бэ?
- Хэвлэн нийтлэгч баримт бичгээс юу хүлээж байгааг та мэдэж байгаа юу?

Санаагаа тоймлох нь

- Та таксинд суугаад, замдаа жолоочтой ярьж явна гэж төсөөл. Тэр таны хийж байгаа ажлын тухай асуулаа. Гурван өгүүлбэрээр товч бөгөөд ойлгомжтойгоор хариулаарай. Хэрэв та санаагаа ингэж тодорхой бөгөөд товчоор илэрхийлж чадахгүй байгаа бол хэлэх гэж байгаа санаагаа өөртөө илүү тодорхой болгох тал дээр ажиллах хэрэгтэй байна гэж олон хүн зөвлөдөгийг санаарай.

5. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧИГ: БҮТЭЦ БОЛОН БИЧВЭРИЙН БҮРДЭЛ ЭЛЕМЕНТҮҮД

Гарын авлагын өмнөх хэсэгт бид бодлогын сүлжээнийхний дунд хэрэглэгддэг бодлогын судалгааны баримт бичигтэй холбоотой нийгмийн хүчин зүйлсийг нарийвчлан судалж ирлээ. Харин дараа дараагийн хэсэгт бид бодлогын судалгааны баримт бичгийн нийтлэг бүтэц, бичвэрийн бүрдэл хэсгүүдэд анхаарлаа хандуулна. Эхлээд бид бодлогын баримт бичгийн бүтцийн элементүүдийг тоймлон тайлбарлаад, судалгааны баримт бичгийг шууд авч хэрэглэж болох төлөвлөгөөг товч таницуулья. Үүний дараа бүтцийн элемент нэг бүрийг салган судалж, түүний бүтцийн болон бичвэрийн онцлог шинжүүдийг тайлбарлах юм.

Бодлогын судалгаа болон бодлогын шинжилгээ нь угтаа хоорондоо нягт уялдаатай гэдгийг харуулахын тулд энэ хоёр салбарын ялгааг хоёр, гурав, дөрөвдүгээр бүлгүүдэд өгүүлсэн билээ. Харин энэ хэсэгт бид зөвхөн бодлогын судалгааны баримт бичгийг авч үзэх бөгөөд энд дурьдагдах жишээнүүд бүгд бодлогын судалгааны салбарт хамаарна.

Бодлогын судалгааны баримт бичгийн хэд хэдэн тодорхойлолт⁷, олон жишээг судалж үзэхэд бүтцийн дараах элементүүд нийтлэгээр давтагдаж байгаа нь ажиглагдлаа:

⁷ Энэ бүлэгт дараах эх сурвалжийг ашиглав: Бардак (1996), Бартл (2002), Бостоны их сургууль (2002), Кэйти (2002), Охайо мужийн Их сургууль (1998), Пасифик Лютеран их сургууль (огноогүй), Скотт ба Гаррисон (1995), Вашингтон мужийн Их сургууль (2001).

Бодлогын судалгааны баримт бичиг

Гарчиг
Товьёг
Хураангуй/товчоон
Удиртгал
Асуудлын тодорхойлолт
Бодлогын хувилбарууд
Дүгнэлт, зөвлөмж
Хавсралтууд
Номзүй
Төгсгөлийн тэмдэглэл

Баримт бичгийнхээ зорилго, сэдэв, уншигчид хамгийн нийцтэй арга хандлагыг сонгоорой.

Бодлогын судалгааны салбарт ажилладаг олон судлаач баримт бичигтээ эдгээр бүрдэл элементийг нийтлэг ашигладаг. Энэ л бүтэц, бүрэлдэхүүнийг хэвлэн нийтлэгч, бодлогын сүлжээний гишүүд танаас хүлээх болно. Тэгэхдээ энэ бүтэц бол заавал дагаж мөрдөх шаардлага бус харин чиглүүлж өгөх зөвлөгөө бөгөөд дээр жагсаасан бүх бүрдэл хэсгийг яг энэ дарааллаар бодлогын судалгааны баримт бичиг бүртээ багтаах шаардлагагүй юм. Хамгийн гол нь эдгээр бүрдэл хэсгийн тайлбар танилцуулгаас та бодлогын судалгааны баримт бичгээс хүмүүс юу хүлээдгийг ойлгож авах ч судалгааны энэхүү баримт бичгийг гаргаж буй таны өөрийн зорилго, хөндөгдсөн сэдвийн мөн чанар, хэвлэн нийтлэгч болон уншигчдын хүлээлтийг тэнцвэртэйгээр харгалзах нь таны өөрийн шийдэх асуудал юм.

5.1. Баримт бичгийн агуулгыг схемчлэн төлөвлөх нь⁸

Бодлогын судалгааны баримт бичиг гаргах гэж байгаа бол та эхлээд агуулгаа схемчлэн төлөвлөх хэрэгтэй ба үүнд агуулгын бүдүүвчийг ашиглаж болно. Агуулгын бүдүүвч гаргаснаар та баримт бичгийнхээ логик дараалал, гол фокусыг илүү тодорхой олж харах юм. Өөрөөр хэлбэл, агуулгын схем бүдүүвчийг гаргах энэ үйл явц нь баримт бичгээрээ уншигчдад хүргэх гол санаагаа сонгох, үүнийгээ үнэмшилтэй, итгэлтэй хүргэхийн тулд агуулгаа хэрхэн зохион байгуулах зэрэг асуудлаар шийдвэр гаргахад танд туслах юм.

⁸ Энэ хэсэгт Базерман (1985), Гибальди (1995) Сигисмунд Хафф (1999) нарын бүтээлийг ашиглав.

Жишээлбэл, та баримт бичгийнхээ зорилго/ зориулалтын ажлын тодорхойлолтыг⁹ бичихээс ажлаа эхлүүлж болох юм. Үүний дараа та Асуудлын тодорхойлолт хэсгээ хэрхэн бичих тухай нарийвчлан бодож төлөвлөх хэрэгтэй ба үүний тулд асуудлаа бүрэн дүүрэн нээж харуулахын тулд суурь болон бодлогын холбогдолтой ямар үндсэн асуудлуудыг хөндөх тухайд тэмдэглэл хийгээрэй. Дараа нь тэмдэглэж авсан асуудал бүрээрээ илэрхийлэх гол санаа, эдгээрээ дэмжихийн тулд ашиглах баримт, нотолгоогоо бичнэ. Асуудлын тодорхойлолт хэсгийн агуулгыг төлөвлөж дууссан бол одоо яг энэ арга хандлагаараа Бодлогын хувилбарууд, Дүгнэлт хэсгүүдээ төлөвлөөрэй.

Агуулгын бүдүүвчээр баримт бичгийнхээ гол санаа, логик дарааллыг төлөвлөөрэй.

Агуулгын бүдүүвчийг гаргахад ашиглаж болох олон загвар байдаг. Эдгээр нь дэс тоогоор тэмдэглэсэн бүлэг, дэд бүлгүүдийн тогтолцоо бүхий маш албан загвараас авахуулаад тун энгийн, албан бус загвартай байж болохыг Гибалди (1995)-ийн гарын авлага зэрэг эх сурвалжаас харж болно. Хэдийгээр өөрт хамгийн тохиромжтой загварыг та сонгох ч гэлээ уншигч, хүрэхээр зорьж буй зорилтот бүлгээ давхар бодолцох хэрэгтэй юм.

Бодлогын судалгаа, түүнд тулгуурласан баримт бичгийг голдуу багаар гүйцэтгэж байгаа нөхцөлд агуулгын бүдүүвчийг эхлээд ноорог хэлбэрээр боловсруулах нь нэн тустай. Ноорог бүдүүвч нь багийн гишүүдэд баримт бичгийн талаар санал солилцох суурь болдог бол нооргоо хянаж сайжруулах, дахин ноороглох явц нь баримт бичгийнхээ талаар нэгдмэл ойлголттой болж санал нэгдэх үйл явцад дэм болдог. Иймд төлөвлөлтийн энэ шат бол судалгаанаас бичих ажил руу шилжихэд ашиглагдах нэн чухал арга хэрэгсэл юм.

Агуулгаа төлөвлөх нь хамтран бичих үр дүнтэй арга байдаг.

Агуулгын бүдүүвч гаргах ажил нь танд баримт бичгийнхээ агуулгыг логиктой зохион байгуулж дараалуулахад туслаад зогсохгүй баримт нотолгоо дутаж буй, нэмж боловсруулах хэрэгтэй хэсгүүдийг олж харахад тусалдаг. Үүний хажуугаар, ингэж төлөвлөх нь таны дүгнэлт, байр суурийн үндэслэл болж чадах нотолгоо баримтыг сонгож авах, мөн ашиглахгүй үлдээх баримт нотолгоог салгаж авахад тусалдаг тул

⁹ Зорилгын ажлын тодорхойлолт гэдэг нь боловсруулагдаж буй, харахан эцэслээгүй байгаа тодорхойлолт бөгөөд энэ цаашдаа өөрчлөх, улам тодорхой болгон сайжруулах ёстой таны анхны бөгөөд эхлэлийн төсөөлөл юм.

баримт бичгээ өөрийн байр суурийг нотлох логик үндэслэл гэдэг утгаар харж, фокусыг нь өөртөө тодорхой болгоход нэн тустай.

5.2. Гарчиг

Гарчиг нь уншигчийн анхаарлыг өөртөө татах ёстой.

Бодлогын судалгааны баримт бичгийн хувьд нарийвчлан судлах шаардлагатай хамгийн эхний бүрдэл элемент бол гарчиг юм. Бодлогын баримт бичигтэй сайн гарчиг өгөхөд анхаарал дутах явдал нэн элбэг ч гарчиг бол уншигчийн хамгийн түрүүнд олж харах зүйл, бодлогын баримт бичгээр судлаачийн илэрхийлсэн санааг уншигчдад хүргэх үйл явцыг эхлүүлж буй хэрэгсэл гэдэг талаас нь харж, ач холбогдол өгч хандах ёстой зүйл мөн. Сайн гарчиг нь уншигчдад бодлогын энэ баримт бичигт авч үзэх сэдэв, судалгааны фокус, хөндөж буй гол асуудлын талаар товч ойлголт өгөх ёстой. Мөн зарим уншигч хамгийн эхний энэхүү бүрдэл хэсгийн талаар өөрт төрсөн сэтгэгдлийг тухайн баримт бичгийг цааш унших эсэхийг шийдэх шалгуур болгож ашигладаг. Иймд бодлогын баримт бичигтэй уншигчдын анхаарлыг анхнаасаа л татаж, дуустал нь уншуулахын тулд оновчтой сайн гарчиг өгөхөд тодорхой цаг хугацаа, хүчин чармайлт заавал зарцуулах хэрэгтэй.

Сайн гарчиг нь тодорхойлсон шинжтэй, ойлгомжтой, товч, сонирхолтой байдаг.

Гарчиг өгөх нь угаасаа бичиж буй хүний хувийн арга барил, баримт бичгийн зориулалтыг тусгасан нэлээд субъектив шинжтэй үйл ажиллагаа байдаг тул хэрхэн оновчтой гарчиг өгөх талаар нийтлэг бөгөөд энгийн дүрэм гаргах боломжгүй юм. Гэхдээ судлаач танд тус болох үүднээс бодлогын баримт бичгийн гарчгийн гүйцэтгэх үүрэг роль, түүний ач холбогдлыг харгалзан зарим шалгуур, цөөн жишээг энд дурдъя.

Оновчтой сайн гарчиг нь дараах шинж чанарыг агуулж байх ёстой:

- Дүрсэлж тодорхойлсон шинжтэй буюу бодлогын баримт бичгээр хөндөж буй асуудал, сэдвийг тодорхойлсон байх;
- Аль болох ойлгомжтой байх;
- Аль болох товч, хураангуй байх;
- Уншигчид сонирхолтой байх.

Хэвлэгдэн гарсан бодлогын баримт бичгийн шинжилгээ

- Доорх дөрвөн бодлогын баримт бичгийн гарчгийг уншаад, дараах чиглэлээр шинжилнэ үү:
- Гарчигаар уг баримт бичигт авч үзэх сэдвийг ойлгомжтой илэрхийлж чадаж уу?
 - Гарчиг оновчтой болж уу? (Хавсралт А-д багтаасан жишээ баримт бичгүүдийг бүрэн эхээс Удиртгал хэсгүүдийг уншаад, гарчиг хэр оновчтой болсон талаар дүгнэлт хийх боломжтой)
 - Гарчиг өгөхөд баримталсан хандлагуудын ялгаа

Жишээ 1. *“Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах нь: Захиргаадлаас зах зээлд”*

Жишээ 2. *“Орон нутгийн түвшний төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл явц дахь нээлттэй өрсөлдөөн, ил тод байдал, төвийг сахисан байр суурь”*

Жишээ 3. *“Идэвхтэй сайшаах, идэвхгүй дэмжих ба үл итгэн хойш суухын хооронд”*

Жишээ 4. *“Нэгдмэл үзлээс олон ургальч үзэлд шилжих нь: Румын дахь цөөнхийн бодлогын хүрээнд зохицуулалтуудыг нарийвчлах хэрэгцээ”*

Гарчгийн оновчтой байдлыг үнэлэх нь өөрөө субъектив асуудал ч гэсэн жишээнүүдийг шинжилбээс мөн чанар, хэлбэр, арга хандлагатай холбоотой нийтлэг хэд хэдэн зүйл тодорч харагдана. Үүнд:

- ***Ихэнх гарчиг бүтэн өгүүлбэрээр илэрхийлэгддэггүй.***

Энэ нь уншигчийн анхаарлыг өөртөө шууд татахын зэрэгцээ нуршихаас сэргийлэх арга юм. Гэхдээ хоёрдугаар жишээ шиг зарим гарчиг харьцангуй урт хэмжээтэй байх бөгөөд энэ нь гарчигаар асуудлыг дүрслэн, тодорхойлж харуулахад хангалттай мэдээлэл багтаах, нөгөө талаас уншигчийг шууд л залхааж орхихгүй байх гэсэн хэрэгцээнүүдийн хоорондын тэнцвэрийг олох хялбаргүй зорилтыг жишээ юм.

- ***Түлхүүр үгсийг гарчигаараа түрүүлж өгөх хандлага элбэг байдаг.***

Уншигчийн анхаарлыг шууд татахын тулд гарчигт тухайн баримт бичигт авч үзэх сэдэв, хөндөх асуудлыг маш тодорхой зааж өгдөг. Жишээлбэл, хоёрдугаар жишээний гарчигт тухайн бодлогын баримт бичгийн фокус болж буй тодорхой гурван асуудал, мөн баримт бичгийн сэдэв, хөндсөн асуудлын тайлбар зэргийг багтаажээ.

- ***Зарим гарчиг тодорхойлох цэгээр тусгаарлагдсан хоёр хэсгээс бүрддэг.***

Нэг ба дөрөвдүгээр жишээ энэ хандлагаар бичигдсэн бөгөөд хоёр хэсгээс бүрдсэн гарчиг нь нэг хэсэгтэй гарчгийг бодвол уншигчид

илүү их мэдээлэл хүргэх боломж олгодог давуу талтай. Энэ арга нь хэт урт болж мэдэх гарчгийг илүү ойлгомжтой болгоход бас тусалдаг. Тодорхойлох цэг нь бодлогын баримт бичгийн ерөнхий хүрээнээс үүний доторхи тодорхой асуудал руу шилжиж буй (Жишээ 1), эсвэл сэдвийг танилцуулаад дараа нь энэ талаар зохиогчийн баримталж буй байр суурийг илэрхийлж буйн (Жишээ 4) дохио болдог.

- ***Зарим зохиогч бодлогын судалгааныхаа гол үр дүнг гарчигтаа оруулдаг.***

Гарчиг зохиох энэ арга нь зохиогч хэрхэн яаж ийм дүгнэлтэд хүрсэн талаар уншигчийн сонирхол, сониуч занг өдөөх зорилготой. Гуравдугаар жишээнд энэ аргыг ашигласан бөгөөд бодлогын баримт бичгийн сэдвийн талаар уншигчдад огт мэдээлэл өгөлгүй зөвхөн гол дүгнэлт рүүгээ хөтөлсөн байна. Энэ жишээг тайлангуудын эмхэтгэл номоос авсан бөгөөд зохиогч гарчигтаа өгөхдөө номын “Орон нутгийн засаг захиргааны тухай олон нийтийн санал сэтгэгдэл: Төв болон Зүүн Европ дахь нутгийн удирдлагын шинэчлэл, ардчиллын талаарх иргэдийн сэтгэгдэл” гэсэн гарчигт хөтлөгдсөн байх магадлалтай.

- ***Англи хэлний хэл зүйн дүрмээр гарчигт орсон холбоос үг (жишээлбэл but), угтвар (жишээлбэл, from), төлөөний үг (жишээлбэл our)-ээс бусад бүх үг том үсгээр эхэлдэг.***

Энэ арга нь хамгийн чухал үгсийг тодорхой олж харахад уншигчдад тусалдаг. Тэгэхдээ туслах үг гарчгийн эхний үг байх юм бол, эсвэл тодорхойлох цэгийн дараа орсон бол том үсгээр эхэлдэг.

Төлөвлөлтөд ашиглах хяналтын хуудас

Бодлогын баримт бичгийнхээ гарчгийг сонгох, өөрчлөн сайжруулахад танд дараах асуултууд тус болно:

- Гарчиг төлөвлөх аргуудаас аль нь таны зорилгод илүү нийцэж байна вэ?
- Таны өгсөн гарчиг оновчтой (тайлбарлаж тодорхойлсон шинжтэй, ойлгомжтой, товч, сонирхолтой) болж чадаж байна уу?
- Таны өгсөн гарчиг бодлогын баримт бичгийг тань хэр сайн төлөөлж, утга агуулгад нь хэр сайн нийцэж байна вэ?
- Баримт бичгийн гарчгийг тусгайлан нэг нүүр болгож форматлах шаардлагыг хэвлэн нийтлэгч тань тавьдаг уу?

5.3. Товьёг

Энэ бүлгийн эхэнд дурьдсанчлан, бодлогын судалгааны баримт бичиг нь судалгааны тайлантай төстэй бүтцийн элементүүдтэй байдаг ба эдгээрийн нэг нь товьёг юм. Товьёг бол баримт бичгийн араг яс буюу түүний бүтцийн тойм бөгөөд баримт бичгийн үндсэн болон дэд хэсгүүдийг салгаж харуулахын зэрэгцээ нийлээд баримт бичгийн зохион байгуулалтыг бүхэлд нь харуулах гарчиг, дэд гарчгийн систем юм. Бичвэр доторх хэсгүүдийн уялдаа холбоо, мөн ялгаа заагийг харуулах нэмэлт арга хэрэгсэл болгож гарчигтай хослуулан эрэмбэ тоо давхар ашиглах нь бий. Товьёг мөн бичвэрийн тодорхой хэсгүүдийн байршлыг хуудасны дугаараар харуулдаг онцлогтой.

Товьёг нь баримт бичгийн зохион байгуулалтыг харуулдаг.

Бодлогын судалгааны баримт бичигт товьёг оруулж өгөх нь хэд хэдэн ач холбогдолтой:

- *Товьёг нь баримт бичгийн агуулгаар уншигчийг чиглүүлж явах хөтчийн үүрэг гүйцэтгэдэг.*

Хэрэв баримт бичгийн бүтцийг ойлгохын тулд уншигч нэлээд их хүчин чармайлт гаргах хэрэгтэй болох юм бол дуустал нь унших сэдэл байхгүй болж мэднэ. Тиймээс товьёг нь баримт бичгийн агуулгыг зохион байгуулж, бүтцэд оруулахдаа зохиогчийн баримталсан логикийг уншигчдад ойлгомжтой харуулж өгдөг. Бодлогын судалгааны баримт бичиг шиг урт бөгөөд ээдрээтэй бичвэрийн хувьд энэ тусламж нэн чухал юм.

- *Товьёог нь уншигчдын олон янзын хэрэгцээнд нийцэж чаддаг.*

Баримт бичгийн үндсэн болон дэд хэсгүүд, тэдгээрийн байршлыг хуудасны дугаараар зааж өгдөгөөрөө товьёг нь уншигчийг онцгойлон сонирхож буй мэдээллийг агуулсан хэсэг, бүлэг рүү шууд хөтөлж аваачдаг. Товьёг нь тухайн баримт бичгийн үндсэн сэдэв, хөндөж буй гол гол асуудлыг тоймлон харуулдагаараа гүйлгэн уншихад мөн тусалдаг.

Товьёгийн бүтэц, формат, дизайны шийдэл нь таны баримт бичгийг эрхлэн гаргах хэвлэн нийтлэгчийн шаардлагаас шалтгаалан янз бүр байдаг. Гэхдээ товьёгтой холбоотой нийтлэг бөгөөд чухал шинж чанаруудыг онцолж болох бөгөөд үүнийг бид доор жишээнд тулгуурлан танилцуулж байна.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

“Орон нутгийн түвшний төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл явц дахь нээлттэй өрсөлдөөн, ил тод байдал, төвийг сахисан байр суурь” (Баар, 2001) жишээ баримт бичгийн товъёгийг судлахдаа дараах асуудалд анхаарал хандуулаарай.

- Зохиогч баримт бичгийнхээ агуулгыг хэрхэн зохион байгуулсныг товъёг оновчтой харуулж чадаж буй эсэх
- Баримт бичгийн үндсэн болон дэд хэсгүүдийг ялгахдаа зохиогчийн ашигласан систем
- Гарчиг, дэд гарчигуудын оновчтой байдал

ТОВЬЁГ

1. Удиртгал	103
2. Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үйл явцыг зохицуулсан хуулиуд	106
2.1. Европын холбооны заавар, удирдамжууд	106
2.2. Европын холбооны сүүлийн үеийн мэдээ, мэдэгдэл	107
2.3. Төв ба Зүүн Европын орнуудын худалдан авах үйл ажиллагааны хуулиуд	107
3. Худалдан авах гэрээний нээлттэй байдал (ил тод байдал)	110
3.1. Барууны орнууд дахь ил тод байдал	114
3.2. Гэрээ боловсруулах үйл явц дахь олон нийтийн оролцоо, ил тод байдал	118
4. Сонирхлын зөрчлийн хуулиуд	119
4.1. Төв ба Зүүн Европын орнууд дахь сонирхлын зөрчлийн асуудал, түүний зохицуулалт	119
4.2. Европын холбооны орнууд, АНУ-ын сонирхлын зөрчлийн хууль	121
5. Дүгнэлт	124
Хавсралт А	126
Хавсралт Б	130

Товъёг нь баримт бичгийн дотоод логик, уялдаа холбоог харуулдаг.

Жишээ болгож авсан уг товъёгоос энэхүү баримт бичгийн агуулга үндсэн гурван асуудлын дагуу гурван хэсэгт хуваагдаж байгаа нь харагдана. Үндсэн хэсэг бүрийн хүрээнд хөндөгдөх сэдэв, авч үзэх гол асуудлуудыг дэд бүлгийн гарчгаар илэрхийлжээ. Зохиогч стандарт формат, дизайныг товъёгийн туршид тууштай ашигласан

нь бодлогын судалгааны баримт бичгийг бүхэлд нь уншихад тустай, хэсгүүд хоорондын уялдаа холбоог ойлгоход дэм болж, улмаар баримт бичгийн бүхэллэг байдал, дотоод уялдаа холбоог дэмжсэн сайн шийдэл болжээ. Баримт бичгийн бүхэллэг байдлыг хангах зорилгоор дараах хоёр аргыг ашигладаг:

- *Бодлогын судалгааны баримт бичгийн үндсэн болон дэд хэсгүүдийг ялгаж өгсөн эрэмбэ дугаарын системийг ашиглах*

Бидний авч үзсэн жишээнд үндсэн хэсгийг нэг оронтой тоогоор, дэд хэсгийг аравтын бутархай тоогоор буюу 2.1 гэхчилэн дугаарлажээ. Гурав дахь эрэмбийн дэд хэсэг ашиглах хэрэгцээ гарвал 2.1.1 гэж

дугаарлах байлаа. Эрэмбэ дугаарын нэн нийтлэг энэ аргыг бид уг гарын авлагад ч ашигласан билээ.

- *Дэд хэсэг болохыг онцлох зорилгоор догол мөр ашиглах*

Дээрх жишээнд догол мөрийн энэхүү аргыг эрэмбэ дугаарын системтэй хослуулан хэрэглэсэн байгаа бол заримдаа догол мөр нь өөрөө үндсэн хэсгийг дэд хэсгээс ялгах дохио болж дангаараа ашиглагддаг. Гурав дахь эрэмбийн дэд хэсэг ашиглах хэрэгцээ гарвал давхар догол мөрийг ашиглаж болно. Жишээлбэл:

2. Өрсөлдөөнийг зохицуулахыг шаардсан хуулиуд

2.1. Европын холбооны удирдамжууд

2.1.1. Германы хууль тогтоомж

Товьёгт оруулах гарчиг, дэд гарчгийг нийт баримт бичгийнхээ гарчгийг зохиохтой нэгэн адилаар (5.2 хэсэгт дурьдсанчлан) оновчтой томъёолох арга замыг тодорхой зааж сургах арга байхгүй ч өмнөх хэсэгт дурьдсан зөвлөмжүүдийг ашиглаж болох талтай. Нэн ялангуяа гарчигууд тодорхой, шууд ойлгогдохуйц, улмаар уншигчдад баримт бичгийн агуулгын тухай тойм ойлголт өгч чадахуйц байх нь чухал.

Зарим зохиогч баримт бичгийнхээ эхний нооргийг бүхэлд нь бичиж дууссаны дараа л товьёгоо бичдэг бол зарим нь бичих явцдаа баримт бичгийнхээ бүтэц, зохион байгуулалтыг хянаж, сайжруулах зорилгоор бичихтэйгээ зэрэгцүүлэн товьёгоо гаргадаг. Энэ утгаараа бодлогын судалгааны баримт бичгийн товьёг, агуулгын бүдүүвч (5.1-д тайлбарласан) хоёр хоорондоо шууд холбоо хамааралтай. Товьёгт багтаах мэдээлэл нь таны өөрийн арга хандлагаас хамаарах ч баримт бичгээ төлөвлөх шатад таны боловсруулсан агуулгын бүдүүвч нь товьёгийн суурь болж чадна. Товьёгоос илүү дэлгэрэнгүй мэдээлэл багтаадаг агуулгын бүдүүвчийн гарчиг болон дэд гарчигуудыг үлдээж, бусад нарийн ширийн мэдээллийг хасах юм бол үлдэх хураангуй хэлбэр нь ноорог товьёгийн үүргийг гүйцэтгэх боломжтой.

5.3.1 Хүснэгт, зургийн жагсаалт

Бодлогын судалгааны баримт бичигт товьёгийн араас номд ашигласан өгөгдлийн тухай мэдээлэл буюу хүснэгт, зургийн жагсаалтыг оруулдаг. Энэ жагсаалт нь судалгаагаар танилцуулж буй өгөгдлийн төрөл, эх

Хүснэгт, зургийн жагсаалт нь уншигчийн анхаарлыг тухайн номд багтаасан өгөгдөл рүү хөтөлдөг.

сурвалжийн товч хөтөч болдог. Ихээхэн хэмжээний анхдагч өгөгдөл, мэдээлэл бий болгодог бодлогын судалгааг гүйлгэж хараад агуулгынх нь талаар төсөөлөлтэй болохыг хүссэн уншигчдад энэхүү бүрдэл элемент онцгой тустай.

Асуудлын тодорхойлолт хэсэгт (5.6.2) өгөгдлийг хэрхэн танилцуулах, тайлбарлах тухай нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн ч гэлээ дараах жишээн дээр формат, гарчигтай холбоотой зарим асуудлыг авч үзье.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

“Идэвхтэй сайшаах, идэвхгүй дэмжих ба үл итгэн хойш суухын хооронд” (Свианиевич, 2001) нэртэй гуравдугаар жишээнд ашигласан хүснэгт, зургийн жагсаалтыг уншихдаа дараах зүйлсийг анхаарна уу:

- Энэ бүрдэл элементийн хэлбэр, формат (эрэмбэ дугаарын систем, дизайн)
- Хүснэгт, зургийн гарчгийн оновчтой байдал

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Шинжилсэн орнуудын орон нутгийн засаг захиргааны хэмжээ.....	20
Хүснэгт 1.2. Орон нутгийн засаг захиргааны үүрэг роль засаг даргын ойлголтоор.....	24
Хүснэгт 1.3. Таны бодлоор танай хот (тосгон)-ын орон нутгийн засаг захиргаа бүх иргэдийн/ ихэнх иргэдийн/ цөөн иргэдийн/ жижиг бүлгийн хэнийх нь сонирхлыг идэвхтэй илэрхийлдэг вэ?.....	25
Хүснэгт 1.4. Орон нутгийн болон Парламентын доод танхимын сонгуулийн ирцийн мэдээ.....	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Орон нутгийн засаг захиргаа, иргэдийн харилцааны ялгаатай загварууд болох жишээ улс орнуудын харьцуулалт.....	22
Зураг 1.2. Төрийн албаны менежментийн чиг хандлагууд.....	31

Хүснэгт, зургийн жагсаалт нь тодорхой хүснэгт, зургийг хайж олоход хялбар болгох үүднээс хуудасны дугаарыг заасан байдаг зэрэг форматын зарим шинжээрээ товъёогтой төстэй. Харин дээрх жишээнээс харахад хүснэгт, зургийг дугаарлахад ашигладаг эрэмбэ дугаарын тогтолцоо нь товъёгийнхоос ялгаатай ажээ. Эмхэтгэл, товхимолд “Хүснэгт”, “Зураг” гэсэн үгийн өмнө аравтын бутархайгаар илэрхийлсэн эрэмбийн дугаар байдаг бөгөөд үүний эхний тоо нь эмхэтгэлийн бүлгийн дугаарыг, дараагийн тоо нь бүлэг доторхи хүснэгтийн эрэмбийг төлөөлдөг. Хэвлэмэл бүтээлд мөн өргөн ашиглагддаг өөр нэг эрэмбэ дугаарын систем бол баримт бичигт таарах дэс дараагаар нь хүснэгт, зургуудад нэг оронтой дугаар оноох систем юм.

5.4. Хураангуй юу, товчоон уу

Бодлогын судалгааны баримт бичгийн дараагийн бүрдэл бол хураангуй юмуу товчоон юм (заримдаа тойм ч гэж нэрлэдэг). Хэвлэн нийтлэгчид эдгээр нэр томъёог ижил утгаар хэрэглэдэг ч хураангуй, товчоон хоёрын хооронд бас ялгаа бий. Дараах жишээнээс эдгээр бүрдэл элементийн талаар ерөнхий ойлголт авахын зэрэгцээ ялгааг нь харж болно.

Хэвлэгдэн гарсан бодлогын баримт бичгийн шинжилгээ

“Нэгдмэл үзлээс олон ургальч үзэлд шилжих нь: Румын дахь цөөнхийн бодлогын хүрээнд зохицуулалтуудыг нарийвчлах хэрэгцээ” (Хорват, Скаццо нар, 2001) нэртэй дөрөв дэх жишээ, мөн “Төв ба Зүүн Европын орнуудад худалдааны бодлого, өрсөлдөөнийг уялдуулах нь” (Хүүкман, Мавроидис нар, 1994) нэртэй тав дахь жишээний товчооныг уншиж судална уу. Ингэхдээ дараах асуудлыг анхаараарай:

- Хураангуй болон товчооны хоорондох хэмжээний ялгаа
- Эдгээрийн агуулж буй мэдээллийн төрөл

Жишээ 4:

ХУРААНГУЙ

Энэ бүлэгт Румын дахь унгар, цыган, “жижиг” цөөнхийн бүлгүүд (100 мянгаас цөөн хүнтэй) гэсэн гурван бүлгийн жишээнд тулгуурлан цөөнхийн бүлгүүдийн хэв шинжийг тодорхойлох оролдлого хийлээ. Хэв шинжийн энэхүү судалгааны зорилго нь Румын дахь цөөнхийн бүлгүүдийг ганцхан категорид “хавтгайруулан” хамаатуулж болохгүй гэдэг байр суурийг батлан харуулах явдал юм. Румын дахь цөөнхийн дээрх гурван бүлэг өөр хоорондоо нэлээд ялгаатайн дээр нийгэм, улс төр, эдийн засгийн интеграцчиллын түвшнээр ялгагдах онцлогтой. Цаашилбал, энэ гурван бүлгийн хэрэгцээ харилцан адилгүй, улс төрийн оролцооны түвшин өөр өөр юм. Энэ бүлэгт Румын Улсын бодлого боловсруулагчид, төр засгийн удирдлагууд өөр хоорондоо эрс ялгаатай энэ гурван бүлэгтэй холбоотой хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлыг авч үзэхдээ цөөнхийн бүлгүүдийн ялгаатай байдлыг харгалзаж үзэх ёстой гэсэн санааг дэвшүүлж байна. Ялгаатай байдлыг тодруулах ийм хэв шинжийн судалгаа нь орон нутгийн болон төв засгийн газрын түвшний бодлого боловсруулагчдад хэрэг болоод зогсохгүй Румыний олон үндэстнээс бүрдсэн нийгэм, орон нутгуудын асуудлыг хариуцан ажиллаж буй хүмүүст мэдлэг мэдээлэл болох юм.

Энэ бүлэгт 1989 оноос хойш төв засгийн газраас хэрэгжүүлсэн болон орон нутгуудаас санаачилсан цөөнхийн холбогдолтой бодлогуудад дүн шинжилгээ хийн, үнэлгээ өгөх бөгөөд ингэхдээ 1989 оноос хойш төрийн захиргааны шинэчлэл, цөөнхийн боловсролын эрх зүйн хүрээнд цөөнхийн бүлгийн нийгмийн хөгжил, цөөнхийн эрх, цөөнхийн эрхийг хамгаалах институцийн төлөвшилд тулгарч буй асуудал, бодлогын сорилтуудыг онцлон авч үзэх болно. Судалгааны эцэст дээр дурьдсан асуудал бүрээр бодлогын хэд хэдэн зөвлөмж боловсруулснаа танилцуулж байна.

Жишээ 5.

[дараа дахин дурьдах ишлэлүүдийг дөрвөлжин хаалтад хийж дугаарлав]

ТОВЧООН

[1] Болгар, Чех, Унгар, Польш, Румын, Словак зэрэг Төв болон Зүүн Европын (ТЗЕ) бүсийн зургаан орон өргөн хүрээтэй хамтын ажиллагааны нэгэн гэрээг Европын Холбоотой байгуулаад байгаа нь “Европын Гэрээ” нэртэй. Эдгээр гэрээгээр бараа бүтээгдэхүүний чөлөөт худалдааг зөвшөөрөхийн зэрэгцээ Ромын Хүнсний тунхаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх үүргийг ТЗЕ эдгээр орон хүлээж байгаа юм. Энэ судалгаа нь Европын Гэрээний нэг асуудал болох өрсөлдөөний бодлогыг ТЗЕ-ын бүсийн худалдааны бодлогын байр сууринаас авч үзэх юм. Ингэхдээ өрсөлдөөний хуулийн хэрэгжилтийг худалдаа, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулах чиглэлээр ТЗЕ-ын улс орнуудын засгийн газрын ашиглаж болох институцийн механизмуудыг онцлон судлах зорилт тавьж байгаа болно.

[2] Эрх зүйн онолуудад өрсөлдөөний бодлогын зорилго бол нөөцийн үр ашигтай хуваарилалтыг хангах, улмаар үндэсний баялгийг боломжийн хамгийн дээд түвшинд хүргэх явдал гэсэн хандлага давамгайлдаг. Засгийн газрууд худалдааны бодлогыг янз бүрийн зорилгоор авч хэрэгжүүлдэг ч үр ашигтай байдлыг зорилго болгон дэвшүүлэх нь ховор байдаг. Идэвхтэй худалдааны бодлого нь тодорхой салбар, тухайн салбарын үйлдвэрлэлд оролцож буй хүчин зүйлсийг бодлогоор хамгаалах замаар хүн амын бүлгүүдийн дунд баялгийн дахин хуваарилалт хийхийг зорьдог ч үүнийг оновчтой сайн хийж чаддаггүй. Энэхүү үл зохицлын улмаас өрсөлдөөний хууль өрсөлдөөнийг (улмаар эдийн засгийн үр ашгийг) хамгаалахад чиглэж, харин худалдааны бодлого өрсөлдөгчдийг (улмаар үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг) хамгаалахад чиглэсэн шинжтэй болж орхидог. Засгийн газрын өмнө тулгарах хамгийн ноцтой сорилт бол өрсөлдөөн давамгайлах нөхцлийг хангах явдал юм. Үүний тулд тодорхой худалдааны юмуу хөрөнгө оруулалтын бодлогын улмаас өрсөлдөөнд нөлөөлөх үр дагаврыг шууд хянах боломжийг төр, засагт олгосон институцийн механизмуудыг боловсруулах зэрэгцээ шаардлага гарч ирнэ.

[3] Европын Гэрээний нөхцлөөр ТЗЕ-ын улс орон болгон нь ЕХ-той хийх худалдаанд нөлөөлөх аливаа үйл ажиллагаандаа ЕХ-ны өрсөлдөөний үндсэн зарчмуудыг баримтлах үүрэг хүлээнэ. Эдгээр зарчим нь аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдэх гэрээний өрсөлдөөнийг хязгаарлах, бусдаас давуу байдлаа урвуулан ашиглах, улсын хөрөнгө оруулалттай (төрийн өмчийн) аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, өрсөлдөөнд нөлөө үзүүлэхүйц төрийн дэмжлэг тусалцаа (Европын эдийн засгийн холбооны хэлэлцээрийн 85, 86, 90, 92 дугаар зүйл) зэрэг асуудалтай холбоотой. Иймээс өргөн утгаараа өрсөлдөөний бодлого нь аж ахуйн нэгж, Засгийн газрын үйл ажиллагааны аль алинд хамааралтай зохицуулалт юм. ТЗЕ-ын улс орнууд бараг бүгд өрсөлдөөний хууль баталсан бөгөөд өрсөлдөөний зарчмуудыг хэрэгжүүлэх хариуцлагыг хуваарилсан зохицуулалтыг хийгээд байна. ЕХ-ны улсуудын өрсөлдөөний хуулиуд нэр томъёо, хэрэгжилтийн заавар/ шалгуур үзүүлэлтүүд нь зарим тохиолдолд эрс ялгаатай байгаа ч үзэл баримтлалын хувьд эдгээр зохицуулалт нь өрсөлдөөнийг дэмжсэн утга агуулгатай байгаа юм.

[4] ТЗЕ-ын орнуудын өрсөлдөөнийг хянах асуудал хариуцсан байгууллагуудад өрсөлдөөнийг хязгаарлаж буй төрийн бодлого, үйл ажиллагааны өртөг зардлыг тодорхойлох харьцангуй өргөн хүрээтэй эрх олгогдсон байдаг. Үүнтэй холбоотойгоор юуны түрүүнд анхаарах чиглэл бол худалдааны бодлого гэдэг нь тодорхой. Өрсөлдөөнийг хянах байгууллагуудын хувьд худалдааны бодлогыг “гартаа оруулах” хоёр арга зам байна. Эхнийх нь дотоодын зах зээл дээр өрсөлдөөнийг хэт боомилж байгаа худалдааны бодлогыг сөрж зогсох, хоёрдахь нь худалдааны бодлогын улмаас үүсэж буй өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж буй үр дагавар гарсан даруйд нь саармагжуулан тэнцвэржүүлэх явдал юм. Эхний буюу “шууд” арга замыг ТЗЕ-ын орнуудын Өрсөлдөөний албад идэвхтэй ашиглаж ирсэн.

Энэ чиглэлээрх тэдний ажил Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) орнуудын өрсөлдөөний албадаас дутахааргүй өргөн далайцтай юм. Шинээр санал болгосон болон одоо хэрэгжиж буй худалдааны бодлогуудын талаар санал өгөх, шүүмжилж эсэргүүцэх замаар өрсөлдөөний байгууллагууд салбарын бодлого, лобби үйл ажиллагаанаас нийт эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох, хэлэлцэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Гэхдээ өрсөлдөөний албадын эрх мэдэл нь үйл явдал болоод өнгөрсний дараа үнэлгээ өгөхөөр хязгаарлагдаж байгаа юм. Өрсөлдөөний хуулиудыг хэрэгжүүлэхдээ худалдааны бодлогыг заавал харгалзахыг шаардсан хэрэгжилтийн идэвхтэй зарчмыг баримтлан ажиллах нь зах зээлийн хүртээмжийг хязгаарлах үр дагавартай хуулийн төслийг батлагдахаас нь өмнө эсэргүүцэх арга механизмуудын үр нөлөөг улам нэмэгдүүлэх юм.

[5] Өрсөлдөөний хуулийн хэрэгжилтийг улам чангатгах, худалдааны бодлоготой илүү сайн уялдуулахад туслах хэд хэдэн арга хэмжээг тодорхойлж болох байна. ТЗЕ-ын орнуудын монополийн эсрэг байгууллагууд эрх зүйн чадамжаа эрх мэдлийнхээ хүрээнд бүрэн ашиглаж чадахгүй байгаа юм шиг харагддаг нь нэг талаараа хувийн өмч, зах зээлийн харилцааг бий болгох зорилготой шилжилтийн үеийн үр дүнгийн илрэл байх магадлалтай. Нарийвчилсан удирдамж боловсруулан мөрдөх нь өрсөлдөөнийг хязгаарлаж буй ямар төрлийн үйл ажиллагаанд өрсөлдөөнийг хянах байгууллагууд эн тэргүүний ач холбогдол өгч ажиллах талаарх тодорхой бус байдлыг багасгаж өгөхийн зэрэгцээ ямар үйл ажиллагааг цаашид хориглох тухай ойлголтыг тодорхой болгож өгөх давхар ач холбогдолтой. ТЗЕ-ын орнуудын хууль эрх зүйд нэг нийтлэг зүйл байгаа нь өрсөлдөөний хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй байгууллагууд их өргөн хүрээний эрх мэдэлтэй байгаа явдал юм. Энэ нь сөрөг талтай байж болох бөгөөд тухайлбал, энэ нөхцөлд байх ёстой хэд хэдэн чухал хориг хэрэгжих огт боломжгүй болох магадлалтай. Харин сөрөг талуудын нөлөөг бууруулах сайн тал нь гэвэл нарийн зохицуулагдаагүй эрх мэдлээ өрсөлдөөнийг дэмжих чиглэлд ашиглаж чадах юм бол энэ салбарын эрх зүй нь өөрөө өрсөлдөөний хуулийн зорилтуудыг дэмжсэн утга чанартай болох боломж байна. Монополийн эсрэг хуулийн хүрээнд хамруулах зах зээлийг тодорхойлохдоо аж үйлдвэрийн тодорхой салбарын онцлогийг тусгасан худалдааны бодлогын үзэл баримтлалыг тусгахад зайлшгүй анхаарах шаардлагатай. Энэ бодлогын тухайд ч мөн тодорхой заавар, удирдамж гаргах хэрэгтэй. Зах зээлд эзлэх хувь хэмжээг босго үзүүлэлтээр (тухайлбал, ноёлох байр суурийг тодорхойлохдоо) тодорхойлон ойлгож байгаа тохиолдолд энэ хэмжээг зах зээлийн багтаамж, чадавхитай холбон авч үзэх хэрэгтэй бөгөөд энэ нь зах зээлд хүчтэй байр суурьтай байх нь хамгийн чухал үзүүлэлт юм гэсэн дохиог олон нийтэд өгөх юм. Энэ нь ТЗЕ-ын орнуудад зах зээлийн философи хөгжин бэхжихэд маш чухал хөшүүрэг болоод зогсохгүй хэрвээ эрх мэдэл бүхий байгууллагууд өөрсдийн гаргаж буй шийдвэрийн цаана орших үндэслэлийг олон нийтэд мэдээлдэг болох юм бол мөн өрсөлдөөний ил тод байдлыг бэхжүүлэх юм.

[6] ЕХ-ны шаардлагад нийцсэн шударга өрсөлдөөний журам баталж ажиллах, мөн 10 жилийн дотор чөлөөт арилжаа, хөрөнгө оруулалтын эрх чөлөөг бий болгох үүргийг гэрээгээр хүлээлгээд байгаа ч демпинг буюу ижил төстэй барааг өөрийн орны зах зээл дээр борлуулж байгаагаасаа хямдаар гадаадын зах зээл дээр худалдахын эсрэг хоригийг аажмаар арилгах тухай заалт гэрээнд алга. ЕХ-ны зүгээс өөрийн гишүүн орнуудын зах зээлийг хамгаалах бодлогоо үргэлжлүүлсээр байх нөхцөлд ТЗЕ-ын бүс нутгийн аж ахуйн нэгжүүд ЕХ-ны түншүүдээсэ ялгаатай стандарттай тулгарах болно гэсэн үг юм. ЕХ-ны демпингийн эсрэг журмыг хүчингүй болгохгүй л бол ЕХ-ны аж ахуйн нэгжүүд үнийн ялгавартай бодлого явуулж, бараа бүтээгдэхүүнээ ЕХ-ны зах зээл дээрх үнээс доогуур үнээр худалдаалах боломжтой байхад харин ТЗЕ-ын орнуудын компаниудийн хувьд ийм үйл ажиллагаа хориотой байх болно. Бүс нутгийн эдийн засгийн интеграцчиллыг дэмжихэд чиглэсэн хэлэлцээрүүдийн хүрээнд демпингийн эсрэг журмыг цуцлуулах чиглэлд бий болсон туршлагаас үзэхэд дотоодын зах зээлийг өрсөлдөөнөөс хамгаалах бодлогыг хүчингүй болгохын тулд наад зах нь 3 үндсэн нөхцөл бүрдсэн байх шаардлагатай болж байна.

Эдгээр нь (1) чөлөөт худалдаа ба хөрөнгө оруулалтын эрх чөлөө, (2) дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэлийг дэмжих засгийн газрын боломжийг хязгаарласан журам, (3) өрсөлдөөний тухай (монополийн эсрэг) хууль, түүний хэрэгжилт зэрэг болно. Эдгээр нөхцлийг ЕХ болон ТЗЕ-ын орнуудын хоорондын худалдааны харилцаанд нэвтрүүлэх нь аль аль талдаа ашигтай ч демпингийн эсрэг зохицуулалт байхгүй хэвээр л байна.

[7] Европын Гэрээг бүрэн хэрэгжүүлэх бэлтгэл хийгдэж буй энэхүү шилжилтийн үед цаашид анхаарах нэг чиглэл бол ТЗЕ-ын орнуудад ЕХ зүгээс демпингийн эсрэг хуулийн дагуу заналхийлэх, дарамт ирсэн тохиолдолд демпингийн эсрэг хуулийг монополийн эсрэг хуультай холбон хэрэглэх боломжийг судлах явдал юм. ТЗЕ-ын орнуудаас гарал үүсэлтэй бараа таваарын тухайд демпингийн эсрэг хуулийн хүрээнд ямар нэг шалган мөрдөх үйл ажиллагаа явуулах тохиолдолд ЕХ чөлөөт өрсөлдөөний бодлогыг ашиглах ёстой гэсэн шаардлагыг тавьж болох юм. Ингэснээр шалгалт нь зөвхөн ЕХ-ны үйлдвэрлэгчдэд эрсдэл үүсээд байгаа гэсэн үндэслэлд бус харин өрсөлдөөний зарчим бүхэлдээ зөрчигдөөгүй байх үндэслэлд анхаарах юм. Шилжилтийн үед энэ зохицуулалтыг албан бус тохиролцооны замаар шийдэж болох юм. ТЗЕ-ын орнуудын хувьд эн түүнд анхаарлаа хандуулах хамгийн зөв стратеги бол Европын Гэрээг бүрэн хэрэгжүүлээд эхэлмэгц демпингийн эсрэг хуулийг хүчингүй болгуулах явдал юм. Харин демпингийн эсрэг хуулийг зогсоох шийдэлд хүрч чадахгүй болбол хоёрдахь боломжит арга зам нь өрсөлдөөний хуулийн хэрэгжилтийг демпингийн эсрэг мөрдөн шалгалттай холбон журамлах шийдэл юм. Арай ерөнхий хүрээнд авч үзэх юм бол нэгэнт ТЗЕ-ын орнууд өрсөлдөөний салбарт ЕХ-той төстэй эрх зүйн орчин бүрдүүлсэн тул тэрхүү өрсөлдөөний хуулиа сайн мөрдөж чадвал ЕХ-ны стандартын наад захын шаардлагыг хангаж чадна гэж үзэх үндэслэлтэй. Энэ нь демпингийн эсрэг хуулиар хөнгөлөлт эдлэхийг хүсэж буй импорттой өрсөлдөгч ЕХ-ны үйлдвэрлэгч нарт тавигдах шаарлага, босгыг дээшлүүлэх үр нөлөө үзүүлж ч мэднэ. Цаашилбал, үйлчилгээний салбарт, ялангуяа дистрибьюторын үйл ажиллагаанд өрсөлдөөний зарчмуудыг тууштай хэрэгжүүлж чадвал ЕХ-ны аж ахуйн нэгжүүдийн дотоод зах зээлээ хамгаалуулахаар боломж нь багасна.

Дээрх жишээг гүйлгэж харахад л хураангуй, товчоон хоёр нь хэмжээ, агуулж буй мэдээллийн төрлөөрөө ялгаатай болох нь харагдах ба энэ нь бодлогын баримт бичигт эдгээр элементийн гүйцэтгэх үүрэг өөр байдагтай холбоотой юм. Хураангуй, товчоон хоёрын зориулалт, бүтцийн бүрдэл элементүүдийн ижил төстэй болон ялгаатай талуудыг дор тайлбарлав. Үүнд:

- *Хураангуй нь баримт бичгийг ерөнхийд нь товч танилцуулах бол товчоон нь баримт бичигт авч үзсэн гол асуудлуудыг тоймлон тайлбарладаг.*

Хураангуй бол товч танилцуулга юм. Товчоон нь бүхэл баримт бичгийн тойм юм.

Хураангуй юмуу товчооныг бодлогын судалгааны баримт бичгийн Удиртгал хэсгийн өмнө оруулж хэвлэдэг (баримт бичгийн үндсэн бичвэрийн хуудасны дугаарлалтад оруулдаггүй) бөгөөд энэ нь тэдний гүйцэтгэх үүргийнхээ улмаас бие даасан шинжтэй болохыг нь илэрхийлнэ. Уншигчтай нэлээд удаан,

нухацтай харилцах анхны боломжийг олгодог (гарчиг, товъёгийн араас байрладаг) талаараа төстэй энэ хэсэг харин уншигчийн сонирхлыг татах арга зам, унших арга барилд нийцүүлсэн байдлаараа ялгаатай. Хураангуй нь баримт бичгээр хөндөж буй гол сэдэв, авч үзэх асуудлыг товч танилцуулах замаар уншигчийн сонирхлыг татдаг нь Дөрөвдүгээр жишээнээс харагдаж байна. Улмаар хураангуй нь баримт бичгээ дэмжих үүрэгтэй бөгөөд Дөрөвдүгээр жишээний зохиогч нь хураангуйдаа баримт бичгийнхээ хамаарах хэсгийг шууд дурьдсан тайлбар оруулж, уншигчдаа удирдан залж байна. Түүний хураангуй “Энэ бүлэгт ... хэв шинжийг тодорхойлох оролдлого хийлээ” гэж эхлээд, “Судалгааны эцэст дээр дурьдсан асуудлуудаар бодлогын хэд хэдэн зөвлөмж боловсруулснаа танилцуулж байна” гэж төгсгөжээ.

Товчоон нь мөн л уншигчийн сонирхлыг татаж, бодлогын судалгааны баримтыг дуустал нь уншуулах үүрэгтэй бөгөөд үүгээрээ энэ хоёрын чиг үүрэг давхцдаг. Харин товчоон нь баримт бичгийг бүхлээр нь уншихгүй, зөвхөн судалгааны дүгнэлт, санал болгож буй бодлогын зөвлөмжийг голлон сонирхож байгаа уншигч, ялангуяа шийдвэр гаргагчдад хангалттай мэдээлэл өгч, хэрэгцээг нь хангах үүрэгтэй. Энэ зорилгоо биелүүлэхийн тулд товчоон нь бодлогын баримт бичгийн гол гол хэсэг, чухал дүгнэлтүүдийг бүгдийг нь тоймлон танилцуулж, баримт бичгээ бүхэлд нь төлөөлөх чадвартай байх ёстой.

- *Хураангуй, товчоон хоёр ижил бүрдэл элементүүдтэй ч фокус, бүрдэл элементүүдийн хамрах хүрээгээрээ ялгаатай.*

Энд ашиглаж буй болон бусад жишээнээс үзэхэд, хураангуй юмуу товчоон нь дараах дөрвөн бүрдэл элементийг нийтлэгээр агуулдаг бөгөөд эдгээр нь баримт бичгийн бичвэрийн бүрдэлтэй давхцсан байна:

Хураангуй/ Товчоон	{	<ul style="list-style-type: none"> - Бодлогын баримт бичгийн зорилго - Асуудлын томъёолол, тодорхойлолт - Бодлогын хувилбаруудын үнэлгээ - Дүгнэлт, зөвлөмжүүд
-----------------------	---	--

Гэхдээ хураангуй болон товчоон дахь эдгээр элементийн хэмжээ, ач холбогдол нь өөр байгаа нь эдгээрийн хоорондын томоохон ялгааг илэрхийлнэ. Хэдийгээр аль аль нь бодлогын судалгааны баримт бичгийн богиносгосон хувилбар мөн ч зорилгоороо ялгаатай

Товчоон нь хураангуйг бодвол хавьгүй илүү нарийвчилсан, дэлгэрэнгүй байдаг.

тул хэмжээ, нарийвчлалын түвшин нь мөн ялгаатай болохыг энэ номд ашиглаж байгаа жишээ материалуудаас харж болно. Тавдугаар жишээ нь 1200 үгтэй долоон хэсгээс бүрдсэн товчоон, харин Дөрөвдүгээр жишээ 220 үгтэй нэг хэсэг буюу догол мөрт багтсан хураангуйн жишээ юм. Хураангуй нь баримт бичгийг бүхлээр нь унших хүнд үндсэн бичвэр лүү шилжихийн өмнө юуны тухай унших гэж байгааг богино хугацаанд танилцуулах зорилготой тул товч байх ёстой. Тиймээс баримт бичгийн бүрдэл хэсгүүдийн талаар нарийвчилж тайлбарлалгүй ерөнхийд нь дурьддаг онцлогтой. Үүнийг баримт бичгийн зорилго, авч үзэж буй бэрхшээл, хөндсөн гол асуудлуудыг товч танилцуулсан Дөрөвдүгээр жишээнээс тод харж болно. Харин Тавдугаар жишээнд нөхцөл байдал болон баримт бичгийн зорилго (догол мөр [1]), тулгамдсан асуудлын тайлбар (догол мөр [2], [3], [4]), бодлогын хувилбарууд (догол мөр [5] ба [6]), судлаачдын дүгнэлт, боловсруулсан бодлогын зөвлөмжүүд [7]) зэрэг бүрдэл элемент бүрийг илүү дэлгэрэнгүй тайлбарласан байна. Ийм нарийвчлалтай мэдээлэл өгч буйн шалгаан нь баримт бичгийн зөвхөн энэ хэсгийг уншаад, цааш уншихгүй хүмүүст хангалттай мэдээлэл өгөх явдал юм.

Хамгийн сүүлийн бүрдэл элемент болох Зөвлөмж, дүгнэлт хэсгийг хураангуйд багтаах эсэх талаар зохиогчдын байр суурь өөр өөр байдаг. Зарим зохиогч судалгааны үндсэн дүгнэлт, санал болгож буй бодлогын зөвлөмжүүдээ Тавдугаар жишээний сүүлийн догол мөр шиг шууд тоймлон оруулах хэрэгтэй гэж үздэг. Хураангуйн зорилгыг харгалзах юм бол эдгээрийг багтаах нь зүйтэй. Гэтэл зарим зохиогч баримт бичгийг бүхэлд нь уншуулж тодорхой сайн ойлголт өгөх үүднээс уншигчдын сонирхлыг хадгалах зорилгоор гол дүгнэлт, зөвлөмжөө урьдчилж танилцуулахгүй байх арга замыг сонгодог. “Судалгааны энэ ажил нь эдгээр асуудал тус бүрээр бодлогын зөвлөмж санал болгосноор төгсөж байна” хэмээсэн Дөрөвдүгээр жишээний сүүлийн өгүүлбэрт энэ хандлага тодорхой тусжээ. Баримт бичгийнхээ энэ бүрдэл элементийг бичихдээ таны судалгаа, зорилтот бүлэгт илүү тохирох аргыг та өөрөө л сонгох хэрэгтэй болно.

Бодлогын баримт бичгийн энэ бүрдэл элементийг бичихийн өмнө таны тайланг эрхлэн гаргах хэвлэн нийтлэгч хураангуй юмуу товчооны алиныг хүсч байгааг лавлаарай. Дээр өгүүлсэнчлэн хураангуй, товчоон гэсэн нэр томъёог ижил утгаар хольж хэрэглэх нь элбэг ч хэвлэн нийтлэгчийн өгөх заавраас хэр нарийвчлалтай, хэдий хэмжээний

материал хүсэж байгаа нь тодорхой харагдна. Энэ чухал хэсгийн бичихэд танд дараах санаа тус болно:

- Хэвлэгдэн гарсан товчоон, хураангуйтай тогтмол танилцаж, тэдгээрийг оновчтой болгож буй шинж чанар, агуулж буй бүрдэл хэсгүүд, бичигдсэн арга барилыг судалж байгаарай.
- Хураангуй, товчоон нь таны бичсэн бодлогын баримт бичгийн энд тэндээс хуулж авсан хэсгүүдийн цуглуулга огт биш юм. Энэхүү бүрдэл элементийг шинэлэг, дотоод логик сайтай, сонирхолтой болгохын тулд бие даасан хэсэг болгож шинээр бичих хэрэгтэй. Зохиогчдын гаргадаг нийтлэг алдаа бол энэ бүрдэл хэсгийг хамгийн сүүлд бичихээр хойш тавьж, цаг тулсан учраас нэг их хөдөлмөр зүтгэл гаргалгүй хайнга бичдэг явдал юм. Гэтэл таны хүргэхийг зорьж буй санааг уншигчдад амжилттай хүргэхэд энэ бүрдэл хэсэг маш чухал үүрэг гүйцэтгэж чадахыг харгалзах юм бол хангалттай цаг, чармайлт зарцуулахаар анхнаасаа л төлөвлөх нь зүйтэй.
- Энэ элементийг бичихээр бэлдэж байхдаа баримт бичгээ бүхлээр нь, ялангуяа зорилгын хэсэг, бичвэрийн гол хэсгүүд, чухал ач холбогдолтой үндэслэлүүдээ дахин уншиж, агуулгын хүрээ, үндсэн фокусаа тодруулж аваарай. Мөн агуулгын төлөвлөгөө, баримт бичгийн товъёгийг дахин сөхөж үзэн, хураангуй юмуу товчооноо бичих ажлыг чиглүүлэх санаануудаа олж болно.

5.5. Удиртгал

Бодлогын баримт бичгийн удиртгал нь үндсэн бичвэрийн агуулгыг танилцуулж, хүрээг нь гаргаж өгдөг. Иймд удиртгал нь баримт бичгийг эхлүүлж, уншигчдын сонирхлыг улам өдөөх үүднээс авч үзсэн асуудлын мөн чанар болон орчин нөхцөл, гүйцэтгэсэн судалгааны тухай ерөнхий мэдээлэл өгдөг. Энэ нь судалгаагаар хүргэхийг зорьж үндсэн санаа, нарийвчилсан мэдээлэл, ялангуяа зохиогчийн байр суурь, баримт бичгийн агуулгад шингээсэн үндэслэлд багтах тулгуур асуудлуудыг ойлгоход уншигчийг бэлтгэж байгаа хэрэг юм. Харин олон уншигч бодлогын баримт бичгийг бүхэлд нь уншихаасаа өмнө эхний алхам болгож баримт бичгийн агуулгыг тоймлон өгүүлэх хэсгүүдийг (хураангуй буюу товчоо, удиртгал ба

Удиртгал нь нөхцөл байдал, гол асуудал, судалгааг танилцуулах замаар уншигчийг бэлдэх үүрэгтэй.

дүгнэлт) унших хандлагатай байдгийг харгалзах юм бол Удиртгал хэсэгт хангалттай суурь мэдээлэл, тайлбар өгөх нь нэн чухал юм. Удиртгал зэрэг баримт бичгийн бүрдэл элементүүдийг сайн бичих юм бол уншигчид баримт бичгийн үндсэн бичвэрийн гол чиглэл, фокус, гол санаануудын талаар тодорхой ойлголттой болж чадна.

Эдгээр зорилтыг хангасан Удиртгал нь бүтцийн хувьд хэд хэдэн хэсэгтэй байх ёстой. Доор танилцуулах Удиртгалын жишээнүүд нь эдгээр хэсгийг нарийвчлан шинжлэхэд тус болно.

Хэвлэгдэн гарсан бодлогын баримт бичгийн шинжилгээ

Хавсралт А-аас доорх бодлогын баримт бичгүүдийн Удиртгалыг уншина уу.


Жишээ 2: “Орон нутгийн түвшний төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл явц дахь нээлттэй өрсөлдөөн, ил тод байдал, төвийг сахисан байр суурь” (Баар, 2001);

Жишээ 4: “Нэгдмэл үзлээс олон ургальч үзэлд шилжих нь: Румын дахь цөөнхийн бодлогын хүрээнд зохицуулалтуудыг нарийвчлах хэрэгцээ” (Хорват, Скаццо нар, 2001).

Уншиж байхдаа дараах асуудлуудад анхаарлаа хандуулна уу:

- Удиртгалын хоёр жишээнд багтаасан мэдээллийн төрөл
- Удиртгал нь баримт бичгийг уншихад таныг хэр сайн бэлдэж байгаа

Удиртгал хэсгийг бичихдээ зохиогчид нэг талаас товч байх, нөгөө талаас уншигчдыг баримт бичгийг бүхлээр нь уншихад бэлдэхэд хангалттай мэдээлэл өгөх шаардлагуудыг тэнцвэртэй хангахын тулд янз бүрийн арга хандлага баримталдаг нь шинжилгээнээс харагдана. Харин Удиртгалын жишээнүүдийг нарийвчлан шинжилж үзвэл бүтцийн дараах нийтлэг хэсгүүд байгааг харж болно:



Баримт бичгийн Удиртгал хэсгийг илүү сайн ойлгоход туслах үүднээс эдгээр хэсгийг нэг бүрчлэн авч үзье.

- **Бодлогын асуудлын орчин нөхцөл**

Удиртгал нь баримт бичгийн “үйл явдал өрнөх орчинг” тайлбарлах буюу баримт бичгээр авч үзэх бодлогын асуудлыг нийгмийн контекст дунд нь байршуулж харуулснаар эхэлдэг. Энэ нь уншигчийг баримт бичгийн агуулга руу хөтлөн оруулж, цаашид гарах асуудлуудыг ойлгоход

туслах ерөнхий мэдээллийн суурийг хангаж өгдөг. Гэхдээ баримт бичгийн эхэнд л нөхцөл байдлыг маш ерөнхий юмуу хэт нарийвчлан танилцуулах нь уншигчийн сонирхлыг бууруулж болох тул энэ хэсгийг товч хэрнээ тодорхой фокустай байлгах шаардлагатай. Ихэнх зохиогч энэ л шалтгаанаар суурь мэдээллийг маш товч танилцуулаад, шууд л судалгааны гол асуудлуудыг тайлбарлах руу ордог. Дөрөвдүгээр жишээг авч үзвэл, асуудлын нөхцөл байдлыг тайлбарласан энэ хэсэг Удиртгалын гуравны нэгийг эзэлж байгаа бөгөөд эхний догол мөрт л нэгдүгээр өгүүлбэрээр олон үндэстэн хамтран амьдардаг хот, суурингуудын ерөнхий асуудлаас энэ баримт бичгийн сэдэв болж буй асуудлын тодорхой аспект руу (олон хэв шинжийг хүлээн зөвшөөрөх) орж буй логик шилжилт илэрхий харагдаж байна. “Румын улс бол цөөнхийн олон бүлэгтэй орон нутгийг хэрхэн удирдах асуудлаарх судалгааны маш сонирхолтой жишээ юм” гэсэн эхний өгүүлбэр нь Удиртгал хэсгийг нээж өгч буй маш хүчтэй, хурц өгүүлбэр болж чадсан бөгөөд “гайхамшигт кейс”-ийн тухай унших боломж байна гэдэг нь уншигчийн анхаарлыг шууд татах зорилготой ажээ. Ингэхлээр Удиртгалыг бичихдээ хурц өгүүлбэрээр нээж өгөх арга зүйн хандлагыг баримтлах хэрэгтэй.

Удиртгалын энэ хэсгийг бичихдээ улс орон, бүс нутгийн гэх мэт ерөнхий нөхцөлд бус, харин тулгарч буй хүндрэл бэрхшээлийн нөхцөл байдалд (тухайлбал, Румын дахь цөөнхийн бүлэг) фокуслан төвлөрөх хэрэгтэйг мартаж болохгүй. Ер нь энэ жишээ баримт бичгийн хувьд тулгамдсан асуудалтай холбоотой нөхцөл байдал нь агуулгыг тодорхойлно гэсэн хандлага нэвт шингэсэн байна. Бодлогын баримт бичгийн зорилго, түүний “тулгамдсан асуудал - шийдэх арга зам” гэсэн практик фокус нь энэ төрлийн баримт бичгийн Удиртгалыг уламжлалт эрдэм шинжилгээний баримт бичгийнхээс эрс ялгаатай болгодгийг дурьдахад илүүдэхгүй. Энэ л шалтгаанаар зохиогч тухайн асуудлын судлагдсан байдлыг тоймлон харуулах, эсвэл асуудлын судлагдсан байдал дотор энэ судалгаа хэрхэн “сууж” байршихыг тайлбарлах албагүй. Харин баримт бичгийн гол фокус болж буй тулгамдсан асуудал руу түргэн шилжиж орох хэрэгтэй байдаг.

- ***Асуудлын томъёолол***

Удиртгалын энэ хэсэг нь ерөнхий мэдээллээс бодлогын баримт бичгийн фокус болж буй тодорхой асуудал руу шилжих хэсэг юм. Шийдэл шаардсан тулгамдсан асуудал үнэхээр байна гэсэн таны санааг уншигчдад хүргэж, энэ асуудлыг шийдэх боломжит шийдлүүдийг

Шийдэх асуудлыг маш тодорхой томъёолж бичсэнээр үндэслэлээ танилцуулж эхэлж байгаа хэрэг юм.

санал болгох учир таны бичсэн баримт бичгийг унших хэрэгтэй гэдэгт уншигчдыг ятгаж итгүүлэхэд энэ хэсэг чухал нөлөөтэй. Энэ элемент нь тухайн асуудлаарх таны байр суурийг тодорхой илэрхийлдэг тул бодлогын баримт бичгээр санал болгох бодлогын хувилбарууд, зөвлөмжийг ойлгох суурь болж өгдөгөөрөө уншигчдад нэн хэрэгтэй чухал хэсэг юм.

Жишээ болгон ашиглаж буй хоёр Удиртгалыг бичихдээ зохиогчид өөр өөр арга зүйн хандлага баримталсан байх ба эдгээрийн ялгаанаас зарим сонирхолтой зүйлийг харж болно. Нэгдүгээрт, зарим зохиогч асуудлын томъёоллоо зорилгын тодорхойлолттой нягт уялдуулдаг нь харагдана. Энэ нь баримт бичгийн зорилгын тодорхойлолт нь зохиогчийн сонгосон бодлогын асуудлын шийдлийг хөндсөн байдаг тул асуудал-шийдэл гэсэн логик бүтэцтэй баримт бичгүүдэд энэ хоёр элемент салшгүй холбоотой байдгийн тусгал юм. Жишээлбэл, Дөрөвдүгээр жишээнд Удиргалын хоёрдугаар догол мөрд энэ хоёр элементийн холбоо харагдаж байна. Мөн Дөрөвдүгээр жишээнд зохиогч асуудлын томъёоллыг зорилгын тодорхойлолтын дараа байрлуулах сонголт хийсэн нь сонирхол татаж байна. Энэ нь тухайн элементүүдийг төлөвлөж бичихдээ зохиогчид янз бүрийн арга хандлага баримталж болохын жишээ юм.

Хоёрдугаарт, тулгамдсан асуудлыг томъёолж бичихдээ зохиогчид өөр өөр хандлага баримталжээ. Дөрөвдүгээр жишээнд, бодлогын асуудлыг гуравдугаар догол мөрийн хоёр, гурав дахь өгүүлбэрт шууд илэрхийлээд, Румыний засгийн газрын цөөнхийн талаарх бодлогыг “амжилтгүй”, “зохимжгүй” зэрэг үгээр хурц шүүмжилсэн найруулгаар тодорхойлж бичжээ. Хоёрдугаар жишээний хувьд, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой өнөө тулгарч буй бэрхшээл, шийдэх шаардлагатай асуудлуудыг бус харин энэ асуудалтай холбоотой өнөөдөр гаргах шийдвэрүүдийн цаашдын үр дагавар нь энэ баримт бичгийн фокус болж буйг гуравдугаар догол мөрт тайлбарлах замаар бодлогын асуудлыг шууд бус найруулгаар дам илэрхийлжээ.

Энэ элементийг бичих зөв арга гэж байхгүй ч “асуудал-шийдэл” гэсэн холбоос, хамаарал нь бодлогын баримт бичгийн гол шинж болдогийг санах юм бол энэ хэсэг уншигчдад шийдэх шаардлагатай тулгамдсан асуудал байгааг ойлгуулах үүрэгтэй тун чухал хэсэг юм. Улмаар шинжилж буй бодлогын асуудлын мөн чанар, гол аспектуудыг тодорхой, хурц томъёолж, тайлбарлаж чадах юм бол уншигч тэр хэрээр

илүү итгэж үнэмших магадлалтай. Иймд энэ элемент нь судалгааны үндэслэл болдог.

Энэ элементийг бичихэд дараах асуултууд тус болно:

- Ямар асуудал, бэрхшээл тулгараад байна вэ?
- Энэ асуудал, бэрхшээл нийгэмд хэрхэн нөлөөлж байна вэ?
- Энэ асуудалд шууд ба шууд бусаар хамааралтай ямар сонирхогч талууд байна вэ?
- Асуудлыг ямар бүрдэл хэсгүүдэд хувааж болох вэ?
- Энэ асуудлыг тодорхойлохдоо та ямар тэмдэг нэрүүдийг хэрэглэх вэ?
- Энэ асуудалтай холбоотой ямар үндсэн асуултууд, санал зөрөлдөх маргаантай зүйлс байна вэ?

- **Зорилгын тодорхойлолт**

Зорилгын тодорхойлолт буюу баримт бичгийн зорилго, зориулалт гэж нэрлэгддэг энэ элемент нь бодлогын баримт бичгийн зориулалтыг илэрхийлсэн нэг, хоёр өгүүлбэрээс бүрддэг. Зорилгын тодорхойлолт нь бодлогын баримт бичгийн цөм болж буй үндэслэлийг дэлгэн тайлбарлах үйл явцыг эхлүүлдгээрээ ихээхэн ач холбогдолтой хэсэг юм. Иймд тулгамдсан асуудлыг томъёолсон өмнөх элементтэй нягт холбоотой энэ хэсэг нь авч үзэж буй бодлогын асуудлаар зохиогч ямар байр суурь баримталж буйг илэрхийлдэг. Харин бидний шинжилж буй хоёр жишээнээс харахад энэ хэсгийг бичихдээ зохиогчид өөр өөр арга хандлага баримталж болох ажээ. “Энэ бүлэгт Румыний бодлого боловсруулагчид цөөнхийн янз бүрийн бүлгүүдийн хооронд соёл, улс төр, хүн амзүйн чухал ялгаанууд байдгийг хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн үндэслэлээр цөөнхийн асуудлыг авч үзэх юм” гэсэн Дөрөвдүгээр жишээний хоёрдугаар догол мөрийн эхний өгүүлбэр бол энэ баримт бичгийн Зорилгын тодорхойлолт юм. Зохиогчид нь авч үзэж буй асуудлаарх өөрсдийн байр суурийг тодорхой, хурц илэрхийлсэн байх ба уншигчид ч бодлогын баримт бичиг бүхэлдээ энэ үндэслэлийг дэлгэн тайлбарлаж, дэмжихэд чиглэгдэнэ гэсэн ойлголттой болох юм.

Баримт бичгийн зорилгыг илэрхийлэх нь үр нөлөөтэй үндэслэл боловсруулахад зайлшгүй хэрэгтэй.

Харин дээрхээс ялгаатай нь, Хоёрдугаар Жишээний дөрөв дэх догол мөр нь баримт бичигт юуны тухай өгүүлэхийг уншигчдад мэдээлэх утга агуулгатай байна: “Энэ бүлгийн зорилго нь Төв болон Зүүн Европын орнуудад төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхдээ өрсөлдөөнт

сонгон шалгаруулалт, ил тод болон тэгш хандах зарчмуудыг хэрэглэж байгаатай холбоотой үндсэн асуудлуудыг авч үзэн, Европын Холбоо ба бусад орны туршлагаудыг харьцуулж үзэх зорилготой юм". Авч үзэх асуудлаар зохиогч ямар байр суурьтай байгааг тайлбарлаагүй тул уншигчид үндэслэлийг танилцуулж эхлэхийг хүлээх хэрэгтэй болж байна. Дээрх хоёр жишээ уншигчдын сонирхлыг өдөөх, асуудал хэр тулгамдаад байгааг ойлгуулах тал дээрээ уншигчдад нэлээд ялгаатай нөлөө үзүүлэхээр шинжтэй болжээ. Ингээд сайн Зорилгын тодорхойлолт бичихдээ ямар арга хандлага баримтлах нь энэхүү Зорилгын тодорхойлолтын зориулалт, асуудлын мөн чанар, тухайн асуудлаар зохиогч өөрөө хэр хүчтэй байр суурьтай, хэр их сэтгэлийн хөдлөлтэй байгаагаас шалтгаалсан таны өөрийн хийх сонголт юм.

- **Судалгааны арга зүй, сул тал**

Шинжилгээний хамрах хүрээ, судалгааны орчин нөхцлийг товч тайлбарла.

Удиртгал хэсэгт дүн шинжилгээний хамрах хүрээ, үнэлгээнд хамруулж авсан хувьсагчид зэрэг бодлогын судалгааны аргазүйг тоймлон тайбарлах нь элбэг байдаг. Энэ элемент баримт бичгийн арга зүйн талыг ойлгоход уншигчдыг бэлтгэхийн зэрэгцээ зохиогчийн мэргэжлийн нэр хүндийг батлан харуулах, энэ баримт бичгээр танилцуулж буй шинжилгээ, дүгнэлт, үндэслэл нь шинжлэх ухааны баталгаатай арга зүйд тулгуурласан болохыг нотлох зорилготой. Жишээ болгон шинжилж буй хоёр Удиртгалд зохиогчид ашигласан арга зүйгээ товч тайлбарласан байна. Дөрөвдүгээр жишээний хувьд, Удиртгал хэсгийн сүүлийн догол мөрт энэ судалгаа нь хэв шинжийн судалгаа болохыг дурьдаад, гол гол хувьсагчдын жагсаалтыг танилцуулжээ. Хоёрдугаар жишээний зохиогчид нь судалганы аргазүйн хүрээг харьцуулсан шинжилгээ гэж тодорхойлохын зэрэгцээ судалгааны газарзүйн хүрээ, мэдээлэл цуглуулахад ашигласан аргууд зэрэг нарийвчилсан мэдээллийг багтаажээ (4 дэх догол мөр).

Зарим зохиогч энэ хэсэгт судалгааны хамрах хүрээ, сул талыг тайлбарлах нь бий. Авч үзэж буй бодлогын асуудлын бүхий л талыг ганц судалгаагаар шийдэх боломжгүйн дээр судалгааны хүрээнд гүйцэтгэсэн шинжилгээнд ашигласан мэдээллийн хэмжээ, төрөл гэх мэт арга зүйн чанартай хязгаарлалт, сул талууд байгааг хүлээн зөвшөөрснөөр та судлаачийн хувьд мэргэжлийн нэр хүндээ улам өсгөх юм. Хоёрдугаар жишээний зохиогч дөрөвдүгээр догол мөрийн төгсгөлд судалгааны хүрээнд цуглуулсан мэдээлэлтэй холбоотой сул тал байгаа тухай

уншигчиддаа мэдээлсэн байна: “Төв болон Зүүн Европын орнуудын хууль тогтоомжтой холбоотой тодорхой, нарийн мэдээлэл олддог боловч нийтлэгээр ашиглаж буй практик арга барилын талаар маш их ялгаатай сэтгэгдэл, хандлагуудыг хүмүүс илэрхийлж байсны хажуугаар бодит амьдрал дээр өргөн дэлгэрсэн арга барилын талаарх мэдээллийг системтэйгээр цуглуулаагүй болохыг анхаарна уу” хэмээжээ. Энэ сул талыг дурьдсан нь уншигчдад асуудал нарийн ээдрээтэй болохыг харуулж, судалгааны үр дүнд тулгуурлан дэвшүүлж буй бодлогын зөвлөмжийг авч үзэхдээ дээрх сул талыг харгалзан үзэх шаардлагатай болохыг сануулж байна.

- **Баримт бичгийн ерөнхий бүтэц буюу “агуулгын зураглал”**

Удиртгал хэсэгт нийтлэгээр багтаадаг хамгийн эцсийн элемент бол баримт бичиг ямар зохион байгуулалттайг тоймлон харуулдаг “агуулгын зураглал” юм. Энэ хэсэг нь урт, магадгүй нэлээд ээдрээтэй агуулгатай бодлогын баримт бичгийг уншихад уншигчдыг бэлдэх үүрэгтэй. Хоёрдугаар жишээний Удиртгал хэсгийн сүүлийн догол мөрт зохиогч баримт бичигтээ авч үзсэн гурван үндсэн асуудлыг тодорхой нэрлээд, шинжилж буй бодлогын асуудлын гол фокус болон бүрдэл хэсгүүдийг уншигчдад ойлгомжтой хүргэх үүднээс асуудлуудыг дугаарласан байна (энэ нь мөн 5.7.1-д нарийвчлан танилцуулах Шинжилгээний хамрах хүрээг танилцуулах ажлыг эхлүүлж байгаа юм).

Баримт бичгийн зохион байгуулалтыг тоймлон танилцуулаарай.

Бичих явцдаа ашиглах хяналтын хуудас

Бодлогын баримт бичгийн Удиртгал хэсгийнхээ үр нөлөөг улам сайжруулах зорилгоор дараах асуултуудыг ашиглаж болно:

- Иж бүрэн Удиртгал хэсгийн бүх элемент (бодлогын асуудлын нөхцөл байдал болон томъёолол, Зорилгын тодорхойлолт, арга зүй, сул талууд, “агуулгын зураглал”)-ийг та багтаасан уу?
- Бодлогын орчин нөхцлийн тайлбар хэсэг товч, тодорхой асуудалдаа төвлөрч чадсан байна уу?
- Бодлогын асуудлын тулгамдсан байдал, мөн чанарыг та тодорхой, ойлгомжтой тайлбарлаж чадсан уу?
- Бодлогын баримт бичгийн зориулалтыг тодорхой гаргаж бичсэн байна уу?
- Судалгааны арга зүйг тайлбарлахын зэрэгцээ судалгааны хамрах хүрээтэй холбоотой сул талуудыг дурьдсан уу?
- Баримт бичгийнхээ зохион байгуулалтыг ойлгомжтой тайлбарлаж бичсэн үү?

5.6. Асуудлын тодорхойлолт

Асуудлын тодорхойлолт хэсэг нь тулгамдсан асуудал байна гэсэн байр суурийг илэрхийлж өгнө.

Удиртгалыг авч үзсэний дараа бид бичвэрийн үндсэн хэсгийн эхний бүрдэл болох Асуудлын тодорхойлолт руу шилжиж байна. Бодлогын баримт бичгийн энэ бүрдэл хэсэг болон бодлогын мөчлөг дэх асуудлыг тодорхойлох үе шатны хоорондын уялдаанаас (3.1-д авч үзсэн) үзэхэд дараах дөрвөн зүйлээр Асуудлын тодорхойлолт хэсгийг тайлбарлаж болох юм.

- *Асуудлын тодорхойлолт нь бодлогын баримт бичгийн фокус болж байгаа асуудлын мөн чанарыг тодорхойлж, томъёолж, нарийвчлан тайлбарладаг.*

Асуудлын мөн чанарын талаар нарийвчилсан мэдээллийг дэлгэрэнгүй тайлбарладаг Асуудлын тодорхойлолт хэсэг нь авч үзэж буй асуудалд холбоотой оролцогч талууд, илрэх янз бүрийн нөхцөл байдал, учир шалтгаанууд, бэрхшээл, санал зөрөлдөөн, ашиг сонирхол болон үнэт зүйлс, үүрэг роль болон хариуцлага, үр дүн ба үр нөлөө зэрэг асуудлын олон талт байдлыг гаргасан тайлбарыг агуулдаг.

- *Асуудлын тодорхойлолт хэсэг нь судалгааны фокус болж буй энэ асуудлаар төр, засгийн зүгээс арга хэмжээ авах зайлшгүй шаардлага байгаад уншигчийг ятгаж итгүүлэх ёстой.*

Төрийн бодлогын дээд зэргээр улс төржсөн орчин нөхцөлд хэн нэгэн хүний дэвшүүлж буй асуудал нь үнэхээр бодитой оршиж буй бэрхшээл, асуудал мөн гэдэгтэй санал нийлэхгүй олон хүн гарна. Иймд Асуудлын тодорхойлолт хэсэгт тайлбар болон баримтат мэдээллийг өргөнөөр ашиглаж болох ч энэ хэсэг нь төр, засгийн зүгээс арга хэмжээ авч байж шийдэх шаардлагатай асуудал мөн болохыг батлах маргашгүй, иж бүрэн үндэслэл болох ёстой.

- *Асуудлын тодорхойлолт нь ерөнхий нөхцөл байдлыг тайлбарлах бус харин бодлогын асуудлыг нөхцөл байдал дотор нь “байрлуулан” дүрслэх ёстой.*

Бодлогын баримт бичгийн энэ хэсэг нь ерөнхий нөхцөл байдлыг дүрслээд, дараа нь асуудлаа тайлбарлах биш харин шууд л асуудлыг өнгөрсөн болон одоогийн орчин нөхцөлд нь авч үзсэн зорилтот тайлбар байх ёстой. Жишээлбэл, “Молдав Улс ... онд байгуулагдсан” гэж

эхлэхийн оронд “Молдав Улсад арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтын эсрэг анхны иж бүрэн хууль тогтоомжийг... оноос хэрэгжүүлж эхэлсэн” гэж эхлэх нь илүү оновчтой, зорилтот арга хандлага болох юм. Харин ерөнхий утгатай мэдээлэл өгөх эхний арга нь асуудалд төвлөрүүлэлгүй саармагжуулж, хэрэгцээгүй олон зүйл нуршихад хүргэдэг.

- *Асуудлын тодорхойлолт нь дараа танилцуулах бодлогын хувилбаруудын иж бүрэн танилцуулгыг дотор нь байрлуулсан авч үзэх хүрээ хязгааруудыг тогтоож өгөх ёстой.*

Асуудлын тодорхойлолт бол баримт бичгээр авч үзэх асуудлын мөн чанарыг нарийвчлан тайлбарласан хэсэг юм. Иймд энэ хэсэг нь дараа танилцуулах бодлогын хувилбаруудын нарийвчилсан тайлбарын тулгуур, бат бөх суурийг бүрдүүлж чадахуйц хэмжээнд цогц байх ёстой.

Дараах хоёр дэд хэсэгт асуудлын сайн тодорхойлолт бичихэд тус болох бүтцийн болон бичвэрийн бүрдэл хэсгүүдийг нарийвчлан авч үзнэ. Эдгээр нь бүгд нийлж байж хамтдаа асуудлын сайн тодорхойлолтыг бүтээнэ гэдгийг бид сайн ойлгож байгаа ч тодорхой тайлбарлаж, оновчтой жишээ гаргаж өгөх үүднээс тус тусд нь авч үзэж байгаа юм.

Асуудлын тодорхойлолт нь бодлогын баримт бичигт санал болгох бодлогын хувилбаруудын суурь болдог.

5.6.1. Асуудлын тодорхойлолт боловсруулах нь: Бүтэц ба үндэслэл

Асуудлын тодорхойлолт хэсгийн бүтцийн нийтлэг шинжүүдийг мэдэж байх нь бусдыг ятгаж үнэмшүүлэх чадалтай, хүчтэй үндэслэл боловсруулахад тун хэрэгтэй бөгөөд бүтцийн эдгээр бүрдэл хэсгийг тайлбарлан шинжлэхэд дараах жишээг ашиглая.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

Жишээ 1: “Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах нь: Захиргаадлаас зах зээлд” (Бёрд, Эбель, Воллих нар, 1995) гарчигтай баримт бичгээс хэсэгчлэн авсан Асуудлын тодорхойлолт хэсгийг уншаарай. Мөн шинжилгээ хийхэд энэ баримт бичгээр авч үзэх бодлогын асуудлын фокустай танилцах хэрэгтэй бөгөөд үүний тулд Хавсралт А-аас энэ баримт бичгийн Удиртгал хэсгийг уншаарай.

Уншиж байхдаа дараах зүйлсэд анхаарлаа төвлөрүүлээрэй:

- Жишээнд авч үзсэн асуудлын янз бүрийн аспектиуд

[дараа дахин дурьдах ишлэлүүдийг дөрвөлжин хаалтад хийж дугаарлав].

Төвлөрлийг сааруулах бодлогын макро эдийн засгийн орчин

[1] Шилжилтийн эдийн засагтай улс орнууд тогтворжилт, либералчлалын асуудлыг нэгэн зэрэг анхаарч ирсэн. Төв, орон нутгийн засгийн газрын хооронд санхүүгийн эрх мэдлийг хуваарилах шинэчлэлийн бодлого нь макро эдийн засгийн нөхцөл байдал сул, ихэнхдээ төв засгийн газрын санхүүгийн байр суурь мөн суларсан хавсарсан нөхцөлд хэрэгжиж байна (Хүснэгт 1. 5). 1990 онд Унгарт орон нутгийн өөрийн удирдлагын шинэ тогтолцоо бүрдүүлж эхлэхэд төвлөрсөн төслийн алдагдал ДНБ-ий 4 хувьтай тэнцүү, инфляци 32 хувьтай байсан. 1992 онд төсвийн дутагдал ДНБ-ий 7 хувь, 1994 онд 9 хувь болж нэмэгдэн, зардлыг хязгаарлах санхүүгийн хатуу бодлогын орчинд орон нутгийн болон үндэсний хэрэгцээнүүд хоорондоо өрсөлдөх нөхцөлд ороод байлаа. ОХУ-д 1991, 1992 онуудад ДНБ-ий 15 хувиас давж байсан төсвийн алдагдал 1993 онд 8 хувийн түвшинд өндөр хэвээр байсан бөгөөд 1994 онд 10 хувиас дээш гарах тооцоо гарч, инфляци өндөр хэвээр байлаа.¹¹ Болгарын төсвийн алдагдал 1993 онд 10 хувь орчим, Албанийх үүнээс хавьгүй өндөр буюу 16 хувь байв. Румынд төсвийн алдагдал бага ч инфляци өндөр байгаа нь далд тогтворгүй байдлын илрэл бөгөөд санхүүгийн тооцоонд алдагдлыг дутуу тооцоолж байх магадлал байгааг харуулж байна.¹² Санхүүгийн энэхүү түгээмэл хүндрэл бэрхшээл нь төв болон орон нутгийн засгийн газрын хооронд санхүүгийн эрх мэдэл хуваарилах тогтолцооны дизайнд хүчтэй нөлөөлсөн юм.

[2] Хувийн хэвшлийг дэмжих өөрчлөлтүүд нь эдийн засгийг идэвхжүүлэхэд хувь нэмэр болсон ч төв засгийн газрын төсвийн орлогыг бууруулах нөлөө үзүүлсэн юм. Олон жижиг хувийн аж ахуйн нэгжүүд татвар төлөхөөс зайлсхийж, албан бус эдийн засаг татварын бодлогын хэрэгжилт, татвар бүрдүүлэлтэд хүндрэл учруулж байлаа. Улсын үйлдвэрүүд баталгаатай татварын орлогын суурь болж чадахаа больжээ. Зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд татварын шинэчлэл чухал хэрэгтэй ч цоо шинэ орчинд татвар хурааж дасахад цаг хугацаа шаардагдана. Ихэнх оронд татаас, бэлэн мөнгөний өгөөмөр хөтөлбөрүүд, аж ахуйн нэгжийг дэмжих шинэ заримдаа томоохон дэмжлэгүүд, түүнчлэн аж ахуйн нэгж, банкны шинэчлэл, мөнгөн хуримтлалыг нэмэгдүүлэх арга хэмжээ нь төсвийн ачааллыг нэмэгдүүлж, төсвийн тэнцлийг улам хүндрүүлсэн хэвээр байна.

[3] Засгийн газар хоорондын санхүүгийн харилцааг шинэчлэх үйл явц нь засгийн газрын хэмжээг багасгах бодлогын хүрээнд хэрэгжиж байлаа. Унгарт төсвийн зарцуулалт 1988 онд ДНБ-ий 62 хувь байснаа 1993 онд 57 орчим хувь хүртэл буурав. Орост улсын төсөв 1980-аад оны сүүлээр ДНБ-ий 60-аас дээш хувийг эзэлж байсан бол 1993 онд 40 орчим хувь болж, 1994 он гэхэд 20 хувь болгохоор төлөвлөж байлаа. Албанид зарцуулалт 1991 онд ДНБ-ий 62 хувь байсан бол 1993 он гэхэд 44 хувь болж буурчээ (Хүснэгт 1.1).¹³

Хүснэгт 1.5. Шилжилтийн эдийн засагтай орнуудын санхүүгийн тэнцэл, 1993 он.
(Хомсдол/ илүүдлийн ДНБ-д эзлэх хувь)

Улс	Улсын төсөв	Засгийн газрын төсөв	Орон нутгийн засаг захиргаа
Албани	-16.0	-16.0	-
Болгар	-9.2	-9.2	0.0
Унгар	-6.0	-5.1	-0.3
Польш	-2.5	-2.9	0.0
Румын	-0.4	-1.5	-1.7
Орос	-7.9	-6.7	0.6
Украин	-6.2	-6.2	-

— мэдээлэл байхгүй.

Тайлбар: Улсын төсөвт агентлаг, бие даасан нэгжүүдийн төсөв орсон байх магадлалтай тул төв Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны төсвийн дүнтэй нийцэх албагүй болно.

Эх сурвалж: Дэлхийн Банк ба сонгосон зарим улс орны эх сурвалж (хүснэгтийн тайлбарыг үз).

[4] Тогтворжилтын асуудал үндэсний ба орон нутгийн хэлэлцэх асуудлын жагсаалтад тэргүүлэх байрт бичигдэж байгаад гайхах зүйлгүй билээ. Санхүүгийн алдагдыг багасгах нь ихэнх шилжилтийн орнуудын төв болон орон нутгийн аль ч түвшинд бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн суурь асуудал болж ирлээ. Өнөөгийн нөхцөл байдал нь шилжилтийн өмнөх буюу төв засгийн газрын хатуу хяналтын үр дүнд орон нутгийн макро эдийн засгийн үйл ажиллагаа ямар нэг үр дагавар багатай байсан үеэс эрс ялгаатай (Блейер, Сапаро нар 1989, Бааль, Воллих нар 1992). Хуучин тогтолцоонд орлого хуваалцах зарчмууд нь төвөөс нөөц хуваарилах үйл явцыг хялбарчлах захиргааны арга хэрэгсэл төдий байсан бөгөөд зарцуулалтыг төлөвлөсөн нормативуудаар удирдан залдаг байсан. Үүний үр дүнд орон нутгийн засгийн газрын төсөв ядаж л тайлан тэнцэл дээр хэзээд тэнцвэрээ барьдаг байсан бөгөөд шаардлагатай зохицуулалтуудыг төвлөрсөн төсвөөс шилжүүлэх энгийн арга замаар хийдэг байсан.

[5] Макро эдийн засгийн тогтворжилтын шинэ үзэл баримтлалаар санхүүгийн төвлөрлийг сааруулах бодлого нь төвлөрсөн төсвийг хоёр арга замаар багасгах боломжийг төв засгийн газарт олгоно гэж үзэх болжээ. Нэгдүгээрт, зарцуулалтын үүрэг хариуцлагыг орон нутагт шилжүүлэх замаар төвлөрсөн төсвийн алдагдлыг багасгах боломжтой юм. Хоёрдугаарт, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн шилжүүлгийг багасгах нь төв засгийн газрын зардлыг бууруулах юм.


[6] Зарцуулалтын хариуцлагыг шилжүүлэх нь. Зарим оронд нийгмийн салбарын зарцуулалт, нийгмийн даатгалын төлбөр тооцооны санхүүгийн хариуцлагыг орон нутгийн засгийн газруудад шилжүүлж байна. Жишээлбэл, Унгарт 1993 онд халамжийн зардлыг Нийгмийн хамгааллын хуулийн дагуу орон нутагт хариуцуулжээ. Украинд бас нийгмийн даатгалын төлбөр тооцоог орон нутагт хариуцдаг болжээ. Орос Улсад ДНБ-ий 6 орчим хувьтай тэнцэх нийгмийн салбарын төсвийг төв Засгийн газар 1992 онд орон нутгийн төсөвт шилжүүлсэн нь үнэн хэрэгтээ төсвийн алдагдлыг доод түвшин рүү шилжүүлсэн хэрэг болжээ. Эдийн засгийн нөхцөл байдал доройтох ч эдгээр үйлчилгээний хэрэгцээ улам нэмэгдэхээр хандлагатай байсан тул улс төрийн хувьд хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй халамжийг багасгах бодлогыг орон нутгийн засаг захиргаанд хариуцахаар тооцоолсон бололтой. Мөн Орос Улсад 1993 онд үндэсний болон салбар хоорондын хөрөнгө оруулалтын (тээвэр г.м.) хариуцлагыг орон нутагт шилжүүлсэн байна.

[7] Орон нутгийн засаг захиргаанд зарим хөрөнгийг шилжүүлэхдээ мөн л төсвийн шалтгаанаар хийсэн бололтой. Шилжүүлсэн зарим хөрөнгө, ялангуяа орон сууц, зарим аж ахуйн нэгжүүдийн засвар, урсгал зардал нь ихээхэн дарамт болж, түрээсийн орлого (Оросын Холбооны Улсад 1928 оноос хойш 1993 онд л анх удаа шинэчлэн тогтоосон) нь зардлынхаа өчүүхэн хэсгийг ч нөхөж чадахгүй байсныг харгалзах юм бол үнэн хэрэгтээ хөрөнгө гэхээсээ илүү ачаа болсон юм (Альм, Баклей нар, 1994).

Асуудлын тодорхойлолт нь өнгөрсөн ба өнөөгийн нөхцөл байдлыг авч үздэг нь жишээнүүдээс харагдаж байна. Бодлогын баримт бичгийн энэ бүрдэл хэсэг нь судалж буй асуудлын түүхэн нөхцөл байдал, асуудлын мөн чанарыг өнөөгийн бодлогын орчинд авч үздэг

Асуудлын тодорхойлолт нь тухайн асуудлын өнгөрсөн болон өнөөг авч үздэг.

ажээ. Жишээлбэл, нэгдүгээр догол мөрт тус бүс нутгийн улс орнуудын макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг өнгөрсөн үеэс өнөөг хүртэлх (энэ тохиолдолд 1995 он) хугацааг хамруулсан тойм байдлаар үзүүлжээ. Өнгөрсөн болон өнөөгийн орчин нөхцлийн тухай цааш нь мөн хоёр ба тав дахь догол мөрт өгүүлсэн байна. Асуудлыг шийдэх зорилгоор одоо хэрэгжүүлж буй бодлогын тайлбарыг “Зарцуулалтын хариуцлагыг шилжүүлэх нь” гэсэн дэд хэсэгт ([6] ба [7]) багтаажээ. Энэ жишээнээс харахад, мөн энэ бүрдэл хэсгийн зориулалтыг санах юм бол Асуудлын тодорхойлолт нь дараах хоёр хэсэгтэй байна:



Асуудлын тодорхойлолтын энэ хоёр хэсгийг доор нарийвчлан тайлбарлалаа.

- *Асуудлын суурь нөхцөл байдал*

Энэ бүрдэл хэсэг нь нийтлэгээр тухайн асуудлын түүхийг харуулдаг бөгөөд үүнд асуудлын учир шалтгаан, үүнд өртсөн бүлэг(үүд), асуудлын хууль зүй, улс төр, эдийн засгийн болон нийгмийн өрнөл, асуудлыг шийдэх зорилгоор урьд өмнө нь хэрэгжүүлж байсан бодлого, тэдгээрийн үр дүнг багтаана.

- *Асуудлын өнөөгийн орчин нөхцөл*

Энэ бүрдэл хэсэг нь асуудлын өнөөгийн байр байдлыг гаргаж өгдөг бөгөөд үүнд өнөөгийн эрх зүй, нийгэм, эдийн засаг, улс төрийн орчин нөхцөл, асуудлын өнөөгийн цар хүрээ, нөлөөнд нь өртөж буй бүлэг(үүд), асуудлыг шийдэх зорилгоор одоо хэрэгжүүлж буй бодлогууд, хэрэглэж буй арга механизмуудын ололт, дутагдлыг хамарна.

Ийм ерөнхий удирдамж тайлбар тустай ч гэлээ асуудлын цогц бөгөөд оновчтой тодорхойлолт бичиж боловсруулахдаа зохиогчдын баримталдаг арга хандлагуудыг бодитойгоор тайбарлан харуулахад хангалттай мэдээлэл өгч чадахгүй юм. Дараах шинжилгээ нь хэрэглэж болох арга хандлагууд судалж эхлэхэд танд тус болно.

Хэвлэгдэн гарсан бодлогын баримт бичгийн шинжилгээ

Бодлогын баримт бичгийн Нэг ба Хоёрдугаар жишээний товъёоос авсан хэсгийг уншина уу. Эдгээр нь баримт бичгүүдийн Асуудлын тодорхойлолт хэсэг юм. Мөн шинжилгээ хийхэд энэ баримт бичгээр авч үзэх бодлогын асуудлын фокустай танилцах хэрэгтэй бөгөөд үүний тулд Хавсралт А-аас энэ баримт бичгийн Удиртгал хэсгийг уншаарай.

Уншиж байхдаа дараах зүйлсэд анхаарлаа төвлөрүүлээрэй:

- асуудлын тодорхойлолт тус бүрт хамруулсан асуудлуудыг,
- Нэгдүгээр жишээ нь Хоёрдугаар жишээнээс илүү олон асуудлыг авч үзэж байгаагийн шалтгаан.

Жишээ 1:

“Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах нь: Захиргаадлаас зах зээлд” (Бёрд, Эбель, Воллих нар, 1995) гарчигтай баримт бичгийн товъёоос хэсэгчилж авав.

Орон нутгийн санхүү яагаад чухал вэ?

Системийн уялдаа холбоо

Илүү өргөн хүрээтэйгээр авч үзэх хэрэгцээ

Төвлөрлийг сааруулах сүүлийн үеийн хандлага

Өөрчлөлт хийх цаг болжээ

Засгийн газрыг шинээр зохион байгуулах нь

Засгийн газрын бүтэц

Дунд түвшинг бий болгох хэрэгтэй юу?

Засгийн газрын нэгжүүдийн хэмжээ зохистой байна уу?

Засгийн газрын үүрэг ролийн өөрчлөлт: Эзнээс үйлчлэгч болох нь

Засгийн газрын түвшин хоорондын санхүүгийн харилцааны макро эдийн засгийн асуудлууд

Засгийн газрын түвшин хоорондын харилцаа болон татварын шинэчлэлийг зэрэг хэрэгжүүлэх нь

Төвлөрлийг сааруулах үйл явцын макро эдийн засгийн орчин

Төсвийн үр дүнг сайжруулах нь

Хувьчлал ба орон нутгийн засаг захиргаа

Зардлын хуваарилалт

Жишээ 2:

“Орон нутгийн түвшний төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл явц дахь нээлттэй өрсөлдөөн, ил тод байдал, төвийг сахисан байр суурь” (Баар, 2001) гарчигтай баримт бичгийн товъёоос хэсэгчилж авав.

2. Өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг шаардсан хуулиуд

2.1 Европын Холбооны заавар, удирдамж

2.2 Европын Холбооны сүүлийн үеийн мэдээллийн хуудас

2.3 ТЗЕ-ын орнуудын худалдан авах үйл ажиллагааны хуулиуд

3. Гэрээний олон нийтэд хүртээмжтэй байдал

3.1 Ил тод байдал

3.2 Гэрээг боловсруулахад олон нийтийн оролцоо, ил тод байдал

4. Сонирхлын зөрчлийн хууль

4.1. Сонирхлын зөрчлийн хуулиуд, ТЗЕ-ын орнуудын хуулиуд

4.2. Европын холбоо, АНУ-ын Сонирхлын зөрчлийн хуулиуд

Асуудлын тодорхойлолтыг бичихдээ зохиогчдын ашигладаг аргуудыг нэгтгэх, ерөнхийлөн дүгнэх боломжгүй юм. Гэхдээ бидний ашиглаж байгаа жишээ материалуудад шинжилгээ хийсний үндсэн дээр дараах зөвлөгөөг өгч болох байна:

- *Асуудлын тодорхойлолтод багтаах санаа, сэдэв, асуудлын тоо, хамрах хүрээ нь тухайн асуудлын мөн чанар, баримт бичгийн зорилгоос хамаарна.*

Асуудлынхаа тодорхойлолтыг баримт бичгийн сэдэв, зорилго, уншигчдад нийцүүлэн боловсруулаарай.

Шинжилгээндээ бидний ашиглаж буй хоёр жишээ дээрх дүгнэлтийг тодорхой баталж байна. Хоёрдугаар жишээ нь зөвхөн хууль эрх зүйн хүрээг авч үзэж байгаа бол Нэгдүгээр жишээ нь хамаагүй өргөн хүрээтэй асуудлыг хөндөж байгаа тул асуудлын тодорхойлолт нь зөвхөн эрх зүйн орчноор хязгаарлагдахгүй мөн захиргааны арга механизм, эдийн засгийн орчин нөхцөл, төв болон

орон нутгийн засаг захиргааны бүтэц зэрэг сэдвийг багтаажээ.

- *Асуудлын тодорхойлолтоороо уншигчдад итгэл, үнэмшил төрүүлэхийн тулд зохиогчид бичлэгийн янз бүрийн арга барил хэрэглэдэг.*

Зарим тохиолдолд асуудлын өрнөж ирсэн түүхийн талаарх суурь мэдээллийг асуудлын өнөөгийн орчин нөхцөл дэх тодорхойлолтоос салган, хоёр салангид дэд хэсэг болгож бичих нь илүү тохиромжтой байдаг. Өөрөөр хэлбэл, асуудлын тодорхойлолт нь хоёр тусдаа дэд хэсгээс бүрдэх юм. Харин бидний ашиглаж буй хоёр жишээний хувьд зохиогчид нь асуудлын суурь буюу түүхэн нөхцөл байдал болон асуудлын өнөөгийн орчин нөхцлийг нэг дэд хэсэгт багтаан танилцуулах нь тэдний баримт бичгийн хувьд илүү зохимжтой гэж үзжээ. Мөн онцлон тэмдэглэвэл зохих өөр нэг зүйл бол хоёр баримт бичгийн зохиогчид эдгээр хоёр дэд хэсэгт асуудлын тодорхойлолтоо оруулаад зогсохгүй энэ асуудлаар өөрсдийн санал болгож буй бодлогын хувилбаруудаа ч бас танилцуулж байж дараа дараагийн хэсэг рүү шилжиж байгаа явдал юм. Үүнийг Нэгдүгээр жишээний товъёгд хэсэгчлэн авсан доорх ишлэлээс харж болно:

Засгийн газрын түвшин хоорондын санхүүгийн харилцааны макро эдийн засгийн асуудлууд

- Засгийн газрын түвшин хоорондын харилцаа болон татварын шинэчлэлийг зэрэг хэрэгжүүлэх нь
- Төвлөрлийг сааруулах үйл явцын макро эдийн засгийн орчин
- Төсвийн үр дүнг сайжруулах нь

Асуудлын макро эдийн засгийн талыг авч үзэхдээ зохиогч эхний хоёр дэд хэсэгт асуудлын тодорхойлолтыг өгөөд, гуравдахь дэд хэсэгт бодлогын хувилбаруудыг тайлбарласан байна.

Асуудлын тодорхойлолтыг төлөвлөөд, бичиж боловсруулахдаа та баримт бичгийнхээ сэдэв, зориулалт, уншигчдад хамгийн нийцтэй арга хандлагыг олохын тулд сайтар бодож тунгаах хэрэгтэй болсон нь эдгээр жишээнээс тодорхой харагдаж байна.

Бичих явцдаа ашиглах хяналтын хуудас

Асуудлын тодорхойлолтыг төлөвлөж, бичиж байхдаа дараах асуултуудад анхаарлаа хандуулаарай.

- Асуудлын тодорхойлолтыг боловсруулах нь

Асуудал өрнөж ирсэн түүхтэй холбоотой суурь мэдээлэл

- Асуудал хэзээ, хэрхэн анх гарч ирсэн бэ?
- Ямар ямар шалтгаанаар үүссэн бэ?
- Асуудал нь түүхэн, эрх зүйн, улс төрийн, нийгмийн, эдийн засгийн ямар нөхцөл байдалтай явж ирсэн бэ?
- Асуудал хэрхэн олон нийтийн анхаарлыг татсан бэ?
- Энэ асуудалд хэн хэн өртсөн бэ?
- Асуудлыг шийдэх зорилгоор урьд өмнө нь ямар бодлогууд хэрэгжүүлсэн бэ?
- Эдгээр бодлогын үр дүн юу байв?
- Асуудлын өнөөгийн орчин нөхцөл
- Асуудлын өнөөгийн эрх зүй, нийгэм, эдийн засаг, улс төрийн орчин нөхцөл, тэдгээрийн үр дагавар юу вэ?

Асуудлын өнөөгийн хамарч буй хүрээ ямар байна вэ?

- Асуудлыг шийдэхийн тулд одоо ямар бодлогууд хэрэгжиж байна вэ?
- Асуудлын талаар, мөн үүнийг шийдэх арга замын тухайд ялгаатай ямар санаа бодол, байр сууриуд байна вэ?
- Өнөөгийн эдгээр бодлогын юу нь амжилттай, юу нь амжилгүй болж байгаа вэ?
- Өнөөгийн арга хандлагын юу нь буруу байна вэ?

Асуудлын тодорхойлолтыг зохион байгуулах нь

- Асуудлыг бүрэн дүүрэн дэлгэж, уншигчийг ятган, итгэл төрүүлэхүйц дүр зураг гаргахын тулд та Асуудлын тодорхойлолт хэсэгтээ асуудлын ямар талуудыг багтааж бичих вэ?
- Энэ хэсгийг аль болох ойлгомжтой, уншихад хялбар болгохын тулд та ямар бүтэц зохион байгуулалтыг сонгох вэ?

5.6.2. Асуудлын тодорхойлолтыг боловсруулах нь: Бичвэр ба үндэслэл

Асуудлын сайн тодорхойлолт боловсруулахын тулд юуг багтаах, тэдгээрийг хэрхэн логиктой зохион байгуулах тухай сайтар мэдэхийн зэрэгцээ мөн уншигчийг ятгаж, итгэл төрүүлэхүйц үндэслэл боловсруулах тухай хэвшсэн арга хандлагуудын талаар ул суурьтай ойлголттой болсон байх хэрэгтэй. Хэвшсэн эдгээр аргын талаар мэдээлэл өгөх зорилготой энэ дэд бүлэг нь дотоод уялдаа холбоос, үр нөлөөтэй сайн үндэслэл боловсруулах, догол мөр, анхдагч ба хоёрдогч мэдээллийн эх сурвалж ашиглах зэрэг үндсэн ойлголтуудыг авч үзэх болно.

Энэ дэд бүлгийн шинжилгээ, тайлбаруудад “Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах нь: Захиргаадлаас зах зээлд” (Бёрд, Эбель, Воллих нар, 1995) гарчигтай Нэгдүгээр жишээний 43 дугаар нүүрэн дэх хэсэгчилсэн ишлэлийг дахин ашиглах юм. Энэ ишлэлийн догол мөрүүдийг дугаарласан тул одоо энэ дугаараар нь хөөж шаардлагатай догол мөрийг хялбар олох боломжтой.

- *Ятган үнэмшүүлэх чадалтайн дээр ойлгоход хялбар байх шаардлагуудыг хангасан дотоод холбоос сайтай үндэслэл боловсруулах нь*

Сайн үндэслэлийн хамгийн гол нэг шинж нь дотоод уялдаа холбоос юм. Энэ нь үндэслэлийн хэсгүүд хоорондоо илт, тодорхой холбоосоор холбогдож, үүний үр дүнд үндэслэлийн гол санаа бүхлээрээ зурайн харагдаж байх зарчим юм. Дараах шинжилгээгээр бид дотоод уялдаа холбоосын асуудлыг жишээнд тулгуурлан авч үзнэ.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

Нэгдүгээр жишээ буюу “Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах нь: Захиргаадлаас зах зээлд” (Бёрд, Эбель, Воллих нар, 1995) гарчигтай бодлогын баримт бичгийн Асуудлын тодорхойлолт (57 дугаар нүүр), Товьёг (61 дүгээр нүүр) хэсгээс авсан хэсэгчилсэн ишлэлийг судална уу.

Уншиж байхдаа дараах асуудалд анхаарлаа хандуулна уу:

- Энэ жишээнд уялдаа холбоосыг хэрхэн үүсгэж байна вэ?

Жишээ баримт бичгээр авч үзэх бодлогын асуудлын фокустай танилцах нь танд шинжилгээ хийхэд тус болох тул хэрвээ уншиж амжаагүй байгаа бол Хавсралт А-д өгсөн баримт бичгийн Үдиртгал хэсгийг уншаарай.

Жишээ баримт бичгийн товъёг хэсгээс харахад, Асуудлын тодорхойлолт бол хоорондоо харилцан хамааралтай үндсэн болон дэд хэсгүүдээс бүрдсэн нилээд урт, ээдрээтэй үндэслэл юм. Уншигчдад ойлгомжтой, хялбар болгохын тулд эдгээр олон хэсгийг нэгэн бүхэллэг хэсэг болгон холбохын төлөө та нэлээд хичээж ажиллах хэрэгтэй болно. Эдгээр үндсэн болон дэд бүлгүүдийг сайн зохион байгуулалт, утга санаагаа сайн илэрхийлсэн гарчиг, ойлгомжтой дугаарлалтаар холбож өгөхийн хажуугаар бас бичвэрийн хувьд логик холбоосоор холбож уялдаатай болгох шаардлагатай. Жишээлбэл, “Засгийн газрын түвшин хоорондын санхүүгийн харилцааны макро эдийн засгийн асуудлууд” дэд бүлгийг зохиогч дараах догол мөрөөр эхлүүлэхээр шийджээ:

Төв, орон нутгийн засгийн газрын хооронд санхүүгийн эрх мэдлийг хуваарилах шинэчлэлийн бодлого нь макро эдийн засгийн нөхцөл байдал сул, ихэнхдээ төв засгийн газрын санхүүгийн байр суурь мөн суларсан хавсарсан нөхцөлд хэрэгжиж байна. Одоо ид анхаарал татаж буй тогтворжилтын асуудал нь засгийн газрын түвшин хоорондын санхүүгийн харилцааны даацтай, урт хугацааны бүтэц дизайнд онцын шаардлагагүй хүчтэй нөлөө үзүүлэх эрсдэл харагдаж байна.

Догол мөрийг нээж буй энэ хэсэг нь бичвэрийн энэ дэд хэсгийн фокусыг танилцуулж, энэхүү дэд хэсэг нь баримт бичгийн ерөнхий үндэслэлтэй хэрхэн уялдаж байгааг тайлбарлажээ. Ер нь зохиогчид бодлогын баримт бичгийн дотоод логик холбоосыг харуулах зорилгоор дэд хэсгийг иймэрхүү байдлаар нээх нь элбэг байдаг.

Дэд хэсгүүдийг баримт бичгийн ерөнхий үндэслэлтэй уялдуулахын зэрэгцээ зохиогч мөн дэд хэсэг бүрийн доторх уялдаа холбоосыг илэрхий гаргаж өгөх ёстой. Жишээ болгож авсан асуудлын тодорхойлолтод “Шилжилтийн эдийн засгууд тогтворжилт, либералчлалын асуудлыг нэгэн зэрэг анхаарч ирсэн” гэсэн нээлтийн өгүүлбэр нь “Төвлөрлийг сааруулах бодлогын макро эдийн засгийн орчин” нэртэй дэд бүлгийн үндэслэлийн гол санаа болж байгаа юм. Улмаар энэ дэд хэсгийн бусад бүх элемент нь энэ өгүүлбэрээр илэрхийлсэн санааг хөгжүүлэн дэлгэхэд чиглэж байгаа бөгөөд энэ дэд хэсэг тухайн асуудлыг шийдэх зорилгоор одоо хэрэгжүүлж байгаа “зарцуулалтын эрх мэдлийг шилжүүлэх”, “засгийн газрын түвшин хоорондын шилжүүлгийг багасгах” зэрэг бодлогыг нэрлэснээр төгсөж байна. Энэ төгсгөл нь эдгээр бодлогыг нарийвчлан авч үзэх дараагийн хоёр дэд хэсэгтэй шууд холбоос үүсгэж өгч байна. Баримт бичгийн үндсэн болон дэд бүлэг, хэсгийн түвшинд ийм илэрхий уялдаа холбоосыг оруулж өгч чадвал Асуудлын

тодорхойлолтдоо таны гаргаж тавьсан үндэслэлийг уншигчид төвөггүй ойлгох болно.

- *Дэд хэсэгт үндэслэлийн бүрдэл элемент бүрийг уялдаа холбоостой, фокус сайтай боловсруулах нь*

Үндэслэл нь мэдэгдэл, дэмжлэг, баталгаанаас бүрддэг.

Үндэслэлийнхээ бүрдэл хэсэг нэг бүрийг боловсруулахдаа та философич Стефен Тулмины (Карбахын 1987 оны бүтээлд ишлэснээр) санал болгосон үндэслэлийн нэгэн загварыг ашиглаж болно. Тулмины үзэж байгаагаар Үндэслэл бүр нь мэдэгдэл, дэмжлэг, баталгаа гэсэн гурван суурь элементээс бүрддэг бөгөөд эдгээрийг дараах байдлаар тайлбарлаж болно:

- Мэдэгдэл нь таны байр суурь/ үндэслэлийг илэрхийлсэн томъёолол юм.
- Дэмжлэг нь мэдэгдлээ батлах зорилгоор таны ашиглаж буй нотолгоо баримт юм.
- Баталгаа нь мэдэгдэл болон дэмжлэгийн хоорондын холбоосыг тайлбарласан тайлбар юм. Энэхүү холбоос уншигчдад илт ойлгомжтой, илэрхий гэж үзсэн тохиолдолд зохиогч энэ элементийг шууд шулуухан тайлбарлалгүй, тойруу утгаар илэрхийлэх нь бий.

Нэгдүгээр жишээний 6 дахь догол мөрөөс эдгээр гурван элементийг маш тодорхой харж болно:

<p><i>Зарцуулалтын хариуцлагыг шилжүүлэх нь.</i> Зарим оронд нийгмийн салбарын зарцуулалт, нийгмийн даатгалын төлбөр тооцооны санхүүгийн хариуцлагыг орон нутгийн засгийн газруудад шилжүүлж байна. Жишээлбэл, Унгарт 1993 онд халамжийн зардлыг Нийгмийн хамгааллын хуулийн дагуу орон нутагт хариуцуулжээ. Украинд бас нийгмийн даатгалын төлбөр тооцоог орон нутаг хариуцдаг болжээ. Орос Улсад ДНБ-ий 6 орчим хувьтай тэнцэх нийгмийн салбарын төсвийг төв Засгийн газар 1992 онд орон нутгийн төсөвт шилжүүлсэн нь үнэн хэрэгтээ төсвийн алдагдлыг доод түвшин рүү шижүүлсэн хэрэг болжээ. Эдийн засгийн нөхцөл байдал доройтох ч эдгээр үйлчилгээний хэрэгцээ улам нэмэгдэхээр хандлагатай байсан тул улс төрийн хувьд хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй халамжийг багасгах бодлогыг орон нутгийн засаг захиргаанд хариуцуулахаар тооцоолсон бололтой. Мөн Орос Улсад 1993 онд үндэсний болон салбар хоорондын хөрөнгө оруулалтын (тээвэр г.м.) хариуцлагыг орон нутагт шилжүүлсэн байна.</p>	Мэдэгдэл
	Дэмжлэг
	Баталгаа

Үндэслэлийн гурван суурь элемент нь таны бодлогын баримт бичгийн Асуудлын тодорхойлолт хэсгийг бүрдүүлж өгөх үндэслэлүүдийг оновчтой болгох, улмаар нийт баримт бичгийн тань ерөнхий үндэслэлийг үнэмшилтэй, чанартай болгоход чухал үүрэгтэй тул та эдгээрийн төлөвлөлт, боловсруулалтад ач холбогдол өгч хандах хэрэгтэй.

- *Догол мөрийг оновчтой зохион байгуулах нь үндэслэлээ оновчтой боловсруулах, улмаар уншигчдад үндэслэлийн логикийг ойлгомжтой хүргэхэд тань тус болно.*

Догол мөр бол бичвэрийн логик болон биет хуваагдлын илэрхийлэл юм. Тиймээс догол мөр нь танд үндэслэлээ зохион байгуулахад туслаад зогсохгүй уншигчдад ч мөн таны үндэслэлийн бүрдэл хэсэг бүрийг хялбархан ойлгон, холбоос шилжилтийг нь дагахад тусалдаг. Мөн догол мөрүүдийн оновчтой хуваагдалт нь урт бөгөөд ээдрээтэй бодлогын баримт бичгийн агуулгын талаар ерөнхий ойлголт авах зорилгоор гүйлгэн уншихад дэм болдог.

Оновчтой догол мөрүүд нь таны үндэслэлийн логик нэгжүүд болж өгнө.

Догол мөр бүхэн сэдэв өгүүлбэртээ туссан нэг л үндэслэлийг нээж өгдөг. Сэдэв өгүүлбэр гэдэг нь тухайн догол мөрт илэрхийлэгдэх байр суурь/үзэл баримтлалын томъёолол бөгөөд энэ нь Тулмины дээр өгүүлсэн томъёоллоор бол мэдэгдэл юм. Үүнийг тодорхой харуулж буй тохиолдол бол Нэгдүгээр жишээний эхний догол мөрийн сэдэв өгүүлбэр болох “Төв, орон нутгийн засгийн газрын хооронд санхүүгийн эрх мэдлийг хуваарилах шинэчлэлийн бодлого нь ...” гэж эхэлж буй өгүүлбэр юм. Аль нэг догол мөрийн сэдэв өгүүлбэр нь шинэ үндэслэлийг эхлүүлэх, эсвэл баримт бичгийн ерөнхий үндэслэлийн тодорхой нэг санааг дэлгэн тайлбарлах зорилготой байж болно. Нэмж хэлэхэд, догол мөрөөр бичвэрийн логик хуваагдалтыг хэрхэн оновчтой илэрхийлэхийг зохиогч, уншигчдад ойлгуулж өгөх хамгийн гол, түлхүүр ойлголт бол нэг догол мөрөөр нэг л үндэслэлийг нээх зарчим юм.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

Нэгдүгээр жишээний “Төвлөрлийг сааруулах бодлогын макро эдийн засгийн орчин” сэдэвт дэд бүлгийг 58 дугаар нүүрнээс уншина уу.

Унших явцдаа дараах асуудалд анхаарлаа төвлөрүүлнэ үү:

- Догол мөр болгоны сэдэв өгүүлбэрийн байршил

Шаардлагатай бол, энэхүү үндэслэлийн контекстыг ойлгохын тулд энэ хэсгийн эхний дүн шинжилгээг гүйцэтгэхийг зөвлөж байна.

Бидний авч үзэж буй жишээний эхний догол мөрөөс бусад тохиолдолд догол мөрийн эхний өгүүлбэр нь сэдэв өгүүлбэр байна. Догол мөр болгож хуваах нь нарийн төвөгтэй үндэслэлийг урт тайлбараар хүргэх хэрэгцээ гарсан тохиолдолд уншигчдад аль болох амар хялбар ойлгуулах үүднээс зохиогчдийн нийтлэгээр ашигладаг арга хандлага юм.

Оновчтой сайн догол мөрүүдийг өөр хооронд нь уялдаатай төлөвлөн боловсруулсан байдаг.

Догол мөрүүдийг оновчтой зохион байгуулахын хоёрдахь түлхүүр нөхцөл бол уялдаа холбоос юм. Догол мөрийн түвшинд бол доторх өгүүлбэрүүдийг нь илэрхий, тод уяж холбох явдал юм. Ийм уялдаа холбоосыг бий болгоход хэрэглэдэг нийтлэг хэд хэдэн арга байдаг:

- Түлхүүр үгүүдийг давтан хэрэглэх;
- Параллель бүтэц буюу төстэй хэллэг, өгүүлбэрийн бүтцүүдийг ашиглах;
- Шилжилт хийж буйг илэрхийлсэн дараа нь, жишээлбэл, түүнчлэн, мөн, хэдийгээр зэрэг холбох үгс ашиглах юм.

Нэгдүгээр жишээний 6 дугаар догол мөрт эдгээрийг хэрхэн ашигласныг харж болно:

[6] Зарцуулалтын хариуцлагыг шилжүүлэх нь. Зарим оронд нийгмийн салбарын зарцуулалт, нийгмийн даатгалын төлбөр тооцооны санхүүгийн хариуцлагыг орон нутгийн засгийн газруудад шилжүүлж байна. Жишээлбэл, Унгарт 1993 онд халамжийн зардлыг Нийгмийн хамгааллын хуулийн дагуу орон нутагт хариуцуулжээ. Украинд бас нийгмийн даатгалын төлбөр тооцоог орон нутагт хариуцдаг болжээ. Орос Улсад ДНБ-ий 6 орчим хувьтай тэнцэх нийгмийн салбарын төсвийг төв Засгийн газар 1992 онд орон нутгийн төсөвт шилжүүлсэн нь үнэн хэрэгтэй төсвийн алдагдлыг доод түвшин рүү шилжүүлсэн хэрэг болжээ. Эдийн засгийн нөхцөл байдал доройтох ч эдгээр үйлчилгээний хэрэгцээ улам нэмэгдэхээр хандлагатай байсан тул улс төрийн хувьд хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй халамжийг багасгах бодлогыг орон нутгийн засаг захиргаанд хариуцуулахаар тооцоолсон бололтой. Мөн Орос Улсад 1993 онд үндэсний болон салбар хоорондын хөрөнгө оруулалтын (тээвэр г.м.) хариуцлагыг орон нутагт шилжүүлсэн байна.

Хоёр, гурав, дөрөв дэх өгүүлбэрт зохиогч тодорхой улс орны нэрийг дурьдан “энэ улсад” гэсэн параллель бүтэц ашиглаад, сүүлийн өгүүлбэрт мөн бүтцээ давтжээ. Цаашилбал, хоёр дахь өгүүлбэрт “жишээлбэл”, гурав дахь өгүүлбэрт “бас” гэсэн шилжилт хийж буйг илэрхийлсэн үгнүүдийг ашиглан уялдаа холбоосыг улам бататгасан байна. Догол мөрүүдийн уялдаа холбоосыг сайтар бодож төлөвлөх, ингэснээрээ Асуудлын тодорхойлолт хэсгийнхээ логикийн болон биет хуваагдлыг тодорхой гаргаж харуулах нь бодлогын баримт бичгээрээ танилцуулж

буй үндэслэл, байр сууриа уншигчдад илүү ойлгомжтой хүргэхэд чухал ач холбогдолтой юм.

- *Итгэл төрүүлэхүйц, ятгаж үнэмшүүлэх чадалтай үндэслэл боловсруулахад эх сурвалжуудыг ашиглах нь*

Оновчтой, сайн Асуудлын тодорхойлолтыг боловсруулахад хамгийн их нөлөөлөх зүйл бол олон янзын эх сурвалжаар баталж өгсөн үндэслэл юм. Бичвэртээ эх сурвалжуудаа дурьсанаар та үндэслэлийг улам баталгаажуулахын зэрэгцээ бодлогын тодорхой асуудлаар өрнөж буй яриа хэлэлцүүлэгт баримт бичгээрээ оруулж буй хувь нэмрийг тодорхойлоход туслан, байр суурийг тань дэмжиж буй үндэслэлийг гаргаж ирэхдээ ямар мэдээ, материалд тулгуурласнаа уншигчдад мэдээлж байгаа хэрэг юм. Эх сурвалжийг дурьдахдаа анхаарах шаардлагатай асуудлуудыг дараах жишээгээр авч үзье.

Сайн Асуудлын тодорхойлолт бол олон янзын эх сурвалжид суурилсан үндэслэл юм.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

58 дугаар нүүрнээс “Төвлөрлийг сааруулах бодлогын макро эдийн засгийн орчин” дэд бүлэгт эх сурвалжийг хэрхэн ашигласныг судална уу.

Уншиж байхдаа дараах асуудалд анхаарлаа хандуулна уу:

- Дэд хэсэгт дурьдагдсан эх сурвалжуудын төрөл. Энэ асуудалд хамааралтай ишлэлүүдийг Төгсгөлийн тэмдэглэл, номзүйн хэсгээс авснаа дор жагсаалаа.

Төгсгөлийн тэмдэглэлээс авсан ишлэл:

[11 ба 12 дугаар төгсгөлийн тэмдэглэлд эх сурвалж дурьдаагүй байна]

13-р төгсгөлийн тэмдэглэл: Улсын төсвийн зардлын тухай мэдээллийг Унгар, Орос ба Албанийн холбогдох яамдаас авав.

Номзүйн хэсгээс авсан ишлэл:

Alm, James, and Robert M. Buckley. 1994. “Decentralization, Privatization, and Solvency of Local Governments in Reforming Economies: The Case of Budapest.” *Environment and Planning, C: Government and Policy* 12(3): 337-47.

Bahl, Roy, and Christine I. Wallich. 1992. “Intergovernmental Fiscal Relations in China.” PRE Working Paper 863. World Bank, Policy Research Department, Washington, D.C.

Blejer, Mario I., and Gyorgy Szapary. 1989. “The Evolving Role of Fiscal Policy in Centrally Planned Economies under Reform: The Case of China.” IMF (International Monetary Fund) Working Paper WP/89/26. Washington, D.C.

- Дэд хэсэгт эх сурвалжуудын гүйцэтгэж байгаа үүрэг роль. Эдгээр эх сурвалж нь мэдэгдэл, дэмжлэг, баталгааны тухайд ямар үүрэг роль гүйцэтгэж байгаа тухай бодож үзээрэй.
- Зарим эх сурвалжийг нэрлэн дурьдсан/ шууд ишлэн авсан хэрнээ заримыг нь ингээгүй байгаагийн шалтгаан

Энэ дүн шинжилгээнд дурьдагдсан 6 асуудлыг дор дэлгэрэнгүй авч үзлээ.

- *Бичвэртээ нотолгоо болгож ашиглах эх сурвалжийн төрлийг оновчтой сонгох нь*

Нэр хүнд бүхий анхдагч болон хоёрдогч олон эх сурвалж ашиглахыг хичээ.

Дэвшүүлж буй үндэслэл тань үндэслэлтэй, найдвартай гэдэгт уншигчдыг итгүүлэхийн тулд нэр хүнд бүхий анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудаас авсан нотолгоог хангаж өгөх хэрэгтэй.¹⁰ Энэ нь тухайн асуудлаарх таны мэдлэг, ойлголтын цар хүрээ, таны гүйцэтгэсэн судалгааны мөн чанарыг харуулна.

Бодлого боловсруулах үйл явцад нийгмийн бүхий л давхаргын сонирхогч талууд оролцдог тул бодлогын баримт бичигт төрийн хууль тогтоомж, бодлогын чанартай баримт бичиг, засгийн газрын тайлан, төрийн бус болон олон улсын байгууллагын тайлан, бодлогын судалгааны тайлан, эрдэм шинжилгээний товхимол сэтгүүл, эрдэм шинжилгээний хурлын илтгэл, сонин зэрэг олон төрлийн эх сурвалжийг өргөнөөр ашигладаг. Үүнээс гадна та баримт бичигтээ анхдагч судалгааны үр дүн, өгөгдлийг ашиглаж болно. Бидний жишээ болгон шинжиж буй хэсгүүдэд анхдагч судалгаа багтаагүй бөгөөд ер нь ийм өргөн сэдэвтэй, бүс нутгийн фокустай баримт бичгийн хувьд хамгийн найдвартайн дээр олдоцтой эх сурвалж нь тухайн бүс нутгийн улс орнуудын засгийн газар, бүс нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Олон улсын валютын сан, Дэлхийн Банк зэрэг олон улсын байгууллага болж байгаад гайхах хэрэггүй биз ээ. Таны хувьд ч гэсэн судалгааны сэдэв, газарзүйн фокус, баримт материалын олдоц, уншигчид зэрэг хүчин зүйлс ашиглах эх сурвалжуудыг тань зааж чиглүүлэх болно.

- *Эх сурвалжийг үндэслэлдээ оновчтойгоор оруулж өгөх нь*

Үндэслэлээ дэмжих зорилгоор эх сурвалжуудыг ашигла.

Эх сурвалжийг ашиглахтай холбоотой анхаарах ёстой өөр нэг асуудал бол үндэслэлийг баталгаажуулахад эх сурвалжийн гүйцэтгэх үүрэг роль юм. Бидний жишээнээс харахад зохиогчийн дурьдсан эх сурвалжууд нь түүний хийж буй мэдэгдлийг дэмжсэн нотолгоо болж байгаа бөгөөд тухайлбал, гуравдахь догол мөрт зохиогчийн ашигласан

¹⁰ Анхдагч өгөгдөл нь таны өөрийн судалгаа (жишээлбэл, асуулга, ярилцлага, өгөгдөлд суурилсан загварчлал гэх мэт)-ны дүнд бий болсон мэдээлэл юм. Хоёрдогч өгөгдөл буюу мэдээлэл нь таны ажиллаж буй энэ салбарын бусад мэргэжилтэн, судлаачдын судалгаа, тайлангаас эх сурвалжтай.

бүх өгөгдөл яг ийм зорилготой байгаа юм. Та ч гэсэн үндэслэлээ боловсруулахдаа яг энэ арга хандлагыг баримтлах хэрэгтэй. Зохиогчдын хамгийн нийтлэг гаргадаг нэг алдаа бол эх сурвалжуудаа хэт томруун гаргаж, улмаар үндэслэлдээ өөрийнхөө байр суурийг байх ёстой хэмжээнд тодорхой тусгаж өгдөггүй явдал юм. Энэ нь үндэслэлийн фокус алдагдан саармагжихад хүргэдэг тул зохиогчдын анхаарах зүйлийн нэг мөн. Маш тодорхой, фокустай илэрхийлсэн байр суурь, үзэл баримтлалыг сонсохоор хүлээж байдаг бодлогын сүлжээнийхний хувьд ийм алдаа таны баримт бичгийн нэр хүндийг унагаж, ач холбогдлыг бууруулах уршигтай.

Бүх хүний мэддэг зүйл гэж үзэж болохоос бусад бүх тохиолдолд эх сурвалжуудаа нэрлэн ишлэх хэрэгтэй.

- *Үндэслэлд ашигласан хоёрдогч эх сурвалжийг ямар тохиолдолд ишлэн нэрлэхээ шийдэх нь*

Хоёрдогч эх сурвалжаас авсан мэдээлэл, өгөгдлийг бодлогын баримт бичигт ашиглах үед голдуу “Крилли (1997)” гэх маягаар эх сурвалжийг зааж өгдөг ч зарим тохиолдолд ингэх шаардлагагүй байж болно. Ерөнхийдөө, бодлого боловсруулах сүлжээний бүх гишүүний нийтлэг мэдлэг болчихсон зүйлсээс бусад тохиолдолд эх сурвалжаа нэрлэх юмуу ишлэх шаардлагатай. Бидний ашиглаж буй жишээний хувьд эхний догол мөрт дурьдсан өнөөгийн төсвийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээний тухай мэдээллийг нийтлэг мэдлэг гэж үзсэн байхад гурав дахь догол мөрт өгсөн засгийн газрын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээний тухай мэдээллийн эх сурвалжийг бүрэн хэмжээнд дурьдсан байна. Хүснэгтэд өгсөн мэдээллийн бүх эх сурвалжийг хүснэгтийн доор тодорхой нэрлэсэн байна. Мөн, дөрөв дэх догол мөрт хуучин социалист тогтолцооны тухай, эсвэл долоо дахь догол мөрт тодорхой улс орны хэрэгжүүлж буй тодорхой бодлогын тухай өгүүлсэн шиг хүн бүхний мэддэг нийтлэг зүйл биш байж болох мэдээллийг ашиглаж байгаа тохиолдолд хэвлэмэл эх сурвалжуудыг бүрэн хэмжээнд нэрлэх хэрэгтэй.

Мэдээлэл, өгөгдөл нь нийтлэг мэдлэг мөн үү, үгүй юу гэдэг нь тодорхойгүй байх явдал элбэг таардаг. Хэрэв та нийтлэг мэдлэг биш гэж үзэж болох эх сурвалжаас авсан мэдээллээ ишлэлгүй шууд авч ашиглах юм бол хүний оюуны бүтээл буюу хүний санааг хулгайлсан хэрэгт буруутгагдах болно. Энэ нь зөвхөн өөр зохиогчийн үг, өгүүлбэрийг тэр чигээр нь хуулбарлан өөрийн бүтээлд ашиглахаас гадна бас хүний санааг ашиглах тохиолдолд хамаарна гэдгийг битгий мартаарай. Та

хамтран ажиллагсад, бодлого боловсруулах сүлжээний гишүүдтэй ярих, мөн хэвлэн нийтлэгдсэн мэдээ материалуудыг уншиж судлах замаар энэ асуудлыг шийдэж болно. Хэрвээ эргэлзээгээ тайлж чадахгүй бол ишлэл хийх арга замыг сонгоорой.

- *Хэвлэн нийтлэгчийн тогтоож өгсөн, эсвэл өөрийн салбарт хэвшсэн ишлэлийн хэм хэмжээг дагаж мөрдөх нь*

Хэвлэн нийтлэгчийн баримталдаг ишлэлийн хэм хэмжээг судалж мэдээд, дагаж мөрдөөрэй.

Шинжилгээ, судалгааны салбарууд өөр өөрийн зорилгод нийцсэн ишлэлийн дэг жаяг тогтоосон байдаг бөгөөд тухайн салбарынхан бүгд энэ хэм хэмжээг даган, хэрэглэж байхад ихээхэн ач холбогдол өгдөг. Бодлогын судалгааны салбарт зохиогчийн нэр, огноо гэсэн (жишээлбэл, Дойл, 1994) гэсэн ишлэлийн

загварыг ихэвчлэн ашигладаг. Энэ л загварыг энэ гарын авлагад, мөн номын энэ дэд хэсэгт ашиглаж байгаа жишээнүүдэд хэрэглэж байгаа болно. Тэгэхдээ хэвшсэн загварууд нь ашигласан зохиол, зохиогчийн нэрийг бичвэрт хэрхэн дурьдахыг зааж өгөхөөр хязгаарлахгүй Номзүйн жагсаалтаа хэрхэн бүрдүүлэх, тайлбар хийхдээ ямар загвар баримтлахыг мөн хэлж өгдөг (дэлгэрэнгүй мэдээллийг 5.9, 5.10 хэсгийг үзнэ үү). Америкийн сэтгэл зүйчдийн нийгэмлэг (APA) (2001), Орчин үеийн хэлний нийгэмлэг (MLA) (Gibaldi, 1995), Чикагогийн их сургууль (University of Chicago, 1993)-ийн загвар гэж нэрлэгддэг эдгээр хэм хэмжээ нь одоо стандарт хэрэглэгдэхүүн болоод байгаа бөгөөд хэвлэн нийтлэгч, уншигчид энэ л стандартыг танаас хүлээх юм. Бодлогын судалгаанд нийтлэгээр хэрэглэдэг загварын тухай товч ойлголт өгөхийн тулд Хавсралт Б-д ишлэлийн APA загварын товчилсон удирдамжийг орууллаа. Энэхүү хавсралт материалаас бичвэрт эх сурвалжийг хэрхэн зөв нэрлэн дурьдахад баримтлах зарчмууд, Номзүйд эх сурвалжийг ямар форматаар бичиж оруулах тухай заавар багтсан болно. Эцэст нь, салбар бүрт хэвшсэн уламжлалууд байдаг ч таны эн тэргүүнд анхаарах ёстой уншигч бол хэвлэн нийтлэгч тул энэ салбарт тухайн хэвлэн нийтлэгчийн хэвшүүлсэн ишлэлийн загварыг судалж мэдэн, баримтлах хэрэгтэй.

- *Асуудал тодорхойлох хэсэгтээ хоёрдогч эх сурвалжийг хэрхэн оновчтой дурьдахаа шийдэх нь*

Баримт бичигт хоёрдогч эх сурвалжийг нэрлэн дурьдах дөрвөн арга байдгаас зохиогчид нэгийг нь сонгож ашигладаг. Эдгээр нь шууд ишлэл, шууд бус ишлэл (үг, найруулгыг өөрчлөн ижил санааг илэрхийлэх),

тоймлол, ерөнхийлөл зэрэг юм. Зохиогчид нь анхдагч эх сурвалжийг өөрчлөхгүй байх, сонирхолтой бөгөөд хурц хэл найруулгыг хадгалах, эсвэл өөрийгөө ишлэн авч буй санаа юмуу түүний цаана байгаа анхны зохиогчоос салгаж харуулах зорилго агуулж буй үедээ шууд ишлэл ашигладаг. Зохиогч өөр хүний санааг өөрийн үндэслэлдээ эвтэйхэн суулгаж ашиглах гэж байгаа тохиолдолд тоймлох юмуу шууд бус ишлэл (өөрөө хэлбэл, өөр зохиогчийн хэлсэн санааг өөрийг үгээр шинэчлэн найруулах арга) хийх аргыг сонгодог. Ерөнхийлөл нь дээрхтэй ижил утга агуулгатай боловч нэгээс олон зохиогчийн санааг нэгтгэн тоймлох арга юм. Ишлэлийн ямар аргыг сонгох нь тухайн шинжлэх ухааны салбарт хэвшсэн уламжлалаас хамаардаг гэж үздэг.

Бидний ашиглаж буй жишээнд бүх хоёрдогч эх сурвалжийг шууд бус ишлэл, тоймлох, ерөнхийлөх аргаар боловсруулан ашигласан байх ба энэ нь Асуудал тодорхойлох хэсэгт зохиогчийн өөрийн оролцоог хүчтэй тусгасан үндэслэл шаардлагатай байдагтай холбоотой.

– *Бичвэрт багтаасан хүснэгт, зургийг нэрлэн дурьдах, эдгээрийн ач холбогдлыг цохон тэмдэглэх нь*

Үндсэн бичвэр юмуу хавсралтад багтсан хүснэгт, зураг, схем нь Асуудал тодорхойлох хэсэгт их хэмжээний өгөгдлийг багтаах нийтлэг арга юм. Эдгээр хүснэгтээр анхдагч болон хоёрдогч өгөгдлийн аль алиныг танилцуулж болдог. Эдгээрийг Асуудал тодорхойлох хэсэгт хэрхэн хэрэглэх, хэрхэн нэрлэн дурьдаж болохыг жишээнээс үзнэ үү.

Хэвлэн нийтлэгдсэн баримт бичгийн шинжилгээ

58 дугаар нүүрнээс “Төвлөрлийг сааруулах бодлогын макро эдийн засгийн орчин” дэд бүлгийг судална уу.

Уншиж байхдаа дараах асуудалд анхаарлаа хандуулаарай:

- хүснэгтийг бичвэр дотор хэрхэн нэрлэн дурьдсан
- эдгээр ишлэл нь үндэслэлд ямар үүрэг роль гүйцэтгэж байгаа

Шаардлагатай бол, энэхүү Үндэслэлийн контекстыг ойлгохын тулд энэ хэсгийн эхний дүн шинжилгээг гүйцэтгэхийг зөвлөж байна.

Жишээнд хүснэгтийг нэрлэн дурьдсан хоёр тохиолдол байгаагийн эхнийх нь нэгдүгээр мөрийн хоёрдахь өгүүлбэрт, дараахь нь гуравдахь догол мөрийн сүүлийн өгүүлбэрт гарч байна. Эх сурвалжийг нэрлэх дурьдахдаа (Хүснэгт 5.1) гэж хаалтад авсан байх ба догол мөр тус

Бичвэр дотор хүснэгтийг шууд нэрлэн дурьдаад, чухал ач холбогдолтой өгөгдлийг онцлон цохох хэрэгтэй.

бүрээр илэрхийлсэн үндэслэлийн мэдэгдлийг дэмжих нотолгоо болгож ашиглажээ. Эх сурвалжаар дэмжиж өгсөн өгүүлбэрүүд нь хүснэгт дэх өгөгдлийн ач холбогдлыг онцлох зорилготой байгаа бөгөөд өөрөөр хэлбэл, эдгээр нь хүснэгтэд байгаа өгөгдлийн аль нь, ямар учир шалтгааны улмаас онцгой чухал болохыг тайлбарлажээ. Хүснэгт, зураг ашигласан хэрнээ эдгээрийг бичвэртээ нэрлэн дурьдахгүй орхих нь олон зохиогчийн гаргадаг алдаа юм. Өгөгдлийг бичвэртээ багтаасны шалтгааныг тайлбарлах нь зохиогчийн үүрэг хариуцлага бөгөөд яагаад энэ өгөгдөл чухал болохыг уншигч тааж суух ёсгүй.

Энэ хоёр жишээ нь үндэслэлийг бүрдүүлж буй тодорхой санаануудыг хүснэгтийн мэдээллээр дэмжиж өгсний жишээ юм. Заримдаа хүснэгт, зургийг тодорхой санааг шууд дэмжих зорилгоор бус харин тухайн асуудлаарх уншигчдын ойлголтыг тэлэх илүү өргөн хүрээтэй, ерөнхий мэдээлэл өгөх зорилгоор ашиглах нь бий. Ийм төрлийн мэдээллийг үндсэн бичвэрт нэрлэн дурьдахдаа ихэвчлэн “дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт К-аас үзнэ үү” гэх зэрэг үг хэллэг ашигладаг. Гэхдээ ийм төрлийн мэдээллийг хэт олон удаа ашиглавал баримт бичиг тань гол үндэслэлдээ төвлөрч чадаагүй, фокусгүй болсон сэтгэгдэл төрүүлэх тул болгоомжтой хандах хэрэгтэй. Хүснэгтийн өгөгдөл нь үндэслэлд багтсан тодорхой санааг шууд дэмжихийн зэрэгцээ баримт бичгийн өөр хэсгүүдэд ерөнхий дэмжлэг болж өгөх тохиолдолд л иймэрхүү хүснэгтийг ашиглах нь зүйтэй.

Бичих явцдаа ашиглах хяналтын хуудас

Асуудал тодорхойлох хэсэгт оруулах сайн үндэслэл боловсруулахын тулд дараах зүйлсийг анхаараарай:

Уялдаа холбоос

- Та Асуудал тодорхойлох хэсгийнхээ бүх бүрдэл элементийг сайн холбож өгч чадсан уу?
- Асуудал тодорхойлох хэсгийн тань бүх дэд хэсгийн дотоод уялдаа холбоо илт, тодорхой болж чадсан уу?

Үндэслэл

- Таны боловсруулсан үндэслэлийн бүрдэл элемент бүрт мэдэгдэл, дэмжлэг, баталгаа багтсан байна уу?

Догол мөр

- Асуудал тодорхойлох хэсэг тань уншигчдад хялбар ойлгогдох биет хуваагдлыг гаргаж өгсөн догол мөрүүдэд оновчтой хуваарилагдсан байна уу?
- Та үндэслэлийнхээ логик нэгж санаа бүрийг тусдаа догол мөр болгон зохион байгуулж чадсан байна уу?
- Догол мөрүүд хоорондын уялдаа холбоо сайн болж чадсан уу?

Эх сурвалж ашиглах нь

- Та Асуудал тодорхойлох хэсгээ боловсруулахдаа олон төрлийн эх сурвалж ашигласан уу?
- Та үндэслэлээ дэмжиж чадахуйц нэр хүнтэй эх сурвалжуудыг ашигласан уу?
- Та эх сурвалжуудыг өөрийнхөө үндэслэлүүдийг дэмжсэн нотолгоо маягаар ашиглаж чадсан уу?
- Бүх хүний мэддэг нийтлэг мэдээлэл гэж үзэж болохооргүй тийм эх сурвалж, өгөгдлийг та ишлэж юмуу нэрлэн дурьдсан уу?
- Та өөрийн судалгааны салбарт хэвшсэн, эсвэл хэвлэн нийтлэгчийнхээ баримталдаг ишлэлийн хэм хэмжээг мөрдсөн үү?

5.7. Бодлогын хувилбарууд

Боломжит бүх хувилбарыг шинжилсний үндсэн дээр хамгийн сайн гэж үзсэн бодлогын хувилбарын үндэслэлийг Бодлогын хувилбарууд хэсэгт танилцуулдаг.

Судалж буй бодлогын асуудлын суурь нөхцөл, өнөөгийн эрх зүйн орчинг нарийвчлан тайлбарласан хэсгийн дараа бодлогын баримт бичигт энэхүү асуудлыг шийдэх боломжит арга замуудыг тайлбарласан Бодлогын хувилбарууд хэсэг орж ирнэ. Бодлогын баримт бичгийн энэ бүрдэл хэсэг болон бодлогын мөчлөгийн бодлого боловсруулах үе шат (3.1 хэсэгт авч үзсэн)-ын хоорондын холбоог харгалзан үзвэл Бодлогын хувилбарууд элементийг доорх 5 санаагаар тоймлож болох юм.

Бодлогын хувилбарууд хэмээх энэ элемент нь:

- *бодлогуудын хувилбаруудыг тоймлон тайлбарлаж, үнэлэн, харьцуулдаг*

Зохиогчийн боловсруулсан болон бусад хүмүүсийн санал болгож буй бодлогын бүхий л хувилбаруудыг авч үзсэн баримт бичиг л бүрэн дүүрэн, үнэмшилтэй дүн шинжилгээ болж чадна. Бодлогын хувилбар болгоныг тоймлон тайлбарлах зорилготой энэ элемент нь тодорхой хувилбар тухайн асуудлыг хэрхэн шийдэж байгаад үнэлгээ өгөх, бусад хувилбартай харьцуулахад хэр оновчтой байгааг тайлбарлахад төвлөрдөг.

- *хамгийн оновчтой гэж үзэж буй бодлогын хувилбарыг дэмжсэн сайн үндэслэл гаргаж өгдөг*

Бодлогын хувилбаруудыг танилцуулахдаа зохиогч дээрх үнэлгээ, харьцуулалтын үр дүнд тулгуурлан хамгийн оновчтой гэж сонгон санал болгож буй тэр л хувилбар нь асуудлыг хамгийн оновчтойгоор шийдвэрлэж чадна гэдгийг нотолж, улмаар зохиогчийн гаргасан шийдвэр үндэслэлтэй болохыг батлах зорилго тавих ёстой. Мэдээж, ингэхдээ зохиогч мөн нотолгоонд тулгуурлан бодлогын бусад хувилбарыг яагаад дэмжихгүй байгаагаа тодорхой тайлбарлах хэрэгтэй.

- *зохиогчийн гаргасан шийдвэрийг тайлагнахад төвлөрдөг*

Бодлогын баримт бичгийн энэ бүрдэл элемент нь бодлогын мөчлөгийн бодлого боловсруулах үе шатыг судлаач та хэрхэн гүйцэтгэснийг алхам алхмаар тайлбарласан тайлан биш харин бодлогын хувилбар

бүрийн талаар таны гаргасан шийдвэр, энэ шийдвэр учир шалтгааныг тайлбарлах ёстой.

- бодлогын баримт бичгийн Дүгнэлт, Зөвлөмж хэсгүүдтэй шууд бөгөөд тодорхой харагдахуйц уялдаа холбоос үүсгэдэг


Таны хамгийн оновчтой гэж сонгосон бодлогын хувилбарыг дэмжсэн үндэслэл нь таны бодлогын зөвлөмжийн үндэс суурь, учир шалтгаан болох юм. Иймд энэ элемент нь таны баримт бичгийн эцэст байрлах зөвлөмжүүдтэй ойлгомжтой, тодорхой уялдан холбогдсон байх ёстой.

Бодлогын хувилбарууд хэсгийн бүтцийн болон бичвэрийн шинж чанаруудыг дараагийн дэд хэсэгт нарийвчлан тайлбарлав. Доорх хэсэгт танилцуулсан зүйлс нь цогцоороо бодлогын баримт бичгийн энэ бүрдэл элементийг үр өгөөжтэй боловсруулах арга зүй болж чадна гэдгийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ нарийвчлан танилцуулж, тодорхой тайлбар өгөх үүднээс эдгээрийг салган авч үзлээ.

5.7.1. Бодлогын хувилбаруудыг боловсруулах нь: Бүтэц ба үндэслэл

Үр нөлөөтэй бодлогын баримт бичгийн зохиогч бусдыг итгүүлж үнэмшүүлэхүйц үндэслэл боловсруулахын тулд энэ бүрдэл элементийн бүтэц, зохион байгуулалтын нийтлэг шинж чанаруудыг мэддэг байх ёстой гэсэн төсөөллөөр энэ хэсгийг бичлээ.

Бодлогын хувилбарууд хэмээх энэ элемент нь бүтцийн хоёр шинжийг агуулж байдаг.



- Дүн шинжилгээний хүрээ

Дээр өгүүлсэнчлэн, бодлогын баримт бичиг бол тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаарх тодорхой байр суурийг хамгаалсан үндэслэл бөгөөд үүнийг олдоцтой өгөгдөл, мэдээллийн дүн шинжилгээнд тулгуурлан боловсруулдаг. Энэхүү дүн шинжилгээний суурь нь үнэлгээний үйл явцдаа зохиогчийн ашиглах зарчмуудыг багтаасан загвар байх юм. Өөрөөр хэлбэл, Дүн шинжилгээний хүрээ бол хэлэлцэж буй

Дүн шинжилгээний хүрээ бол туйлын зорилгын талаарх судлаачийн төсөөлөл, түүний баримталж буй үнэт зүйлсийн томъёолол бөгөөд энэ нь үнэлгээний ажлыг удирдан чиглүүлж өгнө.

асуудлаар зохиогчийг тодорхой байр суурь баримтлахад хөтөлж байгаа туйлын зорилго (идеал), үнэт зүйлсийн илэрхийлэл, томъёолол юм. Дүн шинжилгээний энэхүү хүрээ нь бодлогын хувилбаруудын үнэлгээг залж чиглүүлж өгдөг. Баримт бичгээрээ таны хүргэж буй үндэслэлийг бодитой үнэлэхийн тулд Дүн шинжилгээний хүрээг заавал тодорхойлсон байх шаардлагатай. Бодлогын баримт бичгийн энэ бүрдэл элементийг боловсруулахад ашиглах арга зүйг дараагийн хэсэгт тодорхой танилцуулна.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

Нэг болон Хоёрдугаар жишээний Дүн шинжилгээний хүрээг тайлбарласан хэсгүүдийг уншина уу. Тайлбаруудыг сайн ойлгож авахын тулд Хавсралт А-аас эдгээр жишээ баримт бичгийн судалгааны асуудал, фокусыг танилцуулсан Удиртгал хэсгүүдийг нэмж уншаарай.

Уншиж байхдаа дараах асуудалд анхаарлаа хандуулна уу:

- Дүн шинжилгээний хүрээнийг боловсруулах, танилцуулахад ашигласан арга хандлагуудын ялгаа

Жишээ 1

“Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах нь: Захиргаадлаас зах зээлд” (Бёрд, Эбель, Воллих нар, 1995) гарчигтай баримт бичгээс хэсэгчлэн авсан энэхүү ишлэл нь 4 нүүр урттай Дүн шинжилгээний хүрээний зөвхөн эхлэлийн болон төгсгөлийн догол мөрийг багтаасан товч хэсэг юм.

Бодлогоо өргөн хүрээнд тодорхойлох хэрэгцээ

[эхлэлийн догол мөр] Засгийн газрын түвшин хоорондын санхүүгийн харилцаа нь дан ганц орон нутгийн асуудал огтоос биш бөгөөд улмаар шилжилтийн эдийн засагтай бараг бүх л улс орны өөрчлөлт шинэчлэлийн үндсэн асуудал болдог. Санхүүгийн федерализмын асуудлаарх уламжлалт шинжилгээнүүд нь төсвийн тогтворжуулалт, орлого хуваарилалт (тухайлбал, нийгмийн хамгаалал), нөөцийн хуваарилалт (Оутс 1972; Масграйв 1983) зэрэг чиглэлээр төв болон орон нутгийн засгийн газарт оногдуулсан (мөн голдуу салангид) чиг үүрэг болон хариуцлагын асуудлыг судалдаг. Энэ фокус нь наад зах нь хоёр шалтгааны улмаас шилжилтийн эдийн засагтай улс орнуудын орон нутаг, төв засгийн газар хоорондын санхүүгийн чухал асуудлуудыг авч үзэхэд хангалттай өргөн байж чадахгүй байгаа юм. Нэгдүгээрт, энэ хандлага нь төсвийн тогтворжуулалт, нийгмийн хамгааллын баталгаа, хувьчлалын асуудлаар орон нутгийн засгийн газрын гүйцэтгэдэг үүрэг ролийг огт анхааралгүй орхигдуулдаг ба энэ нь судалгаа шилжилгээнд хангалттай тодорхой туссан байдаг. Хоёрдугаарт, энэ нь шилжилтийн улс орнуудын хувьд нийтлэг бөгөөд заавал анхаарах шаардлагатай төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн өв уламжлалын асуудлыг бүрэн хэмжээнд тусгаж чадахгүй байгаа юм.

[төгсгөлийн догол мөр] Санхүүгийн төвлөрлийг сааруулах асуудал бол аль ч тогтолцооны хувьд тулгамдсан, ид өрнөж буй динамик үйл явц болоод байна. Харин Төв болон Зүүн Европ, мөн хуучин Зөвлөлт Холбоот Улсын шинэчлэгчдийн өмнө бүтцийн шинжтэй хүндрэл бэрхшээлийг зах зээлийн эдийн засар руу шилжих шилжилтээс үүдэлтэй хүндрэлүүдээс ялган салгах онцлог сорил тулгараад байгаа юм. Тэд төсөв хоорондын шилжүүлэг болон татварын орлогын урсгалыг тогтмолжуулах зэрэг өдөр тутмын үйлдлийн бааз суурь болоход хангалттай хатуу чанд хэрнээ санхүүгийн тогтворжилт, дахин хуваарилалт, хувьчлал зэрэгтэй холбоотойгоор эдийн засагт ид өрнөж буй бүтцийн зохицуулалттай зэрэгцэн оршиход хангалттай уян хатан засгийн газар хоорондын харилцааны зарчмуудыг боловсруулах шаардлагатай болоод байна.

Жишээ 2

“Орон нутгийн түвшний төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл явц дахь нээлттэй өрсөлдөөн, ил тод байдал, төвийг сахисан байр суурь” (Баар, 2001) гарчигтай баримт бичгээс хэсэгчлэн авсан ишлэл

Хамруулсан асуудлууд нь дараах болно:

- (а) Худалдан авалтын тухай хууль, өрсөлдөөнт сонгон шалгаруулалт явуулахыг шаардсан бусад журмыг гэрээлэгч сонгох үйл ажиллагаанд авч хэрэглэх боломж
- (б) гэрээ болон үнэ тогтоох үйл ажиллагаанд ашигласан мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох (мэдээллийн эрх чөлөө)
- (в) Гэрээлэгчдийг сонгоход давуу тал бий болгохгүй байх, сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлагуудыг баримтлах

Дээр дурьдсан бүх зүйл нь төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэхдээ нийтийн эрх ашгийг дээд зэргээр хамгаалах наад захын шаардлагууд гэж үзэж болох юм. Хэрвээ сонирхлын зөрчил гарах нөхцөл үүсэх юм бол тендер жинхэнэ утгаараа өрсөлдөөнтэй болж чадахгүй. Гэрээлэгчээ сонгохдоо өрсөлдөөнт тендер явуулж чадахгүй бол тухайн үйлчилгээг олон нийтэд хамгийн ашигтай нөхцлөөр хүргэх баталгаа үгүй болох юм. Ил тод байдал хангагдаагүй нөхцөлд авилга, хээл хахууль гарах магадлалтай бөгөөд сонгон шалгаруулалт шударгаар явагдсанд итгэх олон нийтийн итгэл алдарна. Цаашилбал, ил тод байдал хангагдахгүй бол гэрээлэх үйл явцад олон нийт оролцох боломжгүй болно. Энэ бүхний үр дүнд олон нийтийн хараат бус хяналт, шүүмжлэл, зөвлөгөө зэрэг боломжуудыг ашиглалгүй алдах эрсдэлтэй.

Дээрх хоёр жишээний зохиогчид Дүн шинжилгээний хүрээгээ өөр өөр арга хандлагаар боловсруулж, танилцуулсан байна. Эхлэлийн догол мөрөөс харахад л Нэгдүгээр жишээний зохиогч эхлээд онолын болон бусад судалгаанаас гарсан дүгнэлтийг танилцуулах замаар өөрийн баримталж буй байр суурийг тайлбарласан байхад Хоёрдугаар жишээний зохиогч ингээгүй байх юм. Мөн, хоёр жишээ нь тайлбарын урт, нарийвчлалын түвшнээрээ ялгаатай байна. Хоёрдугаар жишээний хэсэгчилсэн ишлэл нь тухайн бодлогын баримт бичгийн Дүн шинжилгээний хүрээг бүтнээр нь багтаасан байгаа бол Нэгдүгээр жишээний хэсэгчилсэн ишлэл нь үүнээс хавьгүй өргөн хүрээг хамруулжээ. “Бодлогоо өргөн хүрээнд тодорхойлох хэрэгцээ” гэсэн гарчигтай дэд бүлэгт зохиогчид нь орлого бүрдүүлэх тогтолцоо, улсын салбарын үнэ өртөг тогтоох журам, зарцуулалт, шилжүүлэг, өр зээл, төрийн өмч зэрэг өргөн хүрээтэй хэд хэдэн асуудлаар өөрийн байр суурийг илэрхийлжээ. Тайлбарын урт, нарийвчлалын түвшний энэ ялгаа нь хоёр баримт бичгийн сэдвийн цар хүрээтэй холбоотой юм.

Гэсэн хэдий ч хоёр жишээнд бас ижил төстэй талууд байна. Эдгээр баримт бичиг нь хоёулаа авч үзэж буй асуудлаарх зохиогчдын байр суурийг тун тодорхой илэрхийлж байна.

Жишээ 1. Тэд төсөв хоорондын шилжүүлэг болон татварын орлогын урсгалыг тогтмолжуулах зэрэг өдөр тутмын үйлдлийн бааз суурь болоход хангалттай хатуу чанд хэрнээ санхүүгийн тогтворжилт, дахин хуваарилалт, хувьчлал зэрэгтэй холбоотойгоор эдийн засагт ид өрнөж буй бүтцийн зохицуулалттай зэрэгцэн оршиход хангалттай уян хатан засгийн газар хоорондын харилцааны зарчмуудыг боловсруулах шаардлагатай болоод байна.

Жишээ 2. Дээр дурьдсан бүх зүйл нь төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэхдээ нийтийн эрх ашгийг дээд зэргээр хамгаалах наад захын шаардлагууд гэж үзэж болох юм.

Үүний зэрэгцээ, аль аль зохиогчид нь яагаад ийм байр суурь баримталж буйгаа тайбарлахыг хичээжээ:

Жишээ 1: Харин Төв болон Зүүн Европ, мөн хуучин Зөвлөлт Холбоот Улсын шинэчлэгчдийн өмнө бүтцийн шинжтэй хүндрэл бэрхшээлийг зах зээлийн эдийн засар руу шилжих шилжилтээс үүдэлтэй хүндрэлүүдээс ялган салгах онцлог сорил тулгараад байгаа юм.

Жишээ 2: Ил тод байдал хангагдаагүй нөхцөлд авилга, хээл хахууль гарах магадлалтай бөгөөд сонгон шалгаруулалт шударгаар явагдсанд итгэх олон нийтийн итгэл алдарна.

Ерөнхийдөө, Дүн шинжилгээний хүрээ нь зохиогчдын төсөөлж буй туйлын зорилго, баримталж буй үнэт зүйлсийг маш тодорхой илэрхийлэхийн зэрэгцээ зохиогчийн энэхүү байр суурийг судалж буй асуудалд хамааруулан, эсвэл онолын болон тогтсон хэм хэмжээний үүднээс тайлбарлан үндэслэх ёстой. Энэхүү үндэслэл тайлбарыг мөн хамгаалж батлах ёстой бөгөөд үүний тулд ижил төстэй юмуу адилхан байр суурийг илэрхийлсэн бусад судлаачийг нэрлэх, ишлэх хэрэгтэй.

Жишээнүүдэд хийсэн шинжилгээнээс харагдаж ирж буй өөр нэг сонирхолтой зүйл бол баримт бичиг доторх Дүн шинжилгээний хүрээний байршил юм. Энэ элемент нь бодлогын хувилбаруудын үнэлгээтэй шууд холбоотой боловч хоёр баримт бичгийн зохиогчид хүрээгээ Асуудал тодорхойлох үндсэн хэсгийн өмнө оруулж тоймлон тайлбарлах нь дээр гэж үзжээ. Бодлогын баримт бичгийн логигоор бол Дүн шинжилгээний хүрээ нь бодлогын хувилбаруудын өмнө танилцуулагдах ёстой бөгөөд ингэснээр судлаачийн хийх бодлогын хувилбаруудын үнэлгээ уншигчдад илүү ойлгомжтой болох юм. Гэтэл дээрх хоёр жишээнд Асуудлын тодорхойлолт хэсгийг Бодлогын хувилбаруудын үнэлгээ хэсгээс зааглаж өгөөгүй буюу өөрөөр хэлбэл, зохиогчид нь асуудлын тодорхойлолт болон тухайн асуудлыг шийдэх бодлогын хувилбаруудыг нэг дэд бүлэгт танилцуулах арга замыг сонгожээ. Энэ нь л тухайн хоёр баримт бичиг дэх Дүн шинжилгээний хүрээний байршлыг тодорхойлж

өгсөн бололтой. Дүн шинжилгээний хүрээг бодлогын баримт бичгийн эхэн хэсэгт танилцуулсан нь Асуудлын тодорхойлолт хэсэгт багтаасан зохиогчдын байр суурийг төвөггүй ойлгоход уншигчид тусалж байгаа тул зөв шийдэл болсон байна. Та ч бас ажлаа төлөвлөхдөө энэ хандлага таны баримт бичгийн фокус, зориулалтад нийцэх эсэхийг сайтар бодож тунгаагаарай.

Бичих явцдаа ашиглах хяналтын хуудас

Дүн шинжилгээний хүрээгээ төлөвлөн, бичихэд тань дараах асуултууд тус болно:

- Баримт бичгийнхээ Дүн шинжилгээний хүрээг боловсруулахад та ямар зарчим, туйлын зорилго, үнэт зүйлсийг удирдлага болгох вэ?
- Эдгээр зарчим нь таны судалж буй асуудал дээр хэрхэн "бууж" байна вэ?
- Таны илэрхийлсэн байр суурийн онолын үндэслэл нь юу вэ?
- Та энэ байр суурийг сонгох болсон бусад шалтгаанууд нь юу вэ?
- Таны энэ байр суурийг олон хүн хүлээн зөвшөөрч байна уу?
- Та баримт бичгийнхээ аль хэсэгт нь Дүн шинжилгээний хүрээгээ байрлуулах вэ?

- *Бодлогын хувилбаруудын үнэлгээ*

Дүн шинжилгээний хүрээг тоймлон танилцуулсны дараа бид бодлогын сонголтууд, тэдгээрийг үнэлэх асуудлыг авч үзэх гэж байна. Дараах жишээгээр бид тодорхой асуудлын хүрээнд бодлогын хувилбаруудыг хэрхэн үнэлэх, мөн үнэлгээтэй холбоотой бусад хэд хэдэн чухал асуудлыг судлах юм.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

“Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах нь: Захиргаадлаас зах зээлд” (Бёрд, Эбель, Воллих нар, 1995) гарчигтай баримт бичгээс хэсэгчлэн авсан ишлэлийг судална уу. Энэ хэсэгт тухайн бодлогын баримт бичигт хөндсөн хэд хэдэн асуудлаас нэгийг нь шийдэхэд чиглэсэн бодлогын хувилбаруудын үнэлгээг танилцуулжээ. Өмнө судалсан Асуудал тодорхойлох хэсгийг тайлбарлахад мөн л энэ дэд бүлгийн үндсэн дүн шинжилгээг ашигласан билээ. Тиймээс Асуудал тодорхойлох хэсгийн дүн шинжилгээг та гүйцэтгэчихсэн бол энэ хоёр хэсгийн холбоо хамаарлыг түвэггүй ойлгох бөгөөд энэ нь доорх хэсгийг уншиж ойлгоход танд тус болно. Мөн, та уг баримт бичиг, ялангуяа авч үзсэн асуудлыг мэдэж байх нь доорх дүн шинжилгээг гүйцэтгэхэд тус болох тул баримт бичгийн Удиртгал хэсгийг Хавсралт А-аас уншаарай.

Уншиж байхдаа дараах асуудалд анхаарлаа хандуулна уу:

- Бодлогын хоёр хувилбар (төсвийн алдагдлыг хянах, зээлийг хязгаарлах)-ыг танилцуулах болон тайлбарлахдаа зохиогчийн баримталж буй арга хандлагын ялгаа
- Эдгээр хувилбарын үнэлгээг залж чиглүүлж буй үнэт зүйлс/ зарчмуудын зарим жишээг олж харах [дараа нь дурьдах зорилгоор догол мөрүүдийг дугаарлав].

Төсвийн нийт үр дүнг сайжруулах нь

[1] Төв засгийн газрын богино хугацааны зорилтуудыг хангахад төсвийн уян хатан байдал чухал ч засгийн газар хоорондын шилжүүлэг бол танаж болох зүйл гэж хандаж болохгүй. Орон нутгийн засаг захиргааны үйлчилгээний багагүй хувь нь эдийн засгийн хөгжил, улс төрийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Ихэнх орон нутаг эдгээр үйлчилгээг зөвхөн өөрсдийн дотоод нөөц боломжоор хангалттай хэмжээнд нийлүүлж чадахгүй. Богино хугацааны тогтворжилтын үүднээс харсан ч шилжүүлгийг танах нь оновчгүй зүйл юм. Төсвийн дарамтаас ангижрахын тулд хөрөнгө мөнгө дутсан орон нутаг орлого оруулдаг хөрөнгөө зарж борлуулах, орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг өөрийн мэдэлд авах зэргээр эдийн засгийн хувьд оновчгүй орлого бүрдүүлэх арга замыг сонгоход хүрдэг. Үүний зэрэгцээ, зарим оронд орон нутагт нийгмийн халамжийн нээлттэй үүрэг хариуцлага хүлээлгэсэн явдал нь төв засгийн газарт яаралтай урсгал зардал нэмж дайчлах хэрэгцээ, эргэн төлөгдөх баталгаагүй өрийн хуримтлал, богино хугацааны зээл зэрэг үр дагавар авчирдаг. Орон нутгийн хуримтлагдсан өр Болгар, Орос, Украинд ноцтой асуудал болоод байна. Будапешт хот урсгал зардлаа санхүүжүүлэхийн тулд зээл авч байна (Хавсралт 3-ыг үз). Оросын мужуудад тэтгэвэр, багш нарын цалингийн нэмэгдлийг хэдэн сараар хоцроох явдал гарч байна. Шилжилтийн эдийн засагтай орнуудад ийм хүсэмгүй чиг хандлага хэвшихээс сэргийлэх цорын ганц арга нь засгийн газар хоорондын шилжүүлгийн бодлогыг хадгалах явдал юм.

[2] Төсвийн алдагдлыг хянах нь. Орон нутгуудаас макро эдийн засагт ачаалал ирэхээс сэргийлэх нэг арга зам бол төв засгийн газар орон нутгийн төсвийн алдагдлыг шууд хянах явдал юм. Ийм хязгаарлалтыг, жишээлбэл, Орос Улсад хэрэгжүүлдэг. Иймэрхүү төрлийн арга хэмжээ нь төсвийн “хатуу” хязгаарлалттай нөхцөлд ач холбогдолтой байх ба төсвийн алдагдлыг хянах бодлогыг төсвийн “зөөлөн” хязгаарлалттай хослуулан хэрэглэхэд харин ч сөрөг нөлөө үүсдэг.¹⁴ Орос, Болгарт орон нутгийн төсвийн тэнцэл ашигтай гарах хандлага илт мэдрэгдээд ирэнгүүт төв засгийн газар нь зардлын хариуцлагыг орон нутагт шилжүүлж, татварын хуваарилалтын түвшинд зохицуулалт хийн, шилжүүлгээ багасгасан байна. Харин Болгарын орон нутгийн засаг захиргаа ямар ч нөхцөл, тэр бүү хэл хөрвөх чадвараа нэмэгдүүлэх зорилгоор ч гэлээ төсвийн алдагдал гаргах, зээл авах эрхгүй, Оросын зээл авах боломж, эрх мэдэл нь хязгаарлагдмал төсвүүд нь анхнаасаа л орон нутгийн сар бүрийн зарлагын хэрэгцээг хангахуйц бэлэн мөнгөний илүүдэл нөөцтэй байх шаардлагатай болж байна.¹⁵ Улсын төсвийн орлогоос авах хувь хэмжээ юмуу шилжүүлгийг багасгаснаар энэ хэрэгцээ арилахгүй.

Учир нь орон нутгийн төсөв алдагдалтай байж болохгүй учраас ийм арга хэмжээний үр дүнд зардлын санхүүжилт “байх ёстой” түвшнээс доогуур үзүүлэлттэй харагдаж, өр хуримтлагдахад хүргэх юм. Ийм нөхцөлд орон нутгуудаас төсвийн тэнцлийг хангаж ажиллахыг шаардсанаар асуудал шийдэгдэхгүй.

[3] Зээлийг хязгаарлах нь. Орон нутаг тодорхой томоохон хөрөнгө оруулалтын зорилгоор зээл авах эрхтэй байх нь сайн үр нөлөөтэй байх магадлалтай. Харин зарим улс орны орон нутгийн төсөв санхүүгийн бодлогын нэгэн гайхалтай зарчим бол орон нутгууд бараг л хязгааргүй зээлэх, бүр гадаадаас зээл авах боломжтой байгаа явдал юм (Хүснэгт 1.7). Жишээлбэл, Унгар Улсын Орон нутгийн өөрийн удирдлагын тухай хуулиар орон нутаг урсгал болон хөрөнгийн зардалдаа дотоодоос зээл авах хязгааргүй эрхтэй байхаар заажээ. Албанийн орон нутгууд мөн л хөрөнгийн зардалдаа хязгааргүй зээл авах эрхтэй. Харин бусад ихэнх улс ямар нэг хязгаарлалт тавьж өгсөн байдаг. Жишээлбэл, Польшид орон нутгууд төсөвлөсөн урсгал зардлынхаа таван хувиас илүү гаргаж зээл авах эрхгүй байдаг ажээ.

[4] Захиргаадлын эдийн засгийн үед орон нутгийн зээл нь улсын зээлийн нэгдсэн төлөвлөгөөгөөр тодорхойлогдож, эргэн төлөлтийг нь улсын үйлвэрийн газрын зээлийн нэгэн адилаар төв банк хариуцдаг байжээ. Өнөөдөр бол орон нутагт зээлийн ийм өгөөмөр нөхцөл хангаж өгөх нь тохиромжгүй. Өөрийн орлогын эх үүсвэр нь хангалтгүй юмуу хязгаарлалттай орон нутгууд өрийн санхүүжилтийг хэтрүүлэн хэрэглэх магадлалтай юм. Шилжилтийн эдийн засагтай олон орны макро эдийн засаг тогтворжоогүй байгаа нь орон нутгийн зээл авах эрхийг улам бүр хязгаарлахыг шаардаж байна. Урсгал зардлаа санхүүжүүлэхэд зээл авах, эсвэл орон нутгийн банкныг өөрийн мэдэлд авах замаар зээлийн үнэгүй эх үүсвэртэй болох нэн зохимжгүй бодлого юм. Шинэ тутам байгуулагдаад байгаа орон нутгийн засаг захиргааны ихэнх нь хөрөнгө оруулалтын зах зээлийн талаар туршлагагүйн дээр үндэслэлтэй, бүрэн хэмжээний төсөл боловсруулж, хэрэгжүүлэх чадвартай нь цөөн байна. Ихэнх оронд засгийн газар хоорондын санхүүгийн урсгал хэвээр, орон нутаг нь үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох эрх мэдэл хязгаарлагдмал, өөрөө мэдэн татварын хэмжээг тогтоох туршлага (боломж) бага байна. Тиймээс ч тэдний зээлжих чадавхийг үнэлэхэд хэцүү.

Хүснэгт 1.7. Орон нутгийн зээл, шилжилтийн эдийн засагтай зарим орны жишээ

Улс	Орон нутгийн зээлийн эрх мэдэл	Орон нутгийн зээлийн үйл ажиллагаа
Албани	Хөрөнгө оруулалтын зорилгоор хязгааргүй зээл авах эрхтэй	Мэдээлэл байхгүй.
Болгар	Хязгаарлагдмал зээлжих эрхтэй ч өр хуримтлагддаг	Сангийн яамнаас
Унгар	Хязгааргүй зээлжих эрх	Зарим орон нутаг өрийн үлдэгдэлтэй. Шинэ зээлийг дээд зэргээр хязгаарласан.
Польш	Хязгаарлагдмал зээлжих эрх	Зээлийн үйлчилгээ нь төсвийн орлогын 15 хувиас хэтрэхгүй байх ёстой.
Румын	Зээлжих эрхгүй боловч өр хуримтлагддаг	Үйл ажиллагаа бараг байхгүй.
Орос	Хязгаарлагдмал зээлжих эрх	Шинэ зээлийг дээд зэргээр хязгаарласан (зөвхөн хөрвөх зээл)
Украин	Хязгаарлагдмал зээлжих эрх	Шинэ зээлийг дээд зэргээр хязгаарласан (зөвхөн хөрвөх зээл)

Тэмдэглэл: Хүснэгтийн нэмэлт тэмдэглэлийг үзнэ үү.

Эх сурвалж: Дэлхийн Банкны тооцоо.

Шилжилтийн эдийн засагтай орнуудын санхүүгийн байгууллагууд урт хугацааны эрсдлийг үнэлэх, урт хугацааны санхүүгийн арга хэрэгслийг удирдах чадамжгүй хэвээр байгаа юм. Энэ бүх хүчин зүйлс нь орон нутагт зээл авах эрх олгох асуудалд болгоомжтой хандахыг шаардаж байна. Гэхдээ зарим төсөл ашиг тусаа ирээдүйд өгөх тул орон нутгийн дэд бүтцийн хөгжилд зориулж зээл авахыг эдийн засгийн онолууд дэмждэг. Хөрөнгийн зардлыг урсгал төсвөөс санхүүжүүлснээс болж орон нутгийн хөрөнгө оруулалтын явц, үр ашиг үндэслэлгүй саарах юм. Тиймээс макро эдийн засгийн тогтворжилтод сөрөг нөлөөгүй санхүүжилтийн оновчтой механизмуудыг олох нь гол асуудал болоод байна.¹⁶ Гэтэл ихэнх улс орон нутгийнхаа урсгал зардлыг санхүүжүүлэх найдвартай бүтэц тогтолцоо бий болгох илүү тулгамдсан асуудлыг шийдэх хүртэл энэ чухал асуудлаа хойш тавих хэрэгтэй болж байна.

Дээрх жишээнд бодлогын хоёр хувилбарыг тус бүрт нь тоймлон тайлбарлаад, судлаачийн боловсруулсан Дүн шинжилгээний хүрээнд тулгуурлан хувилбар бүрийн хувьд дэмжсэн болон эсэргүүцсэн үндэслэл гаргажээ. Энэ бол бодлогын баримт бичгийн энэ бүрдэл элементийн хамгийн нийтлэг бүтэц юм. Нэгдүгээр жишээний Дүн шинжилгээний хүрээний тодорхой асуудлуудыг онцлох боломжгүй ч төв болон орон нутгийн засгийн газар хоорондын төсөв санхүүгийн харилцааг илүү тогтвортой, тууштай болгох үр нөлөөтэй тогтолцооны асуудал энэ бичвэрийн туршид илэрч буй үндсэн фокус юм. Зохиогчийн энэхүү байр суурь бидний 77 дугаар нүүрт авч үзсэн Дүн шинжилгээний хүрээнд тодорхой туссан байна:

Тэд төсөв хоорондын шилжүүлэг болон татварын орлогын урсгалыг тогтмолжуулах зэрэг өдөр тутмын үйлдлийн бааз суурь болоход хангалттай хатуу чанд хэрнээ санхүүгийн тогтворжилт, дахин хуваарилалт, хувьчлал зэрэгтэй холбоотойгоор эдийн засагт ид өрнөж буй бүтцийн зохицуулалттай зэрэгцэн оршиход хангалттай уян хатан засгийн газар хоорондын харилцааны зарчмуудыг боловсруулах шаардлагатай болоод байна.

Дүн шинжилгээний хүрээнд тулгуурлан хийсэн бодлогын хувилбаруудын үнэлгээ, түүний үндэслэлийг тайлбарла.

Дээрх жишээнд өнөөгийн макро эдийн засгийн бэрхшээлүүдийг тоймлон өгүүлсэн эхний догол мөр нь бодлогын хувилбарууд (тухайлбал, алдагдлыг хянах, зээлийг хязгаарлах)-ыг танилцуулах хэсэг рүү хөтөлж байна. Бодлогын хувилбар бүрийг дэд гарчгаар онцлон уншигчдад ойлгомжтой хүргэсэн нь энэ хэсгийн дотоод уялдаа холбоосыг улам сайжруулж өгсөн байна. Үүний зэрэгцээ, эхний догол мөр нь өмнө танилцуулсан

Дүн шинжилгээний хүрээ хэсэг рүү холбоос хийж өгч байна. Дээр өгүүлсэнчлэн, баримт бичгийн дотоод логик холбоосыг дээд зэргээр хангаж өгөхийн тулд зохиогч дэд хэсэг бүрийн дотоод логик холбоосыг

байнга анхаарч байхын зэрэгцээ мөн бүрдэл хэсгүүдийг нийт баримт бичгийн логиктой холбоход анхаарч байх ёстойг энэ жишээ харуулж байгаа юм.

Жишээний нэг сонирхолтой шинж бол зохиогч бодлогын эхний хувилбарыг (алдагдлыг хянах) эсэргүүцсэн хүчтэй шүүмж өрнүүлээд, дараа нь харин өөрийн санал болгож буй бодлогын хоёрдахь хувилбарыг (зээлийг хязгаарлах) дэмжсэн үндэслэлээр төгсгөж байгаа явдал юм. Ер нь эхлээд дэмжихгүй байгаа хувилбарт шийдэл, байр суурийг шүүмжлээд, дараа нь өөрийн санал болгож буй хувилбарыг танилцуулах энэ аргыг зохиогч энэхүү баримт бичгийн туршид олонтаа ашиглажээ. Энэ арга нь зохиогчийн дэмжиж буй хувилбарыг танилцуулахаас өмнө бусад хувилбартай харьцуулан зохиогчийн сонголт яагаад зөв, оновчтой байгааг батлах бааз суурийг бэлдэн, зохиогчийн сонгосон хувилбарыг товойлгон гаргаж ирэхэд тустай юм. Уг арга нь гаргасан шийдвэрээ уншигчдад нуршилгүй, шууд хүргэх арга зам буюу хувилбар тус бүрээр хэрхэн шийдвэр гаргаснаа тайлбарлах бус харин хувилбар бүрийн тухайд “яагаад дэмжсэн бэ”, “яагаад дэмжээгүй вэ” гэсэн асуултад өгөх хариултад уншигчийн анхаарлыг төвлөрүүлж чадсан арга юм. Зохиогчийн дэмжиж буй бодлогын хувилбараар энэ хэсэг төгсөж байгаа нь баримт бичгийн хамгийн сүүлийн бүрдэл хэсэг болох зөвлөмжтэй шууд уялдаа үүсэж байна. Гэхдээ энэ арга хандлага зохихгүй олон тохиолдол, нөхцөл гарах тул зорилгодоо нийцсэн арга хандлагыг зохиогч өөрөө сонгох ёстойг дахин сануулья.

Ерөнхийд нь хэлэхэд, бодлогын хувилбаруудыг танилцуулах хэсэг нь хувилбар бүрт өгөх үнэлгээ, энэхүү үнэлгээг хамгаалсан тайлбар агуулсан байх нь нийтлэг ажиглагддаг. Энэхүү үнэлгээ дүгнэлтийг хамгаалсан тайлбар нь өмнө нь танилцуулсан Дүн шинжилгээний хүрээнд тулгуурлах ёстой бөгөөд бодлогын хувилбар нэг бүрийн давуу болон сул талуудыг тайлбарлах хэрэгтэй. Эцэст нь бодлогын тодорхой хувилбар бүрийг өмнө нь танилцуулсан бусад хувилбартай харьцуулж, улмаар энэ нь таны дэмжин санал болгож буй хувилбар мөн эсэхийг онцолж болно.

Энэ жишээ дэмжиж буй бодлогын хувилбараа хэрхэн танилцуулах талаар өөр нэг сонирхолтой аргыг харуулж байна. Хэдийгээр зохиогчид “зээлийг хязгаарлах” нь өнөөгийн энэ нөхцөл байдалд нийцсэн оновчтой бодлогын хувилбар мөн гэж дэмжиж байгаа ч зохиогч мөн

Дэмжиж буй бодлогын хувилбарынхаа сул талуудыг ч мөн тайлбарла.

ямар орчин нөхцөлд бодлогын өөрчлөлт буюу зээлийн хязгаарлалтыг сулруулах арга хэмжээ шаардлагатай болохыг бас дурджээ:

Гэхдээ зарим төсөл ашиг тусаа ирээдүйд өгөх тул орон нутгийн дэд бүтцийн хөгжилд зориулж зээл авахыг эдийн засгийн онолууд дэмждэг. Хөрөнгийн зардлыг урсгал төсвөөс санхүүжүүлснээс болж орон нутгийн хөрөнгө оруулалтын явц, үр ашиг үндэслэлгүй саарах юм. Тиймээс макро эдийн засгийн тогтворжилтод сөрөг нөлөөгүй санхүүжилтийн оновчтой механизмуудыг олох нь гол асуудал болоод байна.¹⁶ Гэтэл ихэнх улс орон нутгийнхаа урсгал зардлыг санхүүжүүлэх найдвартай бүтэц тогтолцоо бий болгох илүү тулгамдсан асуудлыг шийдэх хүртэл энэ чухал асуудлаа хойш тавих хэрэгтэй болж байна.

Бодлогын хувилбараа дагалдуулан ийнхүү нөхцөл зааж өгсөн явдал нь байнга өөрчлөгдөх нийгмийн маш ээдрээтэй бөгөөд мөн чанар нь байнга өөрчлөгдөх асуудал, бэрхшээлийг шийдэх хамгийн оновчтой бодлогыг боловсруулахдаа бодлогын мэргэжилтнүүд байнга хүндрэл бэрхшээлтэй тулгарч байдгийн тусгал юм. Иймд сонгосон бодлогын хувилбарын сайн талын зэрэгцээ сул талыг нь тодорхойлж уншигчдад хүргэх энэхүү арга хандлагыг бодлогын баримт бичиг боловсруулж буй хүн бүр анхаарч судлахад илүүдэхгүй болов уу.

Бичих явцдаа ашиглах хяналтын хуудас

Бодлогын хувилбарууддаа үнэлгээ өгөх, өгсөн үнэлгээ дүгнэлтээ тайлбарлан бичихдээ дараах асуултуудыг анхаараарай:

- Бодлогын ямар хувилбаруудыг та баримт бичигтээ авч үзэх гэж байна вэ?
- Та өөрөө аль хувилбарыг нь сонгон зөвлөж байна вэ?
- Та өөрийн сонгон зөвлөж буй энэ хувилбарыг дэмжин бичихдээ ямар арга хандлага ашиглах вэ?
- Таны сонгон зөвлөж буй энэ хувилбар ямар сул талуудтай вэ?

Бодлогын хувилбар бүрийн тухайд

- Энэ хувилбарын тухайд та ямар ерөнхий үнэлгээ өгч байна вэ?
- Энэ нь яагаад таны сонгон зөвлөж буй хувилбар мөн/ биш вэ?
- Таны ашигласан Дүн шинжилгээний хүрээнд багтсан шалгуур үзүүлэлтүүдийн аль нь таны энэ шийдвэрийн үндэс суурь болсон бэ?
- Энэ хувилбарын эерэг болон сөрөг шинж чанарууд юу вэ?
- Энэ хувилбарыг бодлогын бусад хувилбартай харьцуулахад ямар дүгнэлт гарч байна вэ?

5.7.2. Бодлогын хувилбаруудыг боловсруулах нь: Бичвэр ба үндэслэл

Бодлогын баримт бичгийн чадварлаг зохиогч бол баримт бичгийн бүрдэл элементүүдийн бүтэц, зохион байгуулалтыг мэдээд зогсохгүй бодлогын баримт бичгийн үндэслэлийг хэрхэн бичихтэй холбоотой бичвэрийн арга хандлага, уламжлалыг мэдэж байх ёстой гэсэн үндэслэлээр энэ дэд бүлгийн агуулгыг боловсрууллаа. Асуудлын тодорхойлолт бүрдэл элементийн бичвэр, үндэслэлийг тайлбарласан дэд бүлэгт (5.6.2) энэ асуудал мөн туссан билээ. Тэрхүү дэд бүлэгт авч үзсэн уялдаа холбоос, үндэслэлийн бүрдэл элементүүд, догол мөр зэргийг боловсруулахтай холбоотой олон асуудал энд ч мөн хамаатай юм. Тийм ч учраас энэ дэд бүлэгт бид дээрх хоёр бүрдэл элементийн ялгаатай талууд дээр төвлөрөх бөгөөд эдгээр ялгаа нь голдуу эх сурвалж ашиглахтай холбоотой юм. Хэрвээ та Асуудлын тодорхойлолт дэд бүлэг (5.6.2) -ийг уншаагүй байгаа бол энэ дэд бүлгийн агуулгыг ойлгоход тустай тул заавал уншиж танилцахыг зөвлөж байна.

Энэдэд бүлэгт бидний ашиглаж байгаа жишээ нь бодлогын хувилбаруудын үнэлгээнээс ишлэн авсан хэсэг төдий ч жишээгээр танилцуулах үндэслэл боловсруулах арга хандлага нь мөн Дүн шинжилгээний хүрээ бүрдэл элементэд ашиглаж болох зүйл юм.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

78 дугаар нүүрнээс Нэгдүгээр жишээ буюу “Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах нь: Захиргаадлаас зах зээлд” (Бёрд, Эбель, Воллих нар, 1995) гарчигтай баримт бичгийн бодлогын хувилбаруудыг тайлбарласан бүлгээс хэсэгчлэн авсан жишээг уншиж судална уу. Энэхүү жишээний ерөнхий агуулга, хөндөж буй тодорхой асуудлуудыг мэдэж байх нь доорх дүн шинжилгээг илүү сайн ойлгоход тус болох тул та Хавсралт 1-ээс баримт бичгийн Удиртгал хэсэг, 56 дугаар нүүрнээс Асуудлын тодорхойлолт хэсгийг тус тус уншаарай.

Уншиж байхдаа дараах асуултуудад анхаарлаа хандуулна уу:

- энэ бүрдэл элементийн хувьд зохиогчийн гүйцэтгэх үүрэг ролийг Асуудлын тодорхойлолт элемент дэх зохиогчийн үүрэг рольтой харьцуулах
- энэ бүрдэл элемент эх сурвалжийг ашиглаж байгаа байдлаараа Асуудлын тодорхойлолт элементээс хэрхэн ялгаатай байгаа нь

Жишээнд шинжилгээ хийж үзэхэд Бодлогын хувилбарууд болон Асуудлын тодорхойлолт бүрдэл элементүүдийн үндэслэл нь ялгаатай арга хандлагаар бичигдсэн нь анзаарагдаж байгаа бөгөөд үүнийг дараах тайлбараас харна уу.

- *Үндэслэлд зохиогчийн байр суурь илүү тодорхой илрэх нь*

Бодлогын хувилбарууд бүрдэл хэсэгт зохиогчийн дуу хоолой давамгайлах ёстой.

Жишээ болгон судалж буй Бодлогын хувилбарууд хэсэгт баримт өгөгдөл юмуу дүрслэн тайлбарласан гэхээсээ илүүтэй зохиогчийн санаа бодол, үнэлгээ дүгнэлт түлхүү орсон байгаа нь гүйлгээд уншихад л ойлгогдоно. Жишээлбэл, хэсэгчилсэн ишлэлийн дөрөвдүгээр догол мөрт багтсан

үндэслэл нь зөвхөн зохиогчийн өөрийн санаа бодол, логик, шийдвэрт тулгуурлажээ:

Захиргаадлын эдийн засгийн үед орон нутгийн зээл нь улсын зээлийн нэгдсэн төлөвлөгөөгөөр тодорхойлогдож, эргэн төлөлтийг нь улсын үйлвэрийн газрын зээлийн нэгэн адилаар төв банк хариуцдаг байжээ. Өнөөдөр бол орон нутагт зээлийн ийм өгөөмөр нөхцөл хангаж өгөх нь тохиромжгүй. Өөрийн орлогын эх үүсвэр нь хангалтгүй юмуу хязгаарлалттай орон нутгууд өрийн санхүүжилтийг хэтрүүлэн хэрэглэх магадлалтай юм. Шилжилтийн эдийн засагтай олон орны макро эдийн засаг тогтворжоогүй байгаа нь орон нутгийн зээл авах эрхийг улам бүр хязгаарлахыг шаардаж байна. Урсгал зардлаа санхүүжүүлэхэд зээл авах, эсвэл орон нутгийн банкиг өөрийн мэдэлд авах замаар зээл үнэгүй эх үүсвэртэй болох нэн зохимжгүй бодлого юм. Шинэ тутам байгуулагдаад байгаа орон нутгийн засаг захиргаадын ихэнх нь хөрөнгө оруулалтын зах зээлийн талаар туршлагагүйн дээр үндэслэлтэй, бүрэн хэмжээний төсөл боловсруулж, хэрэгжүүлэх чадвартай нь цөөн байна.

Бодлогын хувилбарууд дотроос хамгийн оновчтой гэж үзсэн нэгийг сонгохдоо зохиогчид өөрсдийн байр суурийг маш хүчтэй илэрхийлж байгаагийн жишээ энэ юм. Үнэхээр ч энэхүү ишлэлийн туршид зохиогчийн байр суурь илт давамгай илэрч байна. Энэ арга хандлага нь мөн тухайн бүрдэл элементийг бичихдээ эх сурвалжуудыг хэрхэн ашиглахыг тодорхойлж өгнө.

- *Үндэслэлд анхдагч болон хоёрдогч эх сурвалжийг тод томруун ашиглахгүй байх*

Бодлогын хувилбаруудын үнэлгээгээр зохиогч өөрийн мэргэжлийн мэдлэг, бүтээлч чадвараа нээж харуулдаг.

Асуудлын тодорхойлолт хэсэгтэй харьцуулахад энэ бүрдэл элементийг бичихдээ эх сурвалжуудыг төдийлөн товчлон гаргаж ирдэггүй болох нь дүн шинжилгээнээс харагдаж байна. Юуны өмнө, энэ элементэд зохиогч давамгай үүрэг рольтой байх ёстой тул энд анхдагч болон хоёрдогч

цөөн эх сурвалжийг нотолгоо болгож ашигладаг. Хоёрдугаарт, энэ бүрдэл элементэд тусах байр суурь нь хүчтэй бөгөөд илт тодорхой

байх ёстой тул зохиогчийн энэхүү байр суурийг дэмжихэд ашиглаж болох эх сурвалжууд нь дүрслэн өгүүлэх баримт бус харин голдуу үзэл бодол, байр суурийг илэрхийлсэн эх сурвалжууд байдаг. Гуравдугаарт, хэдийгээр хоёр бүрдэл элементэд эх сурвалжийг ижил зориулалтаар буюу зохиогчийн дэвшүүлсэн санааг хамгаалах нотолгоо маягаар авч ашиглаж байгаа ч бичвэр дотор ишлэл хэлбэрээр бус харин төгсгөлийн тэмдэглэл (endnote) хэсэгт багтаан нэмэлт маягаар хүргэж байгаа нь эх сурвалжуудын үүрэг ролийг сулруулж, анхаарлын төвөөс гаргаж байна. Энэ нь харин зохиогчийн өөрийн дуу хоолойг тодотгох бас нэгэн арга болжээ.

Бодлогын хувилбарууд хэмээх энэхүү бүрдэл элемент нь бодлогын судлаачдаас мэргэжлийн мэдлэгээ харуулж, санал болгож буй бодлогын хувилбараа ухуулан таниулахад манлайлагчийн үүрэг ролийг өөртөө авч, байр сууриа хүчтэй илэрхийлэхийг шаарддаг. Бодлого судлал нь бодитой оршиж буй асуудал, бэрхшээлийг шийдэх чиглэлтэй, тодорхой нарийн фокустай байх ёстой гэдгийг санах юм бол таны санал болгож буй шийдэл нь тулгамдсан асуудлыг үр бүтээлтэй шийдэх практик шийдэл мөн учраас өрнөж буй бодлогын хэлэлцүүлэг, нийт бодлогын сүлжээний үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр болж чадна гэдгээ батлан харуулах боломж танд олдоод байна.

Бичих явцдаа ашиглах хяналтын хуудас

Бодлогын хувилбарууд хэсэгтээ ашиглах хүчтэй сайн үндэслэл боловсруулахын тулд та дараах асуултуудад анхаарлаа хандуулаарай:

Уялдаа холбоос

- Асуудлын тодорхойлолт болон Бодлогын хувилбарууд элементүүдийг хооронд нь илэрхий, ойлгомжтой уялдуулж чадсан байна уу?
- Бодлогын хувилбарууд элементийнхээ бүх дэд бүлгүүдийг хооронд нь сайн холбож өгсөн үү?
- Бодлогын хувилбарууд элементийн дэд бүлэг болгоны нь дотоод логик уялдаа холбоос сайн болж чадсан уу?

Үндэслэл

- Таны үндэслэлийн бүрдэл элемент бүр нь мэдэгдэл, дэмжлэг, баталгаа агуулсан байна уу?

Догол мөрийн зохион байгуулалт

- Бодлогын хувилбарууд элементийн догол мөрүүдийн хуваагдалт оновчтой, биет хуваагдал нь уншиж байгаа хүнд бичвэрийг хялбар ойлгоход тус нэмэр болж байна уу?
- Та үндэслэлийнхээ логик нэгж бүрийг бие даасан догол мөр болгож бичиж чадсан уу?
- Догол мөрүүд тань хоорондоо уялдаа холбоотой байна уу?

Зохиогчийн дуу хоолой ба эх сурвалжууд ашигласан байдал

- Бодлогын хувилбарууд элементийн туршид та өөрийн байр суурь, логикийг давамгайлэрхийлж чадсан уу?
- Энэ бүрдэл элементэд ашигласан эх сурвалжийн тоо Асуудал тодорхойлох хэсгийнхээс цөөн байна уу?
- Өөрийн үндэслэлийг дэмжсэн нотолгоо маягаар эх сурвалжуудаа ашигласан уу?
- Та өөрийн судалгааны салбарт хэвшсэн, эсвэл хэвлэн нийтлэгчийнхээ баримталдаг ишлэлийн хэлбэр загварыг мөрдсөн үү?

5.8. Дүгнэлт, зөвлөмжүүд

Дүгнэлт хэсэг нь бодлогын баримт бичгийг шийдвэр гаргах хэрэглэгдэхүүн болгож өгдөг.

Бодлогын баримт бичгийн эцсийн томоохон бүрдэл элемент нь судалгааны гол үр дүнгүүдийг нэгтгэн, баримт бичгийн туршид шинжилж ирсэн асуудал, бэрхшээлийг шийдэхийн тулд зохиогчийн санал болгож буй үйл ажиллагаануудыг танилцуулснаар баримт бичгийг төгсгөн хааж өгдөг. Үүгээр ч бодлогын баримт бичгийг шийдвэр гаргалтад ашиглах хэрэглэгдэхүүн, арга хэмжээ авах уриалга болгох туйлын зорилго хангагдаж байгаа болно. Дүгнэлт, зөвлөмжүүд нь бодлогын баримт бичгийн хамгийн сүүлд байрлах чухал бүрдэл элемент тул уншигчдад удаан хугацаанд мартагдахааргүй сэтгэгдэл үлдээх үүрэг хариуцлагыг үүрдэг. Унших үйл явцын өрнөл, мөн уншигчдын гол сонирхлыг санах юм бол энэ бүрдэл элементийн гүйцэтгэдэг өөр нэг үүрэг роль нь тодорч гарч ирнэ. Олон уншигч бодлогын баримт бичгийг бүхэлд нь уншихаасаа өмнө эхлээд энэ хэсгийг Удиртгал, Тойм/ Хураангуйн хамтаар уншиж үздэг. Тэгэхээр Дүгнэлт, зөвлөмжүүд хэсэг нь баримт бичгийн маш тодорхой тоймыг уншигчид хүргэх нэн чухал үүрэг гүйцэтгэнэ. Зарим уншигч тухайн баримт бичигт санал болгож буй бодлогын зөвлөмжүүдийн л онцгойлон сонирхох тул эхлээд зөвлөмжүүдийг уншаад, дараа нь л бодлогын баримт бичгийг бүхэлд нь унших нь бий.

Энэ бүрдлийн мөн чанарыг илүү сайн тайлбарлахын тулд бид дараах хоёр жишээг авч үзэж байна.

Хэвлэн нийтлэгдсэн баримт бичгийн шинжилгээ

Хоёр ба Гуравдугаар жишээний Дүгнэлт, зөвлөмжүүд хэсгийг уншина уу. Эдгээр баримт бичгийн контекстийг ойлгохын тулд Хавсралт А-аас эдгээрийн Удиртгал хэсгүүдийг мөн уншаарай.

Уншиж байхдаа дараах асуудлуудад анхаарлаа хандуулаарай:

- уг бүрдэл элементийн бүтэц, агуулга
- шийдвэр гаргалтад ашиглах хэрэглэгдэхүүн гэдэг талаасаа эдгээр жишээ баримт бичгийн үр нөлөө

Жишээ 2. “Орон нутгийн түвшний төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл явц дахь нээлтэй өрсөлдөөн, ил тод байдал, төвийг сахисан байр суурь” (Баар, 2001)

Дүгнэлт

Энэ судалгаанд хамруулсан Төв болон Зүүн Европын орнуудын төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой бодлого, зохицуулалтуудад ноцтой хэд хэдэн доголдол байна. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын багагүй хэсэг нь өрсөлдөөнт худалдан авалтын шаардлагаас чөлөөлөгдсөн, гэрээг голдуу нууцалдаг, ашиг сонирхлын зөрчил бараг зохицуулагдаагүй байна. Ийм нөхцөлд олон нийт гэрээгээр ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх үйл явцад итгэх, хүндэтгэх үндэс бүрдэхгүй байгаа тул олон нийтийн оролцоо, хяналтын үнэ цэнэ алдагдаж байна.

Энэ чиглэлээр шинэчлэл хийхдээ дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна:

1. Төрийн үйлчилгээг гүйцэтгүүлэх бүх гэрээ (маш жижиг гэрээнээс бусад нь) заавал өрсөлдөөнт худалдан авалтын үйл явцаар дамжих ёстой.
2. Төрийн өмчийг худалдах, түрээслүүлэх болон төрийн өмчийн хувьцааг худалдах үйл явц нь төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй ижил тооцогдож, өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар шийдэгдэж байх ёстой.
3. Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхээр хувийн компанитай байгуулсан бүх гэрээ олон нийтэд ил тод байх ёстой (гэрээний онцгой нөхцөлтэй холбоотой тодорхой хэсэгт хамаарахгүй байх маш явцуу боломж байж болно).
4. Төрийн үйлчилгээг гүйцэтгүүлэх тухай гэрээний төслийг боловсруулахдаа нээлттэй, олон нийтийн санал, хүсэлтийг хүлээн авч тусгах боломжтой үйл явц бий болгох ёстой.
5. Үнэ тогтоох үйл явцад оролцуулахаар ирүүлсэн бүх мэдээлэл олон нийтэд нээлттэй байх ёстой.
6. Сонирхлын зөрчлийн хуульд дараах асуудлуудыг багтаах шаардлагатай:
 - а. Сонирхлын зөрчлийг өргөн утгаар нь харж тодорхойлох
 - б. Төрийн албан хаагч хөрөнгө орлогоо мэдүүлэх, түүнийг нь олон нийтэд нээлттэй болгох шаардлага оруулах
 - в. Төрийн албанаас гарсан хүн тодорхой хугацааны туршид хувийн компанийг төлөөлөхийг хориглох заалт оруулах
 - г. “Шүгэл үлээгчид”-ийг хамгаалах тухай заалтууд нэмэх
 - д. Хууль зөрчигсдөд хариуцлага хүлээлгэх
 - е. Сонирхлын зөрчлийн хуулийн хэрэгжилтийг хариуцсан үндэсний бие даасан хороо байгуулах

Төрийн үйлчилгээний өртөг зардлыг даахгүй байгаа нөхцөлд хөрөнгө оруулалт хийлгүй орхих, эсвэл энэ үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж болно. Гэхдээ энд санал болгож буй шинэчлэлийн арга хэмжээнүүд нь төсвийн хөрөнгө мөнгө шаардахгүй хэрнээ одоо хэрэгжиж байгаа төрийн үйлчилгээнүүдийн хөрөнгө оруулалтыг нэлээд нэмэгдүүлэх боломж гаргаж өгч байгаа юм.

Жишээ 3.

“Идэвхтэй сайшаах, идэвхгүй дэмжих ба үл итгэн хойш суухын хооронд” (Свианиевич, 2001)

Дүгнэлт

Уг бүлгийн эхэнд тэмдэглэсэнчлэн, дүн шинжилгээнд хамруулсан улс орнууд орон нутгийн засаг захиргааны тогтолцоог бүрдүүлэхдээ нутгийн ардчиллын өөр өөр үнэт зүйлсэд гол анхаарлаа хандуулжээ. Чех, Словак улсууд орон нутгийн иргэдийн төлөөллийг хангахтай холбоотой үнэт зүйлсэд илүү анхаарсан бол Польшийн шинэчлэл харин үйлчилгээ хүргэлтийн үр нөлөөг дээшлүүлэхэд төвлөрчээ. Энэ ялгаа болон тухайлбал, Польш Улс том хотууд олонтой байхад бусад улсууд олон жижиг нэгжид хуваагддаг зэрэг нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын ялгаанууд нь орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн харилцаанд тодорхой хэмжээнд туссан байна.

Энэ бүлгийн эхэнд танилцуулсан загвараар тооцоолж үзэхэд, орон нутгийн сонгуульд оролцсон байдлаар хэмжсэн орон нутгийн засаг захиргаанд итгэх итгэл, орон нутгийн нийтийн үйл хэрэгт оролцох сонирхол нь Чех, Словак улсуудад өндөр байхад хотын захирагчийг халж солих явдал Польш Улсад хамгийн их байна. Гэтэл нөгөө талаас, Польшийн орон нутгийн засаг захиргааны тогтолцоо нь хамгийн олон төрлийн төрийн үйлчилгээний төвлөрлийг хамгийн үр нөлөөтэйгээр сааруулах боломжийг олгож байна. Гэвч энэ бол уг бүлгийн хамрах хүрээнээс хальсан асуудал юм. Энэ догол мөрт авч үзсэн улс орнуудын хоорондын ялгаа нь тэдгээрийн “философийн баримтлал”-ын ялгаа, мөн тэдний нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын ялгаанаас үүдсэн байх магадлалтай.

Гэтэл дээр тайлбарласан олон тооны нарийн ялгааны хажуугаар шинжилгээнд хамруулж үзсэн 4 улсын орон нутгийн засаг захиргаа - иргэдийн харилцааны ерөнхий дүр зураг ихээхэн төстэй байгаа юм. Ингэхдээ энэ дүр зураг энгийн биш байгаа нь сонирхолтой. Юуны өмнө орон нутгийн засаг захиргаа байгаа эсэх нь өөрөө олон нийтийн анхаарлыг татахааргүй асуудал гэж үзэж огт болохгүй. Ихэнх хүн төв засгийн газар гэхээсээ илүүтэй орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаанд илүү сэтгэл хангалуун байна. Орон нутаг, хотын захиргаа нь гайгүй сайн ажилладаг гэж тэд үздэг. Мөн орон нутгийн засаг захиргаа зөвхөн тодорхой жижиг бүлгийн бус харин нутгийнхны бүгдийнх нь ашиг сонирхлыг төлөөлөхийг хичээдэг гэж үзжээ.

Гэхдээ орон нутгийн засаг захиргаа нь хүн бүрийн хайр, итгэлийг хүлээж, нийтийн ашиг сонирхлын төлөө орон нутгийн иргэдийг дайчлан хөдөлгөдөг хүч гэсэн хэт өөдрөг дэврүүн дүр зурагт итгэх нь мөн л нөхцөл байдлыг хэт хялбарчилж харсан хэрэг болно. Нэгдүгээрт, дээр дурьдсан олон нийтийн үзэл хандлага нь хүн бүрийн дуу нэгтэй зөвшөөрсөн зүйл бас биш юм. Олон иргэн оролцохгүй байхаар шийдэж, улмаар орон нутгийн засаг захиргааны ажил, гүйцэтгэлийн талаар тодорхой бодол, үнэлгээтэй болж чадахгүй байх нь элбэг байна. Орон нутаг авилгад автах вий гэсэн айдас байдаг ч тухайлбал, Унгарт орон нутгийн засаг захиргаа нь төв засгийн газраас илүү шударга гэдэгт хүмүүс ерөнхийдөө итгэж байна (Польшид бол үгүй). Орон нутгийн сонгуулийн ирц нь парламентын сонгуулийнхаас хамаагүй бага, ялангуяа Словак, Польшид ерөнхийлөгчийн сонгуулийнхаас илт бага байна. Энэ жишээ нь орон нутгийн түвшний улс төрийн амьдралд хүмүүсийн оролцоо бага, үүнийг харьцангуй ач холбогдол багатай гэж үзэх хандлагын бас нэг жишээ юм.

Гэхдээ орон нутгийн засаг захиргаанд хандах олон нийтийн хандлага бүхэлдээ бол сөрөг биш байгааг онцлох хэрэгтэй. Тэр ч байтугай засаг захиргаанд итгэх итгэл зэрэг зарим үзүүлэлтээр олон нийтийн хандлага бүхэлдээ эерэг байгаад зогсохгүй ихэнхдээ тогтвортой байгаа юм. Гэтэл төвийн түвшний улс төрийн төв институцүүдэд (засгийн газар, их хурал, ерөнхийлөгч) үзүүлэх олон нийтийн дэмжлэг харьцангуй богино хугацаанд ч гэсэн нэлээд хэлбэлзэлтэй байна. Зарим тохиолдолд шилжилтийн эхэн үед орон нутгийн засаг захиргаанд хэт их итгэл найдвар тавьж байсан тул төд удалгүй урам хугарч, итгэл нь мохох явдал ажиглагдаж байв. Харин яваандаа орон нутгийн төр захиргаанд итгэх итгэл, түүний үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамж, сонирхлын түвшин хүсэж байсан хэмжээнээс хамаагүй доогуур ч гэлээ муу гэж хэлэмгүй хэмжээнд тогтворжсон байна.

Эцэст нь хэлэхэд, хувь иргэдийн хандлага маш олон янз байна. Тэдний зарим нь “идэвхтэй сайшаах” байр суурьтай байгаа бол өөр нэг хэсэг нь “идэвхгүй хүлээн зөвшөөрч”, бусад нь “үл итгэн хойш суусан” байр суурьтай байна. Энэ гурван бүлгийн аль аль нь анхаарал татахуйц том хэмжээтэй тул биднийг ч гэсэн хэт хялбарчилж хандахаас сэргийлэхэд хүргэж байгаа юм.

Практик зөвлөмжүүд

Энэхүү судалгаанаас амьдралд хэрэгжүүлж болох ямар зөвлөмжүүд гарах вэ? Эдгээрийг дараах байдлаар тоймлон дүгнэж болох юм:

- *Судалгааны хүрээнд авч үзсэн улс орнуудын орон нутгийн засаг захиргаа бол бэхжсэн, хүлээн зөвшөөрөгдсөн ардчиллын институцүүд юм.* Энэ бол орон нутгийн ардчилалд дээр дурьдсан цөөнгүй олон сул тал байгааг үл харгалзан хэлж болох дүгнэлт юм. Тиймээс орон нутгийн засаг захиргааны байр суурийг цаашид ч улам бэхжүүлэх нь ардчилсан тогтолцоог бүхэлд нь бэхжүүлэх оновчтой арга зам болох магадлалтай.
- *Төвлөрлийг сааруулахад чиглэсэн шинэчлэлийн талаар илүү их мэдээлэл шаардлагатай байна.* Судалж үзсэн кейсүүдийн дотор хүн амын дийлэнх нь төвлөрлийг сааруулах шинэчлэлийг дэмжиж байгаа тохиолдол давамгайл байна. Гэхдээ зарим тохиолдолд цаг хугацааны явцад энэ дэмжлэг сулран замхарч байв. Энэ нь хэрэгжүүлж эхэлж буй өөрчлөлт шинэчлэлийн зорилго, тэдгээрийн бодит амьдралд үзүүлэх нөлөө, үр дагаврын тухай мэдээлэл хангалтгүй байсантай бүхэлдээ биш юмаа гэхэд тодорхой хэмжээнд холбоотой гэж үзэх баримт, нотолгоо байна.
- *Лавшруулан судлах шаардлага байна.* Орон нутгийн засаг захиргаа, иргэдийн хоорондын харилцааг сайжруулах аргуудын талаар бид их зүйл мэддэг ч эдгээр аргыг бодит амьдралд хэрхэн хэрэглэх, ингэснээр ямар үр дүн гарах талаар системтэй мэдээлэл алга. Иймд юуны өмнө эдгээр асуудлыг илүү сайн судлахыг зөвлөж байна. Үүнээс гадна, орон нутгийн засаг захиргаа ямар аргуудыг хэрэглэж байгааг бид мэднэ. Тэгэхдээ системтэй дүн шинжилгээний түвшинд бус зөвхөн кейс судалгааны түвшинд ажиллаж байгаа бид эдгээр арга хэр өргөн дэлгэр ашиглагдаж байгааг хэлж чадахгүй. Энэхүү мэдээллийн хомсдол нь улам их судлахыг шаардаж байгаа юм.
- *Илүү их зөвлөлдөх шаардлагатай ч энэ нь зөвхөн хамгийн идэвхтэй бүлгүүдийн эрх ашигт үйлчлэх ёсгүй.* Иргэдийнхээ хүсэл сонирхлыг олж мэдэн, орон нутгийн түвшний бодлого боловсруулалтад тусгах чиглэлээр илүү идэвхтэй ажиллахад орон нутгийн засаг захиргаадыг урамшуулан зоригжуулах нь зүйтэй. Гэхдээ зөвлөлдөх үйл явцад бас зайлсхийх шаардлагатай занганууд байдгийг анхаарах хэрэгтэй. Санаа бодлоо идэвхтэй илэрхийлдэг бүлгүүд ихэвчлэн харьцангуй жижиг хэмжээтэй байдаг учраас олон нийттэй харилцах олон янзын арга техникийг ашигласнаар бодлого, шийдвэр гаргахдаа эдгээр бүлгийн ашиг сонирхолд хөтлөгдөхөөс зайлсхийж болох талаар санаж, болгоомжтой хандах хэрэгтэй болдог.

- *Орон нутгийн үйлчилгээний чанарт эн тэргүүнд анхаараарай.* Бодлого боловсруулах үйл явцад шууд оролцох иргэдийн сонирхол харьцангуй сул байдгийг харгалзан үзвэл орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааны талаар, улмаар орон нутгийн ардчиллын чанарын талаарх иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх хамгийн оновчтой стратеги бол орон нутгийн үйлчилгээний чанарыг сайжруулах явдал болж болно. Энэ нь олон тохиолдолд интерактив засаглал, харилцааны олон янзын арга ашиглахаас ч илүү чухал байж мэднэ. Сайн үйлчилгээтэй орон нутгийн иргэд нь бодлого, шийдвэр гаргалтад өөрсдийнх нь санаа бодол тусгалаа олдогт илүү итгэх хандлагатай байдгийг Унгарын жишээ бидэнд харуулж өгсөн. Нөгөө талаас, тааруухан үйлчилгээтэй орон нутгийн иргэд өөрсдийнх нь дуу хоолойг огт сонсохгүй байна гэж үзэх хандлагатай байдаг ажээ.

Эдгээр болон бусад жишээнд шинжилгээ хийж үзэхэд бодлогын баримт бичгийн Дүгнэлт, зөвлөмж бүрдэл хэсэг нь бүтцийн гурван элементийг агуулдаг байна.

Дүгнэлт, зөвлөмж	}	<ul style="list-style-type: none"> - Гол үр дүнгүүдийн синтез - Бодлогын зөвлөмжүүдийн багц - Хаалтын үг
---------------------	---	---

Энэ бүлгийн дараагийн хэсэгт дээрх гурван бүрдэл элементийг бодлогын баримт бичигтээ зориулж боловсруулахад танд тус болох тайлбар, зааврыг багтаалаа.

- ***Гол үр дүнгүүдийн товч синтез***

Синтез нь Асуудлын тодорхойлолт, Бодлогын хувилбарууд элементүүдийн гол санаануудыг товчлолгоон харуулдаг.

Дүгнэлт, зөвлөмжүүд хэмээх энэхүү бүрдэл элемент нь өмнөх хоёр элементийн (Асуудлын тодорхойлолт, Бодлогын хувилбарууд) хамгийн гол үр дүнгүүдийн синтезээс эхэлнэ. Бодлогын судалгаа нь урт, ярвигтай, нарийн тайлбар ихтэй байж болох тул дүгнэлт өгч, гол гол үр дүнгээ тоймлон синтез хийх нь тодорхой зөвлөмжүүд санал болгож эхлэхээс өмнө хийх нэгэн чухал алхам болно. Гэхдээ энэ бол гол үр дүнгүүдийн

тойм юмуу давталт төдий биш харин дүн шинжилгээний хамгийн чухал, жинтэй үр дүнгүүдийг хооронд нь уялдуулан зангидаж, товчлолгоон харуулах үүрэгтэй синтез байх ёстой бөгөөд дараагийн бүлэг болох Зөвлөмжүүдийг дэмжих, үндэслэл нь болох зорилгод үйлчилдэг.

Дээр бидний дүн шинжилгээндээ ашигласан дүгнэлт, зөвлөмж хоёрын аль алиных нь зохиогчид судалгааныхаа гол гол үр дүнг синтезлэн, дүгнэлт хийхдээ өөртөө бүрэн итгэлтэй, маш шийдвэртэй өнгө аясаар бичиж

найруулсан байх ба энэ бол уг бүрдэл элементийг бичихдээ анхаарах ёстой нэгэн чухал зүйл юм. Гэхдээ хоёр жишээ синтез хэсгийнхээ уртын хэмжээ, нарийвчлалын түвшнээр хоорондоо ихээхэн ялгаатай байна. Хоёрдугаар жишээний синтез хэсэг ганц богино догол мөрөөс бүрдэж байхад Гуравдугаар жишээний энэ элемент нэг нүүрэнд батгахааргүй урт байна. Энэ бүрдлийг бичихэд судалгааны нарийн төвөгтэй байдал, хэрэглэсэн арга, ашигласан тоо баримт, дүн шинжилгээнд хамруулан авч үзсэн асуудлын тоо зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг тул яг хэдий хэмжээний урттай байх талаар ямар нэг заавар өгөх боломжгүй юм. Та бодлогын баримт бичгийнхээ энэ элементийг бичихдээ араас нь залган танилцуулагдах бодлогын зөвлөмжүүд тань логиктойгоор “урсан” гарч ирж байхын тулд хийж гүйцэтгэсэн судалгааныхаа гол үр дүнгүүдээс алийг нь багтаах, хэдий хэмжээнд нарийвчлан танилцуулахаа маш сайн бодож, төлөвлөх хэрэгтэй. Харин энэ хэсгийн зорилго бол судалгааны хамгийн чухал үр дүнгүүдийг тоймлон харуулаад, аль болох хурдан зөвлөмжүүдээ танилцуулж эхлэх явдал гэдгийг битгий мартаарай.

- Бодлогын зөвлөмжүүдийн багц

Энэ хэсэгт бид баримт бичгийнхээ Бодлогын хувилбарууд хэсгээр үндэслэл, нотолгоог нь гаргаж өгсөн оновчтой бодлогын хувилбарыг хэрэгжүүлэхэд шаардлагатай практик алхмуудыг танилцуулна. Бодлогын судалгааны үндсэн зорилго нь бодлогын асуудлаар өгөгдөл цуглуулж, дүн шинжилгээ хийх бус харин хийсэн судалгааны үндсэн дээр багц зөвлөмж боловсруулах явдал тул энэ бүрдэл элемент нь бодлогын баримт бичгийн амин сүнс, цөм нь юм.

Бодлогын асуудлыг шийдэхийн тулд ямар арга хэмжээнүүд санал болгож байгаагаа танилцуул.

Таны санал болгож буй зөвлөмжүүд нь судалгааны туршид гол фокус болж ирсэн бодлогын тэр асуудлыг шийдэх оновчтой арга зам мөн гэдэгт уншигчийг ятгаж итгүүлэхийн тулд тодорхой, практик, ятгаж чадахуйц, дотоод логик сайтай, цогц байх шаардлагатай. Бусад зохиогчдын ашигладаг янз бүрийн арга хандлагыг судалснаар үр нөлөөтэй зөвлөмж бичихдээ хэрэглэж болох санаануудыг олж болох юм. Тухайлбал, Гуравдугаар жишээний зохиогч энэ хэсгээ “Практик зөвлөмжүүд” гэж нэрлэснээрээ зөвлөмжүүд нь тухайн асуудлыг бодитойгоор шийдэх практик шийдэл мөн гэсэн дохиог уншигчдад өгч байна. Зохиогч мөн зөвлөмж бүрийнхээ гол санааг тун тодорхой бөгөөд товчхон нэг өгүүлбэрээр тоймлон илэрхийлсний дараа араас нь дэлгэрэнгүй тайлбар, үндэслэлийг дэлгэн тайлбарлажээ. Жишээлбэл:

Судалгаанд хамруулан авч үзсэн улс орнуудын орон нутгийн засаг захиргаа бол бэхжсэн, хүлээн зөвшөөрөгдсөн ардчиллын институцүүд юм. Энэ бол орон нутгийн ардчилалд дээр дурьдсан цөөнгүй олон сул тал байгааг үл харгалзан хэлж болох дүгнэлт юм. Тиймээс орон нутгийн засаг захиргааны байр суурийг цаашид ч улам бэхжүүлэх нь ардчилсан тогтолцоог бүхэлд нь бэхжүүлэх оновчтой арга зам болох магадлалтай.

Үүнээс ялгаатайгаар Хоёрдугаар жишээний багц зөвлөмжүүд нь маш товч, тодорхой, тус бүр нь нэг өгүүлбэрээс бүрдсэн байна. Жишээлбэл, “5. Үнэ тогтоох үйл явцад оролцуулахаар ирүүлсэн бүх мэдээлэл олон нийтэд нээлттэй байх” гэжээ. Зөвлөмж бичих арга хандлагаа сонгох гэж байгаа бол таны судалгааны сэдэв, гол үр дүнгүүд, санал болгож буй шийдлийн төрөлд аль нь илүү тохирох талаар та сайн бодож эргэцүүлэх хэрэгтэй болно.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

Өмнөх хайрцагт өгсөн жишээ дүгнэлт, зөвлөмжийг дахин нэг гүйлгэж уншина уу. Уншиж байхдаа дараах асуудалд анхаарлаа төвлөрүүлнэ үү:

- Багц зөвлөмжүүдийн дизайн, хэлбэр зэрэг уншигчид хүргэж буй арга

Санал болгож буй шийдлийг бие даасан үйл ажиллагаануудад хуваа.

Бодлогын асуудлыг бодитойгоор шийдэх арга зам нь голдуу стратеги байдаг болохоор асуудлыг цорын ганц зөвлөмж бүрэн гүйцэд шийдэж өгч чадахгүй. Иймд зохиогчид зөвлөмжүүдээ асуудал болон шийдлийнхээ аль нэг талыг хөндсөн бие даасан саналуудад хуваадаг бөгөөд энэ нь бидний судалж буй хоёр жишээнээс тодорхой харагдаж байна. Хоёрдугаар жишээ нь төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх талаар бодлогын хувилбар санал болгохдоо зургаан чиглэлээр зөвлөмж өгчээ. Энэ нь эдгээр зөвлөмж бол бодит амьдралд хэрэгжүүлэх зориулалттай практик санал мөн гэдгийг ойлгуулах дохио болохын зэрэгцээ багц зөвлөмжүүдийг боломжийн хэрээр тодорхой, ятгаж итгүүлэх утга агуулгатай болгох боломж олгож байна. Багц зөвлөмжүүдээ дотор нь хувааж, танилцуулахдаа уншиж буй хүнд зөвлөмж бүрийг төвөггүй олж хараад, хялбар ойлгох загвар, форматыг зохиогчид ашигладаг. Зөвлөмжүүд нь дараах хэлбэртэй байж болох юм:

- Ач холбогдлыг нь илэрхийлсэн гарчиг бүхий бие даасан хэсгээр илэрхийлэх (Жишээ 3);

- Бичвэр дотроо дугаар, догол мөрийн зайгаар онцлох (Жишээ 2);
- Буллет тэмдэглэгээг ашиглан онцлох (Жишээ 3);
- Гол санаа, түлхүүр үгийг налуу үсгийн хэвээр онцлох (Жишээ 2).

Багц зөвлөмжүүдээ бичиж байхдаа эдгээрийг хэрхэн логикийн хувьд бие даасан хэд хэдэн санал болгож хуваан багцлах, мөн бичвэр дотроос ялгаж харахад хялбар болгохын тулд ямар хэлбэр загвар ашиглах тухайгаа бодоорой.

- **Хаалтын үг**

Заримдаа зохиогчид бодлогын баримт бичгийн туршид дэлгэн танилцуулсан үндэслэлээ төгсгөхийн тулд товч хаалтын үг нэмэх аргыг сонгодог. Энэ нь тухайн баримт бичгийн сэдэвтэй холбоотой зарим нэг санааг цааш үргэлжлүүлэн бодуулахаар уншигчдад үлдээх давхар зорилготой. Үг хэсгийг бичихдээ зохиогчдын нийтлэг хэрэглэдэг нэг арга бол голдуу баримт бичгийн эхэнд дурьдагддаг асуудлын хүрээлэл болж буй нөхцөл байдалд уншигчдын анхаарлыг эргүүлэн хандуулах замаар сэдвийн хэлэлцүүлгийг битүүлэн, хаах хандлага юм. Ингэснээр баримт бичиг нь бүрэн гүйцэд, бүхэллэг шинж чанартай болж, зохиогчийн санал болгож буй шийдэл нь нийгэмд бүхэлд нь ул суурьтай нөлөөлж чадахыг уншигчдад тайлбарласнаар зохиогчийн дэлгэн танилцуулсан үндэслэлийг хааж өгөх юм. Дүн шинжилгээндээ бидний ашигласан жишээнүүдэд ийм бүрдэл хэсэг багтаагүй ч гэлээ таны бичиж боловсруулсан бодлогын баримт бичигт ийм хэсэг зохимжтой эсэхийг та бодож үзээрэй.

Хаалтын үг нь бодлогын баримт бичгийг төгсгөн, хааж өгнө.

Бичиж байхдаа ашиглах хяналтын хуудас

Баримт бичгийнхээ энэ бүрдэл хэсгийг бичиж боловсруулахад дараах асуултууд танд тусална:

- Та судалгааныхаа зөвхөн хамгийн гол үр дүнгүүдийг л синтезлэж бичсэн үү?
- Та зөвлөмжүүдээ логикийн хувьд бие даасан арга хэмжээ болгон хувааж, ялгаж харахад хялбар хэлбэр загварт оруулсан уу?
- Бүх зөвлөмжөө оновчтой сайн томъёолж бичсэн үү?
- Хаалтын хэсэг нь баримт бичиг бүрэн гүйцэт, бүрдэж дууссан сэтгэгдэл төрүүлж чадаж байна уу?

5.9. Төгсгөлийн тэмдэглэл

Хэвлэгдэн гарсан бодлогын баримт бичгүүдэд Дүгнэлт, зөвлөмжүүд хэсгийн дараа “Төгсгөлийн тэмдэглэл” гэсэн гарчигтай бие даасан хэсэг багтсан байдаг. Энэ хэсэг бол баримт бичгийн бичвэрийн тодорхой хэсэгтэй холбоотой тайлбаруудын дугаарласан жагсаалт юм. Зарим хэвлэн нийтлэгч ийм тайлбарыг харгалзах нүүр бүрийн доор зүүлтээр бичвэр дотроо багтааж өгөх журам баримталдаг. Зарим салбарт бүх эх сурвалжаа зүүлт, төгсгөлийн тэмдэглэлээр өгдөг ч энэ нь бодлогын судалгааны салбарт нийтлэг хэрэглээ болж хэвшээгүй болно. Бодлогын баримт бичгүүдэд эх сурвалж дурьдах “зохиогч, огноо” гэсэн системүүд зүүлт (footnote), төгсгөлийн тэмдэглэл (endnote)-ийн алийг нь ч ашиглах боломж олгодог бөгөөд алийг нь ашиглахыг ихэвчлэн хэвлэн нийтлэгч шийддэг. Ийнхүү ишлэлийн системүүд нь нэмэлт тайлбар оруулах боломж олгодог ч зохиогч аль болох цөөн нэмэлт тайлбар хэрэглэхийг хичээх нь зүйтэй. Дараах шинжилгээнд бодлогын баримт бичигт энэ элементийн гүйцэтгэх үүргийг тайлбарлав.

Хэвлэн нийтлэгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээ

“Идэвхтэй сайшаах, идэвхгүй дэмжих ба үл итгэн хойш суухын хооронд” (Свианиевич, 2001) гарчигтай жишээ баримт бичгийн “Төгсгөлийн тэмдэглэл” хэсгийг судлахдаа дараах асуудлыг анхаарна уу:

- Зургаа дугаартай төгсгөлийн тэмдэглэлийн гүйцэтгэж байгаа үүрэг

Тэмдэглэл

1. Дүн шинжилгээнд хамруулсан дөрвөн улс дахь төвлөрлийг сааруулах шинэчлэлийн тухай нэмэлт мэдээллийг Балдерсхейм нар (1996) бүтээлээс авч болно.
2. “LDI” төслийг Норвегийн Засгийн газар ивээн тэтгэж, Норвегийн Бергений их сургуулийн профессор Харалд Болдерсхейм удирдан хэрэгжүүлсэн болно.
3. Унгарын орон нутгийн улс төрчдийн үнэлэмжийг харуулсан төстэй мэдээлэл бидэнд байхгүй учраас Унгарын тухай тодорхой дүгнэлт хийх боломжгүй байна. Нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг харгалзан үзвэл Унгар нь Польшоос илүүтэй Чех, Словактай төстэй байх магадлалтай. Гэвч сүүлийн арван жилийн туршид Унгарт өрнөж буй орон нутгийн эрх мэдэл, засаглалын асуудлаарх хэлэлцүүлэг нь үйлчилгээний төвлөрлийг сааруулж, хүргэлтийн үр ашгийг сайжруулах асуудалд төвлөрч байгаа нь ажиглалтаас анзаарагдаж байна.
4. Судалгааг 2000 оны 4 сард орон нутгийн хүн амыг төлөөлөх чадвартай түүвэрт түшиглэн хийсэн бөгөөд судалгааны гүйцэтгэгчээр Чех Улсад “ИВВМ”, Унгарт “ТАРКИ”, Литвад “Вильморус”, Польшид “ЦБОС” байгууллага ажиллалаа. Харамсалтай нь энэ номын дүн шинжилгээд багтсан дөрөв дэх орон болох Словак дээрх судалгаанд хамрагдаагүй болно.
5. 1988 оны шинэчлэлээс хойш хотын захирагчдын зарим нь орон нутгийн засгийн газрын дээд давхаргад дэвшин, улс төрийн карьер сонгосон болохыг нэмж хэлэх хэрэгтэй. Гэхдээ цөөн тооны ийм тохиолдол гарсан нь дараагийн сонгуульд хотын дарга нарын нэлээд хувь нь сонгогдож чадаагүй нийтлэг дүр зурагт нөлөөлөхгүй юм.
6. Чех Улсын тухай мэдээлэл байхгүй ч энд нөхцөл байдал бусад орныхоос ялгаатай гэж үзэх үндэслэл алга байна.

Дээрх шинжилгээнээс харахад төгсгөлийн тэмдэглэл хэсэг нь дараах үүрэг гүйцэтгэж байна:

- **Нэмэлт мэдээлэл, тайлбар өгөх, нэр томъёог тайлбарлах**

Ийм тохиолдолд нэмэлт мэдээлэл нь үндсэн бичвэртэй уялдаа холбоотой, түүнийг дэмжих утга агуулгатай боловч баримт бичгийн үндэслэлийн голлох санаа биш, үндсэн бичвэрт багтаах юм бол үндэслэл тайлбарын логикийг тасалдуулж мэдэх тул үндсэн бичвэрт оруулаагүй байна. Гуравдугаар жишээний нэгээс бусад бүх төгсгөлийн тэмдэглэлийг зохиогч энэ зорилгоор ашиглажээ. Зарим тохиолдолд төгсгөлийн тэмдэглэлээр нэмэлт мэдээлэл өгч байгаагаа зохиогч шууд онцолж хэлдэг (жишээлбэл, 5 дугаартай төгсгөлийн тэмдэглэлд "...болохыг нэмж хэлэх хэрэгтэй" гэжээ).

Төгсгөлийн тэмдэглэл хэсэг нь нэмэлт мэдээлэл, үргэлжлүүлж судлах эх сурвалж зэргийг зааж өгдөг.

- **Баримт бичгийн үндсэн бичвэрт авч үзсэн асуудлаар үргэлжлүүлэн судлах, эсвэл нэмэлт мэдээлэл авах хүсэлтэй уншигчдыг бусад эх сурвалж руу чиглүүлж өгөх**

Зохиогч баримт бичигтээ хөндсөн бүх асуудлын бүхий л талыг нарийвчлан тайлбарлах боломжгүй юм. Тиймээс энэ судалгаатай холбоотой нэмэлт эх сурвалжуудыг төгсгөлийн тэмдэглэлээр зааж өгдөг. "Энэ асуудлаарх нэмэлт мэдээллийг ..." хэмээн эхэлж буй Гуравдугаар жишээний нэг дугаартай төгсгөлийн тэмдэглэл яг энэ үүргийг гүйцэтгэж байна.

5.10. Номзүй

Номзүй буюу ашигласан эх сурвалжийн жагсаалт бол таны боловсруулсан үндэслэлийн бааз суурьтай төвөггүй танилцах боломжийг уншигчид олгодог тул бодлогын баримт бичгийн нэгэн чухал элемент юм. Ашигласан зохиол бүтээлүүдээ жагсаан харуулснаараа та үндэслэлийнхээ бааз суурийг уншигчдад дэлгэн, шүүмжлэлтэй нүдээр харах боломж олгоод зогсохгүй судалж буй асуудал юмуу бүс нутагтай холбоотой эх сурвалжуудын иж бүрэн жагсаалтыг өгч байгаа хэрэг бөгөөд үүнийг уншигчид өөрсдийн судалгаандаа ашиглах боломжтой болж байгаа юм. Номын энэ хэсэгт бид Номзүйтэй холбоотой дараах хоёр чухал асуудлыг авч үзнэ:

Номзүй нь таны үндэслэлийн бааз суурьтай танилцах боломжийг уншигчдад олгодог

- Хэвлэн нийтлэгчийн тогтоож өгсөн, эсвэл өөрийн салбарт хэвшсэн ишлэл хийх дэг жаягийг дагаж мөрдөх нь

Бодлого судлалын салбарт зохиогч-огноо гэсэн системийг ашигладаг

Бичвэртээ ишлэл, эх сурвалжуудыг хэрхэн оруулах тухай нэгдсэн ойлголт бий болгохын тулд судалгааны салбарууд өөр өөрийн зорилгод нийцсэн ишлэлийн дэг жаяг тогтоосон байдаг. Бодлого судлалын салбарт зохиогч - огноо гэсэн системийг ашигладаг уламжлалтай (жишээлбэл, Хакетт, 2001). Уг номын 5.6.2 дугаар дэд

бүлэгт дурьдсанчлан, зохиогч - огноо гэсэн ишлэлийн систем дотор л гэхэд хэд хэдэн загвар хэвшин амжилттай хэрэглэгдсээр байна. Үүний жишээ бол Америкийн сэтгэлзүйчдийн нийгэмлэг (American Psychologist Association буюу APA)-ийн загвар, Чикаго загвар зэрэг юм. Ишлэлийн загваруудыг бичвэр дотор эх сурвалжийг дурьдах аргаар (зохиогч-огноо юмуу зүүлтээр) нь ихэвчлэн ангилдаг ч эдгээр нь мөн Номзүй/Ашигласан эх сурвалжийн жагсаалтаа яаж бичихийг нарийвчлан зааж өгдөг. Дараахь жишээ нь зохиогч - огноо системийн APA загварын дагуу ашигласан эх сурвалжаа хэрхэн дурьдахыг харуулж байна.

Дорнбуш, Рудигер ба Стенли Фишер (1987). Макро эдийн засаг. (4 дэх удаагийн хэвлэлт). Нью Йорк: Макгроу-Хилл хэвлэлийн газар

Зохиогч - огноо системийн APA загварын жишээг Хавсралт Б-ээс үзэж болох бөгөөд үүнд бичвэр дотор эх сурвалж дурьдах, мөн Номзүйд ном, сэтгүүлд гарсан нийтлэл, сонин, сэтгүүл, төрийн байгууллагаас гаргасан хэвлэмэл мэдээллийг жагсаахад баримтлах жаягийг багтаалаа. Ишлэлийн зохиогч - огноо системийн APA загварыг энэ гарын авлагад тууштай ашигласан учраас номын Ашигласан эх сурвалжийн жагсаалт хэсэг нь APA загвараар хийсэн бүрэн хэмжээний номзүйн жишээ юм.

Хэвлэн нийтлэгчийн баримталдаг ишлэлийн системийг олж мэдээрэй.

APA, Чикаго загварын ишлэлийн систем нь уламжлал болж хэвшээд удаж байгаа ч зарим хэвлэн нийтлэгч эдгээрийг дагаж мөрддөггүй. Тиймээс таны судалгааг эрхлэн гаргах хэвлэн нийтлэгч ишлэлээ ямар системээр хийхийг хүсэж байгааг асууж мэдээд, түүнийгээ тууштай дагаж мөрдөх хэрэгтэй. Аз дайрах юм бол хэвлэн

нийтлэгч тань бичвэрт тавигдах шаардлагуудыг нэгтгэсэн удирдамжийг бэлдчихсэн байх бөгөөд үүний нэг хэсэг нь танаас шаардаж буй ишлэлийн дэг жаяг байх юм. Зарим тохиолдолд зохиогч - огноо системийг баримталсан байхад хангалттай гэхээс илүүг хэлэхгүй. Ийм

нөхцөлд тодорхой нэг системийг сонгож аваад, түүнийгээ тууштай мөрдөөрэй. Тогтсон хэв маягийг тууштай баримтлах нь эхэндээ төвөгтэй мэт санагдах ч энэ нь эцэстээ таны бүтээлийг уншигчдад ойлгомжтой хүргэхэд туслан, бодлогын мэргэжилтний хувьд нэр хүндийг тань өсгөхийн зэрэгцээ нарийн ширийн бүхнийг тодорхой сайн тэмдэглэхийг шаарддаг судалгаа шинжилгээний салбарт жишиг тогтооход тусална.

- Бодлогын судалгааны онцлогтой холбоотой анхаарах зүйлс

Уламжлал болж хэвшсэн аливаа ишлэлийн систем нь дотроо тодорхой нөхцөл байдалд зохицуулсан маш нарийн удирдамж агуулсан байдаг бөгөөд эдгээрээс хоёр зүйлийг онцолж Төв болон Зүүн Европын бүсийн бодлогын мэргэжилтнүүдэд зориудаар анхааруулахыг хүслээ. Нэгдүгээрт, зарим бодлогын судалгааны сэдвийн онцлогоос шалтгаалан та ном, мэргэжлийн болон нийтийн зориулалттай сэтгүүл, тайлан, сонин, хууль тогтоомж, төрийн байгууллагаас гаргасан баримт бичиг, ярилцлага гэх мэт олон төрлийн эх сурвалж ашиглах шаардлагатай тулгарна. Эх сурвалжийн төрөл, хэлбэр олон тул номзүйд зохиогчийн нэрээр цагаан толгойн үсгийн дарааллаар жагсааж бичихийн оронд эх сурвалжийн төрлүүдээр ангилж, хэд хэдэн дэд бүлэг болгох хэрэгтэй. Хоёрдугаарт, бодлогын баримт бичигтээ та англиас өөр хэлээр бичигдсэн эх сурвалжуудыг ч бас ашигласан байх. Эдгээр бүтээлийг олон улсын уншигч, хэрэглэгчдэд аль болох ойлгомжтой байдлаар Номзүйдээ нэрлэн дурьдах үүднээс ишлэлийнхээ гол буюу түлхүүр хэсгийг орчуулж ашиглахыг бид зөвлөж байна. Дараах жишээнд ийм төрлийн ишлэлийн түгээмэл нэгэн загварыг харууллаа:

Үндэстэн ястан болон үндэсний цөөнхийн асуудал эрхэлсэн газар (1999).
Kisebbségек Magyarországон (Унгар дахь үндэсний цөөнхүүд). Будапешт:
зохиогч

5.11. Хавсралт

Бодлогын баримт бичгийн үндсэн бичвэрийн араас нэмэлт мэдээлэл хавсралтаар оруулах аргыг зохиогч олонтаа ашигладаг. Гарын авлагынхаа энэ хэсэгт бид хавсралттай холбоотой тодорхой дөрвөн асуудлыг авч үзлээ.

- ***Хавсралтууд бол баримт бичгээрээ илэрхийлж буй гол үндэслэлүүдийг дэмжиж, нөхөн гүйцэлдүүлж байдаг.***

Хавсралт нь баримт бичгийн гол үндэслэлүүдийг дэмжих үүрэгтэй.

Үндсэн бичвэрээ дэмжих үүрэгтэй Хавсралт нь бодлогын баримт бичигт авч үзсэн асуудлуудыг дэлгэрүүлэн судлахыг хүсэж буй уншигчдын хэрэгцээнд нийцсэн бүрдэл хэсэг юм. Хавсралт нь баримт бичгийн үндсэн хэсгийн мэдээлэл дээр нэмж ашиглаж болох эх сурвалжуудыг уншигчдад танилцуулах замаар энэ үүргээ гүйцэтгэдэг байна. “Орон нутгийн түвшний төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл явц дахь нээлттэй өрсөлдөөн, ил тод байдал, төвийг сахисан байр суурь” (Баар, 2001) гарчигтай Хоёрдугаар жишээнд зохиогч нь “Хавсралт А. Төв болон Зүүн Европын орнуудын Мэдээллийн эрх чөлөө болон үүнд хамаарахгүй нууц мэдээлэлтэй холбоотой үндсэн хууль, бусад хуулийн заалтууд (үүний дотор арилжааны нууцтай холбоотой хуулийн заалтууд)”, “Хавсралт Б. Хурдны зам барих концессийн гэрээг олон нийтэд нээлттэй байлгах тухай Унгарын Омбудсмэний шийдвэр” гэсэн хоёр хавсралт нэмжээ. Эдгээр хавсралт нь бодлогын судалгааны үндсэн фокус болсон төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх асуудлыг дэмжсэн эрх зүйн чанартай маш нарийн мэдээллийг агуулж байгаа юм. Тухайлбал, Хавсралт А-д Төв болон Зүүн Европын 13 орны Үндсэн хуулиас ишлэн авсан хэсгүүд багтжээ. Эрх зүйн юмуу гэрээний эрхийн талаар илүү нарийн мэдээлэл авахыг хүсэж байгаа уншигчид эдгээр хавсралтаас хууль эрх зүйн нарийн ширийн мэдээллийг авч болно.

Үндсэн бичвэрийг дэмжих чиг үүргээ сайн гүйцэтгэхийн тулд хавсралтаа илт буюу шууд дурьдах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, зохиогч бодлогын баримт бичгийнхээ харгалзах газруудад хавсралтуудаа нэрлэн дурьдах хэрэгтэй. Хоёрдугаар жишээнд Унгар Улс дахь ил тод байдлын асуудлыг танилцуулж, хэрэглээг нь тайлбарлахдаа зохиогч хоёрдугаар хавсралтыг шууд дурьдаж, “Хавсралт Б-д Омбудсмэны шийдвэрийг бүрэн эхээр

орууллаа” гэжээ. Ингэснээр уншигчид хавсралтын холбоо хамаарал, бичвэрийн аль хэсгийг дэмжих үүрэгтэй ашиглагдаж байгааг шууд олж харах боломжтой болох тул энэхүү нэмэлт мэдээллийг зохиогч ямар сэдэл, үндэслэлээр оруулсан талаар таамаглаж, төөрөгдөхөөргүй болж байгаа юм.

- ***Хавсралт заавал байх албагүй ба шаардлагатай л бол ашиглах нэмэлт юм.***

Энэ гарын авлагыг боловсруулахдаа бидний судалж үзсэн бодлогын баримт бичгийн ихэнх нь хавсралтгүй байсан юм. Иймд хавсралтаар мэдээлэл нэмж өгөхийн ашиг тус, хувь нэмрийг зохиогчид өөрсдөө үнэлж цэгнэх ёстой. Доорх хяналтын хуудасны асуултууд нь баримт бичигтээ хавсралт нэмэх эсэхээ шийдэх, оруулахаар шийдсэн бол үндэслэл гаргахад тань тусална.

- ***Хавсралтаар хүргэх мэдээллийг сонгоход ашиглах нийтлэг шалгуур нь мэдээллийн төрөл, урт, нарийвчлалын түвшин зэрэг болно.***

Бодлогын судалгаанууд хөндөж байгаа асуудал, шийдэхээр зорьж байгаа хүндрэл бэрхшээлээрээ ялгаатайн дээр өөр өөр судалгааны арга, өгөгдлийн эх сурвалж ашигладаг тул хавсралтаар яг ямар мэдээлэл өгөхийг ерөнхийлөн хэлэх боломжгүй юм. Хавсралтад юу оруулах тухайгаа шийдэх гэж байгаа бол эхлээд таны гаргасан шийдвэрт ямар төрлийн мэдээлэл дэмжлэг болж чадахыг үнэлж үзэх хэрэгтэй болно. Хоёрдугаар жишээнд баримт бичгийн туршид зохиогч эрх зүйн орчинд анхаарлаа төвлөрүүлж ирсэн тул зохиогчийн санааг дэмжих нэмэлт мэдээлэл болгож Хавсралт А-д 13 улсын хууль, журмын холбоо хамааралтай хэсгүүдийг ишлэн оруулжээ. Ийм нарийвчилсан мэдээллийг баримт бичгийн үндсэн хэсэгт оруулах юм бол хэлэлцүүлгийн явцыг тасалдуулж сарниулах учир энэ нь хавсралтаар өгөхөд илүү тохиромжтой мэдээлэл юм. Судалгаандаа ашигласан аргууд, өгөгдлөө харгалзан үзэх нь нэмэлт мэдээллийн талаар шийдвэр гаргахад тус дэм болдог. Жишээлбэл, хэрэв судалгааны хүрээнд анхдагч судалгаа хийсэн бол уншигчдад мэдээлэл өгөх зорилгоор судалгаанд ашигласан хэрэглэгдэхүүн, өгөгдлийн нарийвчилсан шинжилгээг хавсралтаар өгч болно.

- **Хавсралтуудын агуулгыг хувааж, гарчиг өгөн, үсгээр дугаарладаг**

Хоёрдугаар жишээ нь А, Б үсгээр ялган харуулсан хоёр хавсралттай байна. Хавсралтуудын дараалал нь баримт бичгийн үндсэн хэсэгт тэдний дурьдагдах дараалалд нийцэж байна. Хавсралтын гол фокус, үндсэн агуулгын талаар уншигчдад мэдээлэл хүргэхийн тулд дүрслэн тайлбарласан гарчиг өгөх хэрэгтэй. Уншигчдад лавлан харахад хялбар талыг нь бодож хавсралтуудын гарчгийг баримт бичгийн товъёгт оруулах нь зүйтэй.

Бичих явцдаа ашиглах хяналтын хуудас

Бодлогын баримт бичгийн тань агуулгыг дэмжих хавсралт шаардлагатай эсэхийг шийдэхийн тулд дараах асуултуудад хариулаарай:

- Хавсралтаар нэмэлт мэдээлэл өгөх шаардлагатай юу, эсвэл баримт бичгийн үндсэн бичвэр дотор тухайн мэдээллийг агуулсан эх сурвалжийг нэрлэн дурьдах (зүүлт/төгсгөлийн тэмдэглэл хэлбэрээр) –ад хангалттай юу?
- Хавсралтаар өгсөн мэдээлэл нь таны боловсруулсан үндэслэлийн тодорхой аль нэг хэсгийг дэмжихэд амин чухал шаардлагатай байна уу?

5.12. Индекс

Индекс бол тодорхой асуудлын байршлыг олох хайлтын чухал хэрэгсэл юм.

Индекс бол хэвлэн нийтлэгдсэн бүтээл, ялангуяа хэд хэдэн бодлогын баримт бичгээс бүрдсэн эмхэтгэлийн нийтлэг нэг хэсэг юм. Хэвлэмэл бүтээлийн энэхүү бүрдэл хэсгийг “Нэр томъёоны индекс”, “Сэдэвчилсэн индекс” гэж нэрлэх нь элбэг ба энэ нь үндсэндээ тухайн хэвлэмэл материалд багтсан асуудлуудыг төвөггүй олж харахад туслах судалгааны хэрэглэгдэхүүн юм. Зав муутай уншигчид өөрийн сонирхсон асуудлуудын тухай өгүүлэх хэсгийг цаг алдалгүй олж унших хүсэлтэй байдаг тул тодорхой асуудлыг хөндсөн номын хэсэг, бүлэг хаана байгааг олохын тулд тэдний хамгийн түрүүнд хандах хэсэг бол цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаасан индекс байх юм. Тиймээс индекс нь тухайн номд ашиглагдсан түлхүүр үгсийн тоймын үүргийг гүйцэтгэдэг бөгөөд номыг сайн танилцуулж чадахуйц, ашиглахад хялбар байх нь юу юунаас ч илүү чухал. Индекс боловсруулах талаар жишээнд тулгуурлан авч үзье.

Хэвлэн нийтлэгдсэн баримт бичгийн шинжилгээ

“Социалист улс дахь төвлөрлийг сааруулах туршлага: Шилжилтийн эдийн засагтай орнуудын засгийн газрын түвшин хоорондын төсөв, санхүүгийн харилцаа” (Бёрд, Эбель, Воллих нар, 1995) нэртэй эмхэтгэлийн индекс хэсгээс хэсэгчлэн авсан жишээг үзнэ үү.

Дараах асуудалд анхаарлаа хандуулна уу:

- индекст багтсан нэр томъёоны төрөл

- индексийн формат, зохион байгуулалт

Enhanced subnational taxes (Орон нутгийн татварыг боловсронгуй болгох), 367–68

Enterprise profit taxes (аж ахуйн нэгжийн ашгийн татвар), 160, 162, 300, 304–5

Enterprises (аж ахуйн нэгж): expenditure responsibilities of (-ийн зарцуулалтын хариуцлага), 36, 62, n20, municipal ownership of (хотын өмчийн), 167, 198, 217–18, 288, natural resource exploitation by (байгалийн баялгийн олборлолт эрхэлдэг), 392, 396, ownership confusion over Romanian (-ийн эзэмшилтэй холбоотой Румынд гарч буй будилаан), 232–33, potential local misuse of (орон нутагт –ийг буруугаар ашиглах эрсдэл), 9, 42, and privatization resistance (мөн хувьчлахад учрах саад тотгор), x, 5, 296–97, 311, 318 n8, proceeds from sale of (-ийг зарж борлуулснаар олсон ашиг), 31, 62 n18, 106, 133–34, public and social services delivery by (-ээр төрийн ба нийгмийн үйлчилгээ хүргүүлэх), 12, 198–99, 287, 288–89, 291, 318 n5, 352–53, subnational government ownership of (орон нутгийн өмчийн), 19, 27–28, 198, 217–18, 232–33, 274, 288, subnational sale of (-ийг орон нутагтаа зарж борлуулах), 30–31, 62 n18, 103, 106, 133–34, 351, subnational taxation of (-д оногдуулах орон нутгийн татвар), 42–43, 304–5

Entrepreneurialism (аж ахуй эрхлэх): of subnational governments (орон нутгийн засаг захиргааны зүгээс), 28–30, 62 n17, 106, 274, 351–52

Environmental taxes (байгаль орчны татвар), 163, 392

Environmental fund (Poland) (Байгаль орчны сан (Польш Улс), 163

Equalization (тэнцэтгэл): block grants and (багц тэтгэлэг ба), 161, formula-based sharing and (томъёонд суурилсан хуваарилалт ба), 47, 363–64, 365, grant formulas and (томъёонд суурилсан багц тэтгэлэг ба), 53, 89, 96, 99, 101, 102, 161, 215, intergovernmental transfers and (загийн газар хоорондын шилжүүлэг ба), 51, 273–74, 313, 360–61, as intra- and interblast revenue issue (бүс нутгийн дотоодын болон бүс нутаг хоорондын орлогын асуудлууд), 369–71, 387–88, measurement of Russian system of (Оросын -ийн тогтолцооны шалгуур үзүүлэлтүүд), 358–61, property taxes and (хөрөнгийн татвар ба), 268, regulating revenues and (орлогыг зохицуулах ба), 298, revenue mobilization and (орлого дайчлах ба), 370, revenue sharing and (орлого хуваалцах ба), 270–71, targeted grants (зорилтот тэтгэлэг ба), 108, tax assignment and (татвар оногдуулалт ба), 212, tax sharing and (татвар хуваарилалт ба), 270–71, 358–61

Equity (хувьцаа): expenditure assignment and (зардлын төлөвлөгөө ба), 28, 29, natural resource revenues and (байгалийн баялгаас олох орлого ба), 396, 400, and natural resource taxation (байгалийн баялагт оногдуулах татвар), 45, normative grants and (нормативт суурилсан тэтгэлэг), 92, revenue assignment and (орлогын төлөвлөгөө ба), 212

Ethnic minorities (үндэсний цөөнх): autonomy demands by (-ийн автономит эрхтэй болох шахалт шаардлага), 380, 381, 384–85, 403, geographic concentration of (-ийн газар зүйн төвлөрөл), 325

European Bank for Reconstruction and Development (Европын сэргээн босголт, хөгжлийн банк), 179

European Charter of Local Self-Government (Council of Europe) (Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай Европын тунхаг бичиг), 156

European Union (Европын холбоо), 41, 304

Энэ жишээнээс харахад индекс бол зохион байгуулалтын үндсэн нэгж болох гарчгийн үүргээр ашигласан өргөн хүрээтэй ерөнхий нэр томьёо, тэдгээрийн дор задарч орж ирж байгаа илүү нарийчилсан, дүрслэл тайлбар маягийн нэр томьёонуудаас бүрддэг ажээ. Нарийвчилсан нэр томьёо нь дэд байр суурьтай болохыг илэрхийлэх үүднээс бичвэр хэлбэрээр цувуулан бичдэг ба үндсэн бичвэр дотор тэдгээрийн дурьдагдах байрлалуудыг харуулсан хуудасны дугаарыг ард нь бичнэ.

6. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГЭЭ ХЭВЛЭН ГАРГАХ НЬ

Бодлогын баримт бичгийг хэвлэн гаргах нь бодлогын судалгаанаас үүдэлтэй санаа оноо, бодлогын зөвлөмжийг түгээн дэлгэрүүлэх үндсэн арга зам юм. Баримт бичиг хэвлэгдэн гарснаар олон сонирхогч тал энэхүү баримт бичгийг уншиж судлан, зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллах боломж бүрдэх бөгөөд үүгээр бодлогын баримт бичгийн арга хэмжээ авахад уриалан дуудах чиг үүрэг нь хэрэгжиж байгаа болно. Бодлогын баримт бичгийг хэвлэн гаргах нь тодорхой асуудлаар өрнөж буй бодлогын яриа хэлэлцүүлгийг өргөжүүлэн баяжуулахад чухал үүрэгтэй бөгөөд улмаар Төв болон Зүүн Европын орнуудын бодлогын сүлжээнийхнийг улам хөгжүүлэх арга зам юм.

Бодлогын баримт бичгийг хэвлэх үйл явцыг эхлүүлснээр зохиогч нь хэвлэн нийтлэгчтэй хамтран ажиллах харилцааг үүсгэж байгаа юм. Энэ бол харилцан ашигтай харилцаа юм. Учир нь бодлогын баримт бичгийг хэвлэн нийтэлж буй тал ихэвчлэн өөрөө бодлогын сүлжээний нэг гишүүн байдаг учир бодлогын тодорхой асуудлаар баримт бичиг хэвлэн гаргахдаа дотроо өөрийн зорилго мөн давхар агуулж байгаа. Улмаар тэд өөрсдийнх нь зорилгод хүрэхэд тус болно гэсэн бодлогын баримт бичгүүдийг хэвлэхээр сонгож авдаг. Хамтын ажиллагааг эхлүүлэх олон арга зам бий. Зохиогч өөрөө санаачилга гарган хэвлэн нийтлэгчид санал тавьж болно. Хэвлэн нийтлэгчид өөрсдөө зар гарган материал хүлээж авах замаар ч ажилладаг. Эсвэл зохиогч нь бодлогын судалгааны хэвлэн нийтлэл эрхэлдэг байгууллага, сүлжээний гишүүн, түншлэгч байж болох бөгөөд энэ тохиолдолд байгууллага нь хэвлэн нийтлэх асуудлыг хариуцах юм. Зохиогч, хэвлэн нийтлэгч хоёрын хоорондын харилцааны мөн чанараас үл хамааран хэвлэн нийтлэгчээ сонгохдоо, эсвэл хэвлэн нийтлэгчээс санал хүлээж авсан бол энэхүү баримт бичгийг хэвлэн гаргаснаар хангахаар хүсэж буй хоёр талын зорилго хангагдаж байхад зохиогч анхаарах ёстой.

Бодлогын баримт бичгийг хэвлэн нийтлэх нь төвөгтэй, цаг авсан үйл явц болж мэдэх бөгөөд гарын авлагын энэ бүлэгт энэхүү үйл явцыг тайлбарлан, зарим зөвлөгөөг өгөх юм. Энэхүү үйл явцын хоорондоо холбоо хамааралтай дөрвөн алхмыг тус бүрт нь нэг дэд бүлэг болгон салгаж тайлбарлах болно.

6.1. Тодорхой хэвлэн нийтлэгчийг “онилж” бичих нь

Бодлогын баримт бичигт тавих хэвлэн нийлэгчийн шаардлагуудыг баримтлах хэрэгтэй.

Хэдийгээр бодлогын баримт бичгийн үндсэн уншигч нь бодлогын сүлжээний хүмүүс мөн боловч дээр цухас дурьдагдсан зохиогч, хэвлэн нийтлэгч хоёрын хоорондын өвөрмөц харилцааны улмаас таны сонгосон хэвлэн нийтлэгч бол энэ баримт бичгийн хамгийн анхны уншигч болох юм. Хэвлэн нийтлэгч болгон бодлогын баримт бичгийн бүтэц, формат, ишлэлийн системийн

талаар өөр өөрийн журамтай байдаг бөгөөд таны бичиж тэдэнд өгөх бодлогын баримт бичиг эдгээр шаардлагыг бүрэн хангах ёстой тул та эдгээрийг тун тодорхой мэдэж байх ёстой.

Хэвлэн нийтлэгчид ихэнхдээ удирдамж, заавар гаргах замаар бичвэрт тавих шаардлагуудаа зохиогчдод ойлгомжтой хүргэн тусалдаг. Ийм удирдамжийг та хэвлэн нийтлэгчийн веб хуудаснаас, эсвэл өмнө нь хэвлэн гаргасан ажлуудаас нь олж харж болно. Төв болон Зүүн Европын төрийн захиргааны сургууль, байгууллагуудын холбоо (ТЗЕТЗСБХ буюу NISPAcee)-ны “Бүтээл хүлээж авах зар”¹¹, Нийгмийн бодлогын сэтгүүлийн “Нийтлэл ирүүлэх заавар”¹² зэрэг нь үүний жишээ юм. ТЗЕТЗСБХ-оос гаргасан судалгааны бүтээлийн талаарх заавар харьцангуй товч байхад Нийгмийн бодлогын сэтгүүлийнх хамаагүй илүү дэлгэрэнгүй, нарийвчлалтай байгаа бөгөөд Редакторын үг, Бүтээлээ хүлээлгэн өгөх, Эх хувиа бэлтгэх, Бичвэрээ бэлдэх, Эцсийн уншилт, Дардас буюу туршилтын хэсэгчилсэн хэвлэл зэрэг хэсгийг агуулсан байна.

Ерөнхийдөө, удирдамж бол бодлогын баримт бичгийн бүтэц, бичлэгийн хэв маяг, урт, формат, ишлэлийн систем, зохиогчийн эрх, тухайн баримт бичигт авч үзэх бодлогын асуудлууд, түүнчлэн редакторлах, хянах үйл явцын тухай мэдээллийг өгдөг. Эдгээр нь таны баримт бичгийн

¹¹ <http://www.ecn.cz/aic/NEWAIC/publadmi.htm> хаягаас үзнэ үү.

¹² <http://uk.cambridge.org/journals/jsp/jspifc.htm> хаягаас үзнэ үү.

бүтэц зохион байгуулалт, бичих үйл явцыг тодорхойлон чиглүүлэх учир баримт бичгээ бичихээс өмнө буюу төлөвлөх шатадаа хэвлэн нийтлэгчийн Бүтээлээ хүлээлгэж өгөх зааврыг унших хэрэгтэй. Тухайн хэвлэн нийтлэгчийн тавьж буй тодорхой шаардлага, удирдамжийг даган биелүүлээгүй нөхцөлд баримт бичгийг тань хэвлэхээс татгалзаж ч болох учир анхаарч хандах хэрэгтэй. Хэрэв хэвлэн нийтлэгч эдгээр удирдамжийг олон нийтэд нээлттэй тараадаггүй бол, эсвэл баримт бичгээ бичиж эхлэхээс өмнө танд лавшруулан тодруулах зүйл гарсан бол хэвлэн нийтлэгч компани, байгууллагын редактортай холбоо барьж, заавар, лавлагаа авах хэрэгтэй. Мөн хэвлэн нийтлэгчийн баримталдаг зарчим, хүлээлтийг ойлгохын тулд тухайн хэвлэн нийтлэгчийн урьд өмнө нь хэвлэн гаргасан бүтээлүүдийг судалж үзээрэй.

6.2. Эх хувийг хүлээлгэж өгөхөд бэлтгэх нь

Энэхүү гарын авлагад бодлогын баримт бичгийн эх бичвэр гэж эцэслэгдээгүй байгаа ажлын баримт бичгийг нэрлэж ирсэн билээ. Иймээс та бодлогын баримт бичгийнхээ бүх бүрдэл элементүүдийн эхний хувилбарыг бичээд дууссан бол одоо баримт бичгийн үр нөлөөг сайжруулахад онцгой нөлөөтэй хянан сайжруулах үе шатад шилжих хэрэгтэй. Эх нооргоо чинээнд нь тултал гүйцэд сайжруулж, редакторт хүлээлгэж өгөхөд бэлэн болтол хянан сайжруулах нь зохиогчийн үүрэг мөн гэдэг дээр зохиогч, хэвлэн нийтлэгч хоёр нэгдсэн ойлголттой байх нь энэ хоёр талын хамтын ажиллагааны амжилтын үндэс болно. Бүрэн хянаж сайжруулаагүй эхийг хэвлэн нийтлэгчид хүлээлгэж өгснөөс редактор эхийг хүлээж авахаас татгалзах, редактортой хамт эх бичвэрээ хянан сайжруулах үйл явц хамаагүй урт хугацаа шаардсан, илүү нарийн төвөгтэй үйл явц болж хувирах, дутуу дулимаг, сулхан ажил хүлээлгэн өгсөн зохиогчийн чадал, чансаанд редактор эргэлзэх зэрэг олон сөрөг үр дагавар гарах магадлалтай. Тиймээс хянан сайжруулах үйл явц бол бичих үйл явцад бүхэлд нь хамаатай, салшгүй нэг хэсэг нь бөгөөд үр өгөөжтэй, үр нөлөөтэй хянан сайжруулах үйл явц бүрдүүлсэн байхад зохиогчид анхааран ажиллах шаардлагатай.

Зохиогч эхээ өөрийн хэмжээнд дээд зэргээр боловсруулсны дараа л хэвлэн нийтлэгчид өгөх ёстой.

Төлөвлөлтийг хянах хуудас

Үр нөлөөтэй хянан сайжруулах үйл явцыг төлөвлөхдөө дараах асуултуудад анхаарна уу:

- Хянан сайжруулах үйл явцыг та хэрхэн эхлүүлэх вэ?
- Та ямар алхмуудаар дамжин ажиллах вэ?
- Баримт бичгээ хянаж сайжруулахад та хэдий хугацаа зарцуулахаар төлөвлөж байна вэ?
- Та хянан сайжруулах ажилд өөр хэнийг оролцуулах вэ?

Баримт бичгийн эх нооргийг хянан сайжруулах тал дээр зохиогч бүр өөрийн арга барилтай байдаг бөгөөд дагаж мөрдөх шилдэг арга гэж байхгүй. Харин дор харуулсан зургаан үе шаттай хянан сайжруулах нэгэн загвар¹³ нь бүтээлээ хэвлэлд бэлтгэхэд танд тус болж магадгүй юм.

Хянан сайжруулах үйл явцын жишээ:

- Бодлогын баримт бичгийнхээ бүрдэл элемент бүрийн агуулгыг дахин шалгаж нягтлах;
- Ноорог баримт бичгийнхээ бичлэгийн хэв маягийг хянах;
- Ноорог баримт бичгийнхээ хэл найруулгыг хянах;
- Баримт бичгийн өнгө аясыг хянаж нягтлах;
- Баримт бичгийг бүхэлд нь олон дахин уншиж, нягтлах;
- Хамтран ажиллагчдаасаа баримт бичгийг хянаж нягталж өгөхийг хүсэх
- **Бодлогын баримт бичгийнхээ бүрдэл элемент бүрийн агуулгыг дахин шалгаж нягтлах нь**

Баримт бичгийнхээ үр нөлөөг бүхэлд нь, мөн баримт бичгийн бүтцийн ба бичвэрийн элемент бүрийн үр нөлөөг тус тусд нь үнэлж үз.

Эхний алхам болгож хэвлэн нийтлэгчээс тавих шаардлагуудыг багтаасан заавар удирдамжийг дахин нэг уншиж үзээд, шаардаж буй бүтцийн элементүүдийг бүгдийг оруулж өгсөн гэдгээ нягталж шалгаарай. Үүний дараа бүрдэл элемент бүрийн үр нөлөө, бүрэн гүйцэд эсэхийг шалгахын тулд тэдгээрийн бүтэц болон бичвэрийн бүрдлүүд, гүйцэтгэж буй зорилгыг нь нэгбүрчлэн шинжилж, үнэлээрэй. Үр нөлөөг үнэлэхэд

¹³ Сигизмунд Хафф (1999)-ын бүтээлээс өөрчлөн авав.

түгээмэл ашигладаг арга хэрэгсэл бол редакторлахдаа ашиглах хяналтын хуудас юм. Өөртөө нийцсэн хяналтын хуудас шинээр боловсруулах, эсвэл бэлэн хуудсыг өөрчлөн ашиглах замаар ноорог баримт бичгээ редакторлах үйл явцаа зохион байгуулалттай болгож, чухал зүйлсийг орхигдуулахгүй байхад хяналт тавих боломжтой. Дараах хяналтын хуудсыг энэ гарын авлагад ашигласан бодлогын баримт бичгийн бүрдэл элемент нэг бүрийг шинжилж судалсны үндсэн дээр боловсруулсан болно.

Бичих явцдаа ашиглах хяналтын хуудас

Бодлогын бичиг баримтынхаа агуулгыг хянаж, үнэлэхдээ дараах хяналтын хуудсыг ашиглаарай. Ойлгомжгүй асуулт, элемент таарах юм бол мэдлэг, мэдээллээ сэргээх зорилгоор уг гарын авлагын зохих хэсгийг дахин уншаарай.

Нийт баримт бичгийн үр нөлөө

- Бодлогын баримт бичиг тань хамгийн оновчтой хэмээн таны сонгож авсан бодлогын хувилбарын үр нөлөөтэй үндэслэл болох үүрэг зорилгоо хангаж чадаж байна уу?
- Та үндсэн зорилтот бүлгээ итгэж үнэмшүүлэхүйц хэмжээнд үндэслэлээ тайлбарлан танилцуулж чадсан уу?
- Та зорилгоо бүрэн хангаж чадсан уу? Өөрөөр хэлбэл, хийхээр зорьсон бүх зүйлсээ баримт бичигтээ багтааж чадсан уу?

Гарчгийн үр нөлөө

- Гарчиг нь сонирхолтой, тодорхой, товч, тайлбарласан утгатай болж чадсан уу?
- Баримт бичигт хөндсөн асуудал, шинжилгээний фокусыг тодорхой харуулсан түлхүүр үгс гарчигт багтсан уу?

Товьёгийн үр нөлөө

- Баримт бичгийн агуулгыг сайн төлөөлж, ойлгомжтой хүргэсэн тойм болж чадсан уу?
- Уншигчдад ойлгомжтойгоор агуулгыг хуваан салгаж, форматлан хүргэсэн байна уу?
- Бүлэг, дэд бүлгүүдийн гарчиг оновчтой бичигдсэн байна уу?

Хураангуй, эсвэл Товчоон хэсгийн үр нөлөө

- Хураангуй/товчоон нь баримт бичгийн агуулгыг сайн төлөөлж чадсан байна уу?
- Баримт бичгийг бүхэлд нь сайн төлөөлөхүйц хэмжээнд шаардлагатай бүрдэл хэсгүүдийг бүгдийг багтаасан байна уу?
- Баримт бичгийг бүхэлд нь унших сонирхол төрүүлж чадаж байна уу?

Удиртгалын үр нөлөө

- Удиртгал хэсэг нь уншигчийг энэхүү баримт бичгийг бүхэлд нь уншихад ятгаж чадахын зэрэгцээ бэлтгэж чадаж байна уу?
- Бодлогын асуудлыг тодорхой бөгөөд үнэмшил төрүүлэхүйцээр тодорхойлж бичсэн байна уу?
- Зорилгоо оновчтой томъёолж чадсан уу?

Асуудлыг тодорхойлох элементийн үр нөлөө

- Асуудлын тодорхойлолт хэсэг нь тулгамдсан асуудал үнэхээр оршиж байгаад уншигчийг итгүүлж чадахаар болж чадсан уу?

- Та тухайн асуудалтай шууд холбоотой ерөнхий нөхцөл байдал болон өнөөдөр үйлчилж буй бодлогын орчинг тайлбарласан уу?
- Үндэслэлийн бүх бүрдэл хэсгийг хангалттай бөгөөд үр нөлөө үзүүлэхүйц хэмжээнд тайлбарлан, дэмжиж чадсан уу?
- Үндэслэлээ эх сурвалжуудаар сайн дэмжиж өгч чадсан уу?
- Хоёрдогч эх сурвалжуудыг бүгдийг нь шаардлагын дагуу, нэгдсэн загвараар тууштай ишлэж харуулсан уу (хэвлэн нийтлэгчийн баримталдаг ишлэлийн системийн дагуу)?
- Зураг, хүснэгтээр өгсөн мэдээлэл ойлгомжтой байна уу?

Бодлогын хувилбарууд хэсгийн үр нөлөө

- Таны сонгож авсан бодлогын хувилбар бол тухайн бодлогын асуудлыг хамгийн оновчтой шийдвэрлэх арга зам мөн гэдгийг Бодлогын хувилбарууд хэсэг тань нотлон харуулж чадаж байна уу?
- Бодлогын хувилбаруудын үнэлгээний суурь буюу Дүн шинжилгээний хүрээ нь тодорхой, ойлгомжтой тайлбарлагдсан байна уу?
- Байж болох бодлогын бүх хувилбарыг тайлбарлан, үнэлсэн байна уу?
- Бодлогын хувилбар бүрийн тухайд та өөрийн байр суурийг тодорхой илэрхийлж, үндэслэл нотолгоогоор сайтар баталгаажуулж өгсөн байна уу?
- Хоёрдогч эх сурвалжуудыг бүгдийг нь шаардлагын дагуу, нэгдсэн загвараар тууштай ишлэж харуулсан уу (хэвлэн нийтлэгчийн баримталдаг ишлэлийн системийн дагуу)?

Дүгнэлт, зөвлөмжүүдийн үр нөлөө

- Энэ хэсэгт бодлогын асуудлыг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхой тоочсон байна уу?
- Энэ хэсэг бодлогын баримт бичгийг бүрэн гүйцэд болгон хааж өгсөн сэтгэгдэл төрүүлж чадаж байна уу?
- Зөвлөмжүүд нь ойлгомжтой бичигдсэн, хэрэгжих боломжтой зүйлс байна уу?
- Зөвлөмжүүдийг бичвэр дотроос төвөггүй ялгаж харах боломжтой байна уу?
- Уншигч зөвхөн Удиртгал, Дүгнэлтийг уншвал баримт бичгийн тухай хангалттай сайн ойлголттой болж чадах уу?

Төгсгөлийн тэмдэглэлийн үр нөлөө

- Та хэвлэн нийтлэгчийнхээ баримталдаг ишлэлийн системийг дагаж мөрдсөн үү (тухайлбал, зүүлт, төгсгөлийн тэмдэглэл зэрэгт)?
- Зүүлт, төгсгөлийн тэмдэглэлүүд нь бүгдээрээ баримт бичгийн үндсэн бичвэрийг дэмжих үүргээ биелүүлж чадаж байна уу?

Номзүйн үр нөлөө

- Баримт бичигтээ нэрлэн дурьдсан эх сурвалжуудаа бүгдийг нь номзүйн жагсаалтдаа оруулсан уу?
- Та хэвлэн нийтлэгчийнхээ баримталдаг ишлэлийн дэг жаягийг тууштай дагаж мөрдсөн үү?

Хавсралтын үр нөлөө

- Бүх Хавсралт нь баримт бичгээ дэмжих чиг үүргээсээ хазайгаагүй, үүнийгээ гүйцэтгэж чадаж байна уу?
- Хавсралтуудыг сайн ашиглаж чадсан уу? Өөрөөр хэлбэл, хавсралт нэг бүрийг баримт бичгийн үндсэн хэсэгт шууд нэрлэн дурьдсан байна уу?

- Ноорог баримт бичгийнхээ бичлэгийн хэв маягийг хянах нь

Баримт бичгийн боловсруулалтын энэ үе шатад уншигчдад хүргэхээр зорьж буй санаагаа илүү ойлгомжтой, дотоод логик холбоос сайтай, товч бөгөөд тодорхой болгон сайжруулахад төвлөрч ажилладаг. Бичвэрийн эдгээр шинж чанар нэн чухал болохыг дараах тайлбар харуулна. Таны бичсэн бодлогын судалгаа маш чухал санааг агуулсан хэрнээ үүнийгээ ойлгомжтой, цөөн үгээр илэрхийлж, хүргэж чадаагүй

Ноорог баримт бичгийнхээ тодорхой бөгөөд ойлгомжтой, дотоод логик сайтай, товч хэрнээ оновчтой зэрэг шинж чанарыг нягтлан хянаарай.

бол уншигч ойлгохгүй өнгөрч мэдэх юм. Үүний үр дүнд шийдвэр гаргалтын арга хэрэгсэл болох ёстой бодлогын баримт бичгийн тань үр нөлөө нэлээд буурна. Хянаж сайжруулах явцын энэ үе шатад таны боловсруулсан баримт бичгийг унших магадлалтай олон янзын уншигчдыг төсөөлж байгаад, тэдэнд таны гарган тавьж буй үндэслэл, тулгуур зарчмууд болон нэр томъёо хэр ойлгомжтой, тодорхой байхыг нухацтай эргэцүүлэн тунгаах хэрэгтэй. Мөн бодлогын баримт бичгийн бүрдэл элемент бүрийн дотоод логик болон бүрдэл элементүүдийн хоорондын уялдаа холбоос алдагдаагүй, сайн болсон байхад анхаарч дахин дахин нягталж, сайжруулах хэрэгтэй. Эцэст нь бидний анхаарах бас нэг асуудал бол эх бичвэрийн уртын хэмжээ юм. Бодлогын баримт бичгийн эхний ноорог нэлээд урт байдаг ч бичсэн зүйл нуруу биш, товч бөгөөд тодорхой байвал уншигчдад санаагаа төвөггүй хүргэхэд тус нэмэртэйн дээр хэвлэн нийтлэгчийн зүгээс тавьдаг хуудасны тоог хязгаарт багтаах боломж олгох тул энэ нь зохиогчийн цагаа зарцуулах ёстой нэг асуудал мөн.

Бичих явцдаа ашиглах хяналтын хуудас

Бодлогын баримт бичгийнхээ бичлэгийн хэлбэр маягт дүн шинжилгээ хийхдээ дараах асуултыг удирдамж болгон ашиглаарай:

- Та дэвшүүлэн тавьж буй үндэслэлүүдээ өргөн хүрээний уншигчдад (үүний дотор тухайн асуудлаар мэргэшсэн болон мэргэшээгүй хүмүүс) уншихад хялбар, ойлгомжтой байхаар шууд бөгөөд логиктойгоор танилцуулан тайлбарлаж чадсан уу?
- Баримт бичгийн бүтэц ойлгомжтой, энгийн хялбар болж чадсан уу?
- Бүлэг, дэд бүлгүүд нь логик холбоос сайтай, нэг нь нөгөөгөөсөө “урсан” гарч, залгамж холбоотой өрнөж байна уу?
- Баримт бичиг дотроос тодорхой мэдээллийг хайж олоход хялбар байна уу?
- Гарчиг, дэд гарчгууд нь уншигчийг бичвэрийн агуулгаар ойлгомжтой бөгөөд үр нөлөөтэй хөтлөн чиглүүлж чадаж байна уу?
- Бодлогын баримт бичигтээ ашигласан үг хэллэг, нэр томъёо нь бүх уншигчдад ойлгомжтой байж чадах уу?
- Утга нэмэхгүй байгаа илүү үгсийг олж хассан уу?

- **Ноорог баримт бичгийнхээ хэл найруулгыг хянах нь**

*Нооргийнхоо хэл
найруулгын алдааг
хянаж нягтлаарай.*

Бодлогын баримт бичгийн эхний нооргийг бичиж байхдаа хэрэглэж байгаа хэл найруулга нь зорилтот уншигчид, бичиж буй сэдэвт хэр нийцэж байгаад зохиогчид тэр бүр илтэд анхаараад байдаггүй.

Агуулгын утга санаанд гол анхаарлаа төвлөрүүлсэн үедээ зохиогчид хайнга байдлаасаа болж, эсвэл хэрэглээд хэвшчихсэн тул хэл найруулгын алдаа гаргах нь элбэг байдаг тул бичвэрээ дахин шалгаж нягтлах шаардлагатай. Үүнд танд бичлэгийн загварын гарын авлага, хэлзүйн дүрмийн номууд тус болох ч эдгээр нь хэт хатуу, тулган шаардсан заавар (жишээлбэл, идэвхгүй хэв ашиглахаас зайлсхий гэх мэт) агуулсан байдаг нь өгүүлбэрийн тодорхой бүтцийг ашиглах таны зорилго, орчин нөхцөл буюу өгүүлбэрийн тодорхой хэсгийг онцолж буйн сэдэл шалтгааныг тусгаж чадахгүй тул хязгаарлагдмал ач холбогдолтой байдаг.

*Нооргийн хэл,
найруулгыг
дахин нягталж,
сайжруулаарай.*

Харин та бичвэрийнхээ үг хэллэг, хэл найруулга нь таны ажиллаж буй орчин нөхцөлд хэр нийцэж байгаа талаас нь харж, анхааралтай шалгах хэрэгтэй. Баримт бичиг тань хэл найруулгын алдаа хэтэрхий олон байх юм бол хүссэн санаагаа уншигчдад хүргэх зорилготой энэхүү харилцааны үр өгөөж, ойлгомжтой байдал буурах юм.

Хэл найруулгын алдаа ихтэй баримт бичгийг хэвлэлтэд хүлээлгэж өгвөл хамтын ажиллагааны хүрээнд зохиогч эх бичвэрээ хэвлэлтэд зориулан зохих түвшинд бэлдэн боловсруулах үүргээ хангалттай биелүүлээгүй гэж редактор тань үзэх магадлалтай бөгөөд энэ нь сөрөг үр дагавруудыг үүсгэнэ. Түүнчлэн, редактортай хамтран бичвэрээ хянан тохиолдуулах үе шатад ирэхэд сайжруулах, хэлэлцэх үйл ажиллагаа нь хэл найруулгын наад захын алдаануудыг засахад бус харин агуулгын утга санаануудад төвлөрч байвал зохиогч, редакторын аль алинд нь өгөөжтэй.

Хэл, найруулгын хувьд зохиогч бүр өөрийн арга барилтай байдаг тул баримт бичгийнхээ нооргийг хянан нягталж байхдаа хэл найруулгын ямар асуудлуудад онцгой анхаарах ёстой болохыг та өөрөө тодорхойлох хэрэгтэй. Хэл, найруулгын холбогдолтой асуудлуудыг дэлгэрүүлж үзэхийн тулд хэлний сайн лавлах ном олж авахыг зөвлөж байна.¹⁴

¹⁴ Жишээлбэл, Мёрфи (1994), Свон (1996), Винс (1994).

- Баримт бичгийн өнгө аясыг хянаж нягтлах нь

Энэ бол баримт бичгээ хянан сайжруулах явцдаа анхаарах ёстой, өмнөх үе шаттай нягт холбоотой нэгэн асуудал юм. Энэхүү баримт бичиг таны дуу хоолой болж, хөндөж буй асуудлаараа тантай харилцан яриа, хэлэлцүүлэгт оролцоход уншигчдыг урин дуудах зорилготой хэрэгсэл болох давхар үүрэгтэй. Иймд та санаагаа уншигчдад үр нөлөөтэй хүргэхийн тулд гаргахыг хүсэж буй тэр л өнгө аясыг бичвэр тань илэрхийлж байх ёстой. Та баримт бичгээрээ энгийн, албаны эсвэл мэргэжлийн гээд ямар өнгө аяс гаргахыг хүсэж байгаагаа эхлээд шийдэх хэрэгтэй.

Хүссэн өнгө аясыг тань баримт бичиг хэр зэрэг сайн илэрхийлж, тууштай хадгалж байгааг анхаарч хянаарай.

Баримт бичгийн өнгө аяс уншигч болон хэвлэлийн төрөлд нийцтэй байхын хажуугаар мөн тэрхүү өнгө аясын тууштай байдал буюу тухайн өнгө аяс бичвэрийн эхнээс эцэс хүртэл хадгалагдаж чадаж байгаа талаас нь анхаарч хянах шаардлагатай. Энэ бол хянаж нягтлах үйл явцын төвөгтэй асуудлын нэг боловч дараах арга хандлага, асуултууд танд тусална.

Бичих явцдаа ашиглах хяналтын хуудас

- Та баримт бичгээ ямар өнгө аясаар бичихийг хүсч байна вэ?
- Хүсэж буй өнгө аясыг тань ямар түлхүүр үгсээр тодорхойлж болох вэ?
- Бичсэнээ эргээд уншихад таны дуу хоолой "сонсогдож" байна уу? Та өөрөө ярьж байгаа юм шиг сэтгэгдэл төрж байна уу?¹⁵

- Баримт бичгийг бүхэлд нь олон дахин уншиж, нягтлах нь

Баримт бичгийнхээ нооргийг тодорхой асуудал, чиглэлээр хянаж нягталсны дараа зохиогчид баримт бичгээ бүхэлд нь дахин дахин хянаж, сайжруулан бичсээр санаандаа хүртэл нь эцэслэж авдаг. Зохиогчид энэ шатад янз бүрийн арга барил хэрэглэдэг. Зарим нь өмнөх шатны хянан сайжруулах ажлын үеэр анзааралгүй орхисон зүйлсийг олж харахын тулд хоёр, гурван өдөр баримт бичгээ уншилгүй "холдсоны" дараа "шинэ" нүдээр харахыг зөвлөдөг. Баримт

Хүлээлгэж өгөхөд бэлэн болтол нь баримт бичгийг дахин дахин сайжруулж бич.

¹⁵ Сигизмунд Нуфф (1999).

бичгээ бүхлээр нь илүү тодорхой харахын тулд нэг удаа бүтнээр нь хэвлэж, дэлгэц дээр биш цаасан дээрх хувилбарыг үзэхэд илүүдэхгүй. Энэ нь баримт бичгийн тодорхой хэсгүүдэд тэмдэглэл хийх боломж олгохын зэрэгцээ хэвлэмэл эхээс чангаар дуудаж унших замаар компьютерийн дэлгэцээс уншихад тэр бүр анзаарагдамгүй хэл найруулга, өнгө аясын зарим асуудлыг олж харахад тусалдаг гэж зарим зохиогч хэлдэг.

- Хамтран ажиллагчдаасаа баримт бичгийг хянаж нягталж өгөхийг хүсэх нь

Бодлогын сүлжээний бусад гишүүдээс бүтээлч шүүмжлэл олж сонсохыг хичээ.

Баримт бичгээ өөрөө нягталж дуусаад шинэ асуудал гаргаж ирэх, ашигтай санаа өгөх, таны ажилд олон янзын шүүмж өгөх бусад хүмүүсээс санал, шүүмжлэл эрэлхийлэх нь нэн ашиг тустай. Хэрэв бодлогын судалгаа, баримт бичгийг багаар хийж гүйцэтгэсэн бол багийнхаа гишүүдээс шүүмж өгөхийг хүсээрэй. Хэрэв та

бодлогын баримт бичгээ ганцаар бие даан бичсэн бол уншиж санал өгөх хүмүүсийг маш сайн бодолцож сонгох хэрэгтэй ч бодлогын баримт бичиг бол урт, ээдрээтэй, уншиж санал өгөхөд цаг хугацаа шаардсан зүйл болохыг бас бодолцоорой. Боломжтой бол бодлогын сүлжээ дотроосоо хэвлэл нийтлэлийн туршлагатэй хүнээс зөвлөгөө өгөхийг хүсээрэй.

Хэвлэн нийтлэх үйл явцын энэ үе шатыг үр бүтээлтэй болгохын тулд хамтран ажиллагсдаасаа зөвхөн магтаал сайшаал хүлээх хэрэггүй. Харин та тэднээс энэ ноорог баримт бичгийг хэрхэн сайжруулах талаар бүтээлч шүүмжлэл, тодорхой санал дэвшүүлэхийг зориудаар хүсэх юм бол гарах үр дүн нь хамаагүй ашигтай байх билээ. Бусдын шүүмж, сэтгэгдлийг сонсохдоо тэд таны хувь хүний шинж чанаруудыг шүүмжлээгүй, харин таны бүтээлийн талаар өөрсдийн санаа бодлоо л илэрхийлж байгааг санаж, тэдний дэвшүүлсэн саналууд таны баримт бичгийн үр нөлөөг дээшлүүлэхэд хэрхэн нөлөөлөхийг сайтар тунгаасны үндсэн дээр баримт бичгээ сайжруулан шинэчлээрэй.

Хянан сайжруулах үйл явцын үе шатуудыг давтсаар мөнх үргэлжлүүлж болох ч нооргоо эцэслэн, редакторт хүлээлгэж өгөх цаг болсныг мөн мэдрэх нь чухал. Яг хэзээ зогсох ёстой гэдгийг яг таг хэлэх боломжгүй ч хэрвээ та олон үе шаттай, нарийвчилсан хянан сайжруулах үйл явцыг гүйцэтгэж дуусаад, баримт бичгээ өөрийнхөө хувьд эцэслэн сайжруулж дууссан гэдэгтэй итгэлтэй байгаа бол нооргоо хүлээлгэж өгөхөд бэлэн

болжээ. Харин энэхүү шийдвэрийн цаг нь болсон эсэхийг мэдэхийн тулд өөрөөсөө “Таны боловсруулсан баримт бичгийг эцэслэн, хэвлэлтэд бэлэн болгохтой холбоотой хамтын ажиллагааны хүрээнд та өөрийн хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн үү?” гэж асуугаарай.

6.3. Эх хувиа хүлээлгэн өгөх нь

Зохиогч олон үе шаттай, нарийвчилсан хянан сайжруулах үйл явцыг гүйцэтгэж дуусаад, бодлогын баримт бичгээ сайжруулж дууссан гэж үзэн сэтгэл хангалуун байгаа бол одоо хэвлэн нийтлэх үйл явцын дараагийн шат болох эх хувиа редакторт хүлээлгэн өгөх ажлыг эхлүүлэх хэрэгтэй. Бодлогын баримт бичгийнхээ бүтэц, форматыг сонгохтой нэгэн адилаар эх хувиа хүлээлгэж өгөхдөө хэвлэн нийтлэгчийн тогтоож өгсөн журмыг баримтлаарай. Жишээлбэл, хэрэв хэвлэн нийтлэгч А4 хэмжээтэй нүүрээр форматласан эх бичвэрийг цахим файл хэлбэрээр хүлээлгэж өгөхийг хүсэж байгаа бол энэ шаардлагыг биелүүлэх нь таны хувьд нэн чухал. Энэ нь танд илт ойлгомжтой, жижиг зүйл мэт санагдаж болох ч олон эх дээр зэрэг ажилладаг редакторын хувьд нэг стандартаар форматласан баримтуудтай ажиллах нь хялбар байх юм.

Эх хувиа хүлээлгэж өгөхдөө хэвлэн нийтлэгчийн хэвшүүлсэн журмыг дагаж мөрдөөрэй.

Хэвлэн нийтлэгч бүр л эх хувийг хүлээж авахтай холбоотой өөр өөрийн шаардлагыг тавьдаг ч хүлээлгэж өгөх эх хувийн тоо, хүлээлгэж өгөх арга зам (шуудангаар, эсвэл цахим шуудангаар), хүлээн авагчийн нэр болон хаяг, хүлээж авах эцсийн хугацаа, баримт бичгийн формат (цаасны хэмжээ, мөр хоорондын зай, фонт) зэрэг нийтлэг шаардлагууд бас бий. Хэрвээ хэвлэн нийтлэгч тань эх хувиа хүлээлгэж өгөхтэй холбоотой тодорхой зааварчилгаа өгөөгүй бол редактортайгаа холбоо барьж, зөвлөгөө авах хэрэгтэй. Зааварт энэ тухай дурьддаггүй ч эх хувьтайгаа хамт товч танилцуулах захиа бичиж хүргүүлэх нь эхийг тайлбарлан танилцуулаад зогсохгүй хэвлэн нийтлэгч, зохиогч хоёрын холбоо харилцааг гүнзгийрүүлэхэд тустай байдаг.

6.4. Хянан тохиолдуулагчтай хамтран ажиллаж, бүтээлээ хэвлэлтэд бэлдэх нь

Редакторлах үйл явц бол зохиогч, редакторын аль алиных нь сэтгэлд нийцсэн бүтээл гаргахад чиглэсэн хамтын ажиллагаа, хэлцэл юм.

Эхийг хэвлэхээр зөвшөөрсөн бол хэвлэн нийтлэх үйл явцын энэ үе шат эхэлнэ. Харин эх хувийг хэвлэхээс татгалзсан бол зохиогч энэхүү шийдвэрийн үндэслэл, шалтгааныг сайтар ойлгож авахын тулд редактортай уулзаж тайлбар авах хэрэгтэй. Ингэснээр зохиогчид өөрсдийн энэхүү туршлагаас суралцан, эх бичвэрээ улам сайжруулж ажиллаад, дахин хэвлүүлэх оролдлого хийх боломжтой болно. Татгалзсан хариу авсан бол эх бичвэрийг хүлээж авахгүй байхад хүргэх олон хүчин зүйл байдгийг санаж, зохиогч болон ирээдүйн хэвлэн нийтлэгчийн хооронд ажил хэргийн холбоо тогтоох боломжгүй нөхцөл ч гардагийг ойлгон, зөвхөн өөртэйгөө холбон хэт эмзэг хүлээж авахгүй байхыг хичээгээрэй.

Харин эх хувийг хэвлэлтэд авахаар зөвшөөрсөн бол хэвлэн нийтлэх ажлын сүүлийн шат эхэлнэ. Талуудын аль алиных нь нүдээр энэ үйл явцыг авч үзвэл дараах асуудлууд чухал болж ирнэ.

- ***Эх хувийг редакторлах ажил бол хамтран ажиллах үйл явц юм.***

Эх хувийг хүлээлгэж өгснөөр хэвлэн нийтлэх үйл явцад зохиогчийн гүйцэтгэх үүрэг дуусгавар боллоо гэж тооцож болохгүй. Энэ үе шат нь эх хувийг хянан сайжруулан хэвлэлтэд бэлтгэх хамтарсан үйл ажиллагаа бөгөөд үүнд редактор, туслах редактор, хэвлэлийн эх уншигч, шүүмжлэгчид, мөн мэдээжийн хэрэг зохиогч зэрэг олон хүн оролцдог. Таны бичсэн эхэд санал шүүмж өгч байгаа хүмүүсийн гүйцэтгэх үүрэг роль, анхаарах асуудлууд өөр байдаг. Тухайлбал, шүүмж бичигчид голдуу тухайн салбарын экспертүүд байдаг бөгөөд эхийн агуулгатай холбоотой санал, зөвлөгөө өгдөг бол хэвлэлийн эх уншигч нь хэл найруулга, бичлэгийн хэв маяг, өнгө аяст гол анхаарлаа төвлөрүүлдэг. Редакторлах үйл явц нь оролцож байгаа хүний тоо, эх бичвэрийг уншиж танилцахад зарцуулах хугацаа, баримт бичгийн чанарын талаарх төсөөлөл, мөн редактор болон зохиогчийн аль алиных нь сэтгэлд нийцэх хүртэл хэлэлцэх, хянан сайжруулах ажлын цар хүрээ гээд олон хүчин зүйлсийн улмаас нэлээд удаан өрнөж мэдэх үйл явц юм. Байгууллагаас

нь хэвлэн нийтэлж буй баримт бичгүүд бүгдээрээ боломжийн хамгийн сайн чанартайн дээр зорилтот бүлэгтээ үр нөлөөтэйгээр хүрч чадахуйц байх шаардлагыг хангаж ажиллах нь редакторын үүрэг юм. Зохиогчийн хувьд хэвлэн нийтлэгчийн шаардлагуудыг хангахын зэрэгцээ бодлогын сүлжээ дотор явагдаж байгаа яриа хэлэлцүүлэгт зохиогчийн хувь нэмрийг тод томруун гаргах давхар зорилт агуулж байгаа тул хэвлэн нийтлэгчтэй хамтран ажиллах нь зохиогчийн үүрэг юм.

- ***Редакторлах ажил бол хэлэлцэн зөвшилцөх үйл явц юм.***

Хэд хэдэн хүн эх хувийг уншиж, санал боловсруулсны дараа ч баримт бичгийг хэвлэн нийтэлж болох түвшинд хүртэл нь хэлэлцүүлэх, зөвшилцөх үйл явц үргэлжилнэ. Ноорог эх дээрээ хамтран ажиллагсдаасаа санал, шүүмж авч байсантай яг адил, энэхүү шүүмжийг сонсож, хянан сайжруулах үйл явцыг зохиогч та эх бичвэрээ сайжруулах нэгэн боломж гэж ойлгож хүлээж аваарай. Энэ үе шатад редакторлах ажил хэрхэн өрнөхийг хэвлэн нийтлэгч бүр өөр өөрийнхөөрөө журамладаг бөгөөд зарим нь эх бичвэр хүлээлгэж өгөх удирдамждаа энэ үйл явцын холбогдолтой товч тайлбар оруулж өгдөг. Хэрвээ байхгүй байвал зохиогч энэ үйл явцын талаар тайлбар авах хүсэлт гаргах хэрэгтэй. Редактор, хэвлэлийн эх хянагч нар эх бичвэрт өөрчлөлт хийх, эх бичвэрийг бүхий л талаар өөрчлөх санал, зөвлөгөө өгөх ч явдал гардаг. Улмаар редакторлах үйл явцын талаар судалж мэдсэн байх нь хяналтаа бусдад алдсан, бүтээлийн агуулгаа өөрийн хүссэнээр тодорхойлж чадахгүй болсон мэт сэтгэгдэл төрөхөөс зайлсхийхэд зохиогчдод тусална. Санал болгосон өөрчлөлтүүд, уншиж санал өгсөн шүүмжлэгч, редакторуудын зөвлөгөөг зохиогч бүгдийг нь хүлээж авч, тусгах үүрэггүй билээ. Гэхдээ санал өгч буй хүмүүс гол төлөв тухайн асуудлаар мэдлэг туршлагатай, таны бүтээлийг “шинэ” нүдээр харж, санал боловсруулахад багагүй цаг зарцуулсан хүмүүс юм. Эдгээрийг санаж, өөрчлөлт хийхийг хүссэн саналуудын үндэслэл, учир шалтгааныг сайтар эргэцүүлэн, эдгээр нь таны баримт бичгийг сайжруулж чадах эсэх, чадах бол хэрхэн сайжруулахыг үнэлж тунгаах нь хамгийн үр бүтээлтэй байх болно.

Хэрэв санал, зөвлөмжийг нийцгүй гэж үзвэл энэ асуудлаар редактортай ярилцаж, үндэслэлтэй тайлбар өгөх замаар тэдний саналыг яагаад хүлээж аваагүй болохоо итгэл үнэмшилтэй тайлбарлах нь чухал юм. Ер нь хоёр талын аль алиных нь сэтгэлд нийцсэн бүтээл гарч, хэвлэлд шилжих хүртэл яриа хэлэлцүүлэг тасралтгүй үргэлжлэх ёстой.

7. ТӨГСГӨЛИЙН ҮГ

Бодлогын баримт бичиг боловсруулан, хэвлүүлнэ гэдэг бол томоохон амжилт мөн. Юуны өмнө, таны баримт бичиг зорилгодоо хүрвэл та өөрийн улс оронд тулгамдаад байгаа асуудлыг шийдэхэд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулсандаа сэтгэл хангалуун байж болно. Хоёрдугаарт, бодлогын сүлжээний идэвхтэй гишүүн байснаар та зөвхөн хувь хүний болон мэргэжлийн хувьд ахиж хөгжөөд зогсохгүй өөрийн бүтээл, туршлагаараа бүс нутгийн бодлогын сүлжээний хөгжлийг дэмжиж байгаа хэрэг юм.

Бодлогын баримт бичиг боловсруулаад, хэвлэн нийтлүүлэх өргөн хүрээт үйл явцыг дүүргэх бүртээ та энэхүү ээдрээтэй үйл явцын бүхий л чиглэлээр өөрийн мэдлэг чадвараа ахиулах үнэ цэнэтэй боломжийг олж авна. Ийм суралцах боломжийг алдалгүй ашиглах нь судлаач, зохиогчийн хувьд өсөн хөгжихөд тань туслах бөгөөд таны дараагийн хэвлэн нийтлэх ажил өмнөхөөсөө улам бүр үр өгөөжтэй, үр нөлөөтэй байна гэж найдаж байна.

Төлөвлөлтөд ашиглах хяналтын хуудас

Дараагийн бодлогын судалгааны баримт бичиг боловсруулах үйл явцаа төлөвлөхдөө ийм баримт бичиг бичих, хэвлэн нийтлүүлэхтэй холбоотой өмнөх туршлагаа эргэн хараарай.

- Бодлогын асуудлаа судлан шинжлэх, бодлогын баримт бичиг бичиж боловсруулах, хэвлэн нийтлэх явцын аль талууд нь хамгийн амжилттай болсон бэ?
- Энэ явцад танд ямар хүндрэл бэрхшээлүүд тулгарч байсан бэ?
- Энэ үйл явцын аль хэсэг, талуудад та өөртөө итгэлтэй байсан бол аль хэсэгт нь танд эргэлзээ төрж байсан бэ?
- Баримт бичгийг боловсруулах үйл явцыг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд та дараагийн удаа ямар өөрчлөлтүүдийг оруулах бодолтой байна вэ?

ХАВСРАЛТ А. УДИРТГАЛЫН ЖИШЭЭ

- *Нэгдүгээр жишээнийн удиртгал.* “Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах нь: Захиргаадлаас зах зээлд” (Бёрд, Эбель, Воллих нар, 1995).

Засгийн газрыг солино гэдэг бол системийг солино гэсэн үг биш, бараг үүний урьдчилсан нөхцөл нь юм. Системийг өөрчилнө гэдэг бол урт удаан хугацаа шаардсан түүхэн үйл явц юм.

Янош Корнай, “Социалист систем”

Төв болон Зүүн Европд эрс шинэчлэл явагдаж байна. Олон ургальч, ардчилсан нийгэм, үр өгөөжтэй зах зээлийн эдийн засгийн суурь болох шинэ институци, эдийн засгийн дэд бүтцийг байгуулж байна. Энэхүү шинэчлэлийн хамгийн их анхаарал татаж буй асуудал нь хувьчлал буюу захиргаадлын эдийн засгаас либеральчлагдсан зах зээл, чөлөөт эдийн засаг руу шилжих шилжилт болоод байна. Хоёр дахь асуудал нь зах зээлийн эдийн засгийн хувьд дээрхээс ч дутуугүй ач холбогдолтой төрийн өөрийнх нь төвлөрлийг сааруулах асуудал юм.

Шилжилтийн эдийн засагтай ихэнх оронд социалист дэглэмийн үед ч орон нутгийн засаг захиргааны тогтолцоо тодорхой хэмжээнд байсан. Гэвч төсөв санхүүгийн тогтолцоо дээд зэргээр төвлөрсөн шинжтэй байсан тул орон нутгийн түвшин нь төсөв санхүү болон эрх зүйн бие даасан эрх мэдэлгүй, зөвхөн төв засгийн газрын захиргааны хэлтэс, нэгжийн үүрэгтэй ажиллаж байсан юм. Эдийн засагч Корнай (1992) нэгэн томоохон бүтээлдээ хуучин социалист системийг ихэд нарийвчлан судалжээ. Харин тэрбээр орон нутгийн засаг захиргааны тогтолцоо оршиж байсныг бараг дурьдалгүй, зөвхөн төв засгийн газар орон нутгуудыг бүхий л асуудлаар нэн хатуу хянадаг байсныг тэмдэглээд орхисон нь сонирхол татаж байгаа юм. Орон нутгийн засаг захиргаанууд нь төсөв санхүүгийн хувьд бараг эрх мэдэлгүй, төв засгийн газрын орон нутаг дахь салбар төдий чиг үүрэгтэй, төсөв санхүүгийн эрх мэдэл бараг юмуу огт байхгүй нэгжүүд байсан юм. Бүр албан ёсоор

“холбооны” бүтэцтэй гэж тооцогддог байсан ЗСБНХУ, Чехословак зэрэг орны хувьд ч нөхцөл байдал ийм л байлаа. Бодлого төвлөрсөн, хатуу хяналттай орчинд боловсруулагдан, орон нутгууд бие даан татвар тогтоох, орлогоо зарцуулах эрхгүй шахам, орон нутгийн төсөв нь төвлөрсөн төлөвлөгөөний “зарц”-ын үүрэгтэй төдий байжээ.

Одоо Төв ба Зүүн Европын олон орон, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудад улс төр, эдийн засгийн төвлөрлийг сааруулах өргөн цар хүрээтэй ажил өрнөж байна. Улс төрийн утгаараа, төвлөрлийг сааруулах энэхүү үйл явц нь өнгөрсөн үеийн өргөн хүрээтэй төвлөрсөн хяналтын эсрэг доороос өрнөсөн хариу үйлдэл, мөн төв засгийн газрын зүгээс буюу дээд түвшнээс хувьчлах үйл явцыг ахиулж, санхүүгийн дарамтыг багасгах оролдлогын илрэл юм. Эдийн засгийн утгаараа, төвлөрлийг сааруулах үйл явц нь нийгмийн баялгийг өмнөх үеэс илүү үр ашигтай ашиглах зайлшгүй шаардлага байгааг тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрч буйн үр дүн гэж үзэж болно. Эдгээр улсын төрийн захиргаа нь эдийн засгийн аливаа үйл ажиллагааны адилаар хэт төвлөрсөн шинжтэй байсан юм. Оновчтой төлөвлөж, хэрэжүүлж чадвал төвлөрлийг сааруулах бодлого нь төрийн үйлчилгээний хүргэлтийг сайжруулах үр дүн авчрах магадлалтай.

Улмаар төвлөрлийг сааруулах үйл явц бол захиргаадлаас зах зээлийн эдийн засагт шилжих үндэсний шилжилтийн цөм юм. Өргөн хүрээтэй эдийн засгийн шилжилтийн нэгэн адил энэ нь маш олон, хүнд хэцүү шинэчлэлийг шаардана. Зөвхөн татварын тогтолцоо болон шилжүүлгийн механизмуудыг өөрчлөн, засгийн газрын түвшнүүдийн зарцуулалтын эрх мэдлийг дахин хуваарилаад төр засаг юу хийх ёстой, юу хийж болох тухай ойлголтыг өөрчлөх шаардлага тулгарна. Улсын салбарын нийт үйл ажиллагааны цар хүрээг эрх хумихтай зэрэгцүүлэн орон нутгийн шинэ засаг захиргаад төсөв санхүүгийн талаар гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээх нөхцлийг хангасан байдлаар институцийн болон хүний нөөцийн чадавхиа бүрдүүлэн ажиллах боломжтой болох ёстой.

Төв болон орон нутгийн төсөв санхүүгийн харилцааны ид өрнөж буй шинэчлэл нь маш чухал үйл явц юм. Засгийн газрын түвшин хоорондын харилцааг шинэчлэх, орон нутгийн (төр засгийн дунд түвшин болон орон нутаг) засаг захиргааг бэхжүүлэх нь хөгжиж буй улсын болон хувийн салбарыг дэмжихэд нэн чухал үүрэгтэй. Төв засгийн газрын үйл

ажиллагаа хумигдан, өмнө нь төв засгийн газрын хариуцаж байсан олон үйлчилгээг орон нутгууд хүргэх болсон шилжилтийн эдийн засагтай орнуудад улсын салбарын үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргааны эзлэх хувийн жин өсч байна. ОХУ-д орон нутгийн төсвийн зарцуулалт 1992 онд улсын төвлөрсөн төсвийн 38.6 хувийг, 1993 онд 42.99 хувийг тус тус эзэлжээ. Унгар Улсад орон нутгийн төсвийн зарцуулалт 1988 онд улсын төвлөрсөн төсвийн 22.39 хувь байсан бол 1993 онд 30.49 хувь болж өсчээ (Хүснэгт 1.1). Засгийн газрын түвшин хоорондын харилцааны бүтэц нь нөөцийн оновчтой ашиглалт, хувьчлал, нийгмийн хамгаалал, тогтворжилт зэрэг бодлогын эгзэгтэй асуудалтай нягт уялдаатай болж байна. Төсөв санхүүгийн салбарт жишээлбэл, татварын шинэчлэл, төсвийн алдагдлын хяналт, засгийн газрын түвшин хоорондын санхүүгийн харилцаа зэрэг харилцан уялдаатай асуудлууд юм. Өөрөөр хэлбэл, эдгээр тогтолцооны аль нэгний төлөвлөлт, зохион байгуулалт доголдвол санхүүгийн тогтолцоо бүхэлдээ ганхахад хүрнэ. Үүний нэгэн адилаар, засгийн газар хоорондын харилцаан дахь урамшууллын механизмууд зохих ёсоор ажиллаж чадалгүй төв засгийн газрын давамгайлал хэвээр хадгалагдах, эсвэл хувийн салбарын хөгжлийг сааруулах нөлөө үзүүлэх юм бол шинэчлэлийн үйл явцад итгэл алдарч, улмаар ардчилал, зах зээлийн аль алиных нь хөгжилд эрсдэл авчрах юм.

- **Хоёрдугаар жишээний удиртгал:** “Орон нутгийн түвшний төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл явц дахь нээлттэй өрсөлдөөн, ил тод байдал, төвийг сахисан байр суурь” (Баар, 2001).

Удиртгал

Төрийн суурь үйлчилгээ, үүний дотор дүүргийн дулаан, цэвэр болон бохир усны үйлчилгээ, хог хаягдлын менежмент, зам талбай, цэцэрлэгийн арчилгаа зэргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, хувьчлах нь Төв болон Зүүн Европ (ТЗЕ)-ын орнуудад нийтлэг бөгөөд цар хүрээгээ тууштай тэлж буй үзэгдэл юм. Үйлчилгээг хувьчлах энэхүү үйл явцыг богино хугацааны гэрээ, урт хугацааны концессийн гэрээгээр зохицуулахаас гадны нийтийн үйлчилгээний өмчийг худалдах замаар хэрэгжүүлж байна.

Баруун Европыг бодвол, ТЗЕ-ын орон нутгууд үйлчилгээг гэрээлэх, хувьчлах ажлаас илүү хамааралтай байдалтай байна. Баруун Европын улс орнуудын төр засаг нь хувийн компаниудад олдож буй зээлээс бага

хүүтэйгээр зээл авч, системүүдээ сайжруулах боломжтой байхад ТЗЕ-т байдал эсрэгээрээ буюу орон нутгууд аливаа хөрөнгө оруулалт хийхийн тулд гадны хөрөнгөөс бүрэн хамааралтай байгаа юм. Цаашилбал, ТЗЕ-ын орон нутгийн засаг захиргаад Европын Холбооны стандартад нийцэхийн тулд цэвэр, бохир усны үйлчилгээгээ сайжруулах шахалттай тулгараад байна. Мөн дулаан хангамжтай холбоотой санхүүгийн дарамтаа багасгахын тулд орон нутгууд дүүргийн дулааны системээ сайжруулах шаардлагатай нүүр тулаад байна.

Үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх, хувьчлах үйл явц хэрхэн хэрэгжихээс эдгээр суурь үйлчилгээний ирээдүйн төлбөрийн хэмжээ хамаарах ба энэ нь өрхийн төсөвт багагүй нөлөө үзүүлэх тул нийтийн эзэмшлийн томоохон хөрөнгийн цаашдын эзэмшил, хяналтыг тодорхойлох болно.

Энэ бүлэг ТЗЕ-ын орнуудад нийтийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл явцад өрсөлдөөнт тендер, ил тод, сонирхлын зөрчлөөс ангид зарчмуудыг ашиглаж буй байдалтай холбоотой суурь асуудлуудыг авч үзэн, Европын Холбоо болон бусад оронд хэрэгжиж буй туршлагатай харьцуулах зорилготой болно. Энд бид ТЗЕ-ын дөрвөн орны (Чех, Унгар, Румын, Словак) нийтийн үйлчилгээг гэрээлэхтэй холбоотой туршлага, тэдгээрийг Баруун Европ, АНУ-ын туршлагатай харьцуулснаа танилцуулж байна. Энэ бүлгийн агуулга нь ярилцлага, судалгааны дүгнэлтэд түшиглэсэн бөгөөд ТЗЕ-ын орнуудын хууль эрх зүйн холбогдолтой нарийвчилсан мэдээлэл олдоцтой хэрнээ давамгайл ашиглагдаж буй практик туршлагын талаарх үнэлгээ дүгнэлт олон янз байсны улмаас, мөн тодорхой кейсд хамааралтай бодит туршлагын талаарх мэдээллийг системтэйгээр цуглуулаагүйгээс үүдэлтэй зарим сул тал агуулж байх магадлалтай юм.

Энд бүлэгт дараах асуудлыг авч үзлээ:

- (а). Өрсөлдөөнт шалгаруулалт явуулахыг шаардсан худалдан авалтын хууль зэрэг эрх зүйн зохицуулалтуудыг гэрээлэгч сонгон шалгаруулах үйл явцад авч хэрэглэх боломж
- (б). Гэрээ болон үнэ тогтооход ашигласан мэдээллийн олон нийтэд нээлттэй байдал
- (в). Гэрээлэгч сонгоход сонирхлын зөрчлөөс ангид, төвийг сахисан байр сууринаас хандах шаардлага.

- **Гуравдугаар жишээний удиртгал:** “Идэвхтэй сайшаах, идэвхгүй дэмжих ба үл итгэн хойш суухын хооронд” (Свианиевич, 2001).

Чех, Унгар, Польш, Словакийн орон нутгийн засаг захиргааны шинэчлэлийн талаарх иргэдийн санал бодол, тэдний оролцооны түвшинг хооронд нь харьцуулж үзэхэд үндэслэлтэй дүгнэлт гарах магадлалтай. Учир нь энэ дөрвөн улсад төвлөрлийг сааруулах зорилготой өөрчлөлт шинэчлэлийг ижил төстэй орчин нөхцөлд, бараг нэг цаг үед эхлүүлсэн юм. Польшид 1990 оны 3 дугаар сард Орон нутгийн засаг захиргааны тухай шинэ хууль баталж, мөн оны 5 дугаар сард орон нутгийн сонгууль явагджээ. Бусад гурван улсад орон нутгийн анхны ардчилсан сонгууль үүнээс нэг их холгүй буюу 1990 оны 10, 11 дүгээр сард явагджээ.

Улс төрийн шилжилт хийснээс хойш 10 жил өнгөрөөд байгаа энэ үед өөрчлөлт шинэчлэлүүд нь эдгээр улс орны нийгэм-улс төрийн нөхцөл байдлыг хэр гүн гүнзгий өөрчилж чадсаныг шинжилж үзэхэд сонирхолтой байх болно. Эдгээр өөрчлөлтийг орон нутгийн хүн ам анзаарч, сайшааж байна уу, эсвэл иргэдийн ихэнх нь орон нутгийн засаг захиргааг өөрсдөд нь хамаагүй, үр нөлөөгүй гэж үзэж байна уу? Дөрвөн улсын орон нутгийн шинэчлэлийн үйл явц олон төстэй зүйл агуулж байгаа нь илт ч бас цөөнгүй ялгаа байгаа юм.¹⁶

Энэ номын зохиогчдын үзэж байгаагаар, хамгийн чухал хоёр ялгаа нь газар нутгийн улс төрийн дахин хуваарилалтын арга хандлага, энэхүү хуваарилалттай холбоотойгоор шинэ статусдаа хүрэхийн тулд орон нутгуудын баримталсан үзэл баримтлал буюу философи юм.

Эдгээр дөрвөн улсын орон нутгийн засаг захиргааны уламжлалт жижиг нэгжүүдийг 1960-70-аад онуудад нэгтгэсэн билээ. Захиргаа, үйлчилгээг хүргэх тогтолцоог нягтруулах замаар эдийн засгийн хэмнэлт гаргах боломжтой гэсэн итгэл үнэмшлээр хийгдсэн энэ нэгтгэлийг хуучин коммунист удирдлагууд иргэдтэй огт хэлэлцэж зөвлөлдөлгүйгээр хийсэн юм. Үүнийг албадлагын аргаар хэрэгжүүлсэн, заримдаа маргаантай алхам гэж үзэх болсонд гайхаад байх хэрэггүй биз ээ.

Коммунист систем задран унасны дараа Чех, Унгар, Словакт энэ өөрчлөлт тун хурдан хуучин байдал руугаа эргэсэн ч Польшид ингээгүй

¹⁶ Дээрх дөрвөн улсын төвлөрлийг сааруулах зорилготой өөрчлөлт шинэчлэлийн тухай нэмэлт мэдээллийг, жишээлбэл, Бальдерсхайм нар (1996) зэрэг эх сурвалжаас харна уу.

юм. Польшид орон нутгийн нэгжийн тоо бага зэрэг нэмэгдсэнийг үл харгалзан нутаг дэвсгэрийн нэгтгэлийн тогтолцоог (хот) хэвээр хадгалахаар шийджээ. Бусад гурван улсад нь бараг бүх суурин, тосгод хэмжээнээс үл хамааран өөрийн засаг захиргаатай болохыг хүсч байв. Хэдийгээр энэхүү жижиглэн хуваагдалтыг дэмжих тодорхой томъёолсон бодлого байгаагүй ч Чех, Унгарын улс төрчид гэнэт үүссэн энэ үйл явцыг аажимдаа бэхжих боломж олгосон юм. Польшид харин нутаг дэвсгэрийг жижиг нэгжүүдэд хуваагдахыг дэмжсэн доороос дээш чиглэх шахалт шаардлага хүчээ аваагүй билээ. Төв засгийн газар ч мөн нутаг дэвсгэрийн хуваарийг жижиглэхийн эсрэг тууштай зогсох хандлагатай байлаа. Энэ үйл явцын үр дүнг Хүснэгт 1-д товч хураангуйлав.

Хүснэгт 1. Шинжилсэн орнууд дахь орон нутгийн засаг захиргааны хэмжээ

	Хүн амын дундаж тоо	1000-аас доош хүн амтай орон нутгийн эзлэх хувь /%/
Польш	15 500	0
Унгар	3 330	55
Словак	1 850	68
Чех	1 700	80

Эх сурвалж: Т. Хорват (2000), Г. Петери (1991)

Орон нутгийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын эдгээр ялгаа нь орчин цагийн төрийн тогтолцоон дахь орон нутгийн засаг захиргааны гүйцэтгэх үүрэг ролийн талаарх үзэл баримтлал, философийн гүн гүнзгий ялгаанаас үүдэлтэй гэж зарим хүн үзэж болох юм. Эдгээр ялгаа болон орон нутгийн удирдлага, иргэдийн хоорондын харилцааны хэв маягт эдгээрийн үзүүлэх ялгааг дор тайлбарлалаа.

- **Дөрөвдүгээр жишээний удиртгал:** “Нэгдмэл үзлээс олон ургальч үзэлд шилжих нь: Румын дахь цөөнхийн бодлогын хүрээнд зохицуулалтуудыг нарийвчлах хэрэгцээ” (Хорват, Скаццо нар, 2001)

1. Удиртгал

Румын Улс бол цөөнхийн олон бүлэгтэй орон нутгийг хэрхэн удирдах асуудлаарх судалгааны маш сонирхолтой жишээ юм. Румынд үндэсний

цөөнхүүд нийт хүн амын арав гаруй хувийг эзэлдэг. Наад зах нь 16 үндэсний цөөнх байгаа нь соёл, улс төр, хүн ам зүйн ялгаатай шинж төрхүүдийг бүрдүүлж байгаа юм. Румыний цөөнхийн бүлгүүдийн нийгэм, улс төр, эдийн засгийн оролцооны түвшин жигд биш. Өөр хоорондоо ялгаатай эдгээр бүлэг нь пост-коммунизмын үед улс төрийн харилцан адилгүй стратеги, өөр өөр зорилготой бодлого баримталж иржээ. Ялгаатай эдгээр бодлогуудыг үнэлж үзсэнээр бид Румыний цөөнхийн бүлгүүд соёлын болон үндэсний өвөрмөц өвөө хадгалан, түгээн дэлгэрүүлэхдээ тулгарч буй тодорхой бэрхшээлүүдийг тодорхойлох боломжтой болох юм.

Энэ бүлэгт бид цөөнхийн асуудлыг авч үзэхдээ Румыний бодлого боловсруулагчид цөөнхийн бүлгүүдийн хооронд оршиж буй соёл, улс төр, хүн амын чухал ялгаануудыг харгалзах ёстой гэсэн үндэслэлийг дэвшүүлж байна. Улмаар бодлогын болон бодит практикийн түвшинд төв засгийн газар энэ зарчмыг огт хэрэгжүүлж чадахгүй байгаа тул өөр хоорондоо ялгаатай эдгээр бүлэгтэй холбоотой асуулт, асуудлуудыг нэг бөөн болгож харах хандлага баримтлах болжээ. Румын Улсын үндэсний болон соёлын олон ургалч орчин нөхцөлд энэхүү нэгдмэл хандлага тохиромжгүй болохыг энэ номд тайлбарлахыг оролдлоо. Илүү мэдрэмжтэй, өөрөөр хэлбэл, Румын Улсын цөөнхийн бүлгүүдийн өөр хоорондоо ялгаатай хэрэгцээ, шаардлагуудыг харгалзан үзсэн арга барил хэрэгтэй байна.

Бидний санал болгож байгаагаар, Румын Улс дахь цөөнхийг хүн амын тоо, нутаг дэвсгэрийн нягтрал, улс төрийн идэвх, улс төрийн зорилго, түүхэн ба нийгэм, эдийн засгийн статусыг нь үндэс болгосон дор хаяж гурван тусдаа бүлэгт хуваан үзэж болох юм. Бидний судалгааны дүгнэлтээр 1) Унгар гаралтай цөөнх, 2) Герман, Украин, Литв зэрэг гаралтай (нэг зуун мянгаас цөөн хүн амтай) цөөнх, 3) цыганууд гэсэн наад зах нь гурван бүлэг байж болохоор байна. Эдгээр хэв шинжийг хүлээн зөвшөөрөх нь төв болон орон нутгийн бодлого боловсруулагчдад олон үндэстнээс бүрдсэн орон нутгийг удирдан зохицуулахтай холбоотой асуудлуудаар шийдвэр гаргахад тустай зүйл болно гэдэгт зохиогчид итгэлтэй байна.

ХАВСРАЛТ Б. Америкийн сэтгэлзүйчдийн нийгэмлэг (American Psychologist Association буюу АРА)-ийн загвар¹⁷

БИЧВЭР ДОТОР ХАШИЛТ АШИГЛАН ИШЛЭХ ЗААВАР

Байршил

Бичвэр дотор ишлэл байршуулах гурван хувилбараас сонго.

- *Өгүүлбэрийн эцэст, эсвэл тохиромжтой хэсэгт зохиогч(ид), огноо(нууд)-г хашилтад бичих:*

Жишээ: Эрүүл мэндийн чанартай боловсрол (Фишер, 1999), үйлчилгээг хүргэхэд (Вайст, Кристодулу нар, 2000) бэлтгэгдсэн ажиллах хүч дутмаг байгаа нь нийтлэг бэрхшээл болж байгааг судлаачид цохон тэмдэглэжээ.

- *Зөвхөн огноог хашилтад бичих:*

Жишээ: Калифорни мужид бүрэн дунд боловсролын гэрчилгээ авахын тулд эрүүл мэндийн боловсрол эзэмшсэн байх шаардлага тавьж байхыг Фишер (1999) зөвлөжээ.

- *Зохиогч, огноог өгүүлбэрт өгүүлэх:*

Жишээ: Залуучуудын сэтгэцийн эрүүл мэндийг үнэлэх зорилгоор Хүүхэд залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн үзүүлэлтүүдийг ашиглаж байх саналыг Уэйст 2001 онд дэвшүүлжээ.

¹⁷ Висконсин-Мэдисон их сургуулийн Бичвэрийн төвөөс эрхлэн гаргасан “Зохиогчийн гарын авлага” (бүрэн эхийг <http://www.wisc.edu/writing/Handbook/DocAPA.html> хаягаас үз), мөн “АРА загварын гарын авлага” (бүрэн эхийг <http://www.lib.usm.edu/~instruct/guides/apa.html> хаягаас үз) номуудаас өөрчлөн авлаа.

Аль мэдээллийг ямар эх сурвалжаас авсныг тодорхой харуулах зорилгоор ишлэлийг өгүүлбэр, догол мөр дотор байрлуулаарай.

Ишлэлийг бичвэрдотор Америкийн сэтгэлзүйчдийн нийгэмлэг (American Psychologist Association буюу APA)-ийн загварын дагуу байрлуулахтай холбоотой нэмэлт мэдээллийг [http://www.wisc.edu/writing/ Handbook/ DocAPA.html](http://www.wisc.edu/writing/Handbook/DocAPA.html) хаягаас авна уу.

ЭХ СУРВАЛЖИЙГ ЖАГСААЛТАД ДҮРЬДАХ ЖИШЭЭ

Сэтгүүлд багтсан өгүүлэл

Нэг зохиогчтой

Roy, A. (1982). Suicide in chronic schizophrenia. *British Journal of Child and Family Studies*, 141, 171–177.

Хоёр зохиогчтой

Adkins, A., and Singh, N. N. (2001). Reading level and readability of patient education materials in mental health. *Journal of Child and Family Studies*, 10, 1–8.

Гурваас зургаан зохиогчтой

Baldwin, C. M., Bevan, C., and Beshalske, A. (2000). At risk minority populations in a church-based clinic: Communicating basic needs. *Journal of Multicultural Nursing and Health*, 6(2), 26–28.

Сэтгүүлийг бүхлээр нь ишлэсэн бол

Conover, T. N. (Ed.). (1986). Testing concepts: Measurements of health [Special Issue]. *American Psychologist*, 42(18).

Сэтгүүлд хэвлэгдсэн материалын электрон хувилбар

Hackett, E. J. (Ed.). (1994). Perspectives on scientific misconduct [Special issue, electronic version]. *Journal of Higher Education*, 65(3).

Ном

Нэг зохиогчтой ном

Baxter, C. (1997). Race equality in health care and education. Philadelphia: Balliere Tindall.

Зохиогчийн редакторласан ном

Stock, G., and Campbell, J. (Eds.). (2000). Engineering the human genome: An exploration of the science and ethics of altering the genes we pass to our children. New York: Oxford University Press.

Редакторласан номд багтсан бүлэг, өгүүлэл

Eiser, S., Redpath, A., and Rogers, N. (1987). Outcomes of early parenting: Knowns and unknowns. In A. P. Kern and L. S. Maze (Eds.), Logical thinking in children (pp. 58–87). New York: Springer.

Хэвлэн нийтлэгч нь хамтран зохиогч байх

National Institute of Mental Health. (1989). Manual of cognitive learning. Washington, DC: Author.

Сэтгүүлийн нийтлэл

Greenberg, G. (2001, August 13). As good as dead: Is there really such a thing as brain death? *New Yorker*, 36–41.

Сонины нийтлэл

Өөр өөр нүүрт хэвлэгдсэн материал

Reichenbach, M. (1988, May 10). Mind and body of a child. *Christian Science Monitor*, pp. 4, 16.

Зохиогчгүй

Understanding early years as a prerequisite to development. (1986, May 4). *The Wall Street Journal*, p. 8.

Өдөр тутмын сонинд хэвлэгдсэн зохиогчгүй өгүүллийн цахим хувилбар

Mad-cow may tighten blood-donor curbs. (2001, April 19). The Gazette [Montreal], p. A13. Retrieved August 25, 2001, from Lexis-Nexis database.

Хувийн байгууллагаас хэвлэсэн бүтээл

Swift, A. C. (1985). Determining our children's future (Report no. 12). Milwaukee: Child Care of Wisconsin.

Засгийн газрын тайлан

Нэг зохиогчтой

Williamson, F. J. (1983). Child psychology in the public schools (Contract No. 100-4-62). Washington, DC: National Institute of Education.

Засгийн газрын агентлагийн тайлан

National Institute of Mental Health. (1998). Priorities for prevention research (NIH Publication No. 98-4321). Washington, DC: U.S. Government Printing Office.

Засгийн газрын тайлангийн цахим хувилбар

U.S. Public Health Service. (2000). Report of the surgeon general's conference on children's mental health: A national action agenda. Washington, DC: U.S. Department of Health and Human Services. Retrieved on August 25, 2001, from <http://www.surgeongeneral.gov/cmh/chilreport.htm>.

Ярилцлага

Арчер, Н. (1993). ["Мэдрэмж ба төсөөлөл" номын зохиогч Хелен Бёрсттай хийсэн ярилцлага]. *Journal of Sensory Studies*, 21, 211–216.

Хэвлэгдээгүй ярилцлагыг эх сурвалжийн жагсаалтад дурьдах шаардлагагүй. Учир нь АСЗН-ийн үзэж буйгаар энэ нь "хувийн харилцаа" тул "сэргээн ашиглаж болохгүй өгөгдөл" юм. Бичвэр дотор ярилцлагыг ярилцсан хүний нэрийн эхний үсэг, овгийн хамт харилцааны хэлбэр, ярилцлагын огноог оролцуулан тэмдэглэнэ (Н. Арчер, ярилцлага, 1993 оны 10 дугаар сарын 11).

Цахим мэдээлэл

Цахим мэдээллийг ишлэхтэй холбоотой нэмэлт мэдээллийг <http://www.apastyle.org/electref.html> хаягаас авна уу.

Америкийн сэтгэлзүйчдийн нийгэмлэг (American Psychologist Association буюу APA)-ийн загвараар номзүйн жагсаалт боловсруулах талаарх нэмэлт мэдээллийг <http://www.wisc.edu/writing/Handbook/DocAPA.html> хаягаас авна уу.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

American Psychological Association (2001). Publication manual of the American Psychological Association. (5th ed.). NY: Author.

Anderson, James E. (1994). Public policymaking. 2nd ed. Princeton, NJ: Houghton Mifflin.

Baar, Kenneth K. (2001). Open competition, transparency and impartiality in local government contracting out of public services. In Peteri, Gabor and Tamás M Horvath (Eds.). Navigation to the market: Regulation and competition in local utilities in Central and Eastern Europe. (pp. 103–139). Budapest: LGI/OSI. [Available on the internet at: <http://lgi.osi.hu/publications/2001/76/Reg-Ch2.PDF>]

Bardach, Eugene (1996). The eight step path of policy analysis: A handbook for practice. Berkeley: Berkeley Academic Press.

Bartle, Phil (2002). Preparing a community development policy paper: Guidelines for ministry leaders. Retrieved April 9, 2002 from <http://www.scn.org/ip/cds/cmp/modules/en-pol.htm>.

Bazerman, Charles (1985). The informed writer: Using sources in the disciplines. (2nd ed). Boston: Houghton Mifflin.

Berkenkotter, Carol and Thomas N. Huckin (1993). Rethinking genre from a sociocognitive perspective. *Written Communication*, 10:4, 475–509.

Bird, Richard M., Robert D. Ebel and Christine I. Wallich (1995). Fiscal decentralisation: From command to market. In Bird, Richard M., Robert D. Ebel and Christine I.

Wallich (Eds.). Decentralization of the socialist state: Inter-governmental finance in transition economies. (pp.1–69). Washington, DC: The World Bank. [Available on the internet at: <http://www-wds.worldbank.org/> Type the name of the book into the search tool and you will find the webpage]

Boston University (2002). International relations Master's paper guidelines. Retrieved April 9, 2002 from: <http://www.bu.edu/ir/paperguide.html>.

Breen, Michael P. (1987). Contemporary paradigms in syllabus design. Part II. *Language Teaching*, 20:3, 157–174.

Caeti (2002). Policy research paper: Points to ponder. Retrieved April 9, 2002 from: <http://www.unt.edu/cjus/ponderp.htm>.

De Leon, Peter (1994). Reinventing the policy sciences: Three steps back to the future. *Policy Sciences*, 27; 77–95.

Dye, Thomas (1992). *Understanding public policy*. (7th ed.). Englewood Cliffs, NJ: Prentice Hall.

Gibaldi, Joseph (1995). *MLA handbook for writers of research papers*. (4th ed.). NY: The Modern Language Association of America.

Hoekman, Bernard M. and Petros C. Mavroidis (1994). Linking competition and trade policies in Central and Eastern European countries. Policy Research Working Paper 1346. Washington, DC: The World Bank. [Available on the internet at: <http://www-wds.worldbank.org/> Type the name of the book into the search tool and you will find the webpage]

Horvóth, István and Alexandra Scacco (2001). From the unitary to the pluralistic: Finetuning minority policy in Romania. In Внry, Anna-Mória and Petra Kovács (Eds.). *Diversity in action: Local public management of multi-ethnic communities in Central and Eastern Europe*. (pp.243–271). Budapest: LGI/OSI. [Available on the internet at: <http://lgi.osi.hu/publications/2001/18/2–5.PDF>]

Howlett, Michael and M. Ramesh (1995). *Studying public policy: Policy cycles and policy subsystems*. Toronto: Oxford University Press.

Hutchinson, Tom and Alan Waters (1987). *English for specific purposes: A learning-centred approach*. Cambridge: Cambridge University Press.

Hyland, Ken (2000). *Disciplinary discourses: Social interactions in academic writing*. London: Longman.

Illich, I. (1971). *Deschooling Society*. New York: Harper and Row.

- Johns, Ann M. (1997). *Text, role and context*. Cambridge: Cambridge University Press.
- Karbach, Joan (1987). Using Toulmin's model of argumentation. *Journal of Teaching Writing*, 6:1, 81–91.
- Knowles, M. (1983). *The adult learner: A neglected species*. Houston: Gulf Publishing Company.
- Krastev, Ivan (2001). *Think tanks: Making and faking influence*. Unpublished Paper in Open Society Institute Policy Fellows Seminar Notes.
- Majone, Giandomenico (1989). *Evidence, argument and persuasion in the policy process*. New Haven: Yale University Press.
- Miller, Carolyn R. (1984). Genre as social action. *Quarterly Journal of Speech*, 70, 151–167.
- Murphy, Raymond (1994). *English grammar in use*. (2nd ed.). Cambridge: Cambridge University Press.
- Nunan, David (1988). *The learner-centred curriculum*. Cambridge: Cambridge University Press.
- Ohio University (1998). *Components of a technology policy paper*. Retrieved April 9, 2002 from: <http://oak.cats.ohiou.edu/~hill/polpap.htm>.
- Open Society Institute (1999). *The Professional work of policy analysis*. Unpublished OSI Policy Fellows Seminar Notes.
- Pacific Lutheran University (n.d.). *Writing your policy papers*. Retrieved April 9, 2002 from: <http://www.plu.edu/~olufsdw/polpapers.html>.
- Pal, Leslie A. (2000). *Context for policy analysis*. Unpublished Open Society Institute Seminar Notes.
- Prior, Paul (1998). *Writing/disciplinarity: A sociohistoric account of literate activity in the academy*. Mahwah, NJ: Lawrence Erlbaum.
- Russell, David R. (1997). Rethinking genre in school and society: An activity theory analysis. *Written Communication*, 14:4, 504–554.
- Scott, Gregory M. and Stephen M. Garrison (1995). *The political science student writer's manual*. NJ: Prentice Hall.

Sigismund Huff, Anne (1999). *Writing for scholarly publication*. Thousand Oaks, CA: Sage Publications.

Smith, Catherine F. (2000). Writing public policy: A practicum. *Technical Communication Quarterly*, 9:1, 77–92.

Swianiewicz, Pavel (2001). Between active appreciation, passive approval and distrustful withdrawal. In Swianiewicz, Pavel (Ed.). *Public perception of local governments: Citizens' perception of local government reform and local democracy in Central and Eastern Europe*. (pp.19–40). Budapest: LGI/OSI. [Available on the internet at: <http://lgi.osi.hu/publications/2001/75/PP-Ch1.PDF>]

Swales, John M. (1990). *Genre analysis*. Cambridge: Cambridge University Press.

Swan, Michael (1996). *Practical English usage*. (2nd ed.). Oxford: Oxford University Press.

The University of Washington (2001). Requirements for BLS 421 (Fall 2001) Prof Collins. Retrieved April 9, 2002 from: <http://faculty.washington.edu/swcollin/courses/bls421/requirements.htm>

University of Chicago (1993). *The Chicago manual of style*. (14th ed.). Chicago: The University of Chicago Press.

Vince, Michael (1994). *Advanced language practice*. Oxford: Heinemann English Language Teaching.

Widdowson, H.G. (1998). Communication and community: The pragmatics of ESP. *English for Specific Purposes*, 17:1, 3–14.